

НУУЦГАЙ

ХАЙРЪН

ПАЯН

Доржийн ГАРМАА



Д.Гармаа

## Нууцгай хайрын паян

# НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

-Яаж хоёр яс сална даа?...

Ууганжаргалын санаа алдан хэлсэн үгэнд Батбаяр цочих шиг болов. Эхнэр нь энэ үгийг бүр үнэн голоосоо, хэрэв Ерөө өөрийн нь охин байгаад төрөх гэж тэнд очсон бол эхийн хувьд сэтгэл түгшсэн үедээ хэлмээр тийм л өнгөөр хэлжээ. Үгүй ер нь Ерөө төрж чадах л байгаа даа? Дөнгөж хорин нас шүргэж яваа нялхаараа шахуу амьтан шүү дээ...

Батбаярын сэтгэл туйлын их зовж байв. Тэбээр дэмий л хүлээх өрөөний чулуун шалан дээгүүр нааш цааш алхах ажгуу. Батбаяр Ууганжаргал хоёр хотын нэгдүгээр амаржих газрын үүдэнд хүлээлгийн өрөөнд сэтгэл түгшин, чимээ чагнаж байлаа. Охин хүүхдээ, хань ижлээ төрөхийг хүлээсэн олон хүн үүдний өрөөнд чингэж чимээ чагнан, зарим нь сандал дээр сууж, зарим нь нааш цааш холхих ажээ. Амаржих газрын тасгуудаас сая төрсөн нярай хүүхдийн уйлах энхрий дуун сонстоно.

Гадаа идэр есийн жавар тачигнан, үргэлжид хүмүүс орж гарах гадна хаалгаар жаварлаг хүйтэн салхи цан уур савсуулан үлээнэ. Хүлээлгийн өрөө удам том, чамгүй урт уурын сарзгар хоолой сайн халж байсан боловч гаднаас үргэлжид орох жавар салхинаас болов уу, хүлээлгийн танхим хүйтэн байлаа.

"Ай хайрхан... Бушуухан шиг л төрөөсэй билээ. Битгий л их өвдөж зовоосойдоо". Амьдралдаа Батбаяр төрөх газрын үүдэнд чингэж шинэ хүн хорвоод мэндлэхийг хүлээн сэтгэл түгшин хүлээн зогссон удаагүй. Ууганаа тэр хоёр ханилаад олон жил болсон авч үрийн заяа ирсэнгүй. Удам залгах үр хүүхэд гэгч гэргий нөхрийн аль алины зүрхийг хөндүүрлүүлсэн эмзэг зүйл байв. Өчнөөн жил хамт амьдраад үр хүүхэдтэй болохгүй байгаагийн цаад нарийн зовлонг Батбаяр сэтгэлээрээ туулан шаналавч, харин учир начрыг нь олох гэж эмч домчид очсонгүй. Учир нь Батбаяр эмчийн үзлэгт ороод "Та үргүй юм байна" гэх аймшигт үгийг сонсохоос эмээж байлаа. Ууганаад ч мөн тийм зовлон буй заа. Эмчид сав суулгаа үзүүлэв гэж л юм ярьсангүй. Гэтэл энэ Ерөө төрөх нь... Гадны хүний нүдээр харвал Ерөө тэдний юу нь билээ?

Намрын нэгэн үдэш бага зэргийн халамцуу Батбаяр гэртээ хүүхэд шиг намхан нуруутай бүсгүйг дагуулан ирж билээ. Тэр тухай хүлээлгийн өрөөнд Ууганаа дурсан саналаа. Гэрийн эзэгтэйгээс зовсон юм шиг хавар намрын хөх пальтоныхоо захыг босгон нүдээ нуусхийн үүдэнд зогсох бүсгүйг Батбаяр дуудаж:

-Ор ор, Ерөө! Энэ бүсгүй оюутан юм. Зайлуул суух айл олдохгүй, оюутны байр зайгүй, зүдэрч яваа юм байна. Юу ч гэсэн хэд хоногтоо манайд байг даа. Чамд ч гэсэн ханьтай амар... гэжээ.

Царай зүс сайтай, хөөрхөн ч гэмээр тэр бүсгүйг баяртайгаар угтаад Ууганаа:

-Ор охин минь, битгий санаа зов хэмээн гараас нь хөтлөөд зочдын өрөөнд оруулжээ.

-Уг нь хуучин Дарханд гэр нь байдаг, олон хүүхэдтэй айлын ууган охин юм байна. Хувийн "Хууль цааз" сургуульд энэ жил ирж суралцжээ. Аав нь мах комбинатад нормчин, ээж нь

сургуульд цэвэрлэгчийн ажилтай гэнэ. Амьдрал ядуу болохоор айлын хажуу өрөөнд сууя гэхээр төлбөрийг нь дийлэхгүй. Тэгээд... хэмээн Батбаяр хувцасаа солингоо хэлээд:

-Ерөө чи гэртээ байгаа юм шиг л бай. Битгий санаа зов. Манайх гэж ийм л нэг айл байдаг. Эхнэр бид хоёр хоюулхнаа, хүүхэд шуухад гээд чиний хичээл хийхэд саад хийх хүн ч байхгүй. Манай энэнийг Ууганжаргал гэдэг. Эмнэлэгт сувилагчийн ажилтай... Хонуут ажилдаа гараад хоёр өдөр амардаг. Уг нутаг энүүхэн зүүнтэй байх Багануур хотын Баяндэлгэр сумын хүн. Аав нь улсын аврага малчин. Бас олуулаа... За та хоёр сайхан танилцаж эгч дуус болцгоох биз. Ууганаа чи нэг өрөөндөө Ерөөг оруулаад тохижуулж өгөөрэй. Гурвуулаа сайхан амьдрана аа... Бага жаахан охин ч гэсэн эмэгтэй хүний ханьтай болсондоо Ууганаа баяртай болов. Хөх палог нь тайлуулж, гар хөлийг нь угаалган, гэрийн халааз өмсүүлээд гурвуулаа ширээнд суун хооллоцгоожээ. Чингээд гурван өрөөнийхөө нэгийг суллаж оруулав. Уг нь тэр өрөөнд Батбаяр, сэтгүүлч байхдаа юмаа бичдэг байлаа. Ширээг нь хэвээр үлдээж, одоохондоо бэлэн байсангүй тул эвхдэг ор тавьж өгөв.

Ерөө маргааш нь чемодан савтай хувцасаа, дүүрэн ном дэвтэр хийсэн цүнхээ авчирчээ. Тэр харваас сэтгэл хангалуун байх шиг санагдана. Өрөөндөө нэг орвол барагтайд гарахгүй, номоо л үзэж, хааяа хацар дороо хоёр гараа хүүхэд шиг дэрлээд унтчихна. Хөдөөний хүүхэд ажилсаг байдаг болохоор гэр орон цэвэрлэн, хоол хийлцэж, Ууганаатай хамт угаалга хийнэ. Аливаа ажлыг үнэн голоосоо мэрийн хийх нь Ууганаад аятайхан санагдана.

-Ууганаа эгчээ, би хийчихье ээ гээд шал угааж байхад алчуурыг нь авах юм уу, хоол хийх гэж гампанз шүүрнэ. Хоол хошийг сайн хийнэ. Ялангуяа нарийн хоолонд их сүрхий. Багахан мах хөшиглөн, юухан хээхнээр амт оруулан, мантуун бууз, хуушуур хийхдээ чадмаг.

-Би хөдөө гэртээ байхдаа хамгийн том эгч нь болохоор хоолоо ганцаараа л хийдэг байсан...

Ууганаа түүнийг өхөөрөн сонсоно. Ерөө хувцас муутай тул Ууганаа өөрийн богино банзал, жинсэн өмднөөс өгсүүлээд түүнд таарах хувцасаа илүүчилдэг байв.

-Баярлалаа, Ууганаа эгчээ! гэж Ерөө тэр хувцаснуудыг гол төлөв гоёлд өмснө. Хоёр өнжөөд Ууганаа эмнэлэг дээрээ шөнийн ээлжийн сувилагчийн ажилдаа явна. Гэр өөдөө яарч охиноо санасан эхийн сэтгэлээр гүйж ирэхэд нь Ерөө сайхан сүүтэй цай чанаад, жаахан хоол хийчихсэн хүлээн суух бүлгээ. Түүнд нь Ууганаа ихэд баярлана. Өвчтөнгүүдийн хооронд эм тариа гэж гүйн, чөлөө завгүй байсаар бүр ядарчихаад ирэхэд нь урьд бол хэн ч ингэж хоол цай хийн угтдаггүй байсан. Батбаяр өглөө эрт хэвлэлийн газар руу явчихсан байна. Гэр орноо цэвэрлээгүй, ядаж цай чанаад халуун саванд хийчихээгүй байхад Ууганаа ядарсандаа болж шууд л орондоо орж унтаад өгдөг байжээ. Гэтэл гэр эзэнтэй болж, түүнийг хүлээх хүн буй болсонд Ууганаа баярлаж барахгүй байлаа.

Хэдийгээр гучин найм хүрч буй Ууганаагаас арван хэдэн насаар дүү боловч Ерөөг аажимдаа тэрбээр бараг л хүсээд хүсээд олдоогүй үр хүүхэд нь хувь заяаны тавилангаар хүрээд ирсэн мэт санах болов. Ууганаа түүний эзгүйгээр ар гэрт юу болж буйг үл анзаарна. Ямар ч байсан Ерөө байгаа болохоор эр нөхөр нь хоолтой цайтай, гэр орон цэвэр цэмцгэр байгаа гэж бодоход сэтгэл оег тавтай байна.

Хөдөөний жаахан бүсгүйд ингэж сэтгэлээ зориулаад, Ууганжаргал нөхөртөө хэлж баймааж буйдан ор өрөөнд нь оруулаад, ямар ч гэсэн нэг удаадаа хувцасыг нь бүрнээ сольж өгөв. Тэр бүхэнд Ерөө баярласан гялайснаа хэлэх боловч яагаад ч юм гэрийн эзэгтэйг ичсэн, айсан нүдээр хардаг байлаа. Тэр нь бол хөдөөний хүний бүрэг ичимтгий зангийн илрэл буй заа хэмээн бодож аль болох сэтгэлийг нь зассан үг хэлэхийг хичээнэ.

-Чи надаас битгий ичиж зовж бай. Би чам шиг л хөдөөний бүрэг дорой бүсгүй энэ айлын хаалгаар орж ирж байсан. Бас оюутан болж анагаахын дээд сургуульд суралцаж үзсэн. Манайх мал хуй ихтэй болохоор хөдөөний хамаг ажлыг хийдэг байсан. Яг л чам шиг том эгч ёсоор гэрийнхээ хамаг ажлыг хийж дүү нараа асардагсан. Адилхан заяатай бүсгүй улс бие биеээсээ ичиж цэрвэн, зовоод яах билээ. Харин ч сэтгэл нээлттэй байж зовлон жаргалаа хуваалцах ёстой шүү.

Ууганжаргалын үгийг сонсоод Ерөө зөвшөөрөх мэт толгой дохих боловч хөдөөний хүний бүрэг зан тийм ч амархан арилсангүй билээ. Ууганаа эмнэлэгт сувилагч болоод яг л Ерөө шиг амьтан хүнээс зовж, бүрэгшин их л удаж байж нүүр хагарсан болохоор өөртэйгөө жишин бодож өрөвдөн, нэг их шахаж шаардахыг байв.

Тэр үед Ууганаад нөхөртэйгөө танилцсан сайхан цаг эргэж санагдана. Дөнгөж аравдугаар анги төгсч Анагаахын дээд сургуулийн хуваарь аваад гэртээ зуссан тэр жил тэднийх Хэрлэн голоос холгүй Нүүрэнтэй хэмээх газар ганц гэрээрээ нутаглаж байлаа. Хэдэн дүү нар нь зуны халуунд нүцгэн шахуу гүйлдэж, ишиг хургаа зарим нь хариулж, өсгөлүүн зарим нь адуунд давхиж, ээж аав хоёр гүүгээ бариад өдөржин сааль сүү гэсэн өдрүүд өнгөрч байлаа. Нэгэн удаа хотоос залуухан сурвалжлагч улсын аврага малчныг сурвалжлахаар зориуд зорьж ирэв. Өндөр нуруутай, том нүдтэй, холын Москвад суралцдаг Батбаяр гэгч тэр залуу дадлагаар төвийн нэгэн сонинд ажиллах зуураа чингэж томиллолтоор тэднийд иржээ. Яриатай хөөрөөтэй Батбаярыг чимчигнэсэн айргаар дайлж, хот газар суралцдаг гэхлээр нь аав нь хонь төхөөрч их л найр тавьжээ. Харваас их юм сонсч дуулсан эрдэм номтой залуу хөдөөгийн сайхан бүсгүй Ууганжаргалд талтай байлаа. Яриа хөөрөөтэй нүүрэмгий тэр залууг Ууганжаргал анх хараад л нүд алдав. Энэ хорвоод учрах ёстой аз жаргал нь хүрээд ирсэн мэт далдын совин татаж, тэр хүний араар тойрч хойморт гаран, арван жил төгссөн гэрчилгээгээ, Анагаахын хуваарьтайгаа үзүүлэх гэж аавынхаа хэлснээр авдар уудлахдаа яагаад ч юм бэ дотносон мөрөн дээр нь зөөлөн дараад авмаар санагдаж билээ. Гэвч тэр хэтэрхий бүрэг даруу байлаа. Үзүүлэх ёстой зүйлээ тэр хүнд өгчихөөд ухаангүй ичиж гарч гүйхэд аав нь:

-Үгүй чи байз гэм. Хүлээгээч... гэж хойноос нь дууджээ. Ууганаа ичиж зовсон улаан царайтай амьтан буцаж ирэв.

-Манай энэний ичимхийг яана даа. Гэтэл одоо дээд сургуулийн оюутан болох гэж байдаг. Уг нь би охиноо малын эмч юм уу зоотехникч болоосой гэж бодож байсан юм. Одоо чинь сурлагаар жагсаалт гаргаад сургуулиас нь аль сургуульд орох хуваарийг нь санал харгалзахгүй өгчихдөг болчихсон юм байна шүү дээ. Гээд яах вэ. Олон дүү нартай, хөгшин эцэг эхтэй хүн сайн эмч болж байвал учиртай л юм санж. Хүү чамайг буцахад дагуулаад явуулбал болох уу? Бид олон малтай, тэгээд ч тэр сургууль номын газрыг нь мэдэхгүй. Хүү чи үүний минь замыг зааж, орох ёстой сургуульд нь оруулаад өгвөл ашгай юу даа гэж ээ.

-Тэгье ээ тэгье. Анагаахын дээдэд аавын танил ч бий.

Ингэж Ууганаагийн хувь заяа шийдэгдэв. Тэр үдэш Батбаяр унага таталцаж, Ууганжаргал гүү саав. Жаахан бүсгүй хотын дэгжин залууг эгц харж чадахгүй гүүний дор тонгойн, гагцхүү хөдөөгийн бүсгүйн чийрэг гараар шувтарсан сүү хувинд шаагиж байхад Батбаяр:

-Ууганаа, хоюул жаахан ярилцъя л даа. Залуу улс байна гэхэд бүсгүй дальдрах мэт улам доош тонгойв.

-Чи үерхдэг залуутай юу? Энэ үг Ууганааг:

-Яана аа... Ямар зовмоор юм хэлдэг хүн бэ? хэмээн уулга алдахад хүргэжээ.

-Битгий ингэж ичиж бүрэгшиж бай. Хотынхон хэт бүрэг хүнд дургүй шүү. Одоохон чи том сургуульд орж, оюутан бүсгүй болно. Хүний хэлсэн үг бүхэнд ичиж дуу алдаад байвал юу болох билээ. Хөдөөдөө олдохооргүй хөөрхөн бүсгүй байж, харин ч дуутай шуутай, олонтойгоо үгээ хуваалцдаг байвал хүмүүс чамайг илүү хүндэлнэ шүү дээ.

Батбаярын үгийг анхааралтай сонсоод Ууганжаргал, яг ийм үгийг ангийн нь багш хэлснийг санаж биеэ хичээн барьж хотын залуутай ярих гэж хичээв. Гэртээ орсны хойно аавынхаа морийг аргамжихаар гарахдаа, хамт явъя гэх шиг Батбаярын мөрөн дээр аяархан дараад авахад залуу хүн учрыг нь ойлгон боссон билээ. Тэд морь хөтлөн гэрээс холдоход зуны шөнө хэдийнээ эхэлж, бүдэг гялаан одод харанхуй тэнгэрийн уудамд тодрон бүдэгрэн байлаа. Хөлийн дор нялх ногоо гишгэгдэн Хэрлэнгийн зүгээс чийгний үнэр ханхална.

-Танай энэ газрыг Нүүрэнтэй гэдэг үү? Энэ хавьцаа их зохиолч Д. Нацагдоржийн төрсөн гэрийн буурь бий гэдэг байх аа?

-Тийм ээ. Энүүхэн зүүнтэй байгаа. Маргааш хоюулаа очиж үзсэн ч болно шүү.

Ууганаа их зориг гарган хэлжээ.

-Баярлалаа. Тэр буурийг маргааш очиж үзнэ ээ... гээд Батбаяр гэнэт түүнийг тэврэн авч туйлын энхрий дотноор уруул дээрээс нь озон үнсэв. Бүсгүй ичиж байсан боловч түүний халуун үнсэлтэнд авгаж, сэтгэл нялхраад хариу үнсэхдээ, харанхуй шөнөөр гул барьж баахан зориг орсон шинжтэй байлаа. Тэгсэн хэдий ч Ууганаа хэн нэгнээс айсан маягтай дагжин чичирч, өдий болтол эр хүнд чингэж үнсүүлээгүйгээ санан, хамрын угаар шархиран, юу юугүй уйлмаар ч болов. Батбаярт тэврүүлэн үнсүүлж зогссон мөч хэдийгээр маш түргэн хугацаанд болж өнгөрсөн боловч, харин залуу бүсгүйд бол ер хэт удаан болсон шиг санагдах авай. Сэтгэл нь бадарсан Батбаяр, бүсгүйн сая ургаж буй хатуу чийрэг хөхийг илэн, тааламжтай үгс шивнэн гараа доош явуулж эмзэг бүхэнд нь хүрэх шиг болохуй бүсгүй биеэ зайлсхийн тавиулж, аавын морьны аргамжааны гадсыг тэмтчин хайв.

-Аль вэ, би шаагаад өгье! гэж Батбаяр гадас муныг авч цохив. Ууганаа сэтгэлдээ баяртай байсан авч, түүний тэврэлтээс мултарсан минь зөв болов уу, буруу болов уу, энэ залуу надад гомдчихоогүй байгаа даа? гэж бодож байлаа. Хоюул морь аргамжаад хөтлөлцөн буцаж явлаа.

Онц юм ярьсан ч үгүй. Харин гэр ойртож, лааны гэрэл хаяагаар нь туссан их таван ханат хэдэн алхмын цаана харагдахад Батбаяр:

-Би шөнө чамд очвол болох уу? гэж шивнэн асуулаа.

Ууганаа юу хэлэхээ мэдэхгүй хэсэг түгдэрснээ:

-Би илүү гэрт унтана аа... гэж хэлчихээд гүйн алга болов.

Хөгшчүүл унтах гэж ор дэрээ янзлан, хоймроор олон жаахан хүүхдүүд зулаастай дугжирч байлаа.

-Хүү чи айраг уу. Ууганжаргал хайчив? Айраг хийж өгөөсэй билээ гэж эцэг хажуулдан хэвтэхдээ хэлжээ.

-Зүгээр ээ, би айраг уумааргүй байна.

-Тэгвэл унтаж амар даа хүү минь...

Батбаяр хэдийнээ хөнжил мухлайдаж дэр тавьсан баруун орон дээр гарч хэвтэхэд өвгөн лаагаа унтраав. Гэрт түнэр харанхуй боллоо. Хүүхдүүдийн шуухинах, хөгшин эцгийн ханиах, гадаа хотонд хонь яраглахаас өөр чимээ үл сонсогдоно. Тэрбээр хүмүүсийн нам нойрт дарагдахыг хүлээн зүүрмэглэх үгүйн хооронд тийчигнэн урваж хөрвөсөөр нилээд уджээ. Өвгөн аав хурхирч гарлаа. Батбаяр хөлөө орны урдуур унжуулан хэсэг чимээ чагнан сууснаа үүд рүү сэм алхав. Хаалгыг аяархан онгойлгон гарлаа. Зүүн өмнийн тэнгэрт сар бүдэгхэн тэмдгэрч байлаа. Залуу эр илүү гэр лүү дур тачаалдаа дийлдэн гэтсээр очлоо.

Батбаярыг ороод ирнэ гэж хүлээсээр Ууганжаргалын нойр нь хүрэхгүй, газраар дэвссэн гудсан дээрээ тийчлэн байв. Хаалга зөөлхөн онгойх чимээнээр залуу бүсгүйн хацар нь улайж, хамаг биеэр үл мэдэг цочрол харвав. Том халуун алгаараа Ууганаагийн үсийг илэн, толгойг тэмтрэн олоод, ухаан алдам сэрэл хөдөлгөсөн халуун үнсэлтээр хацар уруулийг шившин үнсэхэд Ууганаа аяархан гиншин түүнрүү харан тэврэв. Хэн нь ч олон үг ярьсангүй бие биеийн илчинд халууцан үг дуугүй биесийг таалан орчлонгийн эр эм хүмүүсийн хүсэлт сайхан мөчийг амсацгаан жаргав. Дахин давтагдашгүй үлэмжийн сайхан мөчид хайрын үнсэлт, янагийн тэсч ядсан дуу алдалт аль аль нь үл мэдэг сонсогдож билээ.

-Чамаас нуух юу байхав. Хотын арван жилд ч, хойно оюутан ахуй цагт ч, болзоонд гүйгээд ирэх сайхан бүсгүйчүүд таарч л байсан... Гэвч эхээс төрсөн цэвэр ариухнаараа, хамгийн гол нь хөдөөний бүсгүйн цэвэр ичимтгий зангаараа чи надад олдошгүй эрдэнэ байсан. Олон эрчүүлийн дор хэвтсэн хотын шунаг шунахай хүүхнүүд надад хань болохгүй гэж би боддог болсон байлаа. Чамтай тэгж танилцахад аав чинь дэм өгсөн гэж боддог шүү... хэмээн олон жилийн хойно Батбаяр, гэргий хань болсон хойно нь Ууганжаргалдаа хэлсэн билээ.

Батбаяр чингээд буцахын цагтаа Ууганжаргалыг дагуулан явав. Боривтой айраг, хонины мах, ааруул өрөмтэй бортого зэрэг ачаатай нь залуу бүсгүйг хотод авчирахдаа шууд л гэртээ буужээ. Хэдэн өдөр Анагаахын дээд сургуулиар явж ажлыг нь амжуулаад Ууганжаргалыг

сургуульд нь оруулав. Арван хэдэн хоног өнгөрөхөд залуу хүмүүс бие биедээ бүр дассан байлаа. Ууганаа есөн сар гаргаад сангийн аж ахуйд явахаар болов. Харин наймдугаар сарын эцэс болсон тул Батбаяр Москва руугаа явахаар бэлдэж эхлэв. Хол явахын өмнө нэгэн удаа Ууганааг дэлгүүр явсан хойгуур аав нь:

-Одоо чи яваад өгнө. Энэ охиныг яая гэж бодож байна гэж асуужээ.

-Хотод таньдаг айл байхгүй гэдэг. Аав ээж нь хөдөөний хүмүүс. Тэгээд ч бид хоёр... гээд Батбаяр түгдрэв.

-Чи энэ охинтой нэг орон дээр л унтдаг болж. Хэрэв хүсэл байгаад ханилан суухаар тохирсон бол манайд л байг даа хөөрхий. Хөдөөний бүсгүй элдэв зангүй, даруухан бүрэг охин байна. Ээж бид хоёрт чинь ч ханьтай.

Хот газрын хашир хурандаа, залуу бүсгүйг өрөвдөн хайрлахын хамт бас чиг улсын аврага малчных охиндоо гээд үе үехэн хүнээр өгчилгөдөг боривгой айраг, хонины махыг давхар бодолцсон буй заа.

Батбаяр Москвагийн их сургуулийн дөрөвдүгээр курсэд суралцаж байлаа. Дадлагын ажлаа амжилттай хийсэн тодорхойлолттой, хөдөөгийн цэцэг цэврүү шиг сайхан бүсгүйг гэртээ авчираад залчихсан, сэтгэл дүүрэн оюутан залуу намар найман сарын сүүлчээр холын Москваг зорин нисчээ. Ууганаа хань нөхрөө чингэж анх удаа Буянт-Ухаагийн нисэх онгоцны буудлаас алс замд нулимстай үдэв.

-Би өвлийн амралтаараа ингээд л хүрээд ирнэ. Харин чи хичээл номондоо сайн явж, аав ээж хоёрыг минь сайхан асраад, эр нөхөр намайгаа хүлээн сууж байгаарай. Би чамд захидал дандаа бичиж байна. Сардаа ямар ч гэсэн утсаар ярина. Ирээдүй сайхан болно гэж бодож амьдралдаа бат итгэлтэй бай. Хөдөөгийнхөндөө анхаарал тавина биз...

Хүмүүсээс зайдуухан аваачиж Ууганаагаа үнсээд Батбаяр нь чингэж үгээ захиж билээ. Залуу бүсгүй Батбаярт итгэж байлаа. Үнэхээр хоёр жилийн дараа гэхэд тэр нь төгсөж ирээд нэртэй сэтгүүлч болно. Өөрөө мөн эмч болж энэхүү уудам хорвоо ертөнц дээр аж амьдралаа зохионо гэж тэр мөрөөдөн боджээ. Батбаярын суусан агаарын ганган цагаан хөлөг хойт зүгийг барин нисч одоход Ууганжаргал тасралтгүй нулимсаа унагав. Хэд хоног хамт амьдарсан ч гэсэн угаас төрсөн нь биш болохоор хажууд зогсоо санчиг буурал хурандаа, намхан туранхай хөгшин хоёроос зэнзийрхэн зогсч байхад:

-За охин минь гэртээ харьцгаая. Явсан хүн ирдэг, ниссэн шувууд буцдаг шүү дээ. Батбаярыг хүлээгээд сууж байтал он жилүүд нэг мэдэхэд л өнгөрч бүгдээрээ түүнийг угтаж авах өдөр нэгэнт болчихсон байх вий хэмээн хурандаа аав хэлж, сугадан машин тавьсан газар руугаа явлаа. Нөгөө талаас ээж нь сугаджээ.

Чингээд Ууганаа мөнөөхөн хайртай хүнийхээ гэрт хоёр жил Батбаярыгаа хүлээв. Аав ээж хоёр нь түүнд сайн байлаа. Баяндэлгэрээс өвлийн эхэн сард аврага малчин аав нь хоол хош дөхүүлж ирэв. Үе зэртэмжээ насны хоёр аав галуун хүзүүг дундаа тавьж мах огтлон нэг оройжин сууж хууч хөөрөн танилцжээ.



-Хоёр хүүхэд ингээд бие биедээ хайртай байж аж амьдралаа сайхан зохиовол аштай юу. Армийн нэртэй хурандаа та охиныг минь гэртээ байлгаж халамжлан, хань ижлийг нь иртэл хүлээлгэх гэж санаа тавьсанд баярлавч баршгүй. Муу ээж нь саналаа л гэх юм. Өвөл Батбаярыг ирвэл манайх руу явуулчихна биз дээ? гэж халсан малчин аавыг хэлэхэд:

-Танай охин гэрийн ажилд сайн, гадуур тэнээд байхгүй, бүрэг даруу сайн охин байна. Ингээд бид гурвуулаа Батбаярыгаа хүлээж хэдэн жил болох нь. Энүүхэндээ гэж хэлэхэд эд нар маань үр хүүхэдтэй болж бидэнд үрийн зулай үнэрлүүлбэл яасан их баярлахсан бол... хэмээн хурандаа аав хэлж.

-Бид бүгдээрээ малчнаас гаралтай. Эхнэр бид хоёр улсын аврага малчин. Ийм сайн хүнтэй худ ураг болов гэж их л билэгшээж байгаа. Хүүгээ сургууль номоо дүүргээд ирэхлээр ёстой төртэй хурим найр хийнэ гэж хэлэлцэж байгаа. хэмээн өгүүлэх ажээ.

Ууганаа хичээлдээ гүйсээр байв. Өвлийн ид хүйтэн болоход хот газрын уур утаанд дасч өгөхгүй, тэгээд ханиад томуу элбэг болж, дээр нь Батбаярыгаа санан санасаар Ууганаа заримдаа өвдчихнө. Олон хоногоор хичээлээ таслаад, түүнийгээ хөхөж дийлэхгүй байсаар хэд хэдэн хичээлийн өртэй болов.

Түүнд хадам аавын хэлсэн үр хүүхдийн тухай бодол ямагт сэтгэлийг нь зовооно. Анхны учирлаар лав хүүхэд олсонгүй. Өвөл Батбаяр нь ирээд хоюул гэртээ эрхлэн наадаж, хөтлөлцөн явж, кино жүжиг үзэн туйлын жаргалтай өдрүүдийг өнгөрөөв. Тэр хоёр хөдөө явж Дундбайдраг хэмээх газар өвөлжиж буй хөдөө гэртээ очиж цагаан сараар золгожээ.

Малчин аавындаа үстэй хөнжилд тэврэлдэн хэвтэж байхдаа Батбаяр:

-Чи надад дүрсгүйхэн хүү төрүүлж өгөөрэй мэдэв үү? хэмээн хэлж билээ.

Энэ үг Ууганааг сандралд оруулжээ. Ээжийгээ санавал тэр өдийд ямар ч гэсэн хүүхэд олсон л байх ёстой байлаа. Гэтэл зуны учралаас хойш өчнөөн сар өнгөрөөд байхад хүүхэдтэй болсонгүй. Залуу бүсгүйд юу дутагдаад ийм байдалд хүрэв гэдгийг тэрвээр эс ойлгоно. Гэтэл эр нөхөр болох хүн нь хүүтэй болохыг хүсч байгаа ажээ. Тэд удсангүй хотдоо эргэн ирэв. Батбаяр сургуульдаа явлаа. Олон хичээлийн шалгалт өгөөгүй байсан тул Ууганжаргал өдөр шөнөгүй номын санд суув. Тэр биеэ чагнан, үрийн мөрөөсөл болж байв. Хэрэв тэр үр хүүхэдтэй болох аваас хань ижлээ баярлуулж, хадам аавынхаа итгэлийг хүлээх нь мэдээж ажээ. Магадгүй үр хүүхдийн хувьд тэр яараад байсан байж болох юм. Өвөл Батбаярыг ирээд буцсанаас хойш олон хоног өнгөрлөө.

Ууганжаргал шалгалтуудаа бүрнээ өгч дийлсэнгүй. Аягүйд бол эхний ангиасаа сургуулиас хасагдаж ч магадгүй болов. Сэтгэлийг зовоосон эл явдал сургуулийнхаа нэг багштай уулзан, үнэн учраа гарган хэлж, зөвөлгөө авахад хүргэжээ. Тэр багш залуухан, туйлын эелдэг зантай бүсгүй байлаа. Эмэгтэйчүүдийн өвчний талаар хичээл заадаг тул зарим оюутнууд ганцаарчлан уулзаж жаргал зовлонгоо ярьдаг байв.

-Би тантай уулзмаар байна, гэж хичээлийн завсарлагаанаар Ууганжаргал багшдаа хэлжээ.

-Тэгээ тэг, хичээл тарахын алдад багш дээрээ хүрээд ирээрэй, би ганцаараа байна гэж мөнөөхөн багш нь охин хүүхдийн зовлонг сонсож сурсан зангаараа уриалгахан зөвшөөрчээ.

Нэг үеэ бодоход эрхбиш нүүр хагарч хэлэх юмаа хэлчихдэг болсон авч ялангуяа бүсгүй хүнийхээ зовлонг ярина гэхээс баахан халгаж зовсоор Ууганаа багшдаа очив. Чингээд өнгөрсөн өвлийн хүйтэнд ханиад тусч олон цагаар хичээлд суугаагүй, шалгалтын өр ихтэй байгаагаа ярьж, уг нь яагаад ч эхний ангиасаа сургуулиас хасагдчих хайран байна гэв.

-Чи хичээгээд шалгалтаа өгөхийг бод. Энэ чиний сэтгэл санааны хямралтай холбоотой юм биш биз дээ? Чи гол зүйлээ ярихаасаа зовоод их л холоос тойруулах яриад байх шиг санагдана... гээд багш нь урихнаар инээмсэглэжээ.

-Тиймээ багшаа, би нэг зүйлд жаахан сэтгэл зовоод байгаа юм...

-Багшаасаа юу ч битгий нуу. Үнэнээ л хэл. Би чамд туслахыг бодно. Хүний сэтгэлийн лац ломбыг ханзлан, бүхнийг хэлүүлж чаддаг багш нийн үгэнд Ууганаа уяран, гар хуруугаараа оролдон байж нөхөр нь болоод хадам болох хурандаа гуай түүнийг хүүхэд олохыг хүлээсэн хийгээд, боломжийн учралууд тохиолдон зөндөө хугацаа өнгөрчихсөн байхад хүсээд байгаа үр нь үгүйд сэтгэл шаналж буйгаа уудлан цөмийг багшдаа ярив.

-Чи залуу байна. Сая л дөнгөж хүний хань болох замдаа оржээ. Чамаас үр хүүхэд хүсэх нь нөхрийн чинь болоод хадмын чинь зүй ёсны явдал... Гэвч санаснаар болдоггүй хорвоо шүү дээ. Тэгээд ч нөхөр чини бас оюутан, хаа хол Москвад байна. Яарах юу байх вэ. Тэсвэртэй хүлээ.

Ууганаа ээжийнхээ хааяа ярьдагийг дурсаад авлаа. Ээжийн удмын хүүхнүүд тун амархан хүүхэд олдог гэжээ.

-За яахав чи маргааш дагаад яв. Хоёулаа эмэгтэйчүүдийн нэг сайн эмчид үзүүлбэ. Тэр их туршлагатай, охидын талаар хэдэн ном гаргасан хүн. Нэг шийдтэй юм хэлэх буй заа. Гэхдээ миний бодоход чиний нас болоогүй, биеийн хөгжил хүүхэд олох хэмжээнд хүрээгүйн шалтгаан байхаас бус өөр юу л байв гэж дээ хэмээн багш нь хэлээд үүд хүртэл үджээ.

Маргааш нь Ууганжаргал нэрд гарсан эмэгтэйчүүдийн эмчийн ажил дээр очжээ. Тэндээс гарахдаа Ууганжаргал ямар аймшигтай үг сонссон байх бол хэмээн огт төсөөлсөнгүй билээ. Ууганааг хэвгүүлэн ном журмын дагуу сайтар үзэж, хоорондоо латинаар, оросоор ярилцаад эмч эгчийн асуусан нь:

-Чи ер хэзээ ч юм аваарт орж байсан уу?

Ууганжаргалын зрх палх хийгээд явчихав. Энэ эгч юу асуух нь энэ билээ?

Бүсгүй тийм явдал болсныг огт санаж чадахгүй байлаа. Хөдөө ямар үргэлж машин тэргэнд суугаад байх биш, бүсгүй тэрвээр бензинийх нь үнэрээс болоод хоёр дугуйтад дайгдаж үзсэн удаа бараг үгүй.

-Багадаа морь харнаас унаж бэртсэн буюу, ослоор уул хаднаас ойчсон явдал бий юу, сайн бод доо?

Найм дугаар ангидаа догшин морь туйлж, дөрөөндөө чирэгдэн нэн айхтар бэртэж олон хоног хэвтсэнээ бүсгүй сая л санав. Тэр тухай санамагц духан дээгүүр нь хөлс бөнжийн, амьсгаа нь ихдээд иржээ. Сумын эмнэлгийн өрөөнд ухаангүй хэвтэх үрээ тэврэн ээж нь уйлж, түүнийг цус их алдсан тул сэхэхгүй байх гэж хүмүүс ярилцаж байсан тухай сүүлд л Ууганаа сонсчээ.

-За яав? Санав уу? гэж эмч эгч асуув. Ууганжаргал морь туйлж дөрөөндөө чирэгдэн үхэх шахсан мөнөөхөн аймшигт явдлыг хэлэхээс аргагүй болжээ.

-Охин минь тэр явдлаас чинь ул мөр үлдсэн байж магадгүй. Бид ямар нэгэн багаж, дурангаар хараагүй, зүгээр эмчийн үзлэг хийгээд л тийм онош тавьж байна шүү. Хэрэв чи хүсвэл бид нарийн багаж дурангаар харж өгч болох юм.

Ууганаа сэтгэл санаагаар унав. Түүнийг хүүхэд гаргах чадваргүйг мэдвэл Батбаяр ч, хадмууд нь үзэж чадахгүй хэмээн бодох болжээ. Сэтгэлийн догшин шуурганд автсан бүсгүй шалгалтаа ч бүрэн өгч чадсангүй. Тэрвээр эхний курсээ төгсөж үл чадан сургуулиасаа хасагдах нь тодорхой болов. "Үрийн заяагүй сувай сударган надаар Батбаяр яах билээ дээ" гэж тэр гунин бодох нь их болов. Ууганаад үхмээр санагдаж байсан үе ч бий. Өрөөндөө ороод уйлаад суучихдаг болсон бүсгүйг нэг гэрт амьдарч буй хоёр хөгшин ажиглахгүй өнгөрсөн гэвэл нүгэл болох буй заа. Энэ хүүхдэд нэг л явдал болж, түүнээсээ шаналан өрөөндөө шөнөжин уйлахыг сонсож хурандаа нэгэн өдөр аядуухан дуугаар:

-Охин минь чамд хүнд хэцүү явдал тохиолдоо юу? Юунаас болоод өрөөндөө уйлж унжаад байх болов? Батбаярыгаа санав уу? Эсвэл хөдөө гэрт чинь гай зовлон тохиолдов уу? Хичээл номоо дийлэхээ байгаад багш нартаа хараалгаж зүхүүлэв үү? Үнэнээ хэлдээ охин минь! Бид нэг ёсондоо чиний хадмууд. Хүүгээ иртэл чамайг харж халамжилж байх ёстой улс шүү гэж хэлжээ.

-Нээрээ биднээс юугаа нуух билээ. Ар гэрээ, аав ээжээ санав уу? Бидний амьдарч буй сэтгэлд чинь таарахгүй байна уу? гэж хөгшин нэ санаа зовов.

Ууганаа ямар эмчийн хэлснийг хэлэлтэй биш дээ. Дуугүй хэсэг сууж байснаа, өнгөрсөн өвөл өвчин зовлон ээрээд хичээлээсээ их хоцорсноо, эхний ангийн шалгалтуудаа бүрэн өгч чадаагүйгээс сугуулиасаа хасагдаж магадгүй нь гэдгээ хэлэв.

-Энүүхний төлөө миний охин сэтгэлээ чилээж, уйлж охилон биеэ зовоож юугаа хийнэ. Амь биш заяа биш, амжиж чадахгүй бол сургуулиа орхино л биз. Батбаяр чинь сайн сэтгүүлч болоод удахгүй ирнэ. Та хоёрыгоо сайн сайхан амьдралтай болгоход аав ээж хоёр нь санаа тавих л болно шүү дээ. Гэвч маргааш би тэр багш нартай чинь уулзъя. Өвчтэй зовлонтой байсан нь үнэн л юм чинь. Хүн хэлээрээ, мал хөлөөрөө гэдэг дээ. Бүх насаараа амрид хүчин зүтгэсэн хөгшин хурандаагийн үгийг эрх биш сонсох л байлгүй! гэж хадам аав хэлээд Ууганаагийн толгойг илж хацар дээр нь үнсч билээ.

Азаар түүнд сайн хадмууд таарчээ. Ууганаа нулимсаа арчин, хөгшин аавын үгэнд нэг ана

боловч тайтгарч муухан инээмсэглэх аядлаа. Үнэхээр маргааш нь хадам аав сургууль дээр нь очиж, үнэн учрыг хэлэн гуйсаар байж Ууганаад нэг жилийн чөлөө аваад иржээ.

-Ашгүй цэргийн госпитальд ажилладаг танил эмч маань танай дэкантай нэг анги юмсанж. Тэр хөөцөлдөж, ер эмэгтэй оюутнууд жирэмсний амралт гээд жилийн чөлөө бишгүй л авч байдаг тул тэр журмаар чамайг хойтон болтол чөлөөлөв байна. Тэр болтол биеэ тэнхрүүлж амраад, зав чөлөөгөөр нь номоо сайн үз. Хэрэв ирэх жил нэгдүгээр ангийнхаа шалгалтын дугууг өгчих юм бол дараагийн ангиасаа суралцах юм байна. Миний тэр танил хэрэв чамайг хүсвэл дэргэдээ авч сувилагч хийлгээд, хичээл номонд чинь туслая гэсэн шүү, гэж хадам аав хэлжээ.

Энэ бүхнийг санах гэгч зүрх хөндүүрлэм байсан авч Ууганжаргал сэтгэл эвгүйцүүлсэн дурьдатгал санаснаа Батбаярт мэдэгдэхгүй хэмээн сэмээрхэн санаа алдаж, амьсгаагаа дотогш нь татаж бага багаар гаргалаа.

## ХОЁРДУГААР БҮЛЭГ

Амаржих газрын үүдэнд хүмүүс нэмэгдсээр л байлаа. Сувилагч залуухан бүсгүй хааяа ирж, хэн гэдэг бүсгүй амаржин хэдэн жин ямар хүүхэд төрүүлснийг, биеийн байдал ямаршуу байгааг цонхоор баяртай нь аргагүй зарлана. Тэр баяртай үгийг сонссон хэний ч нүд гялалзан тун урамтайгаар гарч одно.

-Ерөө яагаа бол? Төрөх орон дээр гарсан болов уу? гэж сувилагчийг ирэх тоолонд Ууганжаргал асууна.

-Арай л болоогүй байна. Өвдөлт тийм ч түргэн биш... Гэхдээ та санаа бүү зов. Гайгүй биз дээ... гээд сувилагч цонхоо хаана.

Энэ үг Батбаярыг айлгах шиг болно. Хэрэвзээ Ерөө ингэж өвдөх нь удааширсаар байгаад осол зэхий явдалд орвол яах билээ? Ер залуухан охид төрөхийн орон дээр гарч чадахгүй, хүүхдээ гаргаж амжихгүй аюулд орсон тухай дуулдаж л байсан шүү гэж бодохноо гол харлана. Тэрвээр эхийгээ зовоон, одоохон энэхүү эртний буурал хорвоо ертөнц дээр ирэх гэж яарахгүй байгаа тэр бяцхан амьтныг сэтгэлдээ төсөөлөн, зүрх базлах шиг болно.

Гаднаас цэлийтэл хаалга нээн, хар шубатай, монгол маягийн халиу малгайтай дэгжин байрын өндөр, туранхай хүүхэн орж ирсэн нь Чимгээ байлаа.

-За яав? Ерөө төрөв үү?

-Хэрэгт дурлах мэтээр Чимгээ хүүхэн, авгай нөхөр хоёроос чанга дуугаар асуужээ.

-Арай л төрөөгүй байна. Өвдөлт нь аажуухан байна гэж сувилагч хэлэх юм. Яаж хоёр яс сална даа зайлуул...

Ууганаа сэтгэл зовсноо үл нуун үерхдэг хүүхэндээ чингэж хариулжээ.

-Төрөхийн орон дээр очсон юм уу?

-Одоохондоо очоогүй гэсэн л дээ.

-Нааш нь авчрахдаа шар тос уулгасан уу?

-Үгүй шүү.

-Тэгдэг ёстой байхгүй юу. Ишш... та хоёрыг дээ... Чимгээ тохойд нь санжиганасан том ширэн цүнхнийхээ цахилгаан товчийг шархийтэл татаж онгойлгоод сонинд боодолтой юм, тарианы хамт гаргаж ирэв.

-Май үүнийг сувилагчид нь өгчихийг бод! гээд Чимгээ, Батбаярт мөнөөхөн юмсаа бариулав.

-Юу юм?

-Өвдөлтийг түргэсгэх тариа... Энэ нь баавгайн савар. Гэдэс хээлийг нь маажвал түргэн, өвдөлт багатай төрдөг байхгүй юу. Чи яв яв. Сувилагчийг нь дуудаж уулз. Май энэ шоколадыг өгч амиараа сайн гуй.

Батбаяр баавгайн савар тариа чихрийг барьсан хэвээр эргэлзсэн байртай зогсож байхад Чимгээ:

-За яваа яв. Хүнд ийм үед нь л туслах ёстой юм шүү. Анхны төрөлт амаргүй... Чамаас... Ууганаа та хоёроос өөр Ерөөг наашаа гэх амьтан энэ хотод байхгүй гэсэн биз дээ? Алив би чамайг оруулж өгье! гээд гараас нь хөтлөн явав. Эргэлт оруулдаг цонх нь хаалттай байлаа. Том хаалга руу нь Батбаярыг хөтлөн дөхөж явахдаа Чимгээ:

-Ерөөгийн хүүхдийн эцэг хэн бэ? гэж нухацтайхан асуулаа.

-Батбаяр цочсон мэт түүн рүү харав. Түүний нүд дальтчаа, хэрэг хийсэн хүний гэмтэй харцтай байлаа.

-Чи мэдэхгүй юм уу? Танайхаар тэр эцэгшүү юм нь шагайгаагүй гэж чи хэлмээр байна уу?

-Үгүй үгүй. Би танихгүй...

-Чи эцгийг нь олох л хэрэгтэй болж дээ! гээд Чимгээ цонхыг нь нударгаараа хүчтэй цохижээ.

-Тэртэй тэргүй Ерөөг хүүхдээ аваад эмнэлгээс гараад ирэхэд бүх юм тодорхой болно. Тэр хүүхдийн царай хэнтэй адилхан байх нь вэ?

Чимгээ ууртай ч гэмээр, бас хардсан ч гэмээр чингэж шивнэн хэлжээ. Энэ хүүхэн авааль гэргий Ууганжаргалаас илүүгээр болж буй хэрэгт бухимдаад байна уу даа гэмээр санагдана. Түүний бухимдлын цаад нарийн учрыг сэтгэл зүрх, бие цогцсоороо мэдэрч буй хүн Батбаяр л байлаа. Энэхүү хорвоо дээр эр хүн болж ирээд хийсэн хэргийнхээ төлөө сэтгэл зовж байлаа... Зөвхөн дотор хүнтэйгээ л яриваас Батбаяр ил далд, залуу, нас ахимаг гурван эхнэртэй хүн болох нь.

...Яг одоо бүгд нэгэн дор цуглараад зарим нь сэтгэл зовж, зарим нь хардаж үхэх гэж байх шиг. Орон гэртээ гурвуул авааль эхнэр болон хамт амьдраагүй боловчиг, яах аргагүй л гурвуулаа түүний дор хэвтэж, харин өнөө залуу нэг нь хүүхдийг нь төрүүлэхээр амаржих газар ирээд, нас ахимаг нөгөө хоёр нь үүдэнд нь сахиж байна. Ийм амьдрал гэж байхуу даа?

Батбаяр айх ч шиг, ичих ч шиг болов. Одоо тэгээд яалтай билээ?

Ууганжаргал тэр хоёрыг хоорондоо юуг ч юм хэлэлцэн, хана доргитол Чимгээ хаалга нүдэхийг харж зогсоод түрүүхэн нь түүний хэлсэн үгийг бодов. Хүн төрөхөд юу хэрэгтэйг мэдэхгүй будилснаа санахаас байж ядав. Өөрөө тиймийг үзсэн биш гэхэд амьтан хүнээс асууж болох л байсан даа. Уг нь манайд шар тос бий л дээ. Сайн сураглавал баавгайн саварыг ч, эм тариаг ч олох л байсан даа. Даанч мэдэхгүй, түүн дээр миний энэ хэнэггүй зан уу?...

Чимгээ нүүрмэг, ам хэлээр ч галзуу билээ. Сувилагчид чихэр атгуулж авч ирсэн зүйлээ өгөөд,

Ерөөгөөс хариу бичиг аваад ирээрэй гэж гуйхад Батбаяр түүний авхаалжтай зоримогийг гайхаж барахгүй байлаа. Чимгээ сая санаа нь амарсан мэт Батбаяр өөд нэг л эгэлгүй дулаахнаар харав. "Намайг тэгэхэд төрсөн бол чи бас л ингээд энд зогсож байх байсан даа?" гэсэн асуулт түүний харцанд ил байлаа. Чимгээ сэмээрхэн Батбаярыг чимхээд авав.

-Яваа? гээд Батбаяр өвдсөндөө ярвайсхийв.

-Чи сэтгүүлч хүн... Хэвлэлийн газрын эзэн хүн гэж байгаа... Бодож сэтгэж л байгаа биз дээ?

-Юуг тэр вэ?

-Төрөх хүүхдийн эцгийг... Би ч тэмээ хариулсан хүн буурынхаа занг андахгүй гэж хуучны үгийг санаж л байна.

-За болиоч дээ Чимгээ!

Эргэлт оруулдаг цонхтой хаалганаас холгүйхэн зогсоод Чимгээ түүнд гомдсон мэт чингэж хэлэхэд, үгийг нь Ууганаа сонсчих вий гэхээс яс хавталзан, гэргийн зүг өөрөө ч мэдэлгүй хяламхийв. Харин Ууганжаргал ер ажиг сэжиг авсан шинжгүй, Чимгээгийн цүнхийг нэг гартаа барьж, нөгөө гараараа даарсан мэт уурын хоолойг дарж үзэж байлаа. Ай даа мөн ч амар амгалан амьтан шүү.

"Ерөөгийн хүүхдийн эцэг хэн бэ?" хэмээн Чимгээ хэт хардаад байгаагийн учрыг Батбаяр ойлгохын дээдээр ойлгож байлаа. Тэгэхэд Ууганаа ер ажиг сэжиг аваагүй мэт, ер тэр тухай бодох ч үгүй байх шиг...

Тэр нэгэн зун сургуулиа төгсөж ирсэнээс хойш хятад хэл дээр гардаг "Ажилчны зам" сонинд орлогч эрхлэгчээр ажиллах болсон Батбаярыг гэртээ байхад нь нэгэн залуу урилга авчирч өгч билээ.

"Манай гэргий Хорлоогийн Чимгээ Санхүү-Эдийн засгийн сургуулиа амжилттай төгссөнийг тэмдэглэх зугаалганд эрхэм хүндэт сэтгүүлч Батбаяр таныг гэргий Ууганжаргалын хамт морилон ирэхийг урья" хэмээн бичээд хэдийд ямар унаа явахыг тодорхой заасан байлаа. Чингэж Батбаяр Туулын Уубуланд цөөхөн хүнтэй боловч идэх уухаар элбэг дүүрэн зугаалганд Ууганаатай хамт очжээ. Голын ногоон тохойд майхан барьж, бэржээнх дэвсэн, ил гал түлж, идэх уухыг дэлгэсэн тэр найр орой болтол үргэлжлэв.

-Батбаяр сэтгүүлчээ! Нэгд гэвэл манай эхнэрийг тэр жил Москвад жуулчинаар явахад орчуулагч болж, хэдэн савхийг боломжийн үнээр зарж өгснийг бид хоёр одоо болтол ярьсаар байдаг. Нөгөөд гэвэл хятад хэлтэй хүний хувьд харилцаа холбоо хөгжиж буй өнөө үед урд зүгийнхэнтэй хамтарч хувийн үйлдвэр, аж ахуй, наймааны ажилд тус болно гэж найдаж байгаагаа хэлчихье. Танай манай хоёр айл хоорондоо ойр дотно танилцана байх гэж найдаж байна... хэмээн Чимгээгийн нөхөр, хотын нилээн юмтай баячуудын нэг бөгөөд, автомашины инженер Чулуун тэр зугаалган дээр хундага өргөжээ.

Батбаяр дадлагын ажлаар ирээд Ууганаатай учирч, гэртээ авчирсны хойтон, Москвад ид мод

ногоорч, хүүхнүүд нүцгэн шилбээ гялалзуулан, эр хүний шохоорхлыг татан, даашинзтай гүйлдэх таван сарын дундуур Улаанбаатараас хэдэн хүн туристээр ирсэн билээ. Танил орос орчуулагч хүүхэн, хуучин найзын ёсоор Батбаяр руу утасдаж, одоохондоо монголчуудад үйлчлэх орос хэлмэрч үгүй тул, түүнийг цөөхөн хэдэн хоног нутгийнхандаа хэл ул болохгүй юу, цалин мөнгийг нь хайрлахгүй өгнө гэжээ. Оюутан хүнд мөнгө хэрэгтэй байлгүй яхав. Батбаяр уухайн тас зөвшөөрч "Юность" буудал руу яарч билээ. Залуу хүүхнүүд, нас ахимаг хөдөөний хүн зэрэг арав гаруй монголчууд хэлмэрчийг хүлээж байлаа. Батбаяр тэдэнтэй танилцан автобусаар зугаалж Москва мэддэг хүн гэдгээ харуулав. Хэнээс ч илүүгээр үзэсгэлэнт хотын гол гоё газруудаар музеи үзэсгэлэн үзүүлж, театр циркийн тоглолтонд оруулж монголчуудын гол сонирхох дэлгүүр хоршоогоор дагуулан шавайг нь ханатал үйлчлэв. Бас чиг гэж зарим хөгшчүүлийн гуйснаар ганц нэг савхин цамц, ноосон ороолт, алчуур сэлтийг нь сэм борлуулж өгөв. Харин бусдаас дэгжин, өндөр өсгийт өмсөж, орос даашинзаар гоёсон, өөртэй нь үе зэргэмжээ насны нэгэн хүүхэн түүнийг мөрөөдлийн нүдээр харж, үе үе санаа алдах боловч, ингээч тэгээч гэж юм гуйхгүй байснаа нэгэн орой өрөөндөө урив.

-За хэлмэрч гуай суучих. Аяга хүйтэн ундаа уух уу? гэж тэр ганц ортой өрөөнд орсон хойноо асуужээ. Гадаа халуун, тэгээд ч жуулчидыг дагуулан, дэлгүүр хэсч, баахан явсандаа ам цангсан тул Батбаяр толгой дохин, аягалж өгсөн ундааг тэр дор нь залгилав. Чингэтэл бүсгүй эр нөхрийнхөө хажууд байгаа мэт ер эрээлхэх цээрлэхгүйгээр даашинзаа тайлж, нүцгэн биеэ гаргаад, өндөр өсгийтөө хөлөөс мултлан тун найр тавьсан байдалтай, хажууд нь үнэртэн анхилуулан суугаад, нутгийн цагаан бөгст хатуу архи задалжээ. Түрүүхний амны цангаа арилсан гэвч, сайхан бүсгүйн эм биений үнэр, нүдэнд ил харагдах ангир цагаан цээж, чанга хатуу хөх, цацагтай нимгэн дотоожны цаанаас үл мэдэг томбойх нандин эрхтэн нь, Батбаярын бие болоод сэтгэлийн цангааг сэдрээв. Эхнэрээсээ хол удсан, тэгээд ч хичээл шалгалт гэж гүисээр ойрд бүсгүй хүнтэй наргиж дарвиагүй залуу эрийн хүсэл нь бадарч ирэв. Түүний хүйсийг сануулсан цэргийн хар нь өмдний товч таслах шахан босч ирлээ.

Чимгээ түүний энэ хуял тачаал, сэтгэлийн хөөрлийг нь хүлээж байсан мэт хаалгаа түгжин, хоёр хундаганд архи дүүргэн хийж тулган уугаад хүзүүгээр нь тэврэн өөртөө шахав. Батбаяр уусан архины ааг, хуял тачаалдаа болоод, тэсч үл чадан хүүхнийг тэврэн орон дээр зөөлхөн тавьж хүссэн бүхнийг нь амсуулав. Залуу оюутнаас хүссэн шим шүүс бүхнээ Чимгээ орилох чарлах шахуу хөдлөн байж алтан хундагаа дүүргэж авав.

Чингээд залуу хүмүүс ахиад хэдэн хундага дарс хүртэн ертөнцийн эр эм хүмүүсийн хүсэл тачаалын галыг шөнөжин асааж үүрээр унтацгаажээ. Батбаяр Чимгээ хоёр хэдэн өдөр шөнө янагийн халуунд авгав. Залуу оюутан эр бүсгүйн хүссэн жаргалыг өгч чаджээ. Хорвоогоос ийм л хүчтэй, ийм л дээрэлхүү эрийг олоосой гэсэн хүсэл бодлоо Чимгээ Москва хэмээх хотод биелүүлэв. Батбаяр ч хэн хүнээс амсаагүй бие болоод сэтгэлийн жаргалыг амсчээ. Чимгээгийн авч явсан чемодан дүүрэн савхин дээл, цамцыг шинэхэн янагийн ёсоор тэврээр танил оросуудад их үнээр өгчээ. Чингээд монголд үнэ хүрнэ л гэсэн эмэгтэй хүний гоёл чимгийн зүйл овоохныг цүнх саванд нь хийж өгөөд үдэн явуулжээ. Нутаг буцахын өмнөх шөнө Чимгээ өрөөндөө өргөн орон дээр Батбаярыг тэврэн хэвтэж байхдаа:

-Чиний эхнэртэй, миний нөхөртэй ямар хамаа байхав. Эндээс л би насан туршийнхаа амрагийг олж буцлаа гэж бодож байна. Чи эм хүнд үнэхээр хөнжлийн жаргал өгч чадах хүн



юм. Чинийх юутай хүчтэй, юутай хатуу юм бэ? Хэрэв чи армийн монгол хурандаагийн хүү бишсэн бол урд зүгийн ясан голтой эрхтэнтэй чийрэг нанхиад эрийн үр л гэж бодох нь...

Би одоо чамаас салахгүй шүү. Чамаас шөнийн жаргал эдэлж байхын тулд би юугаа ч хайрлахгүй гэж хэлсэн ажээ. Үнэндээ бол Батбаяр аль хэдийн монголжсон эрт цагийн хужаа хүний тав дахь удмын хүүхэд байлаа...

Чимгээ яваад өгөв. Онгоцонд орохдоо тэр нууцханаар нулимсаа арчжээ.

Батбаяр сая л Ууганаагийн өмнө нүгэл хийснээ ухаарч нүүр улайх шиг болов. Гэвч хувь заяаг яалтай. Батбаяр цаашид ч энэ хүүхэнтэй насан туршдаа холбогдож мэдэхнээ... Харин Ууганаагаа тэр хэзээ ч хаяхгүй.

Аавын нь ямагт үглэж байдаг нэгэн үг бий. Тэр бол "Хүн ямар ч нөхцөлд нэрээ бодох хэрэгтэй" гэсэн үг юм. Архи дарс, авгай хүүхний явдлаас болж хичнээн сайхан алдар нэрээ уландаа гишгэсэн хүмүүс байдгийг аав нь жишээлж ярьдаг. Хүнд ямар үйлийн үр тохиолдовч өөрийн нэрээ өндөрт өргөж явах ёстой бөгөөд энэ бол олон үе дамжсан тэднийхний амьдралын хатуу хууль мөн гэжээ. Ингээд бодохлээр хөөрхий муу Ууганаагаа далдуур доромжлон өөр хүнтэй явалдсан ч гэсэн түүнийгээ ямагт хайрлан насан туршдаа өвөр нөмрөөсөө гаргахгүй гэсэн хатуу үзэл Батбаярын толгойд бууж иржээ. Тэд амьдраад олон жил болов. Хүсэн хүлээсэн ганц зүйл үр хүүхэд л байлаа. Хүсэл хясал хосолж байдаг хорвоод Ууганаа нь түүнд нойтон сормуустай үрийн буян хайрласангүй.

-За орхи цааш нь... Үргүй хуурай, сувай сувдарган эмээр яах юм бэ? Чамд өнөө нь учраад маргааш нь хүүхэд төрүүлээд өгөх залуу сайхан бүсгүй захаас аваад олдно... гэж танил хүн хэлсэн нь буй. Гэвч Батбаяр ямар ч үед Ууганаагаа гомдоон хаяхгүй гэсэн хатуу бодлоосоо ухраагүй. Тэр бол түүний нэр төрийн хэрэг байлаа.

Уубуланд болсон Чимгээгийн сургууль төгссөний баярын зугаалганд Батбаяр оролцохдоо хүмүүсийн яриа, уулзалтын завсраар тэр хүүхэнтэй халыг тааралдахад тэрвээр,

-Энэ зугаалгыг яагаад зохиох болов гэдгийг чи сайн бодоорой. Би эхнэртэй чинь үй зайгүй дотно болох хэрэгтэй байсан юм.

Тэгэх нь чи бид хоёрын хэн хэнд хэрэгтэй шүү дээ. Одооноос эхлээд би танайхаар чөлөөтэй орж гардаг болно. Ууганжаргал ч гэсэн надаас салахыг байна. Ингээд бид хоёр нэгэн бүсгүйн сэтгэлээр чиний төлөө тэмцэх болно. Ойлгов уу? гэжээ.

Чимгээгийн хэлсэн үнэн байлаа. Тэр цагаас хойш тэрвээр Ууганаагийн үерхдэг хүүхнүүдийн хамгийн ойр дотны хүүхэн болж амжив. Хоёр бүсгүй үргэлжид утсаар ярих юм уу уулзацгаан, эм хүмүүсийн заншлаар авсан гоёлоо бие биедээ үзүүлцгээн, эрчүүлээ уруу татан хааяа зоогийн газар орон наргих болов. Чингэж тэднийд очих бүрдээ, бааранд сууж наргих бүрдээ Батбаяртай ярилцан "Москванд чамд хэлсэн үг бий шүү" гэж сануулна. Өдөр болгон биш юм аа гэхэд хааяадаа Чимгээ уулзах газар олон Батбаярыг ирээч гэж дуудна. Тэр нь ихэнхдээ Чимгээгийн найвдартай танилын эзгүй гэр байх юм уу, мөнгөөр амыг нь тагласан зочид буудлын жижүүрээс олж авсан сул өрөө байна. Ганц шил юм задалж зууш амссан болоод

нууц амрагууд орондоо орно. Чимгээ хэзээ ч ханаж цадахгүй байх шиг аашилна. Түүний бие сэтгэлийг хангах гэж Батбаярын хувьд хүнд ажил, ядаргаатай зүйл боловч, хүслийг нь биелүүлэн эр хүнийхээ тэнгэрийн ёсыг биелүүлэх л гэж хичээнэ. Учир нь тэр жил ирэх тутам Чимгээд өртэй болж байлаа. Энэ нь Чимгээ Чулуун хоёр томоохон компани байгуулж ихэд баяжсантай холбоотой аж.

Чулуун захиралтай, Чимгээ ерөнхий ня-ботой Улаанбаатарын нэртэй том "Авто-Жин" оросоос болон өмнөд солонгос, тэр бүү хэл японы томоохон үйлдвэрүүдийн гэрээт борлуулагч болж, дэлхийд нэртэй сайн үйлдвэрүүдийн машин тэрэг, хоёр дугуйтыг дураараа оруулж ирэн их үнээр борлуулж байлаа. Дансандаа хэдэн арван тэрбум төгрөгтэй хоёр найз нь, зүгээр нэг хятад хэл дээр гардаг байсан сонины эрхлэгч байсан Батбаярыг өөд нь татав. Эхлээд ерээд онд тэдний дэмжлэгээр Батбаяр "Янагийн халуун" хэмээх эротик сонин гаргав. Монголчууд шинэ нөхцөлд юм юмыг сонирхон, бүсэлхийнээс доош юм бичдэг хэвлэл их уншдаг байсан тэр хэдэн жилд Батбаяр овоо хөлжөөд ирсэн нь сонин сайн борлогдсоных байлаа. Чингэтэл хүн улам цаашлах дуртай байдаг юм хойно Батбаяр хэвлэлийн том газрыг хэвлэх үйлдвэртэй нь байгуулахсан гэж мөрөөдөх болов. Чухам тэр мөрөөдлөө биелүүлэхэд нь Чимгээ тусалжээ. Хэдэн саяын хөрөнгө Чимгээгийн нууц хайрын хүчээр Батбаярын дансанд ороод ирэв.

## ГУРАВДУГААР БҮЛЭГ

-За хонгор минь хүссэнээ хий дээ. Би чамайг хүслээ биелүүлээд сэтгэл хангалуун явахыг чинь хараад баярлая хэмээн Чимгээ ээлжит нэгэн болзооныхоо үеэр хэлжээ.

Чимгээ зөвхөн мөнгөөр туслаад зогссонгүй, мэргэжлийн сайн эдийн засагчийн хувиар, мөн бизнесийн ухаанд Батбаяраас хэдэн хувиар илүүгээрээ хэвлэлийн газар байгуулан, үйлдвэрийн тоног төхөөрөмж гаднаас оруулж ирэх, ажиллах хүч олох эхний бэрхшээлийг давж хөлөө олоход нь шууд тусалжээ. Харин энэ тал дээр хань нөхөр Чулуунтайгаа ярилцан байж, бараг л Батбаярын гарын нягтлангийн үүрэг гүйцэтгэж баймааж нь тусалсан хэрэг. Энэ бүхнийг бодохлоор Батбаяр нууц эхнэрээсээ холдох, хөндийрөх эрхгүй бөгөөд, Чимгээгийн хичээл зүтгэлийг, үнэнч сайн найзын сэтгэлийг Ууганжаргал үнэлж барахгүй байлаа.

Нэгэнтээ Батбаяр ядаргаагаа тайлах гэж Оргил рашаан сувилалд амрав. Тэнд очно гэдгээ мэдээжээр Чимгээд хэлсэн боловч харин нууц амрагийн ажлыг хүн олонтой амралтын газар эдэлж болохгүйг хэн хэн нь мэдэж байлаа.

Хэд хоног чимээгүй байсан Чимгээ түүнийг утсаар дуудав. Тэрвээр нилээд сандарсан шинжтэй утсаар дугаа нам болгон хэлсэн нь:

-Чи минь эмнэлэг дээр хүрээд ирвэл сайн байна. Би хэнд ч хэлэлгүйгээр амаржих газар түр хэвтэх нь... Уг нь чи бид хоёрын үр юм... Гэвч хэн хэндээ гай болж, гэмгүй дотно байдаг хүмүүсийн уур унтууг хүргээд яахав гэж бодоод үрээ үгүй хийхээр шийдлээ... гэжээ.

Энэ бол Батбаярын хувьд нэгэн талаар бодоход аймаар, нөгөө талаар бодоход өөрийн нь хүч чадлын үнэнийг баталсан учраас баярламаар сураг байлаа. Батбаяр түүнийг хүүхэдтэй болгож чаджээ. Тэрвээр сэтгэл догдлон нэгэн мөч чимээгүй зогсоход:

-Чи яав аа? Миний хэлсэнд дургүй чинь хүрэв үү? гэх Чимгээгийн гомдонгуй дуу гарлаа.

-За би одоохон очлоо. Яг одоо гарлаа! гэж Батбаяр хашгирах шахам хэлээд Батбаяр утсаа хаяж гүйн гарав.

Тэрвээр хөлсний тэрэг авч нэгдүгээр амаржих газарт яаран очиход Чимгээгийн хувцсыг сольчихоод сувилагч дагуулан явж байлаа. Үр хөндүүлэх өрөө рүү авч яваа нь тэр ажээ.

-Чимгээ...

Батбаярын дууг сонсоод хүүхэн хоромхон түдэн зогсож, инээмсэглэл гуниглал хосолсон харцаар нэгэнтээ ажаад явж оджээ.

-Байг, битгий түүнийг хөнөөгөөч!

Хэрэв өөрийн нь ханилсан албан ёсны гэргийсэн бол Батбаяр ингэж хашгирахад бэлэн байлаа. Энэ бол түүний хамгийн зүрхний хөндүүр зүйл, хичнээн жил ханиасаа хүлээн хүсээд олдоогүй ганц үр нь байлаа. Амьдрал яасан егөөтэй юм бэ? Ханийнхаа алтан хэвлийд хийж

чадаагүй үр нь харин нууц амрагт нь олджээ. Гэтэл гурвын гурван дэрсхэн хүүтэй Чимгээ, гучин долооныхоо жилд Чулуунаас өөр хүнээс хүүхэд олоод түүнээ гаргах эрх байсангүй. Зориг гаргаад хүүхдээ гаргадаг юмаа ч гэсэн тэр нялх амьтан Батбаяртай усны хоёр дусал шиг адилхан байхад Чулуун хараад юу гэж бодохсон билээ. Нууц амраг нууц байх тусмаа амттай биш гэж үү?

Батбаяр амаржих газрын үүдэнд зүрхээрээ уйлж зогссон юм. Хорвоо түүнд цорын ганц удаа үр заяахдаа ингэж ч хатуугаар тоглох гэж дээ... Чимгээ ч мэдээжээр эмчийн гар дор хэвтэж, Ертөнцөд туйлын дотно хүнээсээ олсон үрээ зулбуулж байхдаа баярлаагүй нь магад билээ. Хоёр их хайрын үр, мөч мөчөөрөө салан эхийн алтан хаалганы өмнө тавьсан тосгуурт унаж буйг тааварлан Чимгээ сэтгэлээ барьж чадамгүй байсан чиг ганц дуу ган хийгээгүй гэдэг...

Өнөөдөр тэгвэл Батбаярын хувьд хүссэн юм хүзүүгээр татаж, шинэхэн залуу амрагийнхаа алтан саванд бүрэлдэн буй болсон үрээ хүлээхийн догдлолд автан байхад Чимгээ харин хардах янзтай байгаа нь амьдрал ямар их эрээн бараан байдгийг хэлээд байх шиг...

-Ерөө төрөхийн орон дээр очлоо...

Сувилагчийн хэлсэн үг, хүлээн зогсч тус тусдаа бодол болон байсан гурван хүнд номхон команд өгчих шиг болов. Батбаяр давхийн цочсон бол, Ууганжаргал "Одоо яана аа" хэмээн дуун алдаж, харин Чимгээгийн царай хүнд өвчнөөс болсон шиг цонхийн цайж ирэв.

Сэтгэлийн догшин шуурга Чимгээгийн цээжинд маналзан байлаа. Тэрвээр тэр жил олдсон үрийг үгүй хийсэндээ одоо хүртэл харамсаж явдаг ажээ. Батбаяр шиг сайхан хүний үрийг тээчих хувь дутсан азгүй эм хэмээн тэр бодох бөлгөө. Энэ хорвоод учраасай хэмээн хүсч явсан хүн нь энэхүү сэтгүүлч залуу мөн байсан. Азаар түүнтэй харь газар учирснаа хувь заяаны хишиг хэмээн бодож заншжээ.

Хүүхнүүдийн шохоорхдог том алаг нүд, тэгш өндөр сайхан нуруу, эрдэм мэдлэг төгс боловч эгэл даруу сайхан зан нь, хамгийн гол нь учрахуйн мөчид дуу алдуулсан жинхэнэ эр хүний эрхтэн нь, шөнийн ажилд эм хүнийг жаргааж чадах элдэв ааш аяг нь Чимгээгийн хүсч байсан ертөнцийн хамгийн гайхамшиг амьтан мөн шүү гэдгийг батална. Тийм амьтныг насан туршдаа алдахгүй байхсан хэмээн Чимгээ маш их мэрийн, магадгүй монгол хүүхнээс гарамгүй нүүрэмгий загнасан ч байж болох. Батбаярыг алдахгүй сэн, түүнд өөрийг нь жаргаасан мөч бүрийнх нь тоогоор хариу тус болохсон гэхдээ Чимгээ юугаа ч хайрлаагүй. Хэрэв Чулуун шиг сайн хань тааралдаж, гурван сайхан баньдийн ээж болоогүйсэн бол Чимгээ огт бодохгүйгээр, юунаас ч айхгүйгээр Батбаяртай суучих л байлаа. Гэтэл хувь заяаны зам өөр ажээ. Тэр хичнээн түүнийг хайрладаг авч гурван хүүхдээ өнчрүүлэн, сайн ханиа гомдоох эрхгүй хүн байлаа. Тэгээд ч өдөр бүрий нэг гэрт, нэг орон дээр хөлбөрч уйдсанд орвол, хааяа нэг гал дөлтэй учран янаглах нь илүүтэй санагджээ. Гагцхүү тэр нэг хүүхэд... Хөөрхий минь хүү байсан гэдэг шүү. Батбаяртай жигтэйхэн адилхан амьтан байсан байх даа.

Ерөөгийн хүүхэд бол яах аргагүй Батбаярынх мөн дөө гэж бодохлээр Чимгээд туйлын зэвүүн санагдана. Түүний хүүхдийг энэ хорвоо дээр гагцхүү Чимгээ л тээж төрүүлэх байсан шиг санагдана. Гэвч тийм хувь заяа үгүй хойно яалтай ч билээ. Анхандаа хардлагаас болоод Чимгээ Батбаярыг цохиод авмаар байсан гэвч, аажимдаа хувь заяатай эвлэрэхээс өөр замгүй

болжээ. Тиймдээ ч тэрвээр амаржих газар ирсэн билээ. Адилхан бүсгүй хүн, зовлонг нь мэдэх юм хойно бушуухан төрөөсэй гэж бодохдоо Ерөөг өрөвдөн гэрээсээ тариа, баавгайн савар хүртэл авчирчээ. Гэхдээ үнэн хэрэгтээ Чимгээ л хий хардаад байгаа болохоос биш, Ерөөгийн хүүхдийн эцэг өөр хүн байвал яах билээ? Үгүй үгүй... тэр андуураагүй. Чимгээг сая ирээд Ерөөгийн хүүхдийн эцэг хэн бэ гэж асуухад Батбаяр гөлөлзөөд харцаа зугатаалгаж байсан шүү. Тэр чинь л учиртайн тэмдэг... Чимгээ ингэж элдвийг бодож, дэмий л хүлээлгийн өрөөн дотуур нааш цааш алхалж байв. Тэрвээр огт тамхи татдаггүй хэрнээ, хааяа нэг үеийнхэнтэйгээ нийлэхдээ саваагүйрхэн зуудаг шигээ сайн янжуур асаан нэг сайхан татмаар санагджээ.

-Намайг дагаад яваарай гэж тушаах мэт хэлэв. Жаахан охин үг дуугуй түүнийг дагажээ.

"Хөөрхий минь өлсөж л яваа даа" гэж бодоод Батбаяр түүнийг дагуулан эргэж, нөгөө зоогийн газрынхаа, түрүүний сууж байсан өрөөндөө оров.

-Та юм захиалах уу? гэсээр үйлчлэгч залуу гүйж ирэв.

-Хоёр хүний идэх оройн хоол, үхрийн хэлэн зууштай, хундага дарс, нэг шил ундаа аваад ирдээ гэж Батбаяр захиалав.

Оюутан охин ичиж зовсон харцаар түүнийг дальдран харна. Хавар намрын хуучин хөх пальтотой, толгойдоо маш нимгэн эрээн алчуур боож, үсээ хоёр салаа сүлжээд, мини хэмээх өвдөгнөөс дээшээ богино банзал өмсч, харин овоо шинэ намхан ултай шаахай углажээ.

-Чамайг хэн гэдэг вэ? хэмээн Батбаяр аль болох эвтэйхэн асуув.

-Ерөө.

-Аль сургууль билээ?

-"Хууль цааз" хувийн дээд сургууль.

-Хэд дүгээр анги вэ?

-Эхний жилдээ... Ах аа та намайг уучлаарай. Цагдаад битгий өгөөрэй. Би арга ядсандаа л анх удаа гудамжинд гарч...гээд Ерөө уйлчихав.

-Чи намайг цагдаагийн хүн гэж бодоод байна уу даа? Үгүй шүү. За танилцъя. Намайг Батбаяр гэдэг... Сэтгүүлч хүн л дээ. Чамайг би ядуу оюутны амьдралаас болоод анх удаа тэнд очсон байх гэж таасан. Хэн чамд энэ замаар орохыг заасан хэрэг вэ?

-Оюутны байранд аль намраас хойш толгой хоргодсон. Сар бүрийнхээ төлбөрийг өгч чадаагүй. Надаас өөр танилтай оюутнууд жижүүрт юмуу аж ахуйн даргад хэдэн цаас, үгүй ядаж шил архи өгөөд аргалж чадаж байхад надад тийм бололцоо алга. Манайх ядуу... Олон хүүхэдтэй. Аав ээжийн цалин бага, сүүлдээ хоолны ч мөнгөгүй болоод... Өрөөний охин "Зочид буудлын өмнө орой очоод эрэгтэй хүн дагаад явбал мөнгө өгдөг" гэсэн... Тэгээд...

Уилчлэгч хоол авчрав. Ширээн дээр сайхан зууш, хоол тавигдахыг Ерөө өлөн нүдээр горьдон харж, шүлсээ залгижээ.

-За Ерөө, наад гадуур хувцасаа тайлаад тэр өлгүүрт өлгөчих, тэр буланд байгаа тосгуурт гар нүүрээ угаачих. Тэгээд хоол идэцгээе аль болох эелдэгээр Батбаяр найр тавин хэлжээ. Охин босч хувцасаа өлгөн, гар нүүрээ угаав. Хараад байхнаа үнэхээр царайлаг охин юм. Байгаа байдал бүхэн нь... зөөлхөн булбарай хацар, ноосон цамцны дээгүүр цухуйх урт цагаан хүзүү, энгэр цээжинд үл мэдэг товойх сая ургаж буй хөх нь Ерөөг эр хүнтэй хавьтаж үзээгүй, ариун онгоноороо болохыг харуулах шиг болно. Хөдөөгийн хүүхдийн бүрэг ичимтгий зантай энэ жаахан бүсгүйг олоод авсандаа Батбаяр хотын хогон дундаас ширхэг сувд олсон лугаа адил олзуурхахад хүргэв. Иймэрхүү охиныг өөрийн гараар оруулбал хүслийг хангах чандмань эрдэнэ болно доо. Ууганаагаа чухам чингэж л нэг гараар эдэлсэн юм чинь. Зовсон гачигдсан үед нь туслаад өгөхөөр Ерөө миний үгнээс юунд л гарав гэж... Ер нь түүнийг гэртээ аваачвал яана? Дотуур байрны нь төлбөрийг өгчихнө л биз. Нэг өрөөндөө оруулаад, сайхан хувцаслаад сургуульд нь гүйлгэж байтал аандаа тэр миний эрхэнд ороод л ирэх вий. Эхнэр хоёр хоноод эмнэлэгт сувилагчийнхаа ээлжинд гардаг, бүтэн хорин дөрвөн цаг миний мэдэлд байх юм чинь Ерөөтэй үгээ нэгэнт олчихвол сэм сэмээр жаргал эдлээд байж болох биш үү. Байр эрсэн ядуу оюутныг гэртээ суулгаа л биз. Ууганжаргал энэ тал дээр юу л хардав гэж... Манайхаар үе үе ирдэг Чимгээ ч хүүхэд шигээ жаахан охинтой намайг холбож бодохгүй байлгүй.

Ингээд сэтгүүлч найзын хэлснээр дөч шүргэж яваа насандаа залуу цусаар өөрийгөө сэлбэвэл хөгшрөлтөөс өөрийгөө хамгаалж болох биш үү? Би өөрийнхөө болон эцэг эхийнхээ, үе удмынхаа нэр төрийг эрхэмлэдэг билээ. Миний тэр эрмэлзэлд Ерөөг гэртээ суулгаснаар сэв орохгүй биз дээ? Харин Ерөө л амаа сайн хамхиж явбал барж Энэ эгэл даруухан, бүрэг охин миний үгэнд орох вий.

Ерөөг хоол идэж байхад өөрөө өмнөх тавагтайгаасаа ганц нэг сэрээдэн, мөнөөхөн хундагатай виски дарсаа шимэн сууж Батбаяр чингэж л бодлоо.

-За Ерөө! Чи тэгэхээр мөнгө олох гэж гудамжинд, тэр мөртөөсөө журамтай бүсгүй хүн тэр болгон очдоггүй тэр газар анх удаа өнөө орой ирж... Тийм биз дээ? Энэ чинь юу гэсэн үг болохыг мэдэж байна уу?

Ерөө түүн рүү ихэд зовсон нүдээр харав. Тэрээр асуултанд хариулахын оронд нүүрээ улайлган доошоо харж, толгой дохилоо.

-Сонин хэвлэл, албан ёсны бичиг баримтанд энэ явдалд орсон бүсгүй хүнийг "биеэ үнэлэгч" хэмээн шившигтэйгээр нэрлэдэг шүү. Тийм замд нэгэнт орсон хүн эргэж гарах, бие болон нэрээ цэвэрлэн авахад их төвөгтэй хэцүү гэдэг. Тийм үү?

-Тийм ээ... Би үүнийг мэдэж байсан. Ядуу оюутны минь амьдрал л намайг гудамжинд хөөн гаргасан. Би таны юу хэлснийг биелүүлэхэд бэлэн байна гэж Ерөө бүр нэг зориг орсон мэт хэлэв.

-За тэгвэл хоюулаа сайн ярилцаж авъя. Чи намайг дагаад манайд очвол яана? Манайд нэг сул өрөө бий. Эхнэр минь чам шиг л хөдөөний хүн байсан. Чамайг хажиглахгүй. Чиний ядуу

оюутны амьдралд би тусалъя гэж бодлоо. Чиний ярьсан хэлсэнд би итгэж байна. Манайд дураараа сууж, хичээлдээ явж, эхнэрт тулавал барав... Харин надтай яаж уулзсанаа, ер бидний хооронд юу болсон хийгээд, болох явдлыг хэнд ч дурсаж болохгүй. Чи миний юу хэлснийг биелүүлэх л хэрэгтэй болно шүү гэдгийг би одоо халамцуу дээрээ чамд хэлчье. Миний үг ямар санагдав?

-За гэж Ерөө сая урам орсон мэт хэлэв.

-Үнэндээ надад гадуур айлын өрөө олж суух гэхлээр мөнгө байхгүй. Та миний хүнд үед туслах нь. Би таныг бурхан шиг л санаж, хэлсэн бүгдийг чинь биелүүлнэ. Хэнд ч ам алдахгүй. Надад илүү дутуу юм яриад явах тийм хүмүүжил ч байхгүй. Та итгээрэй.

Тэр орой хөлсний машин авчирч, Батбаяр жаахан охиныг дагуулан гэртээ харьсан билээ. Ууганаа Ерөөд төрсөн эгч шиг нь л хандав. Эхнэрээ ээлжийн ажилд явсан тэр шөнө анх удаа Батбаяр жаахан охин дээр оржээ. Ерөө түүнийг гэнэт ороод ирэхэд хярсан туулай шиг чичрэн угтжээ. Батбаяр аргадсан үг хэлэн байж, даарсан мэт чичирсэн бүсгүйг анх удаа үнсэн таалав. Айж ичиж байсан боловч Ерөө, хүний нь сэтгэлийг бодсон уу зориг муутайхан хариу үнсэж, дор нь номхон хүлцэнгүй хэвтжээ. Батбаяр, Чимгээгийн хэзээ ч билээ "ясан голтой" хэмээн өхөөрдөн үнэлсэн, бүсгүй хүнийг сандралд оруулдаг, эр биеийн чанга хатуу эрхтэнээ залуу бүсгүйн төлжиж амжаагүй, бариу давчуу бөгөөд онгон эрдэнэ рүү хүч түрэн хийхэд Ерөө өвдсөндөө ёолон тийчлэв. Батбаяр туйлын жаргалтай хоногийг өнгөрөөж билээ. Чингээд өглөө нь ажилд явахынхаа өмнө Ерөөгийн хамаг эрхтэнийг угааж өгч, тос түрхэн, иллэг хийх зэргээр өөрийн хүний сэтгэл гаргаад, ойрын хэдэн хоног биеэ хэрхэн арчлахыг зааж өгч үнсээд гарлаа. Ерөө анх удаагийн явдалд өвдөж ядарсан боловч Батбаярын халамжинд жигтэйхэн баярласан харцаар харсаар үлджээ. Тэр явдлаас хойш хэд хоногийн дараа Батбаярыг ороход Ерөө хэзээ язааны бие хаа нь хэвдээ орсон, харин ч дур тачаалтай угтжээ. Тэдний нууц амрагийн холбоо чингэж Ууганжаргалыг ээлжийн ажилтай шөнүүдэд улам лавшран гүнзгийрсээр байлаа.

Батбаяр сар өдрүүд өнгөрөх тусам жинхэнэ эм хүний шинжийг олж, мах булчин нь чангаран, хөх нь сэрийж, бөгс нь бүдүүрэн одоо аль ч эр хүн хараад нүд алдмаар болж буй Ерөөг ажигх тутмаа түүнд сэм дурлан сэтгэлээр шатаж байлаа. Тэр бол өөрийн нь хийсэн ажлын үр дүн бөгөөд, чухам Батбаярын сэм цутган өгсөн шим шүүс залуухан охиныг бүсгүй хүн болгон тэжээж, иймд хүргэв хэмээн дотроо баярласан билээ. Харин Ууганаа болохоор Ерөөгийн хэдхэн сарын дотор өнгө засч, бие төлжин, хотын ганган авхай нарын нэг болсны учрыг оюутны даржин амьдралаас салж, эрх дураараа тэдний гэрт жарган, Ууганаа өөрөө хувцас хунарыг нь сольж өгч халамжилсны үр дүн мөн хэмээн хөөрөн ярих бүлгээ.

-Тийм шүү. Чи минь л энэ охинд анхаарал тавьсны хүчинд Ерөө нүд алдам сайхан бүсгүй болж байна хэмээн амыг нь дагуулсхийн Батбаяр өгүүлнэ.

Чингэтэл Чимгээ түүнтэй хийх болзоогоо хийсээр л байлаа. Батбаяр тийм ч дуртай биш байдаг авч болзоонд нь хүний ёсыг бодон очиж, айлын эзгүй өрөөнд өнөөх ажлаа тийм таалалтай биш хийх авч тэр нь Чимгээд хангалттай байлаа.

Нэгэнтээ чингэж болзоонд очоод тэврэлдэн хэвтэж байхдаа Чимгээ урьдын адил

шунахайгаар үнсэн үлгэж байснаа:

-Ямар сонин юм бэ? Чи улам л залуу болчихсон ч юм шиг... гэж дуу алджээ.

-За чи битгий дамшигла. Нас ахиж буй хүн юу л гэж эргээд залуужив гэж дээ хэмээн Батбаяр гайхжээ.

-Нээрээ дээ, нээрээ. Чиний духны үрчлээ хүртэл цөөн болсон шиг, арьс чинь зөөлөрч цайгаад... Үгүй чи ер нь нүүрэндээ залуужуулах тос, түрхлэг хэрэглэдэг болсон юм биш үү? гээд Чимгээ бууж өгсөнгүй.

-Гадаадын ганган хүүхнүүд залуухан эрэгтэй хүний үрийн шингэн уух юм уу, нүүрэндээ түрхэж залуу сайхан арьстай харагддаг гэдэг. Чи минь Ууганаа бид хоёроос өөр, залуухан охинтой үерхэн, цусаа сэлбээд байгаа юм биш биз?

Энэ үг Батбаярыг цохиод авснаас илүүгээр цочоосон боловч тэр ажиггүй царайлжээ. Чимгээ, нэг гэрт байгаа Ууганжаргалаас илүүгээр түүнийг хардаж эхлэх нь энэ бөгөөд, харин ухаан санаанд нь Ерөө тэгэхэд хараахан ороогүй байлаа.

-За дэмий юм яриад бай, гэсхийн Батбаяр яриаг дүйвүүлж хүүхний тэврэлтээс мултран босохыг завдав.

-За за... тоглосон юм. Чи минь залуу сайхан болж байвал надад л сайхан биз... хэмээн Чимгээ халуун үнсэлтээрээ шавшиж, байж ядсан мэт гиншин хамаг бүхнийг тэмтэрчээ. Батбаяр түүнийг баярлуулахаас өөр аргагүй болов.

Хожим гэртээ ирээд толинд өөрийгөө сайтар ажиглав. Нээрээ тэр идэр залуу болсон мэт, духны атираа багасч, нүүр цагааран, эр хүний нь чийрэг хацарт унжсан санжсан илүү арьсгүй гөлгөр байх шиг санагдахад, энэ ч Ерөөгийн надад хайрласан шим шүүс мөн дөө хэмээн бодлоо. Тэр өдрийг хүртэл Батбаяр цаашид болж болох явдлын тухай огт бодож төсөөлөөгүй билээ. Эр хүний ганцхан дусал гэнэт залуу эхийн хэвлийд үр болон тогтно чинээ санаагүй явжээ. Эл хайхрамжгүй байдал нь, магадгүй тэр жил Чимгээд тохиолдсон жирэмслэлт нь олон хоног ноололдсоны үр дүн гэж Батбаяр бодсонтой ч холбоотой байж болох. Ерөөтэй мөн цөөнгүй сар, бүр хэдэн жилээр учрал тохиол болж баймааж элдэв явдал болж болно гэсэн хатуу итгэл түүнд байсан. Гэтэл Ерөөг тэднийд ирж сууснаас хойш гурав юм уу дөрөвхөн сарын дараа залуу бүсгүйд хоол зохихоо больж, хүүхэд олсны шинж тэмдэг мэдэгдээд ирэв. Тэр тухайд хамгийн түрүүнд ажигласан хүн бол Ууганжаргал байлаа. Ариун цэврийн өрөөнд ороод удтал гарч ирэхгүй байх юм уу, хоолны үнэр авч чадахгүй огих болсныг нь мэдээд, танил бүсгүйчүүд болон ээжээрээ жишин санаж нэгэн удаа Батбаярт:

-Ерөө маань хөл хүндтэй болжээ зайлуул... хэмээн аминчлан хэлсэн ажээ.

-Юу? хэмээн эр нөхөр цочин дуу алдав.

-Гадуур нэг их гардаггүй л хүүхэд шүү дээ. Угаасаа үерхдэг хүнтэй байсан юм байгаа биз. Яах аргагүй хоёр юм уу гурван сартай жирэмсэн. Одоо энэ амьтны чинь талаар их



анхаарахгүй бол болохгүй. Бага залуу юм ичиж зовно. Сэтгэл санаа нь хямарч, осол зэхий явдалд ч орж мэднэ. Би өөртэй нь сайн яриад багш дээрээ дагуулж аваачиж үзүүлдэг юм билүү? хэмээн Ууганаа ихэд сэтгэл зовсон шинжтэй ярьж байлаа.

-Үгүй бас сонин юм даа...

Батбаярт үүнээс өөр хэлэх үг олдсонгүй. Ер юугаа ч ярих билээ дээ. Хэргийн эзэн, хэнгэрэгийн дохиур өөрөө гэдгийг тэр сайн мэдэж байлаа. Бүсгүй хүнийг жирэмсэн болгох чадалтай гэдгээ, Чимгээгийн явдлаас хойш сайн мэддэг байсан хэрнээ юм мэдэхгүй гэнэн цайлган Ерөөд ийм явдлаас урьдчилан сэргийлэх тухай ямар нэгэн юм хэлж өгөөгүй нь буруу болжээ. Жаахан бүсгүй түүний гарын аяар хөдлөх хүүхэлдэй болж, тэр хоё Ууганааг жижүүртээ явсан шөнө болгон эр эмийн жаргалыг ханаж цадахаа мэдэхгүй эдэлдэг байсан билээ. Сүүл сүүлдээ Ерөө, хүүхэн хүний шинжийг бүрнээ олж, шөнийн цэнгэлд ч дуртай болжээ. Энэхүү эгэл даруухан хөөрхөн амьтан Батбаяртай л шөнөд тэврэлдэн цэнгэж байвал түүнээс илүү жаргал байхгүй мэд аашлах болжээ.

Гэхдээ хүн л юм болсон хойно гэрт нь суучихаад өөрийг нь эзгүйчилж, эр нөхөртэй нь үүлэн борооны явдлаар цэнгэдэг болсондоо Ууганаагаас баахан зовдог, хажууд бүрэгшин ичдэг байсан нь үнэн юм. Харин түүний эзгүйд бол Батбаяртай залуу эхнэр нөхрийн харьцаагаар харьцаж, ичих зовохыг умартан, ид жаргал эдлэж байхдаа гиншин ёолж, дурлал тачаалдаа шатан хариу үнсч, Батбаярын хий гэсэн хөдөлгөөн бүхнийг хийж чаддаг байлаа. Тэр бүхний гор гарах нь тэр. Батбаяр түүнийг ийм түргэн хүүхэд олчихно чинээ санасангүй явлаа. Гэнэтийн цочир энэ явдал Батбаярыг цочоов. Хамгийн аймаар нь эхнэр нь Ерөөгийн жирэмсэн болсныг түрүүлж мэдсэн явдал байлаа. Хэрэв Батбаяр түүнээс өмнө мэдсэн бол....? Нэг арга бодох л байсан болов уу.

Гэтэл үр хүүхэд гэдэг Батбаярын гол хүсэл мөрөөдөл нь. Ямагт зүрх хөндүүрлүүлсэн эмзэг асуудал нь мөн билээ. Одоо тэр яах ёстой вэ? Өөрийн авааль гэргийгээс хүсээд хүсээд бүтсэнгүй. Нууц амраг Чимгээ нь түүнээс хүүхэд олсон авч, хэл амнаас айгаад бушуухан устгажээ. Санаанд ч үгүй байтал, зүгээр нэг хөнжлийн жаргал эдлэнэ гэж авч ирсэн оюутан жаахан охин түүнээс хүүхэд олчихсон байдаг. Одоо түүнийг нь зулбуулах гэж үү? Батбаярын удмыг залгах үр хүүхдийн эцсийн найдвар энэ ч байж болох. Ууганаадаа үнэнээ хэлээд Ерөөг төрүүлэх талаар санаа тавих уу?

Яахын аргагүй ацан шалаанд оржээ. Ууганаа Ерөөг дагуулан багшдаа очиж үзүүлээд, жирэмсэн болоод хоёр сар гаруй болсон байна гэж хэлж иржээ. Ийм үед нь үр хөндөж болдоггүй юм санж.

-Би өөртэй нь их л дотносон ярьж үзлээ. Хүүхэд хэнээс олсноо мэдэхгүй гээд байна. Хувиараа аборт хийдэг хүмүүс хүүхдийг гурван сартайд нь ч үе мөчөөр нь салгаж байгаад авчихдаг юм байна. Ерөө өөрөө дургүй байх шиг... Эсвэл бага залуу юм, яах ухаанаа олохгүй байгаа ч юм билүү. Миний бодлоор тэр хүүхдээ тээж гаргасан нь дээр байх. Чи бид хоёр л маш их анхаарах хэрэгтэй дээ. Бидний анхаарал халамжаар хүүхэд нь эрүүл саруул гараад ирвэл буян л болох шүү дээ. Тийм үү? гэж эхнэр нь асуужээ.

-За яахав чинийхээр болог. Энэ хүүхдийг анхнаасаа бид л татаж авч өдий хүргэсэн юм чинь

биднээс өөр ямар дотнын хүн байх билээ. Бид л халамжилж анхаарахаас... Харин Ууганаа минь, Ерөөг жирэмсэн болсныг хэн хүнд яриад байж хэрэггүй. Залуу бага юм, ичиж зовно шүү дээ. Хамгийнхаа дотно үерхдэг хүүхэнд, жишээ нь Чимгээд ч одоохондоо яриад хэрэггүй биз дээ. Манай Чимгээ ам задгай, дэндүү сэргэлэн хүн. Ерөөг өөрийг нь ч амар заяа үзүүлэхгүй элдэв юм асуугаад байж мэднэ... гэж Батбаяр хаширласан утгаар эхнэртээ хэлэв.

-Өө тэгэлгүй яахав. Чи намайг ямар эс мэдэх биш. Би амаа хамхиад явж чадна аа.

Дараачийн өдөр Ууганааг ажилдаа явмагц Батбаяр Ерөөгийн өрөөнд шуртхийн оржээ. Ерөө түүнээс зовсон мэт доош харав.

-Юу болох нь энэ вэ? Чи надад эртхэн хэлж болсонгүй юу? хэмээн Батбаяр бүсгүйг тэврэн үнсэж аядуухан асуужээ.

Би мэдэхгүй юм чинь. Нөгөө сарын юм ирэхгүй удаад байхлаар тантай унтсан болохоор тэгдэг юм байлгүй л гэж бодож байсан. Тэгсэн чинь хоолны үнэр авч чадахаа байгаад... Ууганаа эгч мэдэж, намайг хүүхэдтэй болжээ гэж хэлээд... Би яах юм бэ?

Гэнэхэн цайлган жаахан амраг минь дээ хэмээн Батбаяр өрөвдөн бодож сэтгэлдээ хайрлажээ. Гэтэл дараагийн нэг өдөр хоюулаа сууж байгаад Ерөө:

-Та үрийн буянгүй гээд л үглэдэг. Удам залгах, духыг нь үнэрлэх үр Ууганаа эгчээс насан туршдаа хараад бүтсэнгүй л гэдэг... Би тарын үртэй болгоод өгье. Түүний тулд бие сэтгэлээ тан шиг буянтай хүний төлөө зориулан хамаг амьдралаа гарздахаас айх юм алга. Та бол миний бурхан шүү дээ хэмээн маш зоримог хатуу хэлжээ. Ийм юм бодож явдаг хүн байхуу даа?

Ерөөгийн жаахан биенээс гарамгүй ухаан гарч, тэрвээр Батбаярыг өөрт нь гай тарьсан нүгэлтэн гэх нь битгий хэл, харин ч түүнд өчүүхэн тус хүргэснийх нь хариуд хамаг бие сэтгэлээ гагцхүү Батбаярыг үр хүүхэдтэй болгохын тулд золигт гаргахад бэлэн гэсэн үг хэлсэн нь үнэн сэтгэлийн угаас бишрэн хайрлахад хүргэжээ. Батбаяр хэлэх үгээ олохгүй дэмий л жаахан бүсгүйг үнсэн таалж бөлгөө. Сэтгэл доторхи хямрал эцсийн цэгтээ тулав.

Өөрийн нь үр төлийг гаргах гэж эрмэг зоримог зан гарган зүтгэсээр өдий хүрээд, одоо хамаг яс үсээ үгтээн зовж буй жаахан амраг юугаа эсэн мэнд хоёр яс салаасай хэмээн Батбаяр дотроо залбирч, бурхан тэнгэрийг шүтдэггүй боловч маанийн хэдэн үсгийг сэм шивнэн зогслоо. Чингэтэл...

-Ерөө төрлөө. Гурван кило таван зуун грамм хүү төрүүллээ. Эхийн бие сайн байна. Хүлээж байгаа ар гэрийн хүмүүст нь баяр хүргэе.

-Юу? Нээрээ юу? Үнэхээр төрчихлөө гэж үү? Еэ ашгүй дээ хэмээн Батбаярыг бодож ч амжаагүй байхад:

-Бурхан минь яамай даа, яамай. Муу охин минь төрчихөж хэмээн Ууганжаргал дуу алдав.

-За баяр хүргэе. Энэ чинь танайд ирж байгаа шинэ хүн шүү дээ хэмээн Чимгээ хэлж яагаад ч юм сэтгэл догдолсон шинжтэй эхлээд Батбаярыг, дараа нь Ууганааг тэврэн үнсч орхилоо.

Батбаярын хоолой дээр нэг юм зангирч, эр хүний ховор нулимсаа өөрөө ч мэдэлгүй гаргах шахсан авч, хүчээр аньсгаа тас хавчин, бүсгүйчүүдэд мэдэгдэлгүйгээр дотогшоо нэг охилон биеэ барив.

-Өвгөн минь баяр хүргэе! Яасан сайхан аз хийморь вэ? хэмээн сэтгэл хөдөлсөн Ууганаа хэнээс ч үл цэрвэн нөхрийнхөө хацрыг үнсэв.

# ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Хорвоо дэлхий дээр анх ирсэндээ хилэгнэх мэт бяцхан улаан хүн тийчлэн сарвалзаж, эр хонгор дуу хадаан өөрийгөө зарлав. Хамаг яс үс нь салан алдатлаа өвдсөн Ерөө үрийнхээ энэ бахирааг сонсч, тамир муутайхан инээмсэглэх аядлаа. Залуу эхийн хүйнээс холбоотой тийчлэн бархирч байгаа жаахан улаан үрийг эмч сувилагч нар номын ёсоор эхээс салгах гэж үзэж тарж байлаа.

-За энэ дээ, охин минь чи сайхан хүүтэй болж! хэмээн үрийг нь эх баригч эмч боож аваад ув улаахан амьтныг Ерөөд харуулаад ариутгал ёслол хийхээр авч одлоо.

-Аав нь мэдсэн болов уу? Энэ хүмүүс түүнд хэлдэг уум уу? Тэр хүн доод хүлээх танхимд миний тухай сураг сонсох гээд тэсч ядан зогсоо юу үгүй юу?

Ерөө тамирдсан хэрнээ ингэж л бодож амжлаа. Тэр хэлсэндээ хүрчээ. Ачтай буянтай сайн хүний хүслийг биелүүлж үрийг нь төрүүллээ. Ингээсэй ч гэж тэрвээр хэдэн сар сэтгэл шаналсан... Одоо сэтгэл амрав... Гэвч Ерөө цаашдаа яаж амьдрах, дөнгөж хорвоод мэндэлсэн нялх үрээ цаашид яах, хувь заяаны эргүүлэг жаахан бүсгүйг хааш нь авч одохыг одоохондоо мэдэхгүй л байлаа.

Үрийг нь төрүүлсэн болохоор Батбаяр шиг сайн хүн түүнийг хөсөр хаяхгүй гэдгийг л Ерөө сайн мэдэж байв. Тэр амаржих газраас гарна. Мэдээж эргээд өнөөх л өрөөндөө очно. Хүүхдээ өсгөх гэж хичээнэ. Гэрийн эзэд түүнд ямагт сайн сэтгэлээр хандаж ирсэн шигээ байдгаараа тусална. Ууганаа эгч Ерөөд эгч шиг нь хандан, өөрөө төрсөн чинээ санаж халамж анхаарал бүхнээ гаргана. Энэ тал дээр зовох юм даан чиг үгүй.

Гэвч Ерөө цаашдаа, итгэл алдан эр нөхөртэй нь хөхцөж, хүүхдийг нь гаргачихаад, юу ч болоогүй юм шиг байгаад байж болох уу даа? Олон жил ханилсан эхнэртэй нь нэгэн гэрт, хоёр дахь бөгөөд нууц эхнэр нь болж хамт амьдрах аргагүй гэдгээ залуу бүсгүй сайн ойлгож байлаа.

Хувь заяа хэдий хатуу байсан ч гэсэн Ерөө тэднийхээс явж л таарах вий. Бүх үнэнээ Ууганаа эгчид хэлээд сайн хүн, сайхан эр Батбаяртай сууя гэхэд тэр хүн юу гэх сэн бол? Өөрт нь үр төрүүлж өгч чадаагүй эгэл заяандаа гомдоод (хааяа нэг аяга цай ууж суугаад Ууганаа эгч "Би ч хань ижилдээ үр төрүүлж өгч чадаагүй заяа нь хаясан азгүй эм дээ. Батбаяраас өөр хүн байсан бол үрийн тэнгэргүй хуурай, сувай сударган намайг аль хэзээний хөөгөөд явуулах байсан биз. Тэглээ гэхэд би түүнд гомдох эрхгүй юм" хэмээн ярьдаг байжээ) Ерөөг хүүхэдтэй нь хамт орхин одох уу даа?

Үгүй үгүй, Ерөө чингэхийг үл хүснэ. Ууганжаргал эгч бол Батбаяртай л адил, хүний төлөө эхийн сэтгэл гаргасан хүний хайлан юм. Тийм хүнийг гомдоовол заяанд муу болох вий.

Хэд хоноход Ерөөгийн залуу бие амархнаа тэнхрэв. Тасагт шилжсэн түүн дээр өдөрт дор хаяад гэрээс нь 3н эргэлт ирнэ. Гол төлөв Ууганаа эгч нь л ирсэн байна. Заримдаа Батбаяр ирсэн гэж хэлүүлнэ.

"Бие нь тэнхэрч байна уу миний охин? Хүү нь том болж байна уу? Биеэ л сайн бодож шөл ус сайн ууж түргэн тэнхрэхийг бодоорой. Бид чамайгаа гайгүй амархан амаржиж, хүү төрүүлсэнд баярлаж ханахгүй байгаа шүү. Удахгүй шинэ хүнээ тэврээд гараад ирэхийг чинь тэсэн ядан хүлээж байна. Хүүд хэрэгтэй бүхнийг Японд захиулаад авчирсан байгаа. Гол нь чи минь л түргэн тэнхэрч босвол болох нь тэр" гэж Ууганаа зурвасандаа бичсэнийг тасагт нь зэргэлдээ орон дээр хэвтсэн үеийн бүсгүй уншаад:

-Энэ чиний юу вэ хэмээн асуужээ.

-Энэ миний байдаг айлын эгч.. гэхэд

-Үгүй бас харь элгийн мөртлөө ийм сэтгэл гаргадаг хүмүүс байдаг аа? гэж гайхаж билээ.

-Манайхан намайг оюутны байрны үнэ төлж чадахгүй, гудамжинд гарах шахаж явахад минь татаж авсан юм. Төрсөн тэлсэн садангийн ямар ч холбоогүй мөртлөө нэг өрөөндөө үнэгүй суулган, хооллож хувцаслан сургуульд минь явуулдаг байсан ачийг мартахын аргагүй. Одоо гэтэл хар л даа. Намайг хүү төрүүлэв гэж баярлацгааж, гарахыг минь тэсч ядан хүлээж байна. Ийм л сайн хүмүүс дээ хэмээн Ерөө үнэн голоосоо баярлан хэлэхдээ хоолой нь зангирчээ.

-Чи ч азтай бүсгүй юм аа. Гэтэл би гэдэг хүн төрөх гэж хаа байсан Сөүлээс ирчихээд ар гэрээс эргэлт тойролт ч үгүй шахам хэвтэж байдаг. Архинаас өөрийг мэдэхгүй манай хар ер нь намайг өөрт нь үр төрүүлж өглөө гэж мэддэг ч юм уу, үгүй ч юм уу. Хар хүнээ хадмуудтайгаа тэжээх гэж л би анх "Заг" компанийн шугамаар Сөүл явсан. Хэдэн сар, өдөрт арван хоёр цаг ажиллаж нойр хоолоо хасан, үйлээ үзэн, үсээн зулгаан байж олсон бүхнээ наашаа л явуулдаг байсан. Гэтэл одоо ямар байна хар даа...?

Ердийн нэг эрээн даавуугаар толгойгоо боочихоод тэр бүсгүй уйлан байж хамаг үнэнээ Ерөөд ярьдаг байлаа. Олонтаа ирдэг эргэлтийн сайхан шөл, хоол, дээр нь өчнөөн гадаад печень чихрийг идэж барахгүй тул Ерөө тэр хүүхэнтэй л хуваана. Чингэлээ гэж бүсгүй Ерөөд үнэн голоосоо баярлана.

Тодорхой цагаар авчрах хүүгээ хөхүүлэн, духыг нь үнэрлэн суухдаа Ерөөгийн байгалиас заяасан эх хүний сэтгэл уярч, өлгийдөө тарвалзах тэр жаахан амьтан Батбаяртай юутай адилхан болохыг хараад учирч уулзсан гэгээн өдрүүдээ санана.

Арван жилд л байхдаа өмсч байсан хуучин нимгэн хөх пальтотой, сурагч шиг л царай зүстэй ядуу даржин оюутан, амьдрахын аргагүй болоод гудамжинд мөнгө олох гэж гарснаа тэр зүрх хөндүүлэн санадаг билээ. Яахан тэр тухай эс санах... Байрны комендант гэж дандаа архи үнэртүүлсэн явдаг гучаад насны нэг цөлх эр түүнээс байрны төлбөр нэхээд, өгчих мөнгө байхгүй гэхэд нь:

-Хэрвээ залуу улсын ёсоор тохирох юм бол хоюулаа төлбөрөө хаагаад байж болно шүү дээ гэж нэгэнтээ хэлжээ. Тэр нь чухам юу гэсэн үг болохыг сайн ухааж ойлгохгүй Ерөөг гайхан харж байхад комендант түүний гарыг атгаж, энгэр цээжийг нь илээд авч билээ. Тэгэхэд л сая зарим эмэгтэй оюутныг өрөөндөө аваачиж эдлээд төлбөрөөс чөлөөлсөн гэдэг цуу яриа үнэн болохыг мэдэж, ямар ч байсан тэр согтуугийн арганд орохгүй хэмээн зугатаажээ. Тэглээ гээд

комендант бүр өширхөв. Арга ядахдаа л Ерөө тэр намрын орой модот цэцэрлэгт гүйж очсон.

Дүүрсэн хэрэг, согтуугийн угвар, өмхий самхай ханхалсан эрээс холдож байвал өөр хэн ч тааралдсан биеэ өгөхөд бэлэн байсан. Ичиж зовсон түүнийг зориг зүрх муутайхан цэцэрлэгт очиход анхны тааралдсан хүн нь Батбаяр байлаа. Ядуу оюутан бүсгүйг тэнгэр ивээж, бурхан ивээсэн нь тэр. Анхны уулзалтаараа лд халамцуу Батбаяр түүнийг сайхан хооллож, гэртээ аваачих тухай сайхан үг хэлсэн... Тэгэхдээ Ерөө бүхнээ түүнд зориулах ёстой шүү гэдгийг ч Батбаяр шууд хэлсэн билээ. Тэр үгний цаад учрыг ойлгоод дүүрчээ дүүрч, байртай болж байвал энэ сайхан хүний дор хэвтэх ч өнгөрсөн хэрэг гэж л санажээ. Гэтэл Батбаяр бол үнэхээр сайн хүн, сайхан ч эр бөгөөд оюутан жаахан бүсгүйг эм хүн болгоод салж хагацахын аргагүй янагийн эрдэмд сургасан. Эхний шөнө хэцүү байсан боловч Ууганааг ажил албандаа хонуутаар явчихсан үеэр түүнтэй үргэлжид ноололдсоор байгаад Ерөө хайр сэтгэлтэй болж, хорвоод түүнээс сайхан хүнгүй гэж бат итгэсэн. Үнэндээ Батбаяр бүсгүй хүнийг жаргааж чаддаг эр байлаа. Залуу насны ухаангүй дурлалыг нь тэр хүн сэдэж, шөнийн цэнгээд чухам ямар байрлалтай, яаж байвал хүсэл нь бадрахыг зааж өгсөнөөс хойш Ерөө түүнд улам шунан дурлах болсон. Үеийн охидын ярьснаас бодоход нэгд бол анхныхаа учирсан хүнд бүсгүй амьтан ямагт сайн болдог, нөгөөд гэвэл эрчүүдийн аашлах аяглах нь өөр өөр бөгөөд жинхэнэ эр хүний эрхтэн том, эм амьтныг эдлэх эрдэм нь онхи ондоо байдаг гэсэнтэй Батбаярын юм бүхэн таарч байлаа. Ерөө жаргал эдлэхдээ залуу цагийн хучл тачаалаа үл дийлэн, биеэ Батбаярт ыүрнээр өгч сурчээ. Өөринхөө амьдралыг Батбаяргүйгээр ер төсөөлж эс чадах тийм болтлоо түүнд дасчээ. Эм хүнийг өөртөө дасгах далдын ид шид Батбаярт байгаа бололтой.

Тэр хичээлдээ осолтгүй явсаар байх авч тархи толгойноос Батбаяр хэзээ ч салахгүй, ямагт түүнтэй 2 өнжөөд учирдаг сайхан учралыг тэсч ядан хүлээдэг байв.

Чингэж түүнтэй ноололдсон өдөр Ерөө хичээлдээ явдаггүй, унтаж амардаг байлаа. Гагцхүү Ууганаагаас л зовно. Тэр бүсгүйг гомдоож буйдаа жаал бүсгүйсэтгэл нь нэн эмзэглэнэ. Гэтэл Ерөө хөл хүндтэй болжээ. Анхандаа үнэндээ мэдсэнгүй. Сарын тэмдэг ирэхгүй удахад эр хүнтэй ойр ойрхон хавьтахлаар тэгдэг юм байлгүй гэж бодсон. Сүүлдээ биед өөрчлөлт орж, Ерөө бүсгүй хүнийхээ совингоор хүүхэд олсноо мэдсэн. Тэр хүүхдийг аборт хийлгээд алга болгож болох байсан боловч Батбаярт дэндүү хайртай болсон тул чингэх зориг хүрээгүй. Тэгээд ч үнэндээ Батбаяр үрийн мөрөөдөл болсон амьтан гэдгийг мэдэж байлаа. Өөрт нь өчнөөн буян хийсэн, анхны хайрыг нь оволзуулан бадраасан хүнээ баярлуулахын тулд Ерөө залуу бие, сэтгэлээ хайрлахгүй гэж шийдсэн... Түүний хүссэнээр үр нь эрүүл саруул төржээ. Ийм сайхан мантайсан цагаан, яг л Батбаяртай усны дусал шиг адилхан хүү төрөөсэй гэж Ерөө залуу эхийн хувьд мөрөөдсөн билээ.

- Хүүе үр минь чи хэнтэй адил вэ гэдгээ мэдэж байна уу? Аавыг чинь Батбаяр гэдэг юм шүү дээ. Улсын нэртэй сэтгүүлч, том хэвлэлийн газрын эзэн хүн шүү хэмээн хүүгээ хөхүүлэн тэвэрч өхөөрдөн байхдаа Ерөө шивнэдэг байлаа.

- За Ерөө, сайн уу? Бие төлжиж тэнхэрч байна уу? Хүү нь том болж байна уу?

Үүдээр цагаан халаадтай эмэгтэй орж ирэхдээ чингэж чангаар асуусан нь Чимгээ байлаа. Төрөх тасагт гадны хүн оруулдаггүй боловч чиг Чимгээ яаж ийж аргалж байгаад зөвшөөрөл олж ороод иржээ. Тэрээр савтай юм барьсан тэрвээр Ерөөгийн хажууд ирж үнсээд,

- Алив хүүг чинь харая гээд гар дээрээс нь булаах шахам авав. Ерөө яагаад ч юм энэ хүүхнээс харамламаар санагджээ.

Чимгээд өлгий дотроо тийчлэн мурчигнаж, хөхөө ид хөхөж байхад нь дур мэдэн болиулсанд уурласан мэт улаан амаараа төөт эрэн байдгаараа бархирч буй бяцхан хүү Батбаярын багасгасан зураг шиг л харагдана. Хамар, ам, дух ер бүх юм нь Батбаярын үр биш гэж хүн хэлүүзэй гэсэн шиг дуурайсан байхад Чимгээ сэмхэн санаа алдав.

“тэгнээ тэр. Би мэдээд байсан юм. Хуучны үгэнд тэмээ хариулсан хүн буурныхаа занг андахгүй гэж дэмий ч нэг хэлээгү байх шүү” хэмээн хүүхдийг эхэд нь буцааж өгөхдөө Чимгээ бодлоо.

- За тэгээд бие тэнхэрч байна уу? Одоо ч амаржих газар удаадаггүй гээ биз дээ? Эгч нь гурвын гурван баньд төрүүлсэн хүн болохоор зовлонг нь сайн мэднээ... гэж Чимгээ дотор бодлоо нуун инээмсэглэж хэлээд халуун савтай хоол, цай гаргалаа.

Энэ авгай Батбаярынхны сайн найз, Ууганжаргалын үерхдэг хүүхэн гэдгийг Ерөө сайн мэднэ. Уулзахаараа хэл ам сугалчих шахдаг болхоор Ерөө түүнээс баахан айдаг билээ. Харин өглөгч зантай тул Чимгээ ирэх тоолондоо түүнд хэдэн чихэр юм уу, мянгатын дэвсгэрт өгчихөөд явна. Харин Чимгээ Батбаярыг эгэл бус нүдээр хайрлан хардагийг Ерөө ажиглаж мэджээ. Тэр 2 нүдээрээ ярилцаад байна уу даа гэж Ерөө бодсон. Тэдний хооронд ямар нэгэн нууц байна гэж залуу бүсгүй тааварласан боловч онц их сонирхож үзээгүй. Хүмүүсийн явдал түүнд ямар хамаатай билээ дээ.

Харин сая орж ирээд хүүхдийг нь гараас булаах шахам авч удаан ажиглах үед царай нь хувирч, сэмээрхэн санаа алдахыг нь ажаад орхив. Чимгээ түүнийг эргэх гэж ирсэн биш, харин хүүхдийг нь л үзэх гэж иржээ гэдгийг Ерөө гадарлажээ. Яагаад ингэдэг билээ? Тэгэхийн хэрэг юу байгаа?

-Охин минь хөх нь сүүтэй юу? Одоогийн охид хөх дэлэн ч гэж юмгүй, байгаа жаахан нь хүүхэд гаргах үед сүүгүй хэцүү л байх шиг санагддаг юм. Чи ч хаа очиж хөх томтой юмсанж.

Чимгээ түүний аяганы ширээн дээр баахан чихэр, жимс гарган дээр нь арван мянгатын дэвсгэрт тавиад

-Эгч нь чамдчангаамал авчирсан. Тийм нэг болсон шар будаа байдаг шүү дээ. Идэж үзсэн л биз дээ? Хөх сүү оруулдаг юм. Цайндаа дэвгээж байгаад идээрэй. Чамайг төрөхөд Батбаяр, Ууганаа бид 3 үүдэнд хүлээлгийн өрөөнд сандраад ч зогсч байлаа шүү дээ. Бид чинь амь нэгтэй сайн найзууд...

Хэний маань ч жаргал зовлон бидний л бүгдээрэнгийх байх ёстой. Чамайг ер тэднийд суудаг хөдөөний хүүхэд оюутан гэж бодоогүй. Батбаярын гэрийн ам бүлийн нэг л гэж санадаг шүү. За охин минь түргэн тэнхрээд гялалзаад гараад ирээрэй. Чамайгаа бид чинь хүүтэй чинь өөрийн хүүхэд шиг л бөөцийлнэ шүү хэмээн үнсээд Чимгээ гараад явчихав.

Ерөө сая нэг уужим амьсгаа авлаа. Чимгээгийн дэргэд тэр биеэ бариад бушуухан гараасай

гэж боджээ.

Тэр өдрийн орой тасагтаа хоёулханаа үе тэнгийн хоёр бүсгүй зовлон жаргалаа ярилцан суухын завсар мөнөөхөн хажуугийн жаал хүүхэн:

-Чи Солонгос оронд яваач! Ажил нь хүнд боловч цаг агаар дулаахан, тэгээд хөгжилтэй орон болхоор тэнд амьдрахад сайхан л байдаг юм шүү. Би хүүхдээ угжаар хооллохтой болмогц буцаад л явна.

Чамайг очих юм бол найз нь боломжийн цалинтай ажилд оруулж чадна шүү. Хараар очиж айж түгшиж явсанаас уг нь “Заг” мэт албан ёсны гэрээтэй газрын шугамаар явбал амар даа. Хэрэв чамайг очвол хоёулаа тэнд сайхан байх сан... гэжээ.

Энэ үг Ерөөгийн чихний хажуугаар өнгөрсөнгүй. Учир нь тэрвээр сургуульдаа нэг л сүжиг муутай болсон байлаа. Бие давхар болсноос янагш Ерөө бараг хичээлдээ суусангүй. Ерөөсөө ч сургалтын чанар тааруухан, хуулийн хувийн дээд сургуулиуд дотроо хамгийн чанаргүйд тооцогдох болсон “Хууль Цааз”-аас хүүхдүүд сэм гарсаар байлаа. Хуулийн олон сургууль байх тул төгссөн хүмүүст ажил олдохгүй байна гэлцэнэ. Хайрын халуунд шатаж явах цагаасаа Ерөө сургууль хичээлдээ явахгүй болж, орон гэрийн мухар сахин Батбаярыгаа хүлээх болсон тул эрдэм номын ажлаасаа хөндийрсөн гэвэл болох юм. Одоо гэтэл хүүхэдтэй хүн бүр ч сургуулийн тухай бодолтгүй болов. Энэхүү бодол нь цаашдаа Ууганаатай нэг гэрт амьдрах аргагүй гэсэн урдахи өдрүүдийн бодолтой нийлж ирэхэд, үеийн бүсгүйн хэлсэн үзэсгэлэнт Солонгос орны тухай үг нэгийг сануулах шиг болжээ.

Гэвч цаг эрт байлаа. Тэр нялх хүүхдээ яах билээ? Юу ч гэсэн хэдэн сар, магадгүй бүр жил болтол хөхнөөс нь гаргахгүй өсгөөд бор хоолонд орсон хойно нь хаа нэгтээ орхиод явж болох... Харин түүнд бол Батбаяр хүсвэл Солонгосын виз дорхон нь гаргаад л өгнө дөө. Тэр эс чадлаа гэхэд Чимгээ эгч гэж гал амьтан байна. Тэр тухайд Ерөө зовохгүй байж болох байлгүй.

Амьдралынхаа эгзэгтэй бүхнийг нэг тийш болгоод нээрээ урд зүг харь оронд явж үзэж болох л юм. Насны залууд газар үзэж, ажилд хагуужин аав, ээжийгээ ядуу зүдүү амьдралаас нь хөнгөлхийг бодвол аштай юу. Өнөөг хүртэл Ерөө аав ээждээ тус болж чадахгүй л байгаа шүү.

Аажуу уужуу байж байгаад Батбаярт энэ саналаа хэлэх нь онох биз. Гэтэл хүүхдийн нь эцэг тэр хүн юу гэх юм бол доо? Түүний үгийг дагахгүй байж болохгүй гэж Ерөө одож байлаа.

Эмч үзээд хүүхдийн хүй нэгэнт цөглөж байгаа болохоор ирэх долоо хоногоос гарах нь зүйтэй гэж хэлжээ. Гэртээ очих сайхан боловч Ууганаа эгч хүүг нь үзээд юу гэх бол хэмээн сэтгэл зовно. Угаасаа тайван дөлгөөхөн хүн болов чиг ямар ч эмэгтэй байсан сая гарсан Ерөөгийн хүү нөхөртэй нь хачин адилхан байхад юм санахгүй өнгөрөх үү дээ гэж бодохоос байж ядна. Хэрэв өөр таньдаг айлтайсан бол Ерөө тэднийд гараад л очих сон... Даанч тийм танил үгүй байлаа. Одоо яах билээ?

Амаржих газарт гандангаа лам ирсэн дуулдлаа. Хүүхнүүд сая төрсөн үрийнхээ заяа буяныг асуун зарим нь бүр нэр гуйж байгаа дуулдав. Үеийн бүсгүй:



- Хоёулаа очъё л доо гэж гуйв. Ерөө шийдэж чадсангүй. Харин өнөөх хүүхэн хүүхдээ авч лам дээр очоод их л баяртай ирэв.

- Ерөө чи оч оч! Нас намбатай сайхан өвөө байна. Миний хүүгийн заяа төөргийг хэлж өглөө. Чамайг нэрээр чинь дуудан асууж байна. Лав бурханы шавь гэдэг нь байх. Хүүгээ тэврээд лам өвөө дээр яваад оч хэмээн шавдуулав.

Ерөө гайхав. Яахлаараа тэр өвөө миний нэрийг мэддэг билээ? Хэн нэгэн нь намайг зааж өгөв үү? Аль эсвэл манай өрөөний бүсгүй миний нэрийг хэлэв үү? Оньсого таавар шиг эл явдалд баахан гайхасхийгээд Ерөө юу ч гэсэн тэр лам дээр очихоор хүүгээ тэврэн гарлаа.

Амаржих газрын нэгэн өрөөнд нүдэнд дулаахан өвгөн лам сууж байлаа. Хүүхнүүд бүгд очоод дууссан юм уу, өөр хүн байсангүй.

- Охин минь наасшаа суу. Чамайг Ерөө гэдэг үү? Хэмээн лам өвөө асуужээ.

- Тиймээ... гэхдээ Ерөө, хараад л хүний нэрийг мэддэг ид шидтэй хүн өмнөө сууж байна хэмээн бишрэл төржээ.

Ерөөг өмнө суусны дараа хүүг нь адислан, өөрин нь духанд гараа хүргээд амандаа ямар нэгэн ном уншиж эрхээ татаж үзсэнээ лам өвөө,

- Чиний хүү их амны хишигтэй хүүхэд байна. Буянтай аавтай юмсанж... Охин минь алс нь хүүгээ тэр буянтай эцгийг бараадуулбал чиний ч, хүүгий чинь ч хувь заяаны төөрөг сайханаар эргэх юм байна даа. Нэрийг нь хэн гэсэн билээ? гэв.

- Одоохондоо нэр өгөөгүй байгаа л даа...

- Охин минь өөрөө л мэд. Би хүүхдэд нэр хайрладаг л юм...

Ерөө хүүгийн нэрний тухай эцгээс нь сэм асууж байж болсон нь дээр гэж бодоод

- за яах вэ өвөө... аав нь мэдэх байлгүй гэгчхэв.

Ерөө тэндээс гарахдаа лам өвөөгийн хэлсэн “Алс нь хүүгээ тэр буянтай эцгийг нь бараадуулбал ...” гэсэн үгийг л амандаа шивнэсээр тасагтаа иржээ. Өвө ламын хэлсэн үг, нэрийг асуухгүйгээр мэдэж байсан нь, хүүг буянтай хүний үр байна гэж онож айлдсан нь залуу эхийн бишрэлийг өөрийн эрхгүй төрүүлжээ.

Ерөө бүх л оройжингоо бодолд автжээ. Аав, ээж нь шүтлэгтэй билээ. Ялангуяа ээж нь вьм л бол хурал номын газар очиж хэдэн хүүхдийнхээ тухай асууж, гэр орныхондоо зориулан хийморийн сан тавиулдаг. Ерөөг сургуульд явахад хурлын газар дагуулж очоод ном уншин дуустал хамт байжээ.

Өвөө ламын хэлсэн үг зарим талаар ирээдүйнхээ хувь заяаны талаар түүний бодсонтой нийлж байх шиг санагдана. Нээрээ тэр буянтай сайн хүн Батбаярын төлөө л Ерөө биеэ зориулсан болохоор энэ хүүхдийг эцгээс нь хол хөндий байлгана гэж санахын аргагүй.

Чингэж байтал Ерөөд хол газар явахсан гэдэг бодол саянаас төрсөн нь бий. Хэрэв санаснаар ажил үйлс бүтэх юм гэхэд хүүгээ эцгийг нь бараадуулж л орхихоос өөр замгүй шиг...

Гэнэн цайлган Ерөөгийн ухаанд хэн нэгэн хүн залуу эхийн сэтгэлийг жолоодохын тулд буюу тодруулбал үрийг нь эцгийн талд эргэлт буцалтгүйгээр хандуулах арга мэх хийж танил ламаа зориут амаржих газар руу явуулсан гэх хар сэжиг буусангүй билээ.

Ерөө, лам өвөөгийн үгэнд орохоос аргагүй гэж л бодож байлаа.

- За лам өвөө чамд юу гэж хэлэв? Хүүгийн чинь заяа төөргийг үзэв үү? гэж Сөүлийн хүүхэн асуужээ.

- Бучнтай эцэгтэй, амны хишигтэй хүү байна л гэж байна... гэсхийгээд Ерөө цааш олон юм ярьсангүй.

Нэг л мэдэхэд эмнэлэгээс гарах болсон байлаа. Тэр өдрийн өглөөнөөс хойш Ерөө хэт догдлолд автан, хэн нэгнээс айж ичээд байж ядав. Хамгийн хэцүү нь Ууганжаргал эгчийн царайг харах л байлаа. Тэр сайхан сэтгэлт эгч хүүг нь үзээд царай нь хувьсхийвэл тэгээд л дүүрэх нь тэр. Хэрэв тэгвэл Ерөө яах билээ. Хүүгээ тэврээд гараад гүйх үү? Амьдралоо үзэж туулаагүй тэр аймаар мөчийг хэрхэн туулахаа Ерөө мэдэхгүй байв.

Цаг болжээ. Гаднаас өлгий, хүүхдийн бяцхан цамц, өмд даавуу шаавуу, ер нярайд хэрэгтэй бүхнийг сувилагч оруулж ирэв.

- Танайхаас хоёр эгч, нэг сайхан ах иржээ. Цэцэг барьчихсан чамайг угтахаар хүлээж байна. Алив ээ би хүүг чинь өлгийдье. Чи хувцасаа өмс... гэж сувилагч хэлэв.

- За найзаа гараад хоёулаа холбоотой байна шүү. Би чамруу дандаа утасдаж байнаа. Манайх толгойтод болохоор чи өвлийн хүйтэд яаж очиж чадахав. Харин урин дулаан болохоор хоёул заавал уулзана шүү хэмээн сөүлийн бүсгүй дотносов. Түүний үгийг ч сайтар сонсох сөхөө Ерөөд байсангүй. Ууганааг бодохоос л амандаа хэлэх дуртай “Яанаа...” гэсэн үгээ сэм давтаж байлаа. Чингэтэл Ууганаа нь ороод ирэв.

- За миний охин сайн уу? хэмээн тэр энхрий дотноор Ерөөг үнсэж,

- Хүлээж ядаад ороод ирлээ. Ашгүй Чимгээ эмчтэй ярьж зөвшйрүүлэн энэ халаадыг авч өгөөд... Чи минь жаахан тураа юу даа. Царай зүс чинь сайхан байна. Яамай даа, яамай... гэснээ сувилагч охин өлгийтэй нь тэврэн зогсоо хүүг сая харж,

- Хүүе шинэ хүн маань... Аль вэ чамайгаа эгч нь тэврээ гээд авахад Ерөөгийн зүрх зогсчих шиг болов.

- Ээ хөөрхий гэж... эвий минь... нялх амьтан минь... хэмээн Ууганжаргал өөрийн үрээ л энхрийлэх мэт хүүг нь үнсэж

- Нялхын нь үнэр ямар сайхан ариухан юм бэ? Ингээд манайх бүл нэмэх нь энэ дээ. Ерөөдөө баярлалаа хэмээн нулимсаа арчив.

Ерөөгийн түрүүхний айж байсан ямар нэгэн хардлага сэрдлэг болсонгүй. Ууганаа нялх хүүг хараад эр нөхөртэйгээ усны дусал шиг адилхан царайтайг ажигласангүй юу, хөөр баяраас өөр юу ч хэлсэнгүй.

## ТАВДУГААР БҮЛЭГ

Орон сууцны таван давхар байшингийн өмнө шив шинэхэн Мерседсе Бенц машин зогслоо. Тэрэгний хаалга онгойход Батбаяр бууж сая дөнгөж нярайлсан нялх биетэй юм хэмээн их л халамжилн түшиж Ерөөгийн гараас дэмнэн буулгав. Нөгөө талын хаалгыг сая тэрэг байрьж ирсэн чимгээ болгоомжтой нь аргагүй онгойлгоход өлгийтэй хүүхэд тэвэрсэн Ууганжаргал инээмсэглэсээр гарч ирэв. Машин дотроос гал улаан сарнай цэцэг авч Чимгээ, Ерөөд бариулахад Батбаяр түүнийг сугадан орцны зүг явлаа.

Гадаа хүйтэн боловч тэнгэр цэлмэг, өвлийн цонхигор шар наран ээсэн өдөр байлаа. Батбаяр Ерөө рүү харж энхрийлэн хайрласан харцаараа үнсэнэ. Араас нь яваа Ууганаа хүүг өхөөрдөн хайрласан үгээ хэлэн дуу алдсаар л байна. Харин Чимгээ машин тавьдаг газар тэргээ ухрааж байрлуулчихаад тэдний араас гүйх шахам ирэв.

Ерөөгийн сэтгэл тайван, жаргалтай байлаа. Өглөөнөөс хойш айж бэргэсэн сэтгэлийн хүйтэн жаврыг Ууганаа эгчийн дотно дуу, хайр энхрийлэл аль хэдийнэ үлдэн хөөжээ. Ууганаа эгч хүүхдийг нь тэврээд сувилагч охин түшихийн Ерөөг төрхийн тасгаас гарч ирэхэд Цэцэг барьсан Батбаяр туйлын баяртай үнсэн угтаж билээ. Чимгээ мөн түүнийг үнсч, баяр талархлын үг чанга дуугаар хэлж байлаа. Хүлээлгийн өрөөнд Ууганаа Батбаярт хүүг харуулахад ихэд сэтгэл догдолсон эр нөхөр нь бяцхан хүнийг уруул хүргэн үнсээд инээмсэглэжээ. Батбаярын сэтгэл хангалуун царайг Ерөө хараад уярч орхив. Бүсгүй хүн үрийг нь төрүүлээд аавд нь анх удаагаа хүүг нь харуулахад цаадахи нь сэтгэл хангалуун байхад ингэж л хөөрч догдолдог байх даа. Ерөөгийн хоолой зангирч, юу юугүй нулимс нүдийг нь бүрхээд ирэхэд тэр биеэ хүчлэн барьж дотогшоо баярын нулимсаа хийчих шиг шүлсээ залгив. Батбаяр ч, Ууганаа эгч ч, Чимгээ ч цөм баяр баярын манлайг амсах мэт туйлын баяртай байх бөгөөд тэдний харц, хэлж буй үг яриа, хандах хандлагаас Ерөө нэг л их гавьяа байгуулсан шиг олодошгүй аз жаргалыг нь олоод ирсэн шиг чингэж хүндлэн хайрлах ажээ.

Гэрт ороод ирэв. Аль хэдийнэ ширээ дүүрэн амттан, хоол зууш зэхжээ. Чимгээ, Ерөөд үйлчлэн гадуур хувцсыг тайлуулж аваад гэрийн шив шинэ баруун газрын дулаахан памбагар халааз өмсгөн, духны нингэнийг салхи цохиузай хэмээн гоёмсог алчуур толгойд нь зангидаад, ёс болгон ариун цэврийн өрөөнд гар нүүрийг арчуулсан болж ширээнд хүндэт зочны маягтай суулгав.

Эрүүл агаарт гараад хэдийнээ унтсан нялх хөвгүүнийг цаатан нарын урцанд үргэлж хөдлөж байдаг өөжгий лугаа адил гоёмсог дүүжин оронд зөөлхөн тавиад Ууганаа хамгийн түрүүн сүү болсон сайхан цай аягалан Батбаярт бариулж дараа нь Ерөөд хийж өгөв.

- За гэртээ ирсэн хүн байна. Идэж уугаарай. Аль вэ Батбаяраа өвгөн минь архиа хундагалж, шинэ хүнийхээ төлөө өргөх юм биш үү? хэмээн Ууганаа нөхрөө шавдуулав.

- За би одоохон...

Батбаяр ширээн дээр өрсөн том цартай чанасан мах, байцааны, нийслэл салат, үхрийн хэлний болон хиамны, огурцы, помидорын зууш, алаг чихэртэй таваг, “Аз жаргал ерөөе” гэсэн бичигтэй том бялуу зэргийн дунд тавиастай хэдэн шилтэйгээс эхлээд англи виски

өөрийн хундаганд, итали Чинзано хуурай дарс нөгөө гурван хүүхэнд хундагалан хол хол хийлгэв. Чингээд хүн бүхэнд хундага бариулж хэлсэн нь:

- Өнөөдөр манай гэрт аз жаргал өөрийн биеэр морилж байна. Бид бүхний сэтгэлийг нэгтгэн, хайраар дэвтээж байгаа шинэ хүн анх удаагаа орж ирлээ.

Үрийн заяа хүсэн хүлээж өчнөөн жил галаа манасан биднийг энэ бяцхан хүн хөөр баяраар баярлуулан ирэв. Нялх зүстэй, нойтон сормуустай амьтан орж үзээгүй энэ гэр өргөөнд Ерөө минь чи үртэйгээ ирж биднийгээ гийгүүлэн баярлуулав. Бид цөмөөрөө чамдаа машинд их баярлаж байна. Энэ хүүхдийн хойшдын хувь заяа бүхэн энэ гэртэй, гал голомттой холбоотой болсныг бид маш сайн ойлгож байна. Сайхан залуу ээж Ерөө чиний төлөө, бяцхан хүү, шинэ хүнийхээ эрүүл мэндийн төлөө энэ хундагыг өргье гэжээ.

Бүгдээрээ хундагыг өргөн тогтоов. Хөөрч баярласандаа Ерөө ч зөөлөн хуурай дарсыг ууж орхилоо. Чингээд хоол идэцгээв. Ууганаа гараа гарган хийсэн буузаа жигнэн гаргаж Ерөөгийн тавганд хийэ өглөө. Залуу бүсгүй аз жаргалдаа толгой нь эргэж байлаа. Ийм хүндлэлийг хүртнэ гэдэг хэмээн тэр бодож байсан уу даа? Энэ яасан сайхан хүмүүс вэ? Түүний үр төрүүлсэн нь тэдэнд үнэхээр аз жаргал авчирлаа гэж үү? Чингэснээр Ерөө хүний эхнэрийг нь араар нь тавьж, эртэй нь нөхцөн муухай нүгэл хийсэн биш харин энэ айлд анх удаа нялх хүүхдийн үнэр тарааж, дууг сонсон бүхий л насаараа хүлээсэн тэрхүү үрийн буяныг өгсөн юм гэж үү?

- Миний охин их ядарсан даа хөөрхий минь... маргаашнаас би хүүгээ харж асрах болно. Чамайгаа сайхан асарч тэнхрүүлнэ. Нялх амьтанаа л сайн асарч бойжуулах чухал... хэмээн Ууганаа хэлжээ.

- Та ажлаа яах юм бэ? гэж Ерөө гайхан асуув.

- Эгч нь ажлаасаа хэдэн сарын чөлөө авчихсан. Хүүгээ асрах гэж тэр шүү дээ. Одоо бидэнд үүнээс эрхэм юм хаана байна? Чамайгаа сайн асарч тэнхрүүлэх, хүүгээ эрүүл энх бойжуулахад надад хайрлах ю алга. Тэр ажил яахав...

- Тийм шүү. Энэ өдрийг Батбаяр ч, Ууганаа ч насан туршдаа хүлээсэн байлгүй. Амьдрал нь ямар тартагтаа тулчихсан биш. Мөнгө цаасаар дутсан биш. Тэр сувилагчийн ажил ч яамай л байна. Одоо энэ нялх амьтнаа л хүн болгож авахаас өөр эрхэм чухал юм алга... гэж Чимгээ дэм өгөв.

- Ууганаа бид 2 ярилцсан юм. Би түүний зөв л гэж бодож байна. Ер нь ажлаасаа бүр гарсан ч яадаг юм. Би хэвлэлийн газраа, үйлдвэртэйгээ ажиллуулаад байхад юугаар дутах юм бэ? Бяцхан хүүгээ, Ерөөгөө, та гурвыгаа тэжээ дөнгөх байлгүй. Ерөө минь бие нь түргэн тэнхэрвэл сургууль номондоо явж л таарна. Ууганаа шинэ хүнээ хараад гэртээ байхаас аргагүй шүү дээ хэмээн виски ууж ам халсан мэт Батбаяр ярьжээ.

Энэ хүмүүс түүнээс санал асуухгүйгээр бүхнийг бодож шийдсэн мэт байлаа. Хувь заяаг нь хэдийнэ шийдчихсэн шиг... Шинэ хүн Батбаярын хүүхэд гэдгийг бүгдээрээ мэдээд халамж анхаарлаа тавихаар үгээ нэгтгэсэн шиг... Хүүхдийг асран харах гэж Ерөө л лав зоволтгүй

боллолтой. Түүний хийсэн нүгэл хилэнц огт хамаагүй бөгөөд гагцхүү хүү төрүүлж өгснөөрөө л Ерөө гавьяатай мэт...Ямар сонин юм бэ? Хувь заяа үнэхээр Ерөөг чингэж гийгүүлсэн ийм сайхан хүмүүстэй учруулсан юм гэж үү?

Болж буй явдалд Ерөө итгэж ядан байлаа. Тэр өнөөх л арван жилийн жаахан охин хэвээрээ шиг, хүмүүс түүний өмнөөс хувь заяаг нь шийдэж, тэр зөвхөн тэдний зааж зааварласанаар л яваад байх шиг... өөрийн муу ядуу гэртээ ч Ерөө ийм байгаагүй билээ. Олон хүүхэдтэй айлын том нь болохоор ээж нь л лав хийх ажил, бодсон бодол бүхнээ түүнд ярьж, зөвлөх гэдэгсэн.

Тэр эр эм хүмүүсийн явдлыг мэдэхгүй, юм үзээгүй жаахан охин болов чиг ээждээ бол арван жилийн сургууль төгссөн эрдэм номтой том хүүхэн байсан... Эх эцгийн дараа орох эрх мэдэл бүхий ууган охин Ерөө өөрийн ухаанаар, хир чинээгээрээ ээж аавдаа зөвлөн, аж амьдралдаа багаасаа зүтгэж ирсэн... Гэтэл одоо бол энд тэр ердийн нэг нусгай охин шиг, түүний цаашдын бодол санааг хэн ч хэлүүлье, сонсоё гэхгүй өөрсдөө л бүхнийг шийдчихсэн байх нь Ерөөд нэн сонин байлаа.

Яг энэ бодолтой хэмт амаржих газар очсон лам өвөө санаанд нь буулаа. Тэр хүний айлтгасан “хүүг буянтай эцгийг нь түшүүлбэл төөрөг заяанд нь сайн” гэсэн үгтэй энэ хүмүүсийн хэлж буй үг, гаргасан шийд яг таг нийлээд байх шиг... Ямар гайхалтай хэрэг вэ? Яагаад юм бүхэн ингэж өөр хоорондоо зориут зохион байгуулсан вч шиг зохцож таараад байнаа?

Ерөө гайхаж барахгүй байлаа. Чингэтэл туйлын аз жаргалтай энэ мөчдөө тэр ээжийгээ санав. Ууган охиндоо ухаан санаа бүхнээ зориулдаг хөдөөгийн хотын ядуу буурай муу ээждээ үртэй хүүхэдтэй болсноо харуулах сан... Ээж нь яасан их баярлах бол? Аав нь ч гэсэн хайртай охиноо үр төрүүлж, сайн хүмүүстэй учран хүн шиг явааг нь нүдээрээ харж мэдвэл лав сэтгэл тэнийнэ дээ. Муусайн дүү нар нь хэрэв Ерөөг бяцхан хүүгээ өлгийтэй тэврээд очвол хөөрч баярлацгаана даа.

Ерөө аль ноднингоос хойш гэртээ хариагүй ээждээ үнсүүлээгүйгээ саналаа. Жирэмсэн байхдаа ч тэр тухайгаа ээждээ дуулгаагүй билээ. Хүн чухам жаргал, зовлон амсаад ирэхдээ л ээж, ааваа санадаг юм уу даа? Хэрэв үртэй хүүхэдтэй болсныг нь ээж, аав нь мэдвэл ву гэхсэн бол? Хүнд, хүн олдодгүй юм. Миний охин хүүгээ ээжээ авчираад орхичих. Би өсгөөд өгье гэх байлгүй.

Хэдий олуулаа, тарчиг ядуу амьдралтай болов чиг ээж нь төрсөн охиныхоо хүүг байтугай, аль ядарсан зүдэрсэн хүний үрийг ч өргөж аваад өсгөх дуртай байдгийг Ерөө мэднэ. Учир нь тэр жил нутгийн нь нэг ядуу эмэгтэй тэднийд сая төрсөн хүүхэдтэйгээ хэд хонохдоо өөрөө гэдсээ тэжээж чадахгүй байж, хүүхдээр яах билээ, өргөж авах хүн олдвол өгчих юмсан гэж ярихад ээж нь авчих л гээд байжээ. Харин тэр эмэгтэй тун удалгүй айлд хүүхдээ өргүүлж билээ. Тэр тухай одоо Ерөө бодоод ээж, хүүг нь яасан дуртай өсгөх бол гэж боджээ. Тэгэхлээр Ерөө бол ээжээ, ааюаа гээд хүрээд очих гэртэй, оронтой, дууд сургуулийн оюутан, биед хүрсэн бүсгүй бөгөөд өөрийн бодол санаа түүнд бий шүү дээ гэдгийг энэ хүмүүс мэдээгүй биш л баймаар сан...

Ерөө энэ бүхнийг Батбаяр болоод ууганаа эгч, Чимгээ нарт гомдсондоо бодсон биш билээ. Батбаярыг харж энхрий сайхан сэтгэл төрөөд, үрийн минь эцэг юм шүү гэж хэрэв хажууд

хүнгүй сэн бол тэврэн авч үнсэж, үнсэж орхимоор санагдсаар л байлаа.

Түүнтэйгээ хоёулханаа сууж байгаад цаашдынхыг хувь заяаны талаар ярилцах сан гэж Ерөө туйлаас хүсч байв. Ер нь аливаа эм хүн сая дөнгөж төрөхөөс ирээд ингэж л боддог байлгүй. Төрүүлсэн үрээ дундаа тэвэрч, хоёр талаас нь үнсэн таалж, хүүгээ ирээдүйд тийм, ийм хүн болно хэмээн зөгнөн ярилцаж хувь заяагаа хамтаараа шийддэг буйзаа.

Ерөө чингэхийг л хүсч байсан. Гэтэл огт түүний саналыг сонсолгүйгээр бүхнийг шийдээд байгаа нь Ерөөд сонин санагджээ. Гэвч цаг яагаа ч үгүй байна. Энэ хүмүүс түүнд сайндаа, үрд нь хайртайдаа л ингэж ярьж байна. Энэ хүүхдийг Батбаярын үр гэж мэдээгүй ч байж болох шүү дээ. Хүнийхээ сайхан сэтгэлээр түүнд болон үрд нь халамж анхаарал тавьж байгаа хэрэг биш үү?

Ширээний ард нилээн удаан суугаад Ерөө ядарч нойр нь хүрч эвшээв. Чингэтэл ч хүү сэргж уйллаа.

-Охин минь, Ерөө минь ядрах нь... Одоо амарсан нь дээр. Хүү сэрлээ. Алив би аваадхя хэмээн Ууганаа ухас хийв. Тэрвээр хүүгийн өлгийг задлан тэр дор нь хуурайлаад, баяр хөөртөө авгаад хөөрхөн халтлаа виски уусан нөхөртөө нойтон даавуу өгч

-За өвгөн минь ажилдаа ороорой. Хүүгийн даавуу шаавууг одоохон угаачих. Ерөө минь нялх биетэй, гараа норгож болохгүй. Тэгээд ч чи бид хоёр юу гэж хэлэлцлээ? Хүүхэдтэй айлын аав, ээж нар юу хийдэг бүхнийг л хийнэ гэж тохирсон шүү. Нялх хүүхдийн даавуу угааж суух жаргал шүү өвгөн минь гэжээ.

За за. Би даавууг нь угаая. хэмээн Батбаяр дуулгавартай ь аргагүй хүүгийн нойтон өлгий даавууг авч ариун цэврийн өрөө рүү явав. Тэнд цоо шинэ угаалгын түмпэн тавьсан байлаа.

Ерөө хэзээний цагаан гартай, уран бүтээлч Батбаурын тэр байдлыг хараад нэгэн талаар инээд хүрч, нөгөө талаар өрөвдөж хайрлажээ. Тийм хүн нялх хүүхдийн даавуу угаагаад зогсч байх гэдэг ямар байх нь ойлгомжтой байлаа. Энэ яваа насандаа тэрвээр чингэж нялх амьтны даавуу шаавуутай ноцолдоогүй байлгүй...

Ерөө нүд нь анилдаж байвч хүүгээ хөхүүлэн, ховдог амьтан хэрхэн ээжийнхээ хөхийг нударх шахан сорж байгааг мэдрэн, эхийн сэтгэл нь ундрал бялхав.

-За Ерөө минь ингээд гэртээ жаргалтай сууж биеэ тэнхрүүл. Энэ хоёр чамайг асарнаа. Хэрэв хэрэгтэй юм байвал эгчдээ хэлж байгаарай. Би дандаа л чам дээр ирж байх болно.

Чимгээ ингэж хэлээд Ерөөг үнсэн ариун цэврийн өрөө рүү шагайн

-Олигтойхон угаанаа хө. Одоо чиний ажил эхэллээ шүү. Үил үйлээ дагадаг, үнээ тугалаа дагадаг юм хи хи хэмээн шоолох мэт инээв. Ууганаа ч мөн инээжээ. Чимгээ гараад явчихав.

-Алив миний хүү хаана байна? Эвий минь... хөөрхий минь... Жаахан үр минь... хэмээн хүүг эхээс нь аваад Ууганаа өхөөрдөн ярьж гарлаа.

-Ерөө чи одоо амар. Би орыг чинь засчихсан. Сайхан унтаад өг. Босоход чинь би аяга сайхан шөл хийж өгүүз...

Ерөө өрөө рүүгээ явлаа. Үнэндээ ч нүд нь анилдаад ядарсандаа одоохон унтмаар л байв. Түүний унтдаг диваныг тэнийлгэж тавиад, торгон шинэ хөнжил мухлайдан, өдөн дэр тавьсан байлаа. Хөнжлийг сөхөн үзвэл хуучин бүх даавууг сольж, цоо шинийг давсэн ямархан нэгэн гоё үнэртэн цацжээ.

Ерөө хувцасаа тайлаад эрх хүүхэд шиг орондоо орлоо. Тэрвээр дэрэн дээр толгойгоо тавив уу үгүй юу нам унтаж орхив.

Ууганаа хүүхдийг унтуулах санаатай өвөр дээрээ тавин зөөлхөн хөдөлгөн бүүвэйлнэ. Бага залуудаа сая төрсөн дүү нараа бишгүй л нэг өлгийдөж, хэдэн цагаар ч хамаагүй бүүвэйлэн авч унтуулдаг байсан тэр цаг эргээд ирсэн мэт амандаа аяархан бүүвэйн дуу аялана.

Хүүхдийн даавуу усанд базаж угаагаад дэлгэн хатаасан Батбаяр ариун цэврийн өрөөнөө гараад ирэв. Гэрт чимээ шуугиангүй нам гүм байлаа.

- Ерөө унтаад өгөв үү?

- Тэглээ. Нялх биетэй юм, зайлуул ширээнд сууж ядраа байлгүй.

Батбаяр хүүхэд сэрэх вий гэсэн шиг өлмийдөн гишгэсээр хажууд нь ирээд хүүг дөнгөж хошуу хүргэх төдий үнэрлэн үнсэв.

- Хэнтэй ч адилхан юм бэ дээ? гэж зориут үг өдөх мэт тэрвээр чингэж асуув.

- Надтай адилхан байгаа биз дээ? гэж Ууганаа дээш өргөн хүүгийн хацрыг, хацартайгаа нийлүүлэн алджээ.

-Нээрээ адилхан ч юм уу даа? Их хүссэн хүүхэд адилхан байж болох л юм.

- Өвгөн минь хүүхэд өргөж авахсан гэж би чамд хэлдэг байгаагүй билүү? Ерөө энэ жаалаа бидэнд өгөх болов уу?

Бүр чин сэтгэлээсээ, тун их горьдсон өнгөөр Ууганаа ингэж хэлэв.

- Харин л дээ хө. Юу ч гэсэн хүлээ, ээж нь тэнхрэг. Хүү өсөг. Бид чинь Ерөөгийн өөрийн нь санал бодлыг сонсохгүйгээр өмнөөс нь л ингэнэ тэгнэ гэж яриад байгаа шүү. Хэдий бага залуу ч гэсэн эх хүн нэгийг бодож л байгаа даа...

- Тийм шүү. Яарах юу байхав дээ. Би ч энэ хүүхдийг авч тэвэрч бөөцилсөөр байгаад сүүлдээ төрсөн нь шиг нь салж хагацахын аргагүй дасчих байхаа даа. Өөрөө төрсөн юм шиг баяртай байна. Хүүхэд гэдэг мөн ч сайхан амьтан юм. Үгүй чи нялхын нь үнэрийг үнэртээч. Сэтгэл сэргэнэ шүү гэхэд Батбаяр хүүгийн өлгийн засвараар хүзүү рүү нь үнэрлэв. Түүний хамар ер бусын энхрий үнрийг мэдэрч ирэхэд сэтгэл уярч энэ чинь миний яс махны тасархай шүү гэсэн бодол зүрхэнд харвахуй, аньсага нь нойт оргиод ирэх шиг болов. Ууганаа ч түүнрүү



хараад байдлыг мэдэв бололтой нулимсаа арчив. Энэхүү үггүй хэрнээ хэн хэний нь сэтгэлийг хөдөлгөсөн үйл хөдлөл нь ямар ч олон үгнээс илүүгээр бие биенээ ойлгуулах шиг болов. Гадны хүний нүдээр харвал, өөрийн гэх үргүй олон жил хуурай явсан нас хижээл эр эм хоёр хүний хүүхдээр сэтгэлээ тэжээн үнэрт нь авгаж суугаа нь өрөвдмөөр ажээ. Батбаяр ч, Ууганжаргал ч стэгэл нь уярсан тэр мөчид тэдний гал голомтыг энэ бяцхан хүн залгамжлан авч яваасай гэж мөрөөдөж байлаа.

Цэцэгт цэнхэр талд Ерөө хүүгээ зүлгэн дээр дэвссэн дээлэн дээр суулгаад хажууд нь сая түүсэн яргуйгаар сондор хэлхэн сууж байна хамаан зүүдлэв. Хүү нь овоо том болжээ. Эхийн сэтгэл туйлын баяртай байна. Зуны ногоон өдөр зэрэглээ наадна. Тал дүүрэн цэцэг найгаж байх шиг... Чингэтэл тэрхүү нүд баясам цэцгийн цаанаас цав цагаан цамцтай хүн хоёр гараа дэлгэн түүнийг дуудсаар гүйн ирэх шиг болов. Тэр гүйгч сайхан эр Батбаяр байлаа. Хайртай хүнээ хараад Ерөө босч тосон гүйв. Харин урдаас нь гүйж чвсан Батбаярын царай нь харлаж, гэдэргээ хараач гэх адил дохих шиг болов. Ерөө эргэн харлаа. Чингэтэл нэг муухай том хар шувуу хүүг нь амандаа зуугаад нисэн оджээ. Ерөө хойноос нь уйлан хөөснөө бүдрэн унав...

Аймшигт зүүднээс болж уйлж орилсон түүнийг Ууганаа татан сэрээжээ.

- Яав охин минь? Муухай зүүд зүүдлэв үү?

Ерөө нүдээ нээсэн боловч хамаг бие нь хөлс болж, зүрх өвдөн нойрноосоо сайн сэрж чадахгүй, булинггартай бөгөөд нулимстай нүдээр өрөөн доторхийг харан харсаар сая л бодит амьдралыг мэдэрч Ууганааг тэврэн уйлж орхив.

- хар дараад .... ямар муухай зүүдлэсэн бэ? ...

- Тайвшир, тайвшир Ерөө минь. Бие чинь ядруу болоод л тэгэж байгаа юм гээд Ууганаа бүсгүйг үнсэн таалж “Хурай хурай” гэлээ.

Ээждээ эрхэлсэн хүүхэд шиг Ерөө хушуугаа унжуулан Ууганаагийн энгэрт нүүрээ наан хэсэг зуур суув.

- Юм идэж уумаар байна уу? Чи сайхан өтгөн сүүтэй цай чанаж, шөл хийж өгөх үү? гэж Ууганаа асуув.

- Үгүй зүгээр .... би өлсөөгүй байна... харин би бослоо. Зурагтаар гоё кино гарч байгаа болов уу? Ойрд зурагт харсангүй.

- Тэгээ тэг. Харин ядартлаа битгий юм үзээрэй. гээд Ууганжаргал босоод явчихав. Ерөө бослоо. Гэрийн зузаан халааз өмсч шаахай углаад том өрөөнд орлоо. Чингээд зурагт асаан түшлэгтэй сандалд тухлаж авлаа.

Ууганаа хүүг унтаж буй эсэхийг харж мөддөө сэрэх янзгүй болохоор нь гал зуухны өрөөнд мах хөшиглөх гэж оролдов. Тэрвээр Ерөөтэй нэг сайхан яримаар байвч дөнгөж сая эмнэлэгээс гарсан болохоор нь тэсээд ам нээсэнгүй. Батбаярын хэлдэг үнэн юм. Тэд л цаашдын хувь заяаны талаар яриад байгаа болохоос биш, Ерөө чухам хойшид хүүхдээ яах гэж

байгаа, аж амьдралаа яаж зохицуулах, сургуулиа яах тухай юу бодож санаж байгааг асууж хэл ам таталсан хүнгүй байлаа. Өөрийн нь бодол санааг сонсохсон. Хэрэв ая эв нь олдвол хүүг авах тухайгаа ярихсан гэж Ууганаа бодно.

Ерөө чинь эцэг эхээс олуулаа. Аав, ээж нь хуучин Дарханд өлмөн зөлмөнхөн л амьдарч байгаа...Тэдэнтэйгээ ойрд ер хэл ам авалцаагүй байх... Тэдэнтэй нь танилцвал зүгээр юмсан.... Ууган охиноо хүүхэд гаргаж гэж дуулбал тэд яахсан бол? Эх нь хүүхдийг нь өгнө гэдэг болов уу, яадаш бол?

Ууганаагийн сэтгэл хямарч байв. Ямар ч үнээр, ямар ч аргаар хамаагүй энэ хүүхдийг өргөөд авчих юм бол ертөнцөд эм хүн болж төрсний хэрэг бүтэх байлаа. Энэ тухайд Чимгээ л арга чарга мэдэх хүн дээ. Түүнтэй л нэг уулзаасай билээ гэж бодно.

Ажил дээрээ ирсэн Батбаяр сэтгэлд тун зугаатай байсан тул дуу аялж үзэв. Урдаас болгоомжилж байсан бүхэн одоо алга болжээ.Эхнэр нь түүнийн нууцыг мэдсэнгүй. Нялх үрийн үнэр, өхөөрдөм царай, эр хонгор дуугаар уйлах дуу Ууганаагийн алив хар хорийн сэтгэлийг үлдэн хөөв үү гэмээр байлаа. Ерөөсөө ч тэр хардах гэдгийг мэдэхгүй амар амгалан амьтан билээ. Ямар сайндаа танихгүй охин дагуулж ирээд нэг өрөөндөө суулгахад харин ч баяртай байснаар үл барам, жижүүртэй шөнө нь эр нөхөр, жаахан бүсгүй хоёрын дунд эсэн бусын явдал болно гэж зүүдлээ ч үгүй байхсан билээ. Тэр ч байтугай Ерөөг анх жирэмсэн болсныг анх мэдчихээд нөхөртөө тун ч тайвнаар дуулгажээ.

Шинэ хүнийг анх хараад л Батбаяр өөртэйгээ усны дусал шиг адилхан болохыг мэдсэн. Хайр нь оволзон, өөрийн үрийг тэвэрч зогсохдоо, үнэрлэн үнсэхдээ хоолой нь зангирч, самсаа нь шархирсан. Хэрэв Батбаяр анхнаасаа Ууганаагаа хүний хувьд хайрладггүй, цаадах нь хүний сайхан сэтгэлтэй амьтан биш, хэрүүлч нэгэн байсансан бол тэрвээр ер бодож санах юмгүйгээр үрийг минь төрүүлсэн юм даа гээд Ерөөтэй суух л байсан... Гэтэл байдал шал өөрөөр эргэжээ.

Ууганаагаас илүү хардаж сүйд болж байгаа Чимгээ төрөх дээр Ерөөгийн өрөөнд давхин орж хүүхдийг харчихаад, зориуд ажил дээр нь ирж Батбаяртай уулзаад:

- Би ч чиний явдлыг мэднэ гэдгээ эрт хэлсэн шүү. Тэр жаахан нялзрай

амьтан чамтай ямар адилхан юм бэ? Би уг нь уур хүрээд Ерөөг маажчихмар байсан ч чиний дүрийг нялх хүүгээс олж хараад бүр сэтгэл уярчихлаа. Би чиний үрийг төрүүлж өгч чадаагүй. Харин чи одоо азаар заяасан энэ хүүг өөрийн гараар өсгөх л үлдэж... Ууганаа та хоёрт ерөөлөөр ирсэн ч байж магадгүй. Найз нь чамд гомдох юм алга. Ямар намайг аваад суучихсан эр нөхөр минь биш. Элгийг чинь дэвтгээх үр өөр хүнээс ч чамд олдсонд баярлаж явая даа найз нь ... Жаахан хүүг өөрийн болгоход чинь би чадах ядахаараа тусланаа... гэжээ. Ингээд бүх юм болоод явчих нь тэр. Ууганаа нь тэр хүүхдийг хүн хийгээд өгөх биз. Харин Ерөөтэйгээ л нэг сайхан ярилцах юмсан...

төрснөөсөө хойш улам ч гоолиг болсон Ерөө эр хүний нь сонирхол, шохоорхлыг татаж байлаа. Түүнийхээ уруул дээр ханатлаа үнсэж, өөр хүнгүй байхад тэврэн авч хуучин шигээ таалахсан. Харин ингэж бодохдоо Батбаяр учралын амтат мөчийг хүссэн нь бус... Чингэж жаргах цаг

хугацаа ч болоогүй гэдгийг мэдэж байлаа.

Нууц амрагийн хувьд, түүнд баярласнаа өвөрмөцөөр илэрхийлэн ганц цаг боловч зүгээр эрхлүүлэн тэвэрч хэвгэн, хөөрхөн нүдэн дээр нь үнсч сэтгэлийг нь жаргаах юмсан. Ерөө тэгэхийг хүсч байгаа шүү дээ...

Тэр нэгэн намар ямар азаар Батбаяр, Ерөөгөө гудамжнаас олсон юм бэ? Бурхан байдаг бол эзэн тэнгэр л хувь заяаг нь зохицуулж чингэтэл учруулсан байх даа.

Батбаяр хуучин зангаараа хаалгаа түгжин, өвлийн дальтоныхоо захыг босгон гадаа гарлаа. Гав ганцаараа сууж, хундага виски шимэн дотор хүнтэйгээ ярилцмаар байв. Тэрвээр хөнгөн шингэн алхан Улаанбаатар зоогийн газар луу зүглэжээ.

## ЗУРГАДУГААР БҮЛЭГ

Чимгээ ирэв. Ерөөг хүүтэй нь үнсч, авчирсан алим мандаринаа өгөөд том өрөөнд орлоо. Хоёр эгчмэд хүүхэн баахан ярьж инээлдэж байснаа Ууганжаргал орж ирээд,

- Эгч нь Чимгээтэй түр гараад ирье. Хүүг саяхан хуурайлж, хөхүүлж унтуулсан. Нэг хэсэгтээ сэрэхгүй байх. Гадуур гарч идэх юм цуглуулмаар байна гэжээ.

- Тэгээ тэг. Хүү сэрлээ ч би байгаа юм чинь дээ.

- За тэгвэл би явлаа гээд Ууганаа Ерөөг үнсч гарч одов. Хоёр хүүхний чанга чанга ярилцах, инээх, шатруу алхан холдох сонсогдсоор чимээ алдрав. Багшаасаа чөлөө гуйж байгаа сурагч шиг Ууганаа эгч нь чингэжтүр гарахдаа хүртэл Ерөөд хэлсэн нь сайхан санагдав.

Төрөх газраас гараад олон хоножээ. Эдгээр өдөр хоногуудад Ерөөгийн залуу бие амархан төлжив. Ууганаа эгч нь хүүхдийг нь асраад түүний гар хүргүүлсэнгүй. Ажлаасаа ирээд Батбаяр хүүхдийн даавуу угаана. Дуртай ч угаах шиг... Тэр хоёр тохитой учирч хамаг сэтгэл доторхоо уудалж чадаагүй боловч, сиймхий л тааралдвал бие биенээ хайрлан ширтэж, зөрөөд өнгөрөх төдийд хоёр уруул нийлэн, амьсгаа амьсгаагаа үнэрлэж амждаг байлаа. Бие илээршин, нялх цогцос төлжөөд ирэх цагт Ерөө учрлаын сайхныг мөрөөдөх болов. Тэрвээр залуу бүсгүйн хүсэл тачаалаа дарж ядан байлаа. Заримдаа сэтгэлээ барьж дийлэхгүй Ууганаагийн дэргэд ч дэггүй зан нь хөдлөх шахна. Хоол идэж байхдаа өмнөөс нь харж суугаа Батбаярын хөлийг тэмтрэн мэнд хүргэнэ. Чингэхэд Батбаярын нүд сэрэмжилсэнхарцтай болоод “Хүүе чи яаж байна? Болохгүй!” гэх шиг нүдээрээ дохио өгнө. Хоног цаашлах тусам Ерөөгийн эм хүний нь сэрэл хөдлөн Батбаярын заасан эрдэм бүхнийг хуучин шигээ гарган түүнтэйгээ жаргахсан гэж мөрөөднө. Шөнө орон дотроо сэрийн хатуурсан хөхөө, гуя хасаа илж, аяархан гиншин, хүйтэн дэрээ тэмтрэнэ. Хайртай хүн нь энүүхэн хананы цаана унтаж байгаа шүү дээ гэж бодоход болдогсон бол гүйгээд очмоор санагдана. Гэвч тэр эмчийн зөвлөгөөг хатуу баримтлаж байлаа.

Хорио тавигдах хугацаа нэн ойртжээ. Хайрт түүнтэйгээ тавтайхан уулзах боломж олдохгүй л байлаа.

Өдөр болгон шахуу Сэрчмаа хэмээх мөнөөхөн Сөүлийн бүсгүй утсаар ярина. Нэг ярихлаараа сална гэж үгүй. Хүүхдийнхээ тухай, хадмуудынхаа ааш авирыг, тэднийн ямар хоол хийсэн, өөрөө гадуур гарч ямар хувцас авснаа хүртэл тоочин ам хуурай байна гэж үгүй. Нэгэнтээ дуугаа нам болгож байгаад:

- Хүүшээ чи юу яасан уу? гэж асуужээ.

Энэ үгийг нь Ууганаа сонссон байх вий гэж ичин нөгөө хаалга руу хяламхийн,

- үгүй гэхэд нь Сэрчмаа,

- Манай согтуу хар аль хэдийнэ хийдгээ хийчихсэн... цаг хугацаанаас нааш болдоггүй гэж эмч хэлсэн биз дээ гэтэл би... Одоо дүүрчээ дүүрч. Харин сүүлдээ аятайхан ч юм шиг... хи хи хи

ХЭМЭЭН ААЛЫГҮЙТЭН ИНЭЭЖЭЭ.

Үеийн бүсгүй ор хөнжлийнхөө ажлыг аль хэдийнэ эхлэснийг сонсох нь ичмээр байсан боловч, хориотой цаг хугацаа дуусах тутам түүнд атаархмаар санагдах болов. Харин Сэрчмаа Солонгос явах тухайг нь байн байн сануулсаар л байлаа.

Уушанжаргалыг гарснаас хойш цонхон дээр зогсч, одоохон Батбаяр руу утасдая уу? Бушуухан хүрээд ирээч гэж дуудах уу? гэж утас шүүрэн авсанаа болив. Түүни йзүрх хүчтэй цохилон, урьд өмнө хэзээ ч чингэж хүчтэй цохилон хүсч байгаагүйгээр эр нөхрийг хүсэмжлэн байж ядав. Чингэтэл түүний хүслийг таасан вч шиг түлхүүр эргүүлэн Батбаяр ороод ирэх нь тэр. Сэтгэлээ дийлэхгүй Ерөө түүнийг хүзүүдэн авлаа. Тэрвээр ихэд санаснаа илтгэн Батбаярыг үнсч, гадуур хувцасыг нь дотуур цамцтай нь бушуухан тайлж өрөө рүүгээ хөтлөн оруулав.

Чингэж явах завсараа,

- Ууганаа эгч Чимгээтэй гараад явсан... дэлгүүрээс юм цуглуулна гэсэн... хэмээн шулганаж явлаа.

Батбаяр жаалхан амрагаа тэврэн чухам түүгээр л ангаж цангаж байсан шиг үнсэн таалж, хоромхон зуурын дотор хоёр бие уусан нийлэх шиг болов. Батбаярынхаа энэ хүч чадлыг үзэхсэн гэж хүсэн хүлээсэн бүсгүй аяархан гиншин түүний дотор бүжиглэх мэт хөдлөн туйлын баяр жаргалтай хэдэн мөчийг өнгөрөөв.

- За одоо болно... цаг хугацаа гэж юм бий шүү. Бие чинь ядарчихна. Ууганаа ч ороод ирж магад. Хоюул том өрөөнд зурагт харж сайхан ярилцая! Хэмээн Батбаяр амьсгаагаа даран хүйтэн ундаа хөргөгчнөөс авч залиглав. Хамаг хүсэл нь ханаж, хагсаж ангасан бие нь дэвтсэн аятай сайхан болоод Ерөө том өрөөнд орохдоо “Сэрчмаа минь би ч бас жаргалаа амслаа шүү” гэж шивнэж билээ.

- Би чамдаа маш их баярласаар л яваа шүү. Чиний ариун гэгээн бөгөөд асар их хайрыг өдөр болгон нүдний чинь харцаар амсч явах би ямар азтай хүн бэ? Гэвч Ерөө минь амьдрал гэдэг санасан зоргоор бүтчихдэг зүйл биш. Одоо л зайлшгүй бодууштай, шийдүүштэй юм бидэнд байна. Би хүүтэйгээ үүрд хамт байхсан л гэж боддог. Үнэндээ би чамайг хүүг минь төрүүлсэн юм гэж аваад сууж болох л доо. Учраа хэлээд гуйхад Ууганаа хэдий хэцүү байсан ч үгүй гэхгүй л хүн. Тэгж болохгүй. Чам шиг жаахан охин наснаас нь би энэ хүнтэй амьдарсан. Энэ цайлган сэтгэлтэй эмэгтэй чи бид хоёрт ямар ч гэм хийгээгүй. Үрийн мөрөөдөл болсон л нэг хөөрхий амьтан шүү дээ. Тэгж гомдоох эрх надад байхгүй. Чи өөрийнхөө бие, сэтгэлийг үрэн таран хийж баймааж намайг үртэй хүүхэдтэй болгоно гэж нэгэн удаа хэлснээ санаж байна уу? Чи намайг бодоход залуу бүсгүй. Хичнээн ч хүүхэд гаргах нас, бие чамд минь бий. Гэтэл Ууганаа надад саяхан үнэнээ хэлсэн.

- Юу гэж? Бидний тухай мэдсэн гэж үү?

- Үгүй үгүй. Өөрийнхөө яагаад үргүй болсноо... Энэ маань наймдугаар ангид байхдаа догшин мориноос унаж, дөрөөндөө чиргүүлэн үхэх шахсан юм байна. Надтай сууснаасаа хойш хүүхэд гарахгүй болохоор эмэгтэйчүүдийн эмчид үзүүлжээ. Ууганаагийн сав тэр аюулын үеэр

урагдан хазайж, үр тогтох аргагүй болсныг эмч хэлсэн гэнэ. Энэ бол түүний эмгэнэлт явдал мөн гээд Батбаяр санаа алдав.

- Хөөрхий амьтан ... гэж Ерөө дуу алдлаа.

- Бие чинь тэнхэрлээ. Хүүхэд төрсний дараа хүүхнүүд улам гоё болдог. Одоо чи минь нүд булаам сайхан бүсгүй болж байна. Чамайг хараад тэсмээргүй санагддагаа нуугаад яахав. Харин тэсэх л хэрэгтэй болж байна.

- Намайг Солонгос явуулж өгч чадах уу? гэж гэнэт Ерөө асуув.

- Юу гэнээ?

- Би Сөүл явж ажил хиймээр байна. Тэнд очиж чадвал боломжийн ажил олоод өгнө гэж хүн хэлсэн юм.

- Сургуулиа яах гэж?

- Олон хоног хичээлд суугаагүй. Тэгээд ч дур сонирхол алга. Хүүш ээ амаржих газар нэг лам өвөө миний хүүгийн заяа төөргийг үзсэн байхгүй юу. Буянтай сайн эцэгтэй, амны хишигтэй хүүхэд байна. Эцгийг нь түшүүлбэл хувь заяанд өлзийтэй гэж шууд хэлсэн гээч...

- Аа тэгж айлдаа юу? Үнэнийг л хэлсэн байж таарна даа.

- Би ээж аавдаа нэг очмоор байх юм. Аж амьдрал нь тарчиг ядуу хэвээр л байгаа даа. Солонгос явж ажиллавал аав, ээжийнхээ амьдралд тус болж чадахсан....

Гаднаас дуу шуу болсоор Ууганжаргал, Чимгээ хоёр орж ирлээ.

- Өө ашгүй чи ирчихээ юу? Ерөө ганцаараа гэж сэтгэл зовж байсан чинь... хүү сэрээгүй л байна уу? гэсээр тор савтай юмаа барин Ууганаа гал зуухны өрөө рүү оров.

Чимгээ харин хувцасаа тайлаад том өрөөнд орж,

- Зурагтаар юу гарч байна гэж асуун суув.

Ууганжаргал аягаа барьсаар ирээд цай хийж авлаа.

- Ууганаа бид 2 маш чухал зүйл сая шийдлээ гэж Чимгээ дуугаа өндөрсгөөд хэлэв.

- Юу тэр вэ? хэмээн Батбаяр асуужээ.

- Сайхан хүү төрүүлсэн Ерөөгийнхөө аав ээжийг танихгүй суудаг маань дэмий байна. Дархан вяж тэдэнтэй уулздаг юм уу даа гэж ярилаа гэж Ууганаа сэтгэл догдлонгуй ярьжээ.

- Эхлээд би яваад ирье. Манай командиас тэнд тооцоо нийлэх ч ажил бий. Ерөөгийнхөө аав, ээжийг сураглж уулзаад охин нь сайн байгааг дуулгаж бас боломжийнхоо хэрээр хэд гурван

цаас өгье. Яахав Ерөө өгч явуулсан юм гэж хэлнэ биз хэмээн Чимгээ ухаан сийлжээ.

- Харин тэр чинь зөв санаа байна даа. Ерөөгийнхөө дүү нарт хувцас хунар, чихэр боов, аав ээжид нь төнгө төгрөг өгөх нь зүйтэй байх. Би маргааш үйлдвэрээсээ мөнгө гаргуулая хэмээн Батбаяр хэлж,

- Саяхан Ерөө аав, ээжийнхээ тухай дурсч байсныг та 2 мэдсэн юм шиг чухал зүйл шийджээ гэв.

- Аж амьдрал нв хэцүү байгаа бол том болсон дүү нар байвал манай Дарханы салбарт боломжийн ажилд оруулаад өгсөн ч болно шүү дээ гэж Чимгээ их л анхаарал тавьжээ.

Ерөөгийн царай гэрэлтэж ирэв. Сайхан сэтгэл гарган аав, ээжийг нь эргэж очно гэсэн ь юу юунаас чухал, баярламаар явдал байлаа.

- Дүү минь чи аав, ээждээ сайхан захиа бич. Би нөгөөдөр эртхэн шиг гарна шүү. Өөрийнхөө тэргээр хажуудаа санхүүгийнхээ ажилтнаас нэгийг суулгаад д давхичихна. Харин гэрийнхээ хаягийг сайн зааж өгөөрэй.

-Баярлалаа Чимгээ эгчээ. Би захиа бичье.

Ерөөгийн баярласан царайг хараад Чимгээ санаж бодсон нь биелж байгаад урамтай бодов. Тэрвээр анхандаа энэ жаахан бүсгүйг гэртээ суулган, хүүхэдтэй болгосн Батбаярт гомдож байсан боловч эцэстээ хүнийхээ хувьд нууц амраг нь үр хүүхэдгүй хэрхэн санаа сэтгэлээр унах болсныг нь эргэцүүлж бодоод уучлав. Хүүхдийн нь өхөөрдөм царайг харж, Батбаяртай үйлийн үргүй адилхан байхад эхийн сэтгэлээр харйласан билээ.

Энэ хүүхдийг ямар ч үнээр хамаагүй Батбаярт үлдээх нь чухал гэж тэрвээр эрс шийджээ. Хэрэв чингэж чадах аваас өөрийн нь үрийг үрэн таран хийсэн нүглээ наманчлан Батбаярт буян хийж сэтгэлээ амраах юм. Үүнийн тулд Ерөөгийн сэтгэлийг зөв зүгт залах хэрэгтэй байлаа. Чухам Чимгээ л танил ламаа гуйж 1 дүгээр амаржих руу явуулсан билээ. Одоо Дархан хот орж Ерөөгийн эх эцэгтэй уулзан аль бүхнээр тусалвал аргандаа оруулж болно гэж тэр боджээ. Ууганаа ч Чимгээгийн хэлснийг дуртай дэмжиж байлаа.

Тэр орой хэдүүлээ сайхан хоол хийж идэж ганц нэг хундага шимэн хөзөр тоглож удаан сууцгаав. Амьдралын утга учрын тухай, хүмүүст тохиолдсон элдэв явдлын тухай наргиан дундаа ярьцгаажээ. Яг ам халсан тэр яриан дундуур Ерөө Солонгос оронд ажиллахаар явах тухай бодсоноо хэлж орхив. Төрөх газар Сэрчмаатай хамт нэг тасагт хэвтэж байснаа, тэр хүүхэн “Заг” хэмээх компанийн шугамаар албан ёсны гэрээтэй явсан болон боломжийн ажил олоод өгнө гэсэн тухай ам алдав. Энэ бол хүүхнүүдийн хувьд огтын санаандгүй шинэ зүйл байлаа.

- Охин минь сургуулиа яах юм? гэж Ууганаа санаа зовов. Ерөө Хууль цааз дээд сургуульдаа өнгөрсөн намар өвлөөс хойш бараг очоогүйн дээр сургалтын чанар муутай, ерөөс тэр мэргэжил сэтгэлд нь таалагдахгүй байгаагаа нуусангүй.

- Аав ээжийнхээ том охин шүү дээ би чинь... Энэ хорвоод төрүүлж өсгөсөн ачийг нь бодох цаг болсон. Хэдэн муу сайн дүү нар минь ч том эгч надаас харах цаг болж дээ. Сөүлд хүн очиж ажил хийгээд болоод багйаа юм чинь би чадах л ёстой. Тэгвэл ээж аавдаа нэмэр тус болохсон...

- Хүүгээ яачихаад тэр хол явах билээ? гэж Чимгээ зориуд асуужээ.

- Хүүг минь хараад өгөх хүмүүс бий... хэмээн Ерөө ам бардам дуугарчээ. Ерөөгийн өөртөө итгэлтэй дуугарсан үг Ууганаад бол өөрт нь найдах нь гэсэн бодлыг төрүүлсэн бол харин Чимгээ гайхасхийн, Батбаяр хоёр хүүхнийг орж ирэхээс өмнө ярилцаж байснаа санажээ. Ер нь тэгээд хүсээд байсан нь биелэх болсон биш үү хэмээн томчуул бүгд сэм баярлцагаан амьдрал дээр хэрэв хичнээн хүсэж гэм бүтэхгүй юм гэж үгүй ажээ хэмээх бодлыг төрүүлэв.

- За яахав. Ерөөгийн боддог бас чиг гэж охин хүн эцэг, эхээ тэжээх цаг болов гэсэн шудрага л шийд мөн. Харь оронд хүний газар хэцүү нь хэцүү. Харин тэгэхдээ миний охин бол тэр хэцүүг даваад гарчих чадалтай хүн шүү хэмээн Ууганаа хэлж Ерөөг үнсэв.

- Уг нь явах дээрээ тулбал хараар биш, ном журмын нь дагуу тэр “Заг” мэт гэрээ хэлцэлтэй компанийн шугамаар явсан нь дээр дээ. Хүмүүсийн ярихаар тэгэж явсан хүн дуртай цагтаа хүрээд ирж болдог, байр сууцны хувьд санаа зоволтгүй гэлцэх вч билээ. Харин оочир дугаар ихтэй, танил тал, арын хаалга хэрэгтэй л юм гэсэн... Чимгээ бол “Заг” мэтийхнийг аргалчих юм байгаа биз дээ? гэж Ууганаа бас нэмэв.

- Яг Сөүл явах дээрээ тулбал виз зөвшөөрөл авахаас “Заг” мэтийг аргалах зэрэгт миний сэтгүүлчийн нэр нүүр хэрэг болох байх шүү дээ. Хэвлэлийн машин техник оруулж ирэх гэж би чинь Солонгосын элчингийнхэнтэй овоо шиг танилцсан хүн шүү дээ.

Гэхдээ цаг эрт байна. Ямар маргааш хөдлөх гэж байгаа биш. Хүү сайн бойжиг. Бор хоолонд оруулсан хойно юм уу, ядаж угжинд дассан хойно нь энэ тухай бодох нь дээр. Гэтэл Ерөөгийн маань аав ээж бас юу гэх бол? Санаан зоргоор охиноо харь газар явуулаач уу үгүй юу...хэмээн Батбаяр хаширлажээ.

Шөнө дөл болсон хойно тэд тоглоом наргианаа өндөрлөв. Чимгээ гэр рүүгээ яаран гарч одлоо. Ярьсан яриа хэвээр шүү, захиагаа бичээрэй. Маргааш нэг завандаа ухасхийж ирье! Хэмээн явахдаа Чимгээ Ерөөд хэлжээ.

Ууганаа хүүг хуурайлан, Ерөө хөхүүлж унтахаар хэвтэх үед арван тавны тэргэл саран уудам огторгуйд мандан цонхоор бүдэг саарал туяа нь тусч байлаа. Ерөөгийн нойр хүрсэнгүй. Өнөө оройжингийн үйл явдлууд санаанаас нь гарахгүй байлаа. Хамгийн сайхан нь үүлэн чөлөөний нар гялс хийн тусаад өнгөрөх шиг хайртай хүнтэйгээ түргэн яаралтай болов чиг жаргал эдлээд авсан нь бөгөөд түүнийг санахаас бие болоод сэтгэл тайвшран туйлын аз жаргалтай агшинг дахиад амсах шиг болно.

Солонгос явах тухай яагаад гэнэт яриа өдсөнөө Ерөө үл мэднэ. Магадгүй сэтгэлийн хөөрөлдөө болоод чингэж ам алдсан байж ч болно. Магадгүй бас тэр тухай ярих хэрэггүй ч байсан болно. Гэвч хэрэв зориглоод явах юм гэхэд энэ хүмүүс бүхнийг бүтээгээд өгөх юм



байна гэдэг нь багтай болжээ. Тэр утгаар нь бодвол Солонгосын тухай яриа өдсөн нь буруу ч биш юм шиг...

Сарны цонхигор туяа нүүрэн дээр тусахад, Ерөө босож хөшгөө татав. Энэ сар лав Сөүлийн тэнгэрээс ирсэн дээ гэж бодлоо. Харь хол газар явдаг юм гэхэд Батбаярыгаа санана даа. Хажууд нь байгаа мөртлөө тэсэж ядан санаж байгаа хүн чинь холдоод бүр галзуурах байлгүй. Одоо ч гэсэн нулимс гартал Батбаярыгаа хайрлан дэмий л хүйтэн дэрээ тэмтрэв. Үгүй тэрнээсээ Ерөө холдон явмааргүй байв. Ерөө ямар азгүй хүүхэн вэ? Үрийг нь төрүүлсэн атлаа насан туршдаа өвөрт нь хэвтэх хувь тавилан дутдаг нь ямар гачлантай хэрэг билээ...

Ерөөгийн нулимс сул асгарчээ. Хань ижил нь болоод, хажууд нь хүүгээ өсгөн суух хувь тавилангүйдээ тэр гомдмоор байв. Гэвч мориноомоо унаж, дөрөөндөө чирэгдэн сав суулгаа эвдүүлэн үр хүүхэд тогтохгүй болсон Ууганаа эгчийн аймшигтай зовлон, энэ хүний нь өрөвдмөөр хувь заяа, эмгэнэлт явдлыг санаад Ерөө өрөвдөн хайлжээ. Хайртай хүнийхээ үгэнд орж, зовлон үзсэн Ууганаа эгчийн төдийгөөс өдий болтол өөрт нь халамж анхаарлыг бодож шүд зуун энэ айлаас явах л хэрэгтэй юм байна гэдгийг бүсгүй хүний ухаан Ерөөд шивнэх шиг болов. Тэр бас Батбаярынхаа орой хэлсэн үгийг, манаах лам өвөөгийн захисантай харьцуулж бодоод эрт орой хэзээ нэгэн цагт яс махны тасархайн нялх үрийг аавд нь үлдээхээс өөр аргагүй нь дээ гэж бодлоо.

Бодол болон урваж хөрөвсөөр байтал Ерөө нэг мэдэхэд таг унтжээ. Маргааш нь орой Чимгээ ирж захиа болон Батбаяр Ууганаа эгч хоёрын бэлдсэн дүү нарт өгөх баахан хувцас, зуун мянган төгрөг сэлтийг авч явав.

Чимгээ хэлснээрээ өөрийнхөө Мерседес бенц машинаараа Дархан хот руу давхижээ. Юмыг яаж мэдхэв тэрэг чарга муудах ч юм билүү, бас хол замд ганц бүсгүй хүнд ханьтай хэмээн компанидаа л машин сайн мэддэг, санхүүгийн албанд ажилладаг нэгэн залууг хажуудаа суулгажээ.

Чимгээ чингэж явахдаа Ерөөгийн аав ээжтэй уулзана, тус дэм болохыг бодно. Хэрэв Ерөөгийн дүү нараас ажилд орчуулчихмаар том биетэй эрэгтэй хүүхэд байгаад өөрсдөө хүсвэл салбарынхаа засварын газарт ажилд оруулчихыг бодно гэсэн бардам итгэлтэй явлаа.

Хүний хувь тавилан гэж сонин юм. Уг нь бол Чимгээ ингэж явах учиргүй сэн... Харин ч хартай хортой хүүхнүүд шиг Ерөөг нэг нүдээрээ харахгүй байж болох л доо. Өчнөөн жил нууц амрагаа гэж явчихаад түүнтэй ярьж зөвлөх ч үгүйгээр итгэл эвдэн, нялхаараа шахуу амьтанг гэртээ авчиран хамгийн бодлогогүй бөгсний бузар шингэсэн эр шиг түүнтэй сэм явдалсаныг нь санахаас Чимгээ хэн алинд нь хор хонзон бодмоор л байсан... Гэвч хүнийхээ хувьд Батбаяр даан чиг сайхан хүн. Ууганаа гэж ертөнцийн хүүхнүүдийн хамгийн сайхан сэтгэлтэй хүний хайлан болсон эмэгтэйчүүдийн нэг... Ийм хоёр амьтан насан туршдаа үрийн мөрөөдөл болж зовж шаналж явааг нь Чимгээ харсаар үзсээр атлаа, огт хөндлөнгийн хүнээс ч гэсэн үнэрлэх үр олдсон нь муу санаалах аргагүй байсан... Иш чааваас хэдэн жилийн тэртээ Батбаяраа хүүхэд олчихоод би юунд тэгтлээ айж бушуухан үр хөндүүлсэн юм бол? Тээж төрүүлээд гаргачихсан бол манай муу өвгөн нэг их харааж зүхэх ч үгүй байсан байж болох. Батбаярын эхнэр бол бүүр юу ч хэлэхгүй л байж... тэгээд нялхад нь Ууганаад өргүүлээд хүн хийж ав гэсэн бол... Өдийд хоёр ойноос өнгөрсөн сайхан хүү гүйж явахгүй юу. Хэрэв тэгсэн

бол хааяахан очиж хүүгийнхээ барааг хараад Батбаяр бид хоёрын үр төл юм шүү дээ гэж сэтгэлээ баясгаад л явж байхсан даа. Тэнэг ухаангүй юм юунд ч тэгэж яаран сандлран үрээ устгасан билээ?... Чимгээгийн тэрэг хурдан юм. Хэдхэн цаг давхиад Дархан хотод ороод ирэв. Үйлчилгээний төв гэж нэрлэдэг дэлгүүр, зоогийн газартай тэр төвийн дэргэд зогсч машинаа буудалд тавиад хол замд агсагдсан биеэ тэнийлгэн сунайсаар тэрэгнээсээ гарав.

- хоёулаа сайхан хооллоноо. Сайхан цай уумаар байна гээд дагуул залуутай хамт зоогийн газрат оров. Бага үд болж, хүн цөөхөнтэй тул хоёр хүний суудалтай ширээ эзлэн зөөгчийг дуудлаа. Яаралгүй хоолоо идэцгээн нэг ана замын алжаалаа тайлан амраад гарч ирэхдээ Чимгээ:

- Миний танилын аав ээж хуучин Дарханд байдаг гэсэн. Тэднийхийг сургалж уулзаад захиа занааг нь өгчихөөд нэг мөр салбар дээрээ очье доо гэлээ.

- Тэгье тэгье.

Хаяг нь тодорхой байсан болхоор Ерөөгийн ар гэрийг амархан олжээ. Хуучин мах комбинатаас баруун тийш муруйж тахирласан гэр хорооллын гудамжаар Чимгээ, хүүхэд энд тэндээс гарч гүйх вий, муусайн зэвтэй хадаас дугуйнд дайрагдах вий хэмээн машин зам даган аяархан явсаар урагшаа харсан том хаалганы өмнө зогслоо. Хэдэн хүүхэд машины чимээнээр гүйлдэн гарч ирсэн нь тааруухан шиг хувцастай, бага дунд ангийн насны нэг охин, хоёр х°вгүүн байлаа.

- Танайх хэнийх вэ? гэхэд Ерөөгийн аавын нэрийг хүүхдүүд зэрэг хэлэв.

Гоё машинаас ганган хувцастай эгч гараад ирэхэд хөдөөний хүүхдийн зангаар өнөө хэд гирэвшин холдсхийв.

- Аав, ээж нь байна уу?

- Аав ажилдаа явсан. Ээж сая сургууль дээрээс ирээд цайгаа ууж байна.

- Алив эгчийгээ ээжтэйгээ уулзуулаарай, нохойтой юу?

- Байхгүй, та ор л доо...

Хашаа нь уудам юм. Зундаа ногоо тарьдаг бололтой тэр хашаанд шороог нь хамар гарган засч, хоорондуур нь ус гүйлгэсний мөр тодхон харагдана.

- Ээжээ ээжээ таньтай хүн уулзах гэнэ хэмээн хүүхдүүд хойд талд байгаа гурван цонхтой шохойдсон шавар байшин руу гүйлдэцгээв.

Байшинд нүүрс түлсэн бололтой, дулаахан байв.

- сайн байна уу? Тарган тавтай өвөлжиж байна уу?

Цай уугаад духны үрчлээ бүрээр нь хөлс болсон намхан нуруутай, ажлын хүний царайтай

хөгшин танихгүй ганган хүүхнийг гайхан харсаар босч ирэв.

- Та суу, цай уу!

Хуучны маягийн цагаан толгойтой ор хана дагуулан тавьсан, арслантай хоёр авдар дээр байгаа жаазанд Ерөөгийн ганцаараа авхуулсан зураг харагдана.

- Би Ерөөгийн захиа занааг авчирлаа гэж Чимгээг хэлтэл

- Юун ашгүй юм бэ? Охин минь сайн уу? Аль нодлингоос гэртээ ирсэнгүй. Бүр сураг тасраад бид сэтгэл зовж суусан юм... хэмээн хөгшиний царай гийн хөлсөө арчиж, хоол хийх гээд ганпанз шүүрэв.

- Хоол хийгээд ву хийхэв. Сая бид гуанзанд хооллочихсон. Май энэ Ерөөгийн захиа... Өгч явуулсан юм нь гадаа машинд байгаа... би аваад ирье... гээд захиаг өгч Чимгээ гарав. Хөгшин ээж нулимсаа арчин нүднийхээ шилийг хамар дээрээ тохож задгай хэвээр нь тугтуйд хийсэн охиныхоо захиаг яаран задлахдаа

- Та нар энэ эгчтэйгээ хамт гарцгаа! гэж захирав. Чимгээг өнөөх залуутайгаа шуудай савтай юм барьсаар эргэж орж ирэхэд эх захиаг хэдийнээ уншаад хөлс нулимсаа зэрэг арчин шөл тавьчихаад сууж байлаа. Чимгээ дүү нарын нь хувцас гэж шуудай дүүрэн юмыг, баахан чихэр жимсний хамт хөгшинд өгч өврөөсөө 150 мянган төгрөг гарган барив.

- Май, охин чинь өгүүлсэн юм.

- Иш муу охин минь хаанаасаа ийм их мөнгө олсон юм бол доо? Та нар сууцгаа. Аяга шөл ууцгаая. Яаж манайд ирчихээд аяганы амсар зуулгүй гарах билээ хэмээн хоол аягалав.

- Охин тэгээд хүүтэй болсон юм биз дээ? хөгшин эх дээрээ ирээд нярайлчихгүйдээ ач зээтэй болно гэдэг манай жаргал байхгүй юу. Хаана амьдардаг шүү юм бол доо? Нөхөр хань нь юу хийдэг юм бол? хэмээн хөгшиг эх асуужээ.

- Их буянтай сайхан хүмүүстэй тааралдаж тэднийдээ амьдарч байгаа л даа. Нөхрийг нь Батбаяр, эхнэрийг нь Ууганжаргал гэдэг юм. Ууганаа хүүг харж асарч, Ерөө ч хааны гүнж шиг л сайхан айлд амар амгалан сууж байгаа... Одоо ч төрөөд хэдэн сар боллоо доо. Сургууль соёлынхоо мөрийг хөөх юм байгаа биз...

- Хүүгээ аваад нэг ирээсэй дээ. Зээ хүүгээ үзэж нэг баярлахсан...

Тэр өдөр Чимгээ айлд баахан саатаж, хөгшин эх явуулах дургүй охиныхоо тухай асууж шалгаасаар удав. Гэр дүүрэн инээд хөөр, баяр баясгалан авчирсандаа Чимгээ сэтгэл хангалуун байлаа. Харин хөгшин эх нь Ерөөгийн хүүг үзэхсэн гэж байн байн яриад байхад баахан сэтгэл түгшив. Гэвч хөгшин эхийн сэтгэлийг ойлгохгүй байж яахин болох билээ?

Дүү нар нь тус тусдаа шинэ хувцасаар гоёцгоон, чихэр жимс идэж баярлахыг харж, хөгшин эх охиныхоо өгч явуулсан энэ их мөнгөөр аавд нь нэг сайхан малгай юуны түрүүнд авч өгөх юм зэргээр яаж үрэхээ ч Чимгээгээс нуусангүй. Чимгээ Ерөөгийн утсыг өгч, Дарханаас захиалга

өгөөд шууд ярьж болно шүү дээ гэжээ.

Ерөө Дарханаас ирсэн даруй захиа, бас ээжийн нь өгч явуулсан идэх дуртай хуруу зузаан сарлагийн өрөм, арвайн гурил сэлтийг авчирч өгсөн Чимгээд үнэн голоосоо баярлав. Аав, ээжийн нь биесүүд сайн% дүү нар нь сургуульдаа яваад ер ажрахгүй байгаад ч, их мөнгө, баахан бэлэг сэлт явуулсанд нь баярласан гялайснаа хэлж, зээ хүүгээ үзэхийг маш их яаран хүсч байна гэх зэргээр ээжийнхээ захиаг уншин уйлж орхив.

Ахиад 2 сар өнгөрөхөд Ерөө гадуур дуртай цагтаа гарах болов. Хавар хэдийнээ иржээ. Улаанбаатарын гудамжаар хайлсан цас, мөсний цс хааяагүй урс байлаа. Харин хавартаа тавьдаг улаан шуурга боос шинжтэй боловч дулаахан сайхан тул Ерөө хүүгээ яах бол гэж огт зовохгүйгээр Ууганаа эгчид орхичихоод гадуур явах болов. Эхлээд тэр сургууль дээрээ очив. Танил оюутан охидууд, төрж, бие төлжин, хотын ганган авхай болсон Ерөөг бараг танихгүй байлаа. Учир нь Батбаяр Ууганжаргал хоёр түүний бүх хувцасыг сольж орчин үеийн залуу бүсгүйн өмсдөг бүхнээр гоёжээ. Нүүр царайндаа зохицсон сайхан моодтой барууны орны цагаан саарал пальтотой, цоо шинэ дөрвөлжин хошуутай дэгжин шаахайтай, сүүлийн үеийн бие барьсан хар өмдтэй, толгой дээрээ маяг хийцтэй залуу охины малгай тавьж үсээ хоёр салаалсан энэ ганган бүсгүйг, хэзээний л нэг муу хуучин хөх гадуур хувцас, богино банзалаас салдаггүй дунд сургуулийн сурагч шиг Ерөө байна гэж нэг байранд, нэг ангид байсан охид анхандаа таньсангүй билээ.

-Танихгүй байгаа юм уу даа? Би Ерөө л байна шүү дээ гэхэд сая дуу алдацгаан шавжээ.

Дараа нь тэр Сэрчмаатай уулзав. Хоёул баахан гадуур тэнэж, амаа цууртал бүсгүй хүнийхээ сониныг хуучлан Ерөө дааж гуанзанд сайхан хооллов.

- Миний хүү бор хоолонд эрт орсон шүү. Манай хар хүн бүр нэг хүн шиг архи уухаа больсон.

Хадмууд ч хүү төрүүлэв гээд надад жигтэйхэн сайн болсон. Одоо найз нь ирэх сараас Сөүл рүүгээ буцах гэж юмаа хөөцөлдөж байна. Чи надтай яваач! хэмээн Сэрчмаа ярих ажээ.

- Хүүдээ ямар нэр өгсөн бэ? гэж Сэрчмаа үгэнд дурлав?

- Баярболд хэмээн Ерөө ам дүүрэн хэлэв.

- Хэн нэр өгсөн бэ?

- Аав нь...

Сэрчмаатай ярьж суусны гэнэт Ерөө, Батбаярын ажил дээр очмоор санагджээ. Бүр одоохон гээч. Тэр учиргүй яарч гарав.

- Хоёулаа жаахан хамт байя л даа. Вундаа яарсан юм бэ? гэж Сэрчмаа хэлээд ч нэмэр байсангүй.

- Хоёул сүүлд зөндөө уулзах юм чинь...Надад яаралтай явах ажил байна. За баяртай.

Ерөө автобусанд суун хайртай хүнийхээ ажил руу явлаа. Сэтгэл нь догдлон, түүнийгээ бушуухан харахсан гэхээс байж ядав.

Батбаяр өрөөндөө үйлдвэрлэлийн зөвлөгөөн хийж байлаа. Туслах нь Ерөөг гайхан харав.

- та кофе уух уу. Зөвлөгөөн тун удахгүй тарна. Захирал гадагшаа явах ажилтай гэж байсан...  
“Заг” руу очно гэлүү дээ хэмээн туслах бүсгүй ярив.

Батбаяр, Ерөөгийнхөө ажлыг хөөцөлдөж л байгаа юм байна гэж бодоод тэрвээр баяртай инээмсэглэжээ.

# ДОЛДУГААР БҮЛЭГ

Сэтгэлийн хөөрөл, хүсэл тачаал нь унтарсангүй. Харин ч хайртай хүнээ үүдэнд нь хүлээн, түүний мэддэгээс огт өөр захирангуй дуугаар үүрэг даалгавар хүмүүст өгч байгааг нь сонсч инээд нь хүрч, хайрлах нь улам ч дэвэрчээ.

Удсангүй хурал тарав.

- Би таны тухай хэлээдхье. Захирал хүн хүлээж авах нь уу үгүй юу? Таныг Ерөө гэсэн байхаа? гээд туслах дотогш орох гэтэл малгай, пальтогоо өмсөөд урдаас гараад ирэв.

- Хүүе чи юу хийж яваа хүүхэд вэ? хэмээн үүдэнд сууж байгаа Ерөөг хараад Батбаяр дуу алдав. Тэгээд гараад явчихад Ерөө араас нь унага шиг дагалдан гарав.

Гадаа гараад Ерөө түүнийг сугадан авав.

Батбаяр Ерөөг үнсэж нүд рүү нь харав. Бүсгүйн нүд хүсэл дүүрэн дүрлийн байлаа. Эл урьхан харцыг уншаад Батбаярын зүрх хайраар бялхан, жаргалтай учрал тийш дууджээ. Тэрвээр Ерөөтэйгөө учрахсан гэж маш их хүсч байлаа. Магадгүй тэр нь удахгүй хол газар яваад өгч ч мэднэ. Бүхнээс амжин өрсөх хэрэгтэй биш үү? Харин хаана очих вэ? Гэрт уулзах арга олдохгүй байгаа болохоор өөр л арга олууштай. Хичнээн дотно танил байлаа ч айлд очихоосоо Батбаяр зовж байв. Тэр нэрээ бодох ёстой биш билүү? Эцэст нь яадаг юм, хүн ордоггүй орон сав биш, зочид буудалд жижүүрт нь ахиухан мөнгө өгөөд тухлая гэж санажээ. Тэр хоёр такси авч хотын төвөөс зайдуухан орших хувийн жижигхэн зочид буудалд буув. Батбаяр арван мянгатын дэвсгэрт ширээн дээр нь сэмхэн тавиад жижүүрт хандан:

-Өрөөний үнийг жичид нь төлнө, бид хоёр түр амармаар байна гэв. Ахимаг насны эмэгтэй учрыг ойлгосон шинжтэй түлхүүр өгч:

-Надад найдаж болно шүү. Хэн ч амгалан тайван байдлыг чинь эвдэхгүй. Ахиад ирсэн ч би бэлэн л байх болно гэжээ.

Ганц ортой өрөөнд орж хаалгаа түгжээд хоёр амраг хувцасаа яаран тайлж орондоо орцгоов. Батбаярын хамаг шунал тачаал чинээндээ тулж хайртай бүсгүйнхээ нандин бүхнийг тэмтрэн, галзуу хилэнтэйгээр босч ирсэн өнөөхөө Ерөөгийн зөөлхөн халуун эрхтэн рүү хийж өгөхөд бүсгүй чарлах шиг болж, заасан хөдөлгөөн бүхнийг нь тун ч дур тачаалалтай хийж эхлэв. Хоёр амраг цэнгэлийн амьсгаанд бахардан, үнсэлтээр бие биеийг шавшин хэдэн мөч хүсэл тачаалаа ханган жаргацгаав.

-Жаргалын удаан, зовлонгийн түргэн нь дээр гэдэг. Би хажууд чинь байгаад байхлаар чамайг зовоож мэдэх нь. Ер нь би гурвуулаа нэг гэрт байхаас үнэндээ залхаж байна. Хичнээн сэтгэлээ барья гэвч тэсч тэвчиж чадахгүй юм. Юу хийхэв дээ, би явах юмандаа явья, хүү минь ч одоо бор хоолонд оржээ. Намайг танихаасаа илүү Ууганаа эгчийг л харж сүйд болон инээдэг шүү дээ. Одоо тэр хоёр алзахгүй биз.

Хайртай хүнийхээ өвөрт хэвтэж байхдаа санаа алдан байж Ерөө энэ үгийг зориглон хэлжээ.

Батбаяр ч тэгэх нь мөн гэж зөвшөөрөв.

Сэрчмааг сарын дараа гарахад Ерөө хамт гарах, хамаг ажлыг нь Заг компанийн шугамаар Батбаяр хөөцөлдөж бэлэн болгох, харин яван явгал нь энэ буудалд учирч байхаар нууц амрагууд тохиролцов. Батбаяр хайртай бүсгүйнхээ явдал суудлын талаар урьдчилан ярилцаад "Заг" компанийхантай үгээ олох нүхээ хийчихсэн байлаа. Учир нь тэдний хэвлэх үйлдвэрээр баахан гэрээний маягт, бас бус зүйл хэвлүүлье, үнэ хөлсөн дээрээ бодолцож өгөөч хэмээн менежер нь хэд хоногийн өмнө Батбаяр дээр ороод иржээ. Юу ч гэсэн эхний удаа явах хүмүүсийнхээ тоонд манай нэг хүнийг багтаагаад өгвөл юмыг чинь үнэгүй хэвлээд өгсөн ч болно шүү гэсэн санаагаа цухуйлгаад орхижээ. Тэр менежер өглөө утасдаж:

-Захирал тантай уулзъя гэж байна хэмээн хэлсэн билээ. Өнөөдөр уулзаж чадахгүй нь, ажил гарсан. Өглөө эрт ажил цуглах үеэр намайг хүлээж авна уу гэж захиралдаа дамжуулж өгөөч хэмээн Батбаяр буудлаас гар утсаараа ярив. Хоёр амраг гарахдаа мөнөөх жижүүрийн нэрийг асууж мэдээд, дахин ирэхээ ойлгуулаад явцгаав. Чингээд алс явах аянд Ерөө сэм бэлдэж эхэлжээ.

Хоног хугацаа харвасан сум шиг өнгөрөв. Арваадхан хоноод явна хэмээн бүх юм нь жин тан болоод байтал гэв гэнэтхэн ээж нь хүрээд ирэв. Уг нь явахаасаа өмнө нэг ухасхийгээд ээждээ үнсүүлнэ гэж бодож байтал харин эх өөрөө ирээд тээврийн товчоон дээрээс ирж аваач хэмээн шавдуулжээ. Ерөө хөлсний тэрэг авч давхилаа. Хотынхон өлмөн зэлмэн байгаа биз гэсэн шиг баахан бортого савтай сүү тараг, өрөм зөөхийтэй их ачаатай хөгшин ээж олны дунд охиноо хүлээн хөлсөө арчсаар сууж байлаа. Эх охиноо хараад таньж ядан уулзав. Их санасан сэтгэлээсээ уйлж охилон байж ээж нь:

-Хүргэн маань хаана байна? Зээ хүүг маань аваад ирэхгүй яагаав гэж нэхжээ.

-За явцгаая, манайд очъё доо гээд Ерөө хамаг ачааг нь хөлсний тэргэнд ачаад ээжийгээ суулгав. Ерөөгийн ээж хүррэд ирсэн нь энэ айлынхныг сандралд оруулав. Ууганжаргал нөхөртөө утасдан хэл дуулгасанд цаадах нь тэр дороо хүрээд ирэв. Хөгшин аяга цай уухаасаа өмнө охиныхоо хүүхдийг л үнсэх гэж ярав.

-Ай хөөрхий минь... Ийм сайхан мантгар цагаан амьтан юмсан уу? Аль вэ эмээ нь үнсье. Ээ хөөрхий минь... Үгүй тэр байж байгааг нь ээ... Миний хүү эмээдээ очихгүй яагаав? Эмээ нь эх барьж аваад хоосон арьсаа үлгүүлж байгаад ч болов өсгөж болох л байсан. Харин чи минь буянтай хүмүүсийн гар дээр сайхан торнижээ. Одоо эмээтэйгээ явна биз дээ? Эмээ нь тэр холоос хүүгээ аваачих л гэж ирэв шүү дээ хэмээн шүдгүй амаа ангайлган баярлан инээв. Хөгшний үг гэрт байсан хэдэн хүнийг суран ташуураар чанга гэгч нь ороолгохоос илүүгээр айлгах шиг болов. Хөгшнийг ширээнд урин залж, байдгаараа дайлсан авч тэрвээр ам хүрэхээс нааш идэж уусан ч үгүй, хамаг санаа нь бяцхан хүү дээр л байх шиг түүнийг гараасаа салгахгүй тэвэрч, өөр юу ч үл анзаарах ажээ. Гэрийн эзэдтэй ч нэг их ярьсангүй Баярболдыг тэвэрсэн хэвээр ганц хоноод:

-За хүүхэд минь хөгшин эхийг өршөөгөөрэй. Хөдөөний мунгинуу мунхаг амьтан л гэж бодоорой. Би хүүгээ л аваачих гэж ирсэн. Одоо хөдлөх минь... Ерөө чи надтай яв. Аль вэ хувцсаа өмс. Аав чинь анхныхаа зээ хүүг үзэх гээд тэсэн ядан хүлээж байгаа. Аргагүй шүү

дээ. Юу ч болохноо тэр өвгөний элгийг дэвтээж, үрийн нь үрийг аваачиж үзүүлээд орхье. Тэгж байтал учир нь олдно гэжээ.

Ерөө эхийн үгэнд орохоос аргагүй болов. Гэртээ хариад аавтайгаа уулзан, аажуу уужуухан учир байдлаа хэлбэл эрхиш ойлгох байлгүй. Лам өвөөгийн үгийг сонсвол угаас шүтлэгтэй юм чинь ээж тэр хүний хэлсэн айлдсаныг дагах л ёстой.

Ерөө юмаа бэлдэж байхдаа эл учир байдлаа Батбаяр, Ууганжаргал хоёрт хэлж билээ. Тэгээд явцгаав. Ээж, охин, хүү гурвыг Батбаяр Ууганаа хоёр Дархан хот руу явах хөлсний тэргэнд суулгаж өглөө. Хайрыг нь булаасан жаахан амьтнаа үнсч нулимсаа барьж дийлэхгүй байсан Ууганаа тэдний суусан тэрэг холдон одоход эхэр татан уйлж ухаан алдан унав.

## ТӨГСГӨЛ

Нялх үр гэнэт чангаар уйлах шиг болоход Ууганаа үсрэн босч Ерөөгийн өрөөрүү харайлгав. Гэрэл асаахад харин тэнд хэн ч үгүй, ямагт хүүгийн унтдаг байсан өөжгий л эзэнгүй зөөлхөн савчин хөдөлж байлаа.

-Чи минь яаж байна аа? Зүүдлэв үү? хэмээн Батбаяр нүцгэн босч ирээд ханиа тэврэн авав. Ууганжаргал нөхрийнхөө мөрөнд нүүрээ наан уйллаа.

-За тайвшир. Хүү эргээд ирэх байлгүй дээ. Ерөө үнэн учрыг хэлээд аав ээжийгээ үгэндээ оруулж дөнгөх биз. Тэгээд хүүтэйгээ хүрээд л ирнэ шүү дээ гэж Батбаяр ханийнхаа толгойг илэн байж аргадав.

-Надад жаахан виски хийгээд өгөөч.

Батбаяр хөргөгчнөө ямагт бэлэн байдаг виски гаргаж хундагалан Ууганжаргалд өгөхөд эхнэр нь нэг амиар залгилж орхив. Хоюул том өрөөнд ирж сууцгаалаа. Шөнө дуусах ягаа ч үгүй. Ууганаа өврөөсөө нэг юм гарган үнэрлээд санаа алдлаа. Тэр нь нялх хүүхдийн өрөөсөн бойтог байв. Батбаяр ч авч үнэрлэхэд хүүгийн нь нялхын энхрий дотно үнэр ханхалж байлаа.

Ууганжаргал гэнэт бодол болоод явчихав. Тэр нөгөө өрөөнд орж юм түжигнүүлж байснаа сонингийн хайчилбар, өчүүхэн жижиг цаас барьсаар орж ирэхэд "Миний хүүхдийг тээж төрүүлээд надад үрчлүүлэх эмэгтэйд сая төгрөг өгч насан туршид нь дэмжиж тусална" гэсэн том гарчиг нүднээ тусчээ.

Хүсэх тусам хясдаг орчлонд үр хүүхэд хүсээд хүсээд заяадаггүй, бие биендээ туйлын хайртай нэгэн гэр бүлийн хоёр, өөр хүүхний хэвлийд үрээ буй болгох гэж шийдэн сонинд зарлал өгснийг тэрхүү сонины тасархай өгүүлж байлаа.

-Ээ бурхан минь. Ууганаа анхнаасаа бүхнийг мэдэж байж гээч! хэмээн Батбаяр сэтгэл дотроо хашгирчээ. Хэн хэн нь юу ч ярьсангүй.

-Хүү ирнэ ээ, ирнэ гэж Батбаяр аяархан хэлэв. Улиран одох цаг юу авчрахыг энэ гэрийн эр эм хоёр урьдаас тааж чадахгүй байлаа.



Ханын цаг зүрх лугаа адил нэгэн хэмээр цохилсоор л...

# НАЙМДУГААР БҮЛЭГ

## БОЛЗОШГҮЙ АЮУЛААС ЗУГТСАН НЬ

-Эвий хөөрхий үр минь, аль вэ, эмээ нь хүүгээ үнсье... Мантгар цагаахан юутай муухай амьтан бэ? Ийм үртэй болсон байж гэр орондоо ч ирэхгүй айлд байгаад байдаг Ерөө чи мөн бөх зүрхтэй хүн ээ? Өтөлж хөгширсөн хойноо ач зээгээ үзэхээс илүү сайхан жаргал байдаг юм уу? Хөөш Хорлоо чи энэ хөөрхөн амьтныг нэг үнэрлээч. Зээтэй болоод баярлаж байгаа үгүй нь ч мэдэгдэхгүй хачин хүн шүү.

Хөгшин эх өглөө эрт босож аяга цай чанаж уусандаа хамаг нүүрний үрчлээ болгон нь хөлс болж, том алчуураар духаа арчин байж хүүг нь үнсэж үлгэн дуу алдав. Хорлоо хэмээх барагтаа бол дууугардаггүй намхан бор өвгөн инээмэр аядан, гаансныхаа бохийг шоржигнуулан тамхиа татаж, зөөгшсөн цайгаа хааяа нэг балган сууна.

-Босцгоо босцгоо, хийх ажил их байна шүү. Пинд байгаа нүүрсний хогийг шигшиж, томыг нь шуудайлан бусдыг нь хаямаар... Нэг нь нялх дүүгээ харж өгвөл таарна. Томчуул нь энэ зун ямар ажил хийхээ бодмоор... Өвгөн чи гурилын үйлдвэрт очоод мастертай нь уулзаж ноднингийг шиг Золоо хүүгээ ачигчийн ажилд зуны хэдэн сар аваач гэж гуйвал таарна даа. Ерөө чи бага дүү нартаа хүүгээ авхуулаад, боорцог хайрахыг бод. Уригдаж ирсэн зочин биш одоо жаал хөдөлнө шүү. Айлын эрх бэр шиг битгий хэвтээд бай. Наад нялх амьтанд чинь угжны сүү хэрэгтэй. Бор хоол сайн идүүлмээр байна. Бүгдээрээ л зэрэг зэрэг хөдлөхгүй бол энэ олон амыг аавын цалин ээжийн цэвэрлэгчийн хөлс тэжээж дийлэхгүй шүү...

Ээж нь үглээ болсон юм уу даа гэж Ерөө бодов. Гэртээ байх сайхан ч, ээж аавдаа эрхлэнхэн дүү нартайгаа тоглон суух сайхан ч, удаан хоног хол хөндий байгаад эргэж ирсэн анхны өдрүүдийн оргилсон хөөр аажимдаа алга болох шиг болов. Тэр бол зөвхөн өнгөний юм, цаг зуурын явдал бөгөөд амьдралын эргүүлэг өөрийнхөө жам хуулиар бүхнийг зохицуулаад ирэхэд Ерөө орондоо дэвсчих ганц аятайхан цагаан даавуу ч үгүй, зөөлөн буйдан гэхээ байг гэхэд дороос нухсан хатуу банзтай орондоо зузаалчих илүү гудас ч үгүй гэр хорооллын ядуу энэ айлд урьд нь амьдарч ирсэн билүү гэж гайхмаар байлаа. Ямагт хөдөлж байдаг дүүжин өөжгийд нойрсдог асан хүү нь одоо бол Ерөөгийн унтдаг мөнөөхөн цагаан толгойтой, хуучин маягийн орон дээр, өлгийтэйгөө нойрсохдоо мурчигнан уурлах нь олонтаа. Ууганаа эгч гараасаа салгахгүй авсаар муу зан сургасны гор нь одоо л гарч, тавиулахгүй авхуулаад байх санаатай ажээ.

Иддэг уудаг юмны тухайд бол бүр ч ярих юм алга. Өдөр болгон мөнөөх л гурилтай хоолоо хийцгээн, түүнээсээ үл уйдаг муусайн дүү нар нь маргааш үдээр халаан булаацалдах шахан амаа олохгүй идэцгээнэ. Гэтэл Батбаярын Ерөө ямар элбэг дэлбэг амьдарч байсан билээ? Дуртай хоолоо идэж, хүүгээ Ууганаад орхичихоод хэрхэн тэр хааны гүнж шиг эрх дураараа байж, гадуур байдгаараа гоён алхаж, ангийхандаа яаж гайхуулж чаддаг байлаа даа? Тэр бүхэн Батбаярын л ач. Тэр хүн л нууц амраг гээд Ерөөг торгонд ороон, тосонд хөлбөрүүлэн хэсэг зуур жаргаасан. Хэрхэн түүний энхрий янагийн үнсэлтийг, ямагт хайр ундарсан сайхан харцыг мартаж болох билээ дээ. Энэ хорвоод азаар учирсан Батбаяраасаа ганц ч хором хол байж чадахгүй гэдгээ Ерөө одоо л ойлгох шиг болов. Нээрээ тэр ямар жаргалтай байсан юм

бэ? Гагцхүү тэр жаргал нь ингээд үүлэн чөлөөний нар шиг гялсхийгээд өнгөрөх гэж үү?

Хүн нээрээ аливаа нөхцөл байдалдаа амархан дасдаг бололтой. Сайхан амьдрал, илүү их хүндлэлийг бага залуу насандаа хэт ихээр амссан Ерөө өөрийгөө хааны гүнж аятай бодоод сурчихсан юм уу даа? Тэр энэхүү ядуу гэрт төрөөгүй юм шиг санаж, ямагт л амьдралын халуун алган дээр энрхийлүүлэн жаргаж байх юм шигээр төсөөлсөөр толгой нь эргэж орхиж уу?

Үгүй үгүй... Тэр ядуу амьдралын эргүүлгэнд бүх насаараа зүтгэсэн дорой буурай аав ээжээ ад шоо үзсэн юм биш, байгаа амьдралыг нь голж шилсэн ч юм биш. Гагцхүү ийм амьдралд урьдынх шигээ байж чадахгүй болсноо л Ерөө мэдэрчээ. Сардаа ганц том шуудай гурил аваад модон байшингийнхаа буланд босгоод тавьчихдаг. Тал таар төмлс зоорилж бүхэл хонины мах аваад борцолж тавьдаг энэ айл, гурилтай хоол боорцог л байвал өөр юуг ч үл хүсэх бөгөөд, хэдэн хүүхэд л өлсөхгүй бол хэмээн эцэг эх нь ч бодож заншжээ. Хувцас хунарын тухайд ярих ч юм биш. Хөвгүүд голдуу болохоор хувцас тэснэ гэж үгүй. Дандаа л зах нь ханзархай цамцтай, өсгий нь элэгдсэн шаахай юм уу, ажлын хартай ч тоож байгаа шинжгүй гүйлдэцгээнэ. Өвлийн дүн хүйтэнд толгой нүцгэн цохиж явсан ч үл тооно. Саяхан л Батбаяр Ууганаа хоёр бэлдэж, Чимгээгийн авчирч өгсөн шинэ хувцаснууд хэдийнэ хуучирч, хир даг болоод, хөвгүүд бие биенийхээ хувцасыг булаалдан өглөө хэрүүл уруул болцгооно.

-Эгч ээ? Гоё пальтогоо надад нэг өдөр өмсүүл л дээ хэмээн Золбаяр хэмээн бие томтой долдугаар ангийн дүү нь Ерөөг ирсний маргааш гуйжээ.

-Тэр чинь буруу талдаа товчтой эмэгтэй хүний хувцас шүү дээ гэж Ерөө хэлсэн боловч

-Зүгээрээ, манай деревэнгийхэн ямар танай Улаанбаатарын хүүхдүүд шиг боловсон биш. Би зүгээр л гайхуулах гэсэн юм гэж дүү нь пальтог өмсөв.

-Хэнд гайхуулах нь вэ? Цэцэгмаад уу? гэж бага дүү нь шоолох янзтай хэлэхэд Золоо ичиж бушуухан гарчээ. Харин сургуулиас ирэхдээ мөнөөх ганц цайны гэмээр шинэ пальтог нь дан шороо болгож, хэнтэйгээ ноцолдсон юм сугыг нь ханз татсан байлаа. Ерөө уйлах шахав. Ичсэн нэрэндээ л уйлсангүй. Учир нь энэ пальтог хорвоод хамгийн хайртай хүн Батбаяр нь авч өгсөн юм. Ерөөд сайхан зохьсныг нь гайхаж, хааяа нэг нууц болзоонд очихдоо өмсөж бай гэж хэлсэн ажээ. Ерөө тэр оройжингоо ноцолдож байж пальтогоо цэвэрлэж ханзархайг нь оёжээ.

Тун ялимгүй жижигхэн юм шиг явдлуудаас эхлээд аж амьдралын ядуу зүдүү байдал, өглөө гараад л өдөржин ажилд зүтгэн орой хөл гар янгинав хэмээн шаналж суудаг хөгшин аав, сургуулийн хог шороотой ноцолдсоор ядарч туйлддаг ээжийнхээ байдлыг, хэдэн дүү нарынхаа царайг хараад миний тус хэрэгтэй болжээ хэмээн Ерөө амандаа шивнэж байлаа.

Хэд хоног гэрээс гарахгүй сууснаа нэг л өдөр Ерөө, хотынхоо дэгжин хувцасыг өмсөөд гарч одов. Түүний халаасанд Ууганаа эгчийн өгсөн хэдэн цаас байлаа. Гэр хорооллын гудсамжнаас хөлсний тэрэг авч шинэ Дархан өөд давхижээ.

Анхандаа яах, юу хийхээ сайн бодсонгүй. Ямар ч гэсэн жил гаруй ирээгүй төрөлх хотынхоо

байдлыг үзье гэж санав. Зөөлөн салхи машины цонхоор үлээж байлаа. Гадаа хаврын наран байшин барилгуудын дээврийг гялалзуулан тусч, өндөр байшингуудын цонх ид шидийн гэрлээр нүд булааж байлаа.

Цаашид яах гээд байгаагаа ээж нь хэлсэнгүй хэд хонолоо. Ерөө бол охиноо, зээ хүүтэй нь авчирсан ээж хэд хоног сэтгэлээ дэвгээн, хажуудаа байлгаад буцаах биз гэж бодсон билээ. Гэтэл хоног хугацаа өнгөрсөөр байхад ээж нь юу ч ярьсангүй. Харин ч Ерөөг хэдэн дүү нараа захираад, боорцог боовхон хийж гэр орноо цэвэрлээд байж байг гэсэн янзтай. Ерөө бас хүн юм болохоор хэд хоног өнгөрөхөд мөнөөхөн Сэрчмаатай ярьсан яриа, Солонгос явах ажил маань юу болох нь вэ гэсэн сэтгэлийн далд түгшүүрт автжээ. Ерөө аавдаа үнэнээ хэлж нэг сайн ярилцмаар байлаа. Аав бол эхийн амнаас зөрөхгүй, юу л гэж хэлнэ түүнийг нь даган гаансныхаа бохийг ухан сэтгэж суудаг билээ. Гэлээ ч гэсэн аав чинь гэрийн эзэн хүн шүү дээ.

Дардан замаар салхи сүнгэнүүлэн давхисан хөлсний тэрэг шинэ Дарханд ирж, үйлчилгээний төвийн дэргэдэх зогсоолд Ерөөг буулгав. Ямар нэгэн зорилго бодолгүй Ерөө хаалгаар нь хүмүүс орж буй дэлгүүр өөд чиглэн явжээ. Чингэтэл торон савтай юм барьсан нэгэн бүсгүй урдаас ирж явсан нь аравдугаар анги хамт төгссөн, багадаа үерхэж байсан Оюунаа байлаа. Сүрхий таргалж мариалн, давхар эрүү суусан Оюунаа багын найзаа таньсангүй. Хүнтэй сууж хүүхэд гаргасан тэрвээр айлын эзэгтэйн зантай болсон шиг тортой юмруугаа хараад, өөр юм авахаа мартсан юм уу даа, эргэн явах гэхэд нь Ерөө тохойноос нь бариад авав.

-Хүүе Оюунаа сайн уу?

Цаад бүсгүй гайхан харав. Дэгжин хувцастай, нүүрэнд сүр оруулдаг сайхан нарны шилтэй, хот газрын ганган авхай түүгээр яах юм бол гэсэн шиг байхад нь Ерөө:

-Танихгүй байгаа юм уу даа? Би Ерөө чинь л байна шүү дээ гээд тэврэв.

-Ерөө? Ямар Ерөө? Хүүе нээрээ мөн байна. Ерөө минь...!

Хоёр бүсгүй уйлалдан үнсэлджээ. Хэнээс ч ичиж зовсонгүй.

-Үгүй ер дөө. Хаанаас гараад ирэх нь энэ вэ? Чамайг чинь хот яваад сураг тасарлаа гэхэд чинь гайхаж л байлаа. Муу л юм бодож... Гэтэл чи минь танигдахын аргагүй том, гоё хүүхэн болчихсон байдаг. Бас хүүхэд гаргаад... Хамар дээр чинь сайн будсан ч харагдахаар сэвх байна. За манайд очъё гээд Оюунаа найзыгаа гараас нь хөтлөв.

Ойн бяцхан шувууд гэнэт таарсан шиг үеийн хоёр бүсгүй ам хамхилгүй ярьсаар тэднийд ирэв. Оюунаа хувцасаа тайлж Ерөөг дотор өрөөнд буйдан дээр суулгаад, аяга цай чанаж шөл хийв. Хөргөгчнөөсөө шилтэй хүрэн юм гарган ирж:

-Миний нэрсэн жимсний архи, амсаад вз. Эсвэл чи хот газрын хүүхнүүд шиг хатуу юм уудаг болснуу гээд инээв.

Ерөө толгой сэгсэрч Оюунаагийн нэрсэн хар чавганы чихэрлэг амттай нэрмэлийг амсаад:

-Чи минь сайхан л амьдарч байгаа юм байна. Нөхөр чинь юу хийдэг вэ? гэлээ.

-Нөхөр жолооч шүү дээ. Уг нь ачааны тэрэгтэй байгаад хувьчлалаар өөрөө авсан боловч зарчихсан. Хөнгөн тэрэгтэй болж шинэ хуучин Дарханы хооронд хүн зөөж байгаа. Манайд зуун төгрөгөөр хаа дуртай газраа хүргүүлдэгийг чи ямар эс мэдэх биш. Нэг их баяжитлаа олсон хийсэн юм алга, гэхдээ охин бид хоёрыг хоосон хонуулахгүй, нүцгэн гүйлгэхгүй болж л байна. Би яахав, хааяа нэг зах дээр зогсдог ажилтай, бууз хуушуур хийж зардаг санаатай. Одоо ч шалгалт ихсээд, ариун цэврийн шаардлага хангахгүй гээд л хорих болж... Хэдэн жил өвгөн тэргээрээ хүн зөөгөөд, би бас нэмэр хандивын хоолны мөнгө олвол охиноо аваад тэр солонгост юмуу японд өөр хаана ч юм нэг оронд явж амьдрахсан гэж бодох юм. Чи минь ингэхэд ямар хүнтэй ханилсан бэ? Сургуулиа онц төгссөн чам шиг сурлага сайтай хүнд хуулийн дээд сургууль юу ч биш биз дээ?

Багын найзтайгаа уулзсан нь Ерөөгийн сэтгэлийн гунигийг хөнгөлжээ. Тэрвээр жимсний нэрмэл ууж, бас яриандаа халсхийн, хэрхэн хорвоогийн хамгийн сайхан хүнтэй учирсан хийгээд, түүнээсээ хүүхэдтэй болсон, гагцхүү хамт амьдрах аргагүйгээ үнэнээр хэлсэн авч Батбаярын нэрийг болон сэтгүүлч мэргэжилтэйг, мөн үйлдвэрийн эзэн гэх мэтийг гүнээ хайрлаад хэлсэнгүй билээ. Оюунаа ч шахаж шаардсангүй.

Хоёр бүсгүй цай ууж яриа дэлгэн удаан суув. Хүүхнүүдийн зангаар барагтайд ярьдаггүй нууцаа дэлгэцгээж, эр нөхөр нь яадаг, ялангуяа жаахан халчихсан үедээ хэвийн нэг байрлалаасаа өөр зугаа цэнгэл хийж аяглах гэж яаж наргидаг, шөнийн цэнгүүндээ заавал бөгсөн дор нь дэр тавих гэж зүтгэдэг, өнөө юм нь том болохоор ивүүр хэрэглэвэл бүр сандарч орхидог зэргээ Оюунаа нэг л мэдэхэд Ерөөд ярьчихсан байлаа.

Харин Ерөө Ууганаа болоод түүнтэй холбоотой эмгэнэлт явдал, Батбаяр хэрхэн түүнийг онгоноороо байхад нь хамаг сайхан ажилд сургасан зэргийг нь нууцлан үлдээж, хайртай хүн нь Ерөөд ямархан гайхамшигт аз жаргал хайрладаг, ер арван жилийн годгорхон жаалуудыг бодоход эр бие гүйцсэн жинхэнэ сайн хүн эм хүний хүсэл тачаалыг бүрнээр хангахаар барахгүй, ямагт түүнтэйгээ нялуурч л байх нь бие болоод сэтгэлийн тааламжтай шаналгаа өгдөг бололтой гэх зэргээр ярьжээ. Харин Ерөө солонгос явах тухайгаа, хайртай хүн нь хамаг юмыг нь жин тан болгохоор хөөцөлдөж байгааг нуусангүй.

-Хүүшээ, хоюулаа ингэж уулзсаных өнөө орой нэг сайхан наргиад авья. Ойрын хэдэн жил ямар хамт наргиж цэнгэсэн биш, тэгээд ч чи минь сайн хүний ачаар солонгос гэх харь газар явах гэж байна. Дахиад хэзээ ч учраа билээ хэмээн Оюунаа шүүгээ саваа уудлан хамаг л гоёл зүүлтээ гарган Ерөөд үзүүлж ахуйдаа хүн дуулчих вий гэсэн шиг шивнэн хэлжээ. Тэрхүү наргиад авья гэсэн Оюунаагийн үгийг сайхан хоол идэж бага зэрэг балган, хөгжим сонсч бүжиглэе гэсэн утгаар нь Ерөө ойлгоод, төрсөн гэртээ ирээд хэд хоноход аав ээжийн гэрээс гараагүй баахан уйдаг янзтай болсноо санан багын найзаа хүндлэхийн үүднээс толгой дохин зөвшөөрөв.

-өдөр болгон гурилтай хоол идэх ч залхуутай уйдмаар байдаг шүү. Хааяа шинэ шөл ууж байхгүй бол болохгүй. Сэтгэл таарсан хужирхай тэнийм шинэ шөл уучихаад хөлөрчихсөн амьтан хэвтэж байхад ямар сайхан гэж санана даа.

Хамаг л гоёогоо гарган үзүүлж, тэр ч байтугай охиноо гаргах гэж хийсвэр хийлгэсэн сорвио хүртэл даашинзаа сөхөн харуулаад Оюунаа найз нь их л найр тавьж байхад, төрснөөс хойш сайхан хоолноос буцахыг байсан гэнэхэн ариухан Ерөө тэр бүхнийг зүгээр нэг өнгөний утгаар нь, гүнцэг гэдэг талаас нь ойлгоод ховдог амьтан шүү хэмээн үнсчээ. Тэгэхэд харин Оюунаагийн царай улайн хариу үнсэхдээ Ерөөгийн оронд огт өөр эр хүн байгаа юм шиг харц нь хачин уяруу болж ирээд ичиж зовохоор тэвэрч билээ.

Ерөө түүний цээж рүү нь зөөлхөн түлхэж холдуулахдаа эм хүмүүс бие биендээ чингэж янаглаж болно хэмээн зүүдэлсэн ч үгүй.

-За явъя. Би сайхан наргих газрыг мэднэ. Чамд мөнгө бий юу? Надад ч гэсэн нөхрөөс нууж салтаадсан хэдэн бор юм бий... гээд Оюунаа бүр ч яарч гарав. Танилтайгаа уулзан элдвийг ярьсаар хэдэн цаг болжээ. Үд хэдийнээ өнгөрөөд, зөөлөн явган шуурга орон сууцны байшингуудын дундуур цаас хийсгэн маналзаж байлаа. Том барилгын наран талд ургасан өхөөрдөм ногоон зүлгэн дээр ганц эрвээхий дэрвэлзэн нисч байна.

-Чи намайг энд хүлээж бай. Би ээжид ганц үг хэлчихээд хүрээд ирье. Намайг оройтвол нөхрийг дуудаж охиныг өгчихөөрэй гэж хэлье гээд Оюунаа богинохон банзалтай мөртлөө урт хормойгоо хумих гэсэн шиг өвдөгнөөс дээгүүр татсан юбканыхаа доод сэжүүрээс татас хийн гүйж одов. Тэр хэзээний тэгж өмд банзлаа засч явдаг зантай ажээ.

Оюунаа багынхаа занг тавиагүй л байна даа хэмээн Ерөө шоолонгуй бодож зогслоо. Сэтгэл нь амгалан тайван байсан болов чиг хэрэв Оюунаа нь Улаанбаатарт байсан бол ингэж уулзсаных заавал Батбаяртайгаа танилцуулах байсан даа гэж Ерөө бодов. Хайртай түүнийг бодох бүрт сэтгэл хөдлөх тул өрөвдөж хайрласанда ахоолой нь зангирч, сормуус нь нойт оргих шиг болов. Ямарваа наргиан цэнгээний тухай бодох бүрт л Батбаяр нь санаанд орж ирнэ. Аавындаа ирчихээд ээж нь сайхан бууз хийн дайлах юм уу, зузаан гэгчийн өрөм аяганд нь хийж өгөхөд үүнээс түүндээ амсуулах юм сан гэж санасан удаа бий.

Одоо гэтэл Оюунаа шинэ шөл ууя гэв. Хотод байсан бол Батбаярыгаа дагуулаад хамт тэрхүү сайхан шинэ шөлийг нь амсуулахгүй юу. Нээрээ Оюунаагийн хэлдэг үнэн. Өдөр болгон гурилтай хоол идсээр байгаад Ерөө бүр уйдаж орхиж. Хотод байхад Ууганаа эгч нь гаригийн өдрүүдэд янз янзын хоолоор дайлсаар байгаад Ерөөг бүр муу зан сургаж орхижээ.

Оюунаа удсангүй. Цүнх барин гүйхээрээ гарч ирэхдээ өнөөх л зангаараа богино банзлынхаа хормой хотыг дарсаар ойртохдоо:

-За явцгаая гэж урамтай, хөгжилтэй хэлэв.

Оюунаа түүнийг дагуулан үйлчилгээний төвийн дэлгүүрт оржээ. Хоёр шил хатуу архи нэг шил зөөлөн вино авч, хиамны тасаг дээр Ерөөг мөнгөө гарга хэмээн шахаж зууш хийхээр өөх мах алагласан хэсгийг зүсүүлж бэлдүүлээд, үлдсэн мөнгөөр нь нэг өргөст хэмх, улаан лооль авч мөн тавганд тавихаар бэлдүүлэн цүнхлээд гарч одов.

-Хоюулаа айлд очно оо. Зоогийн газрын хоол үнэтэй. Тэгээд ч танилын маань гэр сэлүүхэн, хүүхэд шуухадгүй амар байдаг юм... гээд Оюунаа Дархан хотдоо байтугай Улаанбаатарт ч

өндөрт тооцогдохоор сонин хийцтэй арван найман давхар байшин өөд дагуулав. Ерөө дуулгавартай хүүхэд шиг л түүнийг дагажээ.

Сэтгэлд нь байн байн Батбаяр орж, яагаад ч юм үл таних айлд тэгж их ядарсан өлссөн мэт шинэ шөл уухаар орох гэж байгаа нь нэг л ёсон бус юм шиг санагдан, хөл нь урагшаа алхахаас төвөгтэй шиг санагдавч багын найзынхаа сэтгэлийг бодон явсаар. Хамгийн гайхалтай Оюунаа шинэ шөл ууна гэсэн атлаа дэлгүүрээс баахан архи дарс ногоо л авчээ.

Ерөө энэ явдалд гайхасхийсэн боловч угаас ийм байдлыг мэдэхгүйн эрхээр Оюунааг сохроор дагаж, цайлган цагаан сэтгэлээр түүнд итгэн, айлд нэг сайхан наргих нь дээ гэж бодож явлаа. Оюунаа таван давхарт гараад нэгэн айлын хонхыг зөөлөн дарав. Гэрийн халаадтай, цэмбэн шаахай нүцгэн хөлдөө угласан, насаар нилээд ахимаг, урдаасаа халцарч яваа толгойтой эр, богино өмднөөс өөр хувцасгүй хэрнээ бүсгүйчүүдээс огтхон ч ичиж зовсон шинжгүй хаалга онгойлгон:

-Сайн байцгаана уу? Морилон орцгоогтун! хэмээн найр тавьжээ.

-Танилц. Энэ миний багын үерхдэг байсан охин. Ерөө чи гутлаа тайлчих, битгий нэрэлхээрэй. Зочны өрөөнд сууж бай. Би одоохон зууш бэлдээдхэе хэмээн Оюунаа шаахайгаа хөлнөөс мултлан шидэж гал зуух руу орох нь хэзээ язааны энэ айлын хүн шиг санагджээ. Ерөө гайхасхийн Алтан булаг хивс дэвссэн, зурагт бүхий зочны өрөөнд орж дэмий л ийш тийшээ харав. Тэгэхэд яагаад ч юм бэ, төлбөрөө төлж чадаагүй ядуу оюутан Улаанбаатар зочид буудлын өмнө анх удаа зориг гарган очиж, хэн тааралдсанд нь биеэ үнэлсүгэй хэмээн зогссон гунигт мөч санаанд нь оржээ. Хэрэв тэгэхэд сайхан сэтгэлт Батбаяр нь таараагүйсэн бол юу болох байсан нь ойлгомжтой. Хэрэв тэгээгүй бол? Энэ тухай санахаас Ерөөгийн дотор муухайрах шиг болно. Мэдээжээр тэр гэртээ аваачаагүйсэн бол өдийд Ерөө янхан хэмээх муухай нэртэй, өвчний эрэндэг болсон, эрчүүдийн дэвсгэр төдий л амьтан байхсан бишүү? Тэр бүхнээс Батбаяр нь л түүнийг аварсан. Огт танихгүй хар хүн даган тэднийд очоод эхнэрээс нь зовон, зочндын өрөөнд гайхширан ийш тийш харж суусан тэр мөчийг Ерөө нэхэн санав. Ингэхэд одоо юу гээч болох гээд байна вэ? Оюунаагийн шинэ шөл гээд байгаа нь, налиг шалиг эмсийн нөхрөөсөө өөр хүнтэй унтах явалдах гэсэн утгатай үг юм биш биз? Багадаа зүв зүгээр зантай охин байсан Оюунаадаа тэр дэндүү амархан итгэсэн биш байгаадаа? Бага ангид хөтлөлцөн гүйж явсан, ядуу амьдралтай Ерөөг гэртээ аваачин янз бүрийн идэх юмаар цатган, гэм хоргүйгээр инээлдэн хүүхэд насны жаргалаа эдэлж явсан энэ бүсгүй хүн бие өдгөө ямар болж, юунд тэр сэтгэл алдардаг болсныг Ерөө үнэндээ мэдэхгүй шүү дээ. Гэхдээ Ерөө хүнийг яагаа ч үгүй байхад нь хар сүүдрээр дүгнэж болохгүй гэж бодоод тэсвэрлэн хүлээжээ.

Оюунаа галзуухны өрөөнд өнөөх эртэй инээлдэн тун чиг зугаатай байх бололтой. Хааяа нэг үнсэлцэв үү яав, яриа нь тасалдан шав шув дуугарах шиг... Хэдэн мөчийн дараа Оюунаа орж ирэхдээ бүр хээгээ барж, хамаг хувцасаа тайлаад, зөвхөн хөхний даруулга дотоожтойгоо үлдэж, тавиур дээр хэдийнэ бөглөөг нь авсан архи дарс, гоёмсогоор өрсөн хиам помидорны зууш тавин орж ирээд явган ширээн дээр өрөв. Тэгээд:

-Халуун байна. Наад хувцас хунараа тайлчих. Над шиг л бай гээд цамцных нь товчийг хүчээр тайлах гэв. Ерөө түүний үгэнд орсонгүй. Цамцаа ч тайлсангүй, урт нарийхан хар өмдөндөө ч

түүнийг хүргэсэнгүй. Ямар нэг ёсон бусын юм болох нь уу даа гэсэн хар сэжиг тархинд нь төрөв. Тэр босоод гүйн гармаар л байлаа. Гэвч тэсэв. Арай ч үгүй байлгүй дээ. Юу л гэж дөнгөж уулзчихаад Оюунаа үерхдэг бүсгүйгээ хэн нэгэнд өгөх гэж зүтгэхэв дээ.

Гаднаас гэрийн эзний үеийн, хууз сахалтай, нүдний шилтэй, улаан хамартай хүн орж ирэв. Гэрийн эзэн ч, Оюунаа ч дуу алдан тосч:

-Доктор Цэвэлээ, дээшээ дээшээ хэмээн найр тавьжээ. Тэр хүн ихэмсэг бардам бөгөөд, ёстой л шинэ шөл уух гэж малын зах дээр авах хонио тарган туранхайг нь шинжих баян цаггалан хүний эрээгүй харцаар Ерөөг хараад муухан инээмсэглэн толгой дохив.

-За ширээнд сууцгаа. Манай гал хам Оюунаагийн багын найз охин хүрээд ирсэн байна. Уучлаарай Ерөө. Бид Оюунааг галтай цогтой бөгөөд бидэнтэй хамт хамтран зүтгэдэг болохоор нь ингэж дууддаг юм. Энэ ширээний ард нэгэнт л суусан бол кинонд гардагаар бидний нүдний өнгө, насны ялгаа арилж, эрх чөлөө гэгч жинхэнэ утгаараа биелэх ёстой юм шүү. Юуны төлөө бид чинь хүмүүнлэг ардчилсан нийгэм байгуулж байгаа билээ. Ардчилалын буянаар бидний олон зуун жилийн гол хоцрогдол болох ичих айхын өвчин холдож, ашгүй нэг сэксийн жаргал эдлэх таатай нөхцөл бүрдэж байна... хэмээн нилээд халамцуу дуугаар гэрийн эзэн, их гүзээт эр хундаганд архи хол хол хийлгэн дүүргээд:

-Ардчилал мандтугай! гэмэгцээ хэнийг ч хүлээлгүйгээр ховдоглон хөнтрөвөв. Үзвэл аль түрүүн Оюунаагийн гал зууханд авч орсон архинаас чамгүй балгаад халамцаж орхижээ.

Гэрийн эзнийг халамцуу гэж үл тоон их л сэтгэл бадрангуй байж Доктор гэх Цэвэлээ ч, Оюунаа ч тус тусын хундагыг даруй хоосолцгоожээ. Харин Ерөө уруул ч хүрсэнгүй.

-Чи яав? Уучихаач... гэж Оюунаа сэм нудрав.

-Би чадахгүй нь. Угаасаа сураагүй юм... гэхдээ яагаад ч юм Батбаярыгаа санаад орхив. Хааяахан нэг виски хэмээх архи авч тун чиг удаанаар, ёстой л араандаа шингээн, толгойгоо амраан уудаг нь бодогдоод, сэтгэл хямарсан үедээ юм уу, хөөрч баярласан үедээ балгахаас буцдаггүй боловч, тэр нь согттоллоо ууж балайрдаггүй шүү дээ гэж өхөөрдөн боджээ.

Тэгэхмээр түрүүхний Ерөөгийн бодсон зүйл үнэн болж таарах нь. Шинэ шөл гээч нь ингэж архидан мансуурч, ор хөнжлийн явдалд орохыг хэлдэг байх нь. Намайг эд нар шахаж архи уулган согтоогоод докторынхоо өвөрт хийх санаатай байгаа юм байна. Оюунаа чамайг ийм хүн болсныг мэдээгүй маань юутай халаг. Батбаяраас өөр хэнд үл нээх миний халуун өврийг эзэмдэнэ гэж бүү горьд. Өөр хэнд ч өгөхгүй ариун гэгээн биеэ зөвхөн түүндээ л зориулна гэдгийг мэдэж ав хэмээн Ерөө хэнд ч юм шивнэнэн дотор сэтгэлдээ эргэцүүлэн сэтгэж суулаа.

Ямар ч шинэ шөл чанасангүй. Хоол ундны тухай яриа ч гарсангүй. Эрчүүл архиа ууцгаан, хоёр хүүхнийг шахаж, Оюунаа тэр даруй халамцаад ирэхэд, Харин яаж ч шахаад Ерөөг уулгаж чадсангүй ажээ. Тэгээд эрчүүд өөр арга хэрэглэх гэсэн шиг бүсэлхийнээс доогуур сэдэвтэй заваан онигоо ярьж өөрснөө түүнээсээ таашаал аван инээлдэж байлаа.

Нэг мэдэхэд гэрийн эзэн халзан эр Оюунааг хүзүүдчихсэн уруул дээрээс нь үнсэж, найз



бүсгүй наалинхайтан эрхэлж хажуудаа хүн байгааг ч үл тоон бараг л өнөөх юмаа дэргэд хийх шахснаа хөтлөлцөөд нөгөө өрөө рүү орчихов. Хэсэг зуур чимлээ алдрав. Оюунаагийн тааламжтай гинших, нас ахимаг эрийн сүртэй уухилах дуун нөгөө өрөөнөөс сонсогдож байснаа чимээ тасарчээ.

-Бүсгүй минь чи намайг жаргаах юм биш үү? хэмээн Цэвэлээ ойртож суугаад тэврэх гэв. Бүсгүй аятайхан мултрав. Ямар аргаар энэ хүмүүсээс салж гарах вэ л гэж бодож суулаа.

-Намайг доктор Цэвэлээ гэж дууддаг нь зүгээр нэг тал зассан хэрэг биш л дээ. Бүх насаараа эрдмийн ажил хийж, Чингисийн үүсэл гарлын тухай хоёр ч зузаан ном бичсэний минь төлөө их хааны нэрт академи надад доктор цол олгосон юм. Одоо үед академи нэрт эрдмийн газрууд бойрооны дараах мөөг шиг олон болсон, тэгээд ч доктор цолыг хэн дуртай авдаг нь үнэн боловчиг, би бол жинхэнэ хөдөлмөрөөрөө ном бүтээж байж энэ алдарт хүрсэн тул өөрийгөө худлаа доктор гэж боддоггүй. Эрдэм ном гэсээр яваад гэрлэж ч амжилгүй насны нараа хэвийлгэж орхилоо доо. Одоо л нэг ханьтай болж чам шиг сайхан хүүхнээр хөлөө хучуулаад жаргаж суумаар санагдах юм. Чи нээрээ залуухан ч, сайхан ч хүүхэн юмаа.

Намар үнээн зэлэн дээр салж өгдөггүй дэлэнч хэмээх ялаа шиг Цэвлээ салахгүй дагаж, баахан согтуугаар Ерөөг тэврэх гэж зүтгэв. Бүсгүй түүнээс зугтаж явган ширээний нөгөө талд гарахад, унаа морь эвгүй зан нь хөдлөхөөр хараах гэж ярзайлгадаг шиг сахалтай урт хошуугаа цорвойлгон Цэвлээ доктор дайрч эхлэв. Аягүй бол хүчээ гаргаж ч магадгүй нь ээ...

-Та байз л даа, би одоохон... гээд Ерөө нойл орох гэсэн хүн шиг зочдын өрөөнөөс гарав. Түүнийг нээрээ л давсгаа суллах нь гэж бодсон шинжтэй Цэвлээ суусаар үлдэхдээ шилтэй архианаас зориг орох гэсэн мэт хундагалан ууж байгаа харагдав.

Ерөө бушуухан шаахайгаа углаж гадуур хувцсаа аваад, өлмийдөн гишгэсээр үүдэнд хүрч ганц ухасхийн түгжээг мултлав. Тэгээд гадуур хувцсаа явуут дундаа өмсөн шатаар уруудан зугтлаа.

-Үгүй шүү. Би одоохондоо Оюунаа чам шиг болох дээр тулаагүй байна. Ханилж суугаагүй ч гэсэн хайртай Батбаяртаа би ариун биеэ хадгалж чадлаа. Бид хоёрын дундаас гарсан Баярболд үрдээ ээж нь хэн ч бузарлаагүй цэвэр ариун хэвээр очих минь... Үгүй үгүй, би ариун хэвээр шүү, хэмээн тэр сэтгэлийнхээ чанадад хашгиран хэлж билээ.

Гадаа хэдийнэ харанхуй болжээ. Хаврын оройн гялаан одод бүдэгхэн гялалзаж байлаа. Шороон шуурга намдаад харин ч дотор ариусам сэрүүн тунгалаг салхи зөөлөн үлээн санчигны үсээр тоглох ажээ.

-Ёxxx...

Өндөр байшингаас гарч гүйхээрээ шахам холдоод сая л Ерөөгийн сэтгэл амарч уужим амьсгаа авлаа. Цагаа харвал арав өнгөрч байв. Тэр гэрлүүгээ яарсангүй. Оюунаад гомдсон далд гомдол цээжийг нь мэрэн, түүнийг ашиглан хэн нэгний өвөрт хийх гэсэнд нь сэтгэл бухимджээ. Тэрхүү гомдлоо хэн нэгэн хүнд биш харин энэ хорвоод хамгийн хайртай Батбаяртаа хэлж, дотроо онгойтол уйлмаар байв. Ер ойрд түүнийхээ дууг сонссонгүй. Ерөөг яачихав даа гэж гайхаж байгаа даа... Холбооны газар хажууханд харагдахад Ерөө тэр зүг яаран



## УУГАНЖАРГАЛЫН СЭТГЭЛИЙН ШАНАЛАЛ.

Гэв гэнэтхэн бяцхан хүү ээрч мууртлаа уйлав. Ууганаа нойрон дундаа нүд тас аниастай хэр нь тэмтэрч хүүгээ өвөртөө авчих санаатай сарвалзах авч түүний гарт хэн ч баригдсангүй. Хүүхэд хажууд нь биш, харин зэргэлдээх өрөөнд мөнөөхөн өөжгий нь байгаа тэрхүү Ерөөгийн содон соргог үнэр ханхалсан орны тэндээс дуулдах шиг болохуй, Ууганаа босч тэр зүг явлаа. Ууганаа чингэж босч эзгүй өрөө рүү харанхуйд гараар тэмтрэн явахыг сая сэрсэн Батбаяр мэдэж хойноос нь очив. Ууганаа хоосон ор тэмтрэн, өөжгийг олж түүнийг савчуулан хөдөлгөөд тун чиг гунигтай дуугаар:

-Бүүвэй бүүвэй, бүлтгэр хүү минь унтаарай... хэмээн бүүвэйлж гарав. Батбаяр гэрэл асаалаа. Гэргий хань нь нүд тас аниатай авч, энгэр цээжээ тэмтрэн чингэж үнэн сэтгэлээсээ хүүхдийг өөжгйдөө унтаж байна гэж бодсон мэт аяархан хөдөлгөж зөөлөн бүүвэйлэн дуулах ажээ.

Энэ минь ухаан солиотой болох нь уу даа хэмээн Батбаяр жигтэйхэн айв. Тэрбээр Ууганааг тэвэрч:

-Ууганаа сэрээрэй, Ууганаа гэж дугтрав.

-Чимээгүй бай л даа, миний хүү унтаж байна...

Батбаяр ямар ч л байсан сэрээж сэхээхгүй бол болохгүй хэмээн бодож чанга гэгч дугтран хацар руу нь алгадахад Ууганаа сая л сэрж нүдээ нээв. Болж буй явдлын цаад учрыг ойлгож ядан нойрмог булингартай нүдээр эр нөхрөө харснаа гэнэт асгартал уйлж орхив.

-Үгүй би тэсэхгүй нь ээ. Хүүг минь авчраад өгөөч! Ерөө яагаад алга болчихов оо? Ирэх болсон биш үү? хэмээн нулимсаа арчих ч сөхөөгүй тэрхүү сэтгэлээр ядарсан хүүхэн хэлж байхад Батбаяр тэврэн нойтон хацар уруулыг нь үнсэн тайтгаруулж ор өөд хөтлон явлаа.

Ууганаа түүнд хөтлүүлэн хүүхэд шиг дагав. Тэр хоёр орондоо орлоо. Батбаяр ойр мөч чингээгүй янагийн халуун үнсэлтээр ханиа озов. Чингэж л сэтгэлийг нь цайлган тайвшруулахаас өөр аргагүй гэж боджээ. Чингэтэл үнэн сэтгэлийн халуун үнсэлтэнд Ууганаагийн сэтгэл уярав бололтой хариу үнсч эр нөхрөө тэврэн хариу үнсчээ.

Халуун амьсгаа нь нийлэн, биед ямархан нэгэн илч өгөх шиг болов. Эр хүний хувьд Батбаяр ханиа сэргээж чадах ганцхан арга болох сайхан янаглалын уургаар түүнийг сэрээх явдал л чухал гэж үзжээ. Ойрд хавьтаж ойртоогүй тул Батбаярын эрийн зэвсэг хатууран, хүсэл бадарч эхлэв. Ууганаа ч эрийнхээ тэрхүү байдлыг мэдэж гараараа тэмтэрчихээд ид залуугийнх шигээ аяархан дуун алджээ.

Батбаяр эхнэрээ эрхлүүлэв. Хэн хэн нь хүсч байсан тул ойрд амсаагүй биеийн жаргалыг эдлэн дуу дуугаа авалцан дээр доороо орон цэнгэцгээжээ. Одоо үзвэл Ууганаа нь залуугийнх шигээ л чанга хэвээрээ, аашилж аяглах нь янзтай байх шиг санагдана. Батбаярын хүчтэйг Ууганаа ч бишрэв. Хоюул баахан ноололдож эцэст нь ядран унацгаалаа.

-Жаахан виски амсна уу? гээд Ууганаа хөргөгчнөөс сархад гаргаж шилэн аяганд хийн нөхөртөө барив. Өөрөө ч амсах төдий л ам хүрлээ.

-Ерөө яачихав аа? Хэн хэний нь асуух үг энэ л байлаа. Мэдээж Ууганаагийн хувьд бяцхан хүүгээ л санажээ. Хэрэвзээ тэр бяцхан амьтныг үүрд түүний гар дээр орхих аваас Ууганаа өөр юу ч бодохгүй байж чадах л сан. Харин Батбаярын хувьд залуухан амрагаа санасан нь үнэн авч хамгийн гол нь өнөөдөр "Заг" компаниас утасдаж, явуулах гэсэн хүний нь ажил бүтэмжтэй байгаа, удахгүй гадаад паспорт нь гарна гэж урам хайрласан үг хэлсэн нь байлаа. Эл үгэнд баярлан догдолж байтал утасны нөгөө үзүүрээс:

-Хэд хоногоос манай шугамаар явах бүх хүн солонгосын элчин сайдын яаман дээр ярилцлаганд орно шүү. Дуудсан цагт хүнээ бэлэн байлгаарай. Хэрэв ярилцлаганд орохгүй бол явуулдаггүй юм... гэсэн дуу сонсогдоход Батбаяр ихэд цочжээ. Одоо яадаг билээ? Ерөө гэртээ утас байхгүй. Тэднийх хуучин Дарханы деревин хэмээх гэр хороололд байдаг гэсэн. Яаж хэл дуулгах вэ?

Аяганы тал виски яаралгүй шимэн ууж дотор халуу оргихыг мэдрэн орондоо хэвтэж байхдаа Батбаяр тэр тухай л бодож байлаа.

-Чи юу бодоо вэ? Ерөөг ирээсэй гэж санав уу? хэмээн Ууганаа хөргөгчнөөс хүйтэн ундаа гарган залгилахдаа асуужээ. Батбаяр хариулах гэж яарсангүй. Ерөөг ээжтэйгээ хамт хүүгээ аваад Дархан руу явсны маргааш шөнө Ууганаа чингэж гэнэт хүүхэд уйлав хэмээн нойрмогоор сандарч Ерөөгийн өрөөрүү гүйснийг санав. Тэр шөнө барагтай бол дуугардаггүй Ууганжаргал, нөгөө өрөөнд юм түжигнүүлэн ухаж ухаж нэгэн сонины тасархай авчиран Батбаярт өгч билээ. Яг л өөрсөд шиг нь үрийн мөрөөсөл болсон хоёр залуу аргаа бараад, эр нөхрөөс нь хүүхэд олоод гаргаж өгч гэмээ нь, бүх насаар нь тэжээн тэтгэх, дав даруй сая төгрөг өгөхөөр амлан, тийм бүсгүй хайж буйг зарласан зарлал тэр сонины хайчилбарт байсан.

Тэгэхэд л чухам гэрт болсон бүх явдлыг Ууганаа нь мэдэж байжээ гэж Батбаяр ойлгожээ. Нүүр халам энэ явдлаас болж Батбаяр тэр шөнө олон юм яриагүй билээ. Түүнээс хойш энэ тухай ам нээж чадалгүй явсаар өдий хүрэв.

Хэн хэн нь сэтгэлдээ шаналж явдаг зүйлсээ гарган хэлж нүүр хагаран амрах сан гэж бодовч, Батбаярын хувьд гэргий ханийхаа өмнө нүгэл хийсэндээ бантаад яаж ч чадсангүй. Үгүй нээрэн хажууд нь элдэв явдал болоод байхад Ууганаа мэдсэн ч мэдээгүй юм шиг байж чадсан нь гайхмаар байлаа. Хэрүүлч хардамтгай өөр хүүхэн байсан бол Ерөөг нөхөртэй нөхцсөн гэдгийг мэдсэн даруйд л хэл ам хийх байсан даа.

Ууганжаргалын хувьд эр нөхөр нь үртэй хүүхэдтэй болохсон гэж хүсэхдээ л Ерөөг олж ирсэн, түүнтэй хавьтаж ойртсон ч чухам нэг л утгатай гэж бодсоор яваа билээ. Батбаяр хэзээ ч гэргийгээ ад шоо үзэж байсангүй. Түүндээ тавьдаг халамж анхаарлаа хэдийд ч сулруулж үзээгүй. Үр хүүхэдгүй удсан гээд найдвар тасарсан зарим эр хүн эхнэрээ нэг нүдээр ч үзэлгүй хаяж одсон тухай Ууганаа сонсч л байсан. Адаглаад л чамаас хүүхэд гарахгүй байна. Чи л үр тогтоох чадваргүй энэ тэр гэж хэрүүл хийн дарамтлах явдал байдгийг тэр мэддэг бөгөөд, харин Батбаяр тэр тухайд үг ч цухуйлгадаггүй билээ.

Залуухан сайхан бүсгүй өвөртөлж, түүнийг хүүхэдтэй болгочихоод Батбаяраас өөр хүн бол хуучин хувцас лугаа адил гэргийгээ хаяад Ерөөтэй яваад өгч болох л байсан. Ямар өмч хөрөнгө дутна гэх биш, энэ муу гэрээ, хамаг байдгаа Ууганаад орхиод өмссөн хувцастайгаа шинэ амьдрал зохионо гээд яваад өгөхөд Ууганаа яахсан билээ. Хувь заяандаа гомдоод л үлдэх шүү дээ. Гэтэл тийм явдал болсонгүй. Хэн хэний нь сэтгэлийг бяцхан хүү Баярболд нь эзэгнэж, өдөр тутмын аар саар зүйл, хувийн гомдол гоморхлыг тэр жаахан амьтан ход ход хийн инээх дуугаараа үлдэн хөөжээ. Зорилготой амьдралын нь гэрэл гэгээ Батбаярыг ч, Ууганжаргалыг ч гийгүүлж, энэ айл урьд хэзээ ч байгаагүй тийм инээд хөөр, баяр баясгалангаар цалгиж хэдэн сарыг өнгөрөөжээ. Батбаяр бол сайн эцэг юм. Ажилдаа ядарч ирчихээд хүүхдийн даавуу шаавуу угаахгүй биз, угаасаа цагаан гартай сэтгүүлч хүн ямар тэр тал дээр дадлага туршлага ч байх биш хэмээн анхнаасаа л зүгээр тоглоом шоглоом хийх шахуу хэлсэн үгийг нь үнэн хэмээн ойлгоод эр нөхөр хувцсаа солингуут түмпэн шүүрч авдаг болсон нь сайхан санагдана. Яг ингэж анх удаа Ерөөг эмнэлгээс гарсны дараа түмпэнд ус хийн нялхын даавууг угаахад нь, хэрэв би үр төрүүлсэн сэн бол ингээд л хань минь ажилдаа орж, наддаа туслах байж шүү дээ гэж бодон хоолой нь зангирч билээ.

-За яах вэ, би чамайгаа ойлгож байна. Чи үртэй хүүхэдтэй болохыг анхнаасаа л мөрөөдсөн. Тэр санаагаа биелүүлэх л гэж, намайг үр төрүүлэх найдваргүйг мэдээд Ерөөг чи олж ирсэн байж таарна. Хүн жаргах ёстой. Үр хүүхэд гэдэг тэр жаргалыг авчирдаг юм байна. Одоо чи минь санасандаа хүрсэн болохоор Ерөөгөө аваад дуртай газраа амьдар даа. Гагцхүү надад энэ жаахан хүүг минь л үлдээ. Би чамдаа гомдохгүй. Хүү минь гар дээр дэгэж дэрвэн өсвөл надад түүнээс илүү аз жаргал гэж юу байх сан билээ. Учир нь энэ бол чиний минь яс махны тасархай. Би өөрөөсөө унасан чинээ бодож, сайхан хайрын үр хэмээн бодож өсгөө хэмээн Ууганаа нөхөртөө хэлье гэж бодсон удаа бий. Ингэж хэлэх нь ямар аймшигтай байсан боловч, Ууганаа тэсч тэвчинэ л гэж бодсон. Чемодан саванд хувцсыг нь хийгээд, үүдэндээ хүүгээ тэврэн гаргаж өгч байгаагаар ч төсөөлөн бодсон удаа бий. Нөхөр нь Ерөөг сугадан хөлсний тэрэг рүү явж буй аймаар дүрс нүдэнд бууж ирэхэд, байз би чинь юу бодох нь энэ вэ? Нэг муу хардахчаа болж байгаа юмуу даа гэж өөрийгөө шоолсон...

Сэтгэлийн догшин шуурга чингэж үе үе Ууганааг байж суухын аргагүй болгон зовоосон далд шаналал хэзээ дуусах бол гэж байтал Ерөөгийн ээж ирээд хүсч мөрөөдсөн ганц үрийг нь Ерөөтэй хамт аваад явчихажээ. Шөнөд хоосон, хүйтэн дэрээ тэмтрэн заримдаа ухааны самууралд орон Ерөөгийн өрөө рүү харанхуйд тэмтрэн очихдо хүрдэг гаслан зовлон чингэж эхлэв. Тэр хүүхэн Баярболдгүйгээр амьдарч чадахгүй болтлоо дассан байлаа. Дуунд гардагаар:

... Өөрийн биш дээ

Хүний юм чинь

Үдшийн бүрийдээ хоосондоо... гэгч үг уг нь өөр утгатай боловч Ууганаагийн одоогийн амьдралын зовлон мөн ажээ. Одоо тэгээд яах билээ? Гэнэт мээм нь жигтэйхэн халуу оргин хатгах шиг болов.

Өдөр Ууганаа гэртээ ганцаараа уйдаж өнжинө. Гэрээ хэд дахин цэвэрлээд ч, нөхрийнхөө болон өөрийнхөө хувцасыг хичнээн дахин угаагаад ч явж өгөхгүй удах цаг хугацааг тэсч

тэвчин өнгөрөөх хэцүү санагдана. Тэр бүхэнд сэтгэл үл сатааран, нэг л мэдэхэд хүүгийнхээ бойтгийг авч үнэрлээд уйлж орхисон сууна. Аргаа барахдаа шар сонин худалдан авч бүхнийг гарчигаас нь эхлээд эцсийн нүүрний хаяг хүртэл хаман унших болов. Сонин дээр хов хэрүүлээс эхлээд, улс төрийн явдал, нууц амрагийн тухай гэх зэрэг элдэв л юм бичсэн байна. Ерөөсөө үргүй байсан эр эм хоёр оройтсон насандаа хүүхэдтэй болсон тухай жижигхэн мэдээ Ууганаагийн сонирхлыг татжээ. Бараагаа гүйлгэх гэж ов зохион, бараг л юу ч болоогүй байхад гагцхүү зар тараагчийн эм ууснаар жирэмсэн болчихдог гэж хэлэх нь халаг, зарим рекламаас харин тэр мэдээ өөр байлаа. Бас нэгэн сонин дээр ханиа хүүхэн хүн гэж үзэхийг байсан нэгэн эр, нууц амрагтай болсон гэргийгээ үнэнээ хэлэхэд баахан харааж зүхсэн авч, харин хэрхэн үл таних тэр хүн яаж аашлан аягласныг авгайгаараа яриулсаар байгаад дур тачаалтай болсон тухай бичжээ. Дээрх мэдээг уншаад нээрээ үргүй байсан хүн оройтсон насандаа хүүхэд гаргасан нь үнэн юм бол нялх зүстэй, нойтон сормуустай амьтан надад олдчих юм биш байгаадаа? хэмээн горьдон боджээ.

Ойрд учраагүй сайхан учралаар нөхөр нь түүнийг энхрийлж, хоюул ид залуугийнх шигээ тамирдталаа ноололдсон нь Ууганаад бие сэтгэлийн таашаал төрүүлжээ. Тэрвээр нөхрийнхөө хажууд хэвтээд өөр хэнд ч байхгүй сайхан үнэрийг нь самсаа дүүрэн үнэрлэж байхдаа яагаад ч юм эм хүнийхээ нулимсийг хүчээр барьж байлаа.

-Нойр чинь хүрэхгүй байна уу? гэж Батбаяр хошуу хүргэн үнсээд асуув.

-Чаддагсан бол сайхан тамхи хэд сорох юм сан. Даанч сураагүй юм даа...

-Би чамаас нэг юм асуух уу?

-Тэг л дээ...

-Ерөөг надаас хүүхэд олсон гэж чи яаж мэдсэн юм бэ? Ууганаа намайг уучлаарай. Би чиний сэтгэлийн шархыг сэдэрээх гэсэн биш... Зүгээр л өөрийн зүрх өвтгөж байгаа өвчнийг нимгэлэн чамтайгаа сайхан ярьж сэтгэлээ онгойлгох гэсэн юм...

Ууганаа гэнэт босоод явчихав. Хачин зантай хүүхэн шүү. Юу ч хэлэхгүй ингээд гараад явчихлаараа нөгөө өрөөнөөс ямар нэг нууцлаг зүйл аваад ирдэг шүү. Харин энэ удаад Ууганаа ямар нэгэн өөр юм биш, харин "Алтан товч" хэмээх эртний сайхан судрыг шинээр хэвлэснийг аваад иржээ.

-Май үүнийг унш гэх адил нэгэн хуудас нугалснаа Ууганаа сөхөн эр нөхөртөө үзүүлэв. Батбаяр гайхан авч уншлаа.

...Хулст нууранд

Хун галуу олон гэнэм

Хуруугаа чинэтэл намнахаа

Эзэн минь өөрөө мэднэм за.

Хотол их улсад

Охид эмс олон гэнэм

Хутагт их эзэн минь ирж авахаа

Өөрөө мэднэм за.

Эрхийдээ мэргэн

Эрэг нугас хоёрыг

Хамт харвам гэлээ.

Эр хүн дурлахул

Эгч дүү хоёрыг

Авам гэлээ...

Их Чингис аян замд Хулан хатныг бага хатнаа болгон аваад, анхны авааль Бөртэ үжиндээ зовон байж дуулгахад, цаадах нь хариу хэлсэн гэх энэ үгийг судраас уншаад Батбаяр инээж орхив. Тэдний одоогийн амьдралд таарахгүй байсан боловч Ууганаагийн далд сайхан санааг эр нөхрийн хувьд ойлгоод Батбаяр туйлын өрөвдөн хайрлаж билээ.

Батбаяр ханиа тэврэв. Яагаад ч юм сэтгэл уярч аньсага нойт оргин, эр хүний нь ховор нулимс сул асгарчээ. Ууганаа ч тэссэнгүй...

-За тайвшир. Би чинийхээ сэтгэлийг ойлгож байна. Одоо яана гэх вэ дээ. Хувь заяа л бидэн хоёроор даажин тохуу хийж орхижээ. Хорвоогоос оноосон хувь тавиланг яалтай ч билээ дээ. Эр биеийн шаналгааг тэвчихгүй, үр хүссэн сэтгэлээ тэвчихгүй ингэж бага бүсгүйтэй чиний дэргэд нэр холбогдсон миний буруу... Харин чи ухаантайдаа энэ бүхнийг тэсч тэвчиж... Одоо бид хоёрт ганцхан хүсэл, бяцхан хүүгээ л хүн болгож авах нь чухал байна. Тийм биз дээ?

Батбаяр ханиа аргадан сэтгэлийн далд байсан бөөн хар юмыг аваад л хаячихсан шинжтэй санаа алдав. Ууганаа бага залуугийнх шигээ амархан тайвширч, цээжийг нь халуун амьсгалаараа төөнөн мөн л санаа алдан хэвтэж байхдаа:

-Ингэхэд бид хоёр хүүхэдтэй болчихвол чи яах вэ? гэж асуужээ.

Энэ бол ямар ч боломжгүй зүйл гэдгийг Батбаяр мэдэж байсан тул хариу хэлсэнгүй.

-Ерөөгийн сургийг гаргамаар байна. Тэр яагаад ирнэ гэсэн хугацаандаа ирсэнгүй вэ? Өнөөдөр "Заг"-аас ярьж байна билээ. Паспорт нь бүтэхээр болсон, виз ч яах вэ, нэгдсэн шугамаар даруулчих юм билээ. Харин явах бүх хүн солонгосын элчин дээр ярилцлагад орох ёстой юм гэнэ. Хүнээ бэлэн байлга гэж байна, одоо яадаг билээ?

Батбаяр санаа зовон чингэж хэлэхдээ Ерөө хүрээд ирвэл чиний минь сэтгэлийн шаналал алга болж бяцхан хүүтэйгээ сэтгэл амар байхсан даа гэсэн санаагаа цухуйлгав.

-Ерөө яахав дээ, наашаа явахсан л гэж байгаа. Ээж нь л явуулахгүй байгаа болов уу? Ганц том охины нь хүүхэд, анхны нь зээ шүү дээ манай Баярболд чинь.

Яагаав тэр хөгшнийг ирэв гэж ширээ дүүрэн юм өрөөд найр тавьж байхад юу ч идэхгүй, хүүхэд тэврээд л суугаад байсан шүү. Бурхан минь, тэг тэгсээр хүүг ерөөсөө нааш нь зүглүүлэхгүй бол би яах билээ? Тэгвэл ч би дүүрлээ дүүрлээ.

-Гайгүй байлгүй дээ. Ерөө л мэдэх ёстой биз дээ? Эх нь үрээ мэдэж, эрэг нь усаа хаших байлгүй. За унтъя, маргааш Чимгээтэй зөвлөе, тэр нэг арга бодох байгаа...

Их орой болсон байлаа. Эр эм хоёр тэврэлдээд унтаад өгөв. Унтах ч гэждээ, Батбаяр хурхирч, харин Ууганаа нойр хүрэхгүй тийчлэн хэвтсээр үүр цайлгажээ.

Маргааш орой нь Ерөө ярив. Эхлээд Батбаяр утас авахад:

-Байна уу? гэсэн түүнийхээ намуухан дууг сонсоод тэртээ хол, Дархан дахь утасны үзүүрт Ерөөгийн гомдсон, эрхлэнгүй цурхираан сонсогдоход:

-Сайн уу? Яасан бэ? Юу болсон бэ? хэмээн Батбаяр сандрав.

-Чиний дууг сонсоод сэтгэлээ дийлсэнгүй. Би харимаар л байна. Ээж шийдтэй юм хэлэхгүй нь. Тэгтэл хачин хачин хүн тааралдаад... За яахав, очиж байгаад би бүх үнэнээ ярина аа. Чамайгаа үнсье, Ууганаа эгч байна уу?

Батбаярын нүд гялалзан баярласан шинж илэрхий байхад Ууганаа утсыг авав. Хүүхнүүд нарийн нандин юмаа ярих биз гэж Батбаяр хөргөгч ухан виски гаргаж аяганд хийгээд гал зуухны өрөө рүү явлаа. Ерөөтэй ярьсан нь, тэр бүсгүй ихэд санаснаа нуулгүй дуу сонсоод уйлсан нь, "Үнсье" гэж нүүрэмгий хэлсэн нь сайхан санагдаад зүрхний өвчин намдах шиг л болов.

-Би ярина шүү хөөе. Ярилцлагын тухай эсвэл чи дуулгачих юм уу? гэж Батбаяр Ууганаад хашгиран хэлэв.

Батбаяр галзууханд хулдаасаар бүтээсэн ширээний ард дарс шимэн сууна.

-Би ч нээрээ хоёр эхнэртэй хүн юм даа. Их эхнэр бага хатныг минь хүлээн зөвшөөрсөн хэрэг шүү дээ. Юу гэсэн мөр надад уншуулаа даа? Аан тийм... Эрхийдээ мэргэн эрэг нугас хоёрыг зэрэг намнах, эр хүн дурлаваас эгч дүү хоёрыг зэрэг авах... хэ хэ...

Ууганаа сэтгэлээ онгойтол ярив бололтой. Бас уйлав уу яав, хоолой нь сааралтаж ирээд гайгүй болов.

-Хүрээд ирээчээ, явах ажил чинь бүтэх гээд байна. Элчин дээр ярилцлагад орох юм гэсэн шүү. Ярилцлагад орохгүй бол явуулдаггүй юм байхаа. Би ч хүүгээ санаад уйдаж үхэх нь...



Баярболдоо санаад элэг өвдөн, энгэр заамаа нухсаар байтал мөөм сүү орж мэдэх нь... За миний охин бушуухан хүрээд ир. Ээжийгээ аргалахыг л бод. Чи хүүгийн ээж нь юм чинь яахыгаа мэдэх ёстой биз дээ?

Утсаа тавьчихаад Ууганаагийн царай гийн, тун чиг баяртайгаар гал зууханд орж ирэв.

-Хүүг минь авчрах байхаа. Ээж нь явуулахгүй байна гэнэ. Багаасаа үерхсэн хүүхэнтэй шинэ Дарханд уулзсан юм байх. Цаадах нь дагуулан явж өөрөөс нь олон ах хөгшин хар юмтай танилцуулах гэж зовоосон гэнэ. Тэднийг согтуу байхад зугтаж гарч шүү дээ. Одоогийн хүн чоноо чоно... Хэнд ч итгэх аргагүй болж, Ерөө минь бушуухан л ирээсэй.

Ууганаа сайхан цай уух гэж данхаа сэгсэрч үзээд хоосон байхад халуун ус хийн цахилгаан зуухан дээр тавилаа.

Ууганаагийн сэтгэлийн шаналан бага боловч зөөлрөх шиг болов. Гэвч Ерөөг хүүхэдтэйгээ ирэхээс нааш сэтгэл амрахгүйгээ мэдэж байлаа. Тэр хүүхэн ирж, ярилцлага гэдэгт ороод, хамаг ажил нь бүтэн, нэг л сайхан өдөр Буянт-Ухаагийн нисэх онгоцны буудал дээрээс Ерөөг өмнө зүгийн оронд үдэн явуулсан цагт, бяцхан үр түүний гарт бүр мөсөн үлдэж дээ гэж итгэсэн цагт сэтгэлийн нь шаналан арилах байв.

Эм хүний хувьд тэрбээр даан чиг бэрх бүхнийг шүд зуун тэвчиж өнгөрөөсөн билээ. Хажуу өрөөнд амьдарч буй хөөрхөн, залуухан охинд сэтгэл алдраад байгааг нөхрийнхөө хөдлөх хөдөлгөөн, харах харцнаас Ууганаа тэр даруй л мэдсэн. Эмнэлэг дээр жижүүртэй хонох тоолонд ямар нэгэн явдал болж буйг мэдэхээр барахгүй, эр нөхөр ээлжнээс буух тоолонд бод идсэн боохой шиг болж, эм хүний нь хувьд эрхлүүлэн таалахаа байсныг мэдээгүй, бие сэтгэлээрээ мэдрээгүй гэвэл худлаа...

Батбаяр гэхдээ эхнэрээ бүр өөрөөсөө хөндийрүүлэн хаяагүй билээ. Ерөөтэй яаж цэнгээ бол хэмээн бодож, тэр бодлоосоо болоод сэрэл нь хөдлөн нөхрөө тэврэхэд нь Батбаяр ямагт хариу өгч, түүнтэй үүлэн борооны явдалд ордог байсан боловч, тэр бол зүгээр л гэргийнхээ сэтгэлийг бодож ээлж өнгөрөөсөн хэрэг байснаас биш жинхэнэ янаглалын гал дөл гарахгүй байгааг бие сэтгэлээрээ Ууганаа мэдэрч л байсан. Тэглээ гээд Ууганаа яахсан билээ? Эр нөхөртөө үр төрүүлж өгч чадаагүй муу заяандаа гомдоод л суухаас... Саяхан хүүхдээрээ амьтан ирчихээд, хэдхэн сарын дотор эм хүний шинжийг олж, хөх дэлэн нь урган товойж, шим шүүсээр дүүрээд, гар хүрэхийн төдийд хагарч мэдмээр болдог намар цагийн ид болсон цангис жимс шиг, эм хүнийхээ ид сайхан үед бие төлжсөн Ерөөг хараад энэ бол нөхрийн нь хийж буй хэрэг мөн гэж мэдэж байвч тэр хоёрт үр хэрэгтэй байсан болохоор Ууганаа хувь заяаны догшин эргүүлэгт автан дуугүй л тэвчихээс өөр яахсан билээ?

Чингээд хэдэн сар өнгөрөхөд Ерөө жирэмсэн болжээ. Батбаяраас хүүхэд олсон залуу бүсгүй гэрийн эзэгтэйгээс ихэд айж ичиж байгааг Ууганаа эмнэлэгт сувилагч хийдгийн хувьд мэдэж байсан. Тийм ч учраас түүнийг айлгаж ичээхгүй юм сан гэсэн дээ хамаг л анхаарал халамжаа тавих гэж хичээсэн. Шинэ тулгар залуу бүсгүй айж зовох юм бол гэдсэн дэх үрээ зулбах юм уу, ямарваа нэгэн осол зэхий явдалд орж мэднэ шүү дээ гэж тэр болгоомжлов.

Гол нь Ерөө тэднийд эрүүл саруул үр л төрүүлж өгөх ёстой. Тэгээд санаснаар амархан хоёр яс

салав.

Ерөөг эмнэлгээс гарсан даруйд хамаг анхаарал жаахан үрд хандсан болохоор түүнийг арчлах тойвлох гэсээр нэгэн хэсэг Ууганаа эр нөхөр хийгээд Ерөөгийн тухайд бодох санах ч амжил болсонгүй. Ер нь нялх биетэй Ерөө эмчийн хоригоос нааш ямарваа нэгэн юм хийхгүй гэдгийг сайн мэдэж байлаа. Гэвч цаг хугацаа өнгөрөх тусам эм бие нь төлжин, чухам л үлгэрт гардаг шиг ноорхой жаахан охины цаанаас гоо үзэсгэлэн төгөлдөр бүсгүй урган босч ирэхэд Батбаяр түүнээс нь хүслийн харц юугаа үл салгах болсныг ажаадхав.

Ерөө ч хорио цээр тавигдах цаг дөхөх тутам байж ядан, эрхлэнгүй нүдээр нөхрийг нь ширтэн, хоол идэж байхдаа аальгүйтэн түүнийг хөлөөрөө өдөх юм уу, хонгилд зөрөх зуураа хошуу нийлүүлэн үнсэлцээд авахыг нь харах гэдэг Ууганаад ямар хэцүү байсан гэж санана даа. Тэдний хооронд одоохон эр эмийн явдал болоход бэлхэн бөгөөд яаж ч хориод Ууганаа дийлэхгүйгээ мэдэж байлаа.

Үнэхээр ч тэр явдал Ерөөд хүүхдээ орхичихоод түр гарсан тэр нэгэн өдөр болоод өнгөрснийг бүсгүйн өрөөнөөс ханхалсан заар, шинхэгээс Ууганаа даруй мэдсэн...

За дүүрчээ, дүүрч. Яавал яацгааг. Үр минь л наддаа үлдвэл болох нь тэр гэж тэгэхэд Ууганжаргал хувь заяаны догшин эргүүлгийг залж эс чадах мөхөс доройгоо мэдэн боджээ. Ерөө гадуур чөлөөтэй гарах болов. Түүнийг хотоор дэмий баахан тэнэв, сургууль дээрээ очив гэх мэтээр хэлсээр удаж удаж ирсний орой Батбаяр туйлын ер бусын баяртай байхыг харж, нүүр царайны өнгөөр тэд хаа нэгтээ ханатлаа цэнгэжээ гэж мэдсэн билээ. Энэ явдал хир удаан үргэлжлэхийг мэдэхгүй байтал харин Ерөөгийн хөгшин эх ирэв. Тэр бүхнийг санаж бодсоноос өөрөөр эргүүлж, Ерөөг хүүхэдтэй нь авч явсан билээ.

Өөр хүүхэн Ууганаагийн оронд байсан бол энэ гэрээс Ерөөг яваад өгсөнд нь баярлах ч байсан байж магадгүй. Харин Ууганаа хэдэн сар гар дээрээ дэгүүлж дэрвүүлж өсгөсөн нялх амьтанд дэндүү дассан болохоор Баярболдын эзгүйд хуучин шигээ ахиад л хүйтэн дэрээ тэмтэрч үр мөрөөдөн, шөнөд нойрон дундаа уйлах дууг нь сонсож, Ерөөгийн өрөө рүү очих сэтгэлийн шаналгаа зовоож эхэлсэн билээ.

Ашгүй тэгтэл Ерөө ярив. Бодсон санаснаа хэлж санаа нь амраад, өнөө мөдгүй хүү нь хүрээд ирнэ гэж баясан бодлоо. Нялхынхаа үнэрт согтож, гар дээрээс буулгалгүй тэвэрч, жаргалаа эдлэх цаг минь болов уу. Бусад нь ч яамай юу даа гэх зэргээр тэрвээр бодон сэтгэлээ засч билээ.

# АРАВДУГААР БҮЛЭГ

## ЭХИЙН ЗАРЛИГ

Бага зэрэг архи үнэртүүлсхийн, хүнд доромжлуулсандаа гоморхон, нилээд оройтон гэртээ ирэхэд нь хөгшин эх нялх багынх шиг нь даруйхан гөвшихөөр суран тэлээ барин угтжээ.

-Чи хаагуур тэнэж яваад ирэв? хэмээн уурсан угтаж, гэрийн босго алхав уу үгүй юу далан дундуур нь буулгаад авав. Өвдсөн гэж жигтэйхэн. Ерөө:

-Ёо ёо л доо... гэлээ.

-Чи чиг бүр хүнээ байжээ? Ингэж л дэмий тэнэж яваад эцэггүй хүүхэдтэй болсон биз. Манайхны удамд чам шиг завхуул байсангүй. Барагтайхан байгаарай. Мөчийг чинь санжуулаад хаях минь...

Хөгшин эх ахиад хэд ороолгоход харин Хорлоо гуай босч ирэн хөгшнөө хорьж:

-За больж үз. Явж явж ирэхэд нь аяганы амсар ч зуулгахгүй зодоон нүдээн хийдэг чинь юув? гэжээ.

Чадал мөхөс бүсгүй хүүхэд уйлахаас өөр яахсан билээ. Болсон явдалд сэтгэл эвдэрч, өмгөөлөл хамгаалал эрж ирэхэд нь харин урдаас хараал хэрүүл угтсанд нь гомдож барахгүй байлаа. Гэтэл хот руу ярихад нь Ууганаа эгч нь яаж аргадаж, Батбаяр ямар энхрий зөөлөн үгээр тайтгаруулсан билээ?

Ээж нь мөддөө тайвширсангүй. Уур хилэн нь авсаар амархан гарсангүй, суран бүсээ хаа нэгтээ чулуудан зуухтайгаа ноцолдон тогоо тавихын завсар:

-Чи одоо том болов, гараас гарав гэж битгий их зан гарга. Чамайг яахыгаа би мэднэ. Хичнээн сар хэл сураггүй болж шар махтай минь хатаасан чинь багадаа юу? Одоо чи хаашаа ч явахгүй. Чамайг энэ гэрээс гаргах ч үгүй. Тэр баян цатгалан айлд чиний толгой бүр эргэж орхиж. Мань мэттэй зиндаа таарахгүй л хүмүүс билээ. Тэд баянаараа тэндээ, бид ядуугаараа эндээ. Мэдээ? Хүн ер нь өөрийнхөө хирийг мэдэж байхад илүүдэхгүй. Дархан хотдоо үлдэж, өөрийнхөө зиндааны хир тааруу ажилсаг эгэл хархүү олж суугаад эндээ амьдарвал таарна. Хүнтэй суух гэж тэгж л их хүсээд байгаа юм бол манай хамар хашааны Дамбын сайхан баньди байж л байна. Их сургуулиас гараад саяхан цэрэгт алба хаачихаад ирсэн шүү дээ. Хэнээс дутах юм бэ? Нүдтэй бол том нүдтэй, гартай хөлтэй бол гартай хөлтэй, хар ажилд сайн мөрөөрөө сайхан залуу.

Эхийн үг Ерөөг бүр цочролд оруулав. Юу гэнэ вэ? Эх хүн чинь охиныхоо сэтгэлийн зовлонг хуваалцан аль болохоор тайвшруулдаг сан биш билүү? Би эхдээ нялх хэвээрээ, тэгээд хайрлаж дурлах, хамгийнхаа дотно хүнээсээ олсон үрээ түүндээ л өсгөж өгөх эрхгүй хүн болж байна уу? Ээж миний огт мэдэхгүй, зүс ч үзээгүй хамар хашааныхаа хархүүтэй суулгах гээд бүр оноочихсон хэрэг үү? Чухам тэгэх гэж л намайг гэрээс гаргахгүй хашиж, хот руу буцаахгүй байлгаад байгаа хэрэг үү?

Ерөө хоол ч идсэнгүй, цай ч уусангүй, хүүгээ өвөртлөн буруу хараад хэвтгээд өгөв. Толгой нь таллаж хатгаад хүйтэн хөлс цувж байна.

-Үгүй чи бос гэм. Аяга цай ууна байгаа даа. Хоол халаачихлаа. Ерөө эхийн үгийг сонсох ч дургүй байв.

-Чи минь юу болчихоов? Өнөөх хүн хайрладаг өрөвч сэтгэл чинь хайчив? Биед хүрсэн том хүүхэнд өөрийн гэсэн хөөцөлдөх ажил байлгүй л яав гэж дээ зайлуул. Чи дэндүү юм. Ямар өдөр болгон тэнэж биднийг зовоосон биш. Ганц өдөр яваад оройтсон Ерөөг байтугай, өдөр болгон харцуудтай нийлж, архи дарс уун, зочид буудал хэсдэг шөнийн хүүхнүүдийг эцэг эх нь ингэж харааж зүхдэггүй л юм билээ. Яаж байгаа юм. Бүр хэтэрсэн гэдэг нь.

Буурал эцгийн үг Ерөөгийн нулимсыг бүр ч ундруулжээ. Эцэг хүн цаанаа л өөр, уужимхан ухаантай байдаг ажээ. Аавын нь гаансны бохь шоржигнон дугарч, тэрвээр мэнгэртэн ханиав. Өөрийг нь өмгөөлсөн аавынхаа энгэр цээжинд нь нүүрээ наан ханатлаа уйлмаар. Багадаа бас чингэж айлын хүүхэдтэй муудалцан уйлж орилсоор ирэхэд ээж нь хэрүүл хийлээ гэж суран бүсээр ороолгон, ганц том охиноо хэмээн аав нь өмөөрч цээжээрээ хаадаг байсан нь санаанд оржээ. Аавд тэврүүлчихээд байхад ч ээж суран бүсээр ороолгосоор байсан бөгөөд түүний нүцгэн бие хорсгом цохилт аавын цээж, дал мөрийг онож байсан ч эцэг тоолгүй охиноо аварч чаддаг л байсан даа.

Одоо бол авралын од гэмээр аавдаа үнэн учраа хэлж, тамхи ханхалсан энгэрт нь нүүрээ наан сэтгэлээ онгойлгоод, бүх үнэнээ хэлж Улаанбаатарлуугаа буцахсан гэж Ерөө бодож байлаа. Эцэг л юм чинь охиноо ойлгоод хүүг нь эцэгт нь өгөхийг зөвшөөрөх байлгүй.

Багадаа баахан зөрүүд байсан Ерөөг яаж ч аргадаад хоол идүүлж, цай уулгаж чадахгүйгээ ээж нь мэдэв бололтой чимээгүй болов. Магадгүй уурын мунхагаар охиноо дэмий нэг шавхуурдан, хэлэх хэлэхгүй үгээр хэлснээ ухаарсан ч байж болох.

Сэтгэлийн элдэв шаналалдаа ядарсан Ерөө унтаад өгчээ. Хүү нь хажууд нь уруулаа хөхөн зүүд нойрондоо үе үехэн ход ход хийн инээгээд унтаж байлаа. Маргааш юу болохыг огтхон ч төсөөлөөгүй Ерөө ээжид гомдсон гоморхлоосоо болоод хааяа хүүхэд шиг эхэр татан санаа алдах ажээ.

Өглөө эрт аав нь ажилдаа яваад өгөв. Ээж нь түүнийг аргадах болов уу хэмээн хулгайн нүдээр Ерөө сэм харах авч, эх харин уур хилэн нь гараагүй мэт охиноо тоож харсан ч үгүй. Ерөө дэмий л нэг царайчлан эхийгээ аргадан гуйсан харцаар харж хог шороогоо цэвэрлэн, тоос тортогоо арчиж, хүүгийнхээ даавууг угаахаар түмпэнд ус халаав. Дүү нар хаашаа ч юм гүүлдээд алга болжээ. Ээж нь гараад явчихав. Ерөөгийн уур хүрэх шиг болж, би ямар хэрэг хийсэн биш, тэгээд ч насанд хүрсэн хүн өөрийнхөө хувь заяаг мэдэхтэйгээ болсон хүн байна. Үнэнээ хэлээд хүүхдээ аваад явъя байз. Солонгос явах ажил минь бүтээд, намайг ярилцлагад ор хэмээн Батбаяр Ууганаа эгч хоёр дуудсан шүү дээ хэмээн бодлоо.

Одоо эргээд бодоход ээж нь түүнтэй сэтгэл нээн ганц удаа боловч ярилцсангүй. Хотод жил гарангийн хугацаанд хаана байсан, хэнтэй нөхөрлөсөн, хүүхэд хэнээс олсон болоод сургууль соёлоо яасан, цаашид яах бодолтой байгааг нь ер асуусангүй. Хажууд нь хүсэл мөрөөдөл

дүүрэн бүсгүй хүүхэд байна гэж тоож хэлэлцсэнгүй. Ердийн нэг нусгай охин л замаа алдан завхарч яваад ирсэн аятай, бүүр нэг хатуу ширүүн хандсан нь ямар учиртай билээ? Ерөө хэрэв ээж хүний ёсоор түүнд хандан, үнэн үгийг нь сонсьё гэсэн бол болохгүй явдал бүхнээ уудлан ярихад бэлэн л байсан. Гэтэл харьж ирснээс хойш эх нь үгээ хэлж сэтгэлээ нээх тийм боломжийг олгосонгүй. Хэрэв чингэж Ерөөгийн ам хэлийг чангаан үнэнийг хэлүүлсэн сэн бол охины нь хувьд Ерөө байдгаа тоочоод зогсохгүй, солонгос явж ажил хийн, эцэг эхээ тэжээхээр шийдсэн тухайгаа ч ярих л байсан даа.

Энэ мэтийг бодон хүүгийнхээ даавууг угааж, түмпэнд хөөсрөх савангийн хиргүй хөөсийг ажинхан мушгиж байтал гаднаас эх нь нэгэн залууг дагуулан орж ирэв.

Баахан мангардуу царайтай, ичиж эрээлэхийг мэдэхгүй бүдүүлэг харцтай, бие том тэр залуу сайхан хүүхэн хараад ихэд шохоорхсон шинтэй зогсоход эх нь харин:

-За Бадраа чи өнөөдрөөс эхлээд энэ хүүхнийг харна. Гэрээс гаргаж болохгүй. Хэрэв гарвал нь дагаад яваарай. Элдэв эсийн хүнтэй уулзах вий. Архи дарс уух вий. Би өөрөө ажилтай. Хорлоо өглөө эрт яваад өгсөн. Дүү нарынхаа үгэнд ордоггүй хүүхэн байгаа юм. Хичээж надад тус болж үз. Тэглээ гээд чамд муу юм болохгүй. Залуу улс байна, сайхан танилцана биз... гэх нь тэр.

Цэргийн алба хаагаад ирсэн, хар ажилд сайн, гартай хөлтэй бол гартай хөлтэй сайхан залуу хэмээн урд шөнө эхийн магтсан өнөөх хамар хашааны сайн эр энэ ажээ.

Ерөөгийн уур хилэн, цөхрөл гомдол цээжийг харанхуйлан ирэхэд сормуус норгон нулимс сул асгармаар болсон боловч тэрвээр хүчээр биеэ барьж танихгүй хүнд муу муухайгаа харуулахгүй гэхдээ буруу харжээ.

-Та яаж байна аа? Эрүүлүү согтуу юу? Намайг цагдаагаар мануулж яах гэсэн юм бэ? Би дуртай цагтаа цуртай газраа явах эрхтэй шүү. Битгий та намайг зунгаг нь арилаагүй нялх амьтан гэж бодож үз. Эх хүн биеийг нь төрүүлдэг нь үнэн боловчиг, ухааныг нь төрүүлдэггүй шүү. Надад хайрлаж дурласан хүн бий. Арван тавгайд нь анх ханилж, өөрөөс нь арав ах учир ертөнцийн хүмүүний амьдрах учрыг, эм хүний биеэ авч явах жам ёсыг хэлж өгч сургасан эр нөхрөө Ерөөгийн танил нэгэн эгч "миний төрсөн өвгөн" хэмээн тоглоом болгон дууддаг байж билээ. Тэгвэл нийгмийн хог шавхруунд ордогийн даваан дээр Ерөөг татан авч "хүн хийсэн" Батбаяр бол түүний чухам л "төрсөн өвгөн" нь мөн билээ. Тэр сайхан хүнээ энэ нэг мангар хар юмаар солиод Дарханыхан нутгийн оросууд их байдгаар нь "деревин" хэмээн нэрлэсэн хаяа хотын энэ гэр хороололд залуу насаа өнгөрөөх гэж үү?

Цээжний чанадад далд бослого ингэж бадран, зүрхэн дэх нууц хашгиралт чингэж үл сонсогдох авиагаар бүхий бие сэтгэлийг доргион цуурайтах шиг болсон авч Ерөө юу ч дугарсангүй билээ.

-Хүүе чи энэ хархүүгийн үгэнд ороод томоотой байгаарай. Гадуур тэнэх гэвэл санасны чинь гарз гэж мэд. Өнөөдрөөс эхлээд цаашдаа энэ хархүү чиний эр нөхөр шиг л чамайг дагах болно. Тэр хотынхоо танилуудыг, баян тарган хам нөхдөө мартвал таарна. Тэд чамд алс нь тус болохгүй шүү. Сиймхий ч гэсэн гэр минь, сэгсгэр ч гэсэн ээж минь гэж үг бий. Хэрээ мэдэж

довоо шарлуулах цаг чинь болж. Ахиад чамайг завхруулан, Улаанбаатарын хог руу алдахгүй байхаа би мэдье... гээд хөгшин эх уухилсаар гараад явчихав. Ингэж уурлаж уцаарласаар даралт нь ихсэх вий дээ. Гэнэт их уурласнаас цус харвах ч тохиолдол бий шүү хэмээн Ерөө санаа зовно.

Бадраа сандал дээр суун гайхсан нүдээр түүнийг харна. Ерөө түүний өмнө аяганд цай хийж тавиад нүд рүү нь харав. Тогтуухан харцтай юм гээч. Хүүхнээс бага зэрэг бишүүрсхийн харж буй энэ тогтуухан харцтай бор нүд тийм ч тэнэг хүнийх биш, гэмгүй цайлган болов уу гэмээр хүний нүд байлаа. Гэнэт Ерөөгийн сэтгэлд итгэлийн гал сүүмэлзэн асах шиг болов.

Бүсгүй хүнийхээ уран аргыг хэрэглэж гэм, энэ "цагдан хянагч" залууг эвтэйхэн атгандаа оруулж болмоор шиг... Хүү нь сэрж уйлав. Ерөө хүүхдээ авч, өлгийг нь задлахдаа,

-Гадаа татсан хэцэн дээрээс даавуу оруулаад өгөөч! хэмээн гуйв.

-За тэгье ээ, тэгье... гээд Бадраа гарав. Салхинд хийсэн унах вий хэмээн өрөөсөн үзүүрийг нь хэцэнд бөхөөр торгоон уясан даавуу-нуудыг тэр авах гэсээр түр саатах хооронд Ерөө бушуухан ухасхийн замын зардлын хэдэн цаасаа халаасандаа хийн, гар цүнхэндээ замд хэрэглэх хүүхдийн живх, шинэ даавуу сэлт болоод өөрийн ойр зуур зайлшгүй авч явдаг юмсаа цумжуулан далд хийж амжив. Бадраа ороод ирэв. Тэвэр дүүрэн даавуу авчраад хаана тавих билээ гэсэн шиг ийш тийш харжээ.

-Наад орон дээрээ тавьчих. Тэгээд индүүдээрэй. Чи ч өнөөдрөөс эхлээд миний дагуул болж байгаа биз дээ? Бид хоёрыг танилцаж ав гэж ээж хэлсэн шүү. Одооноос хүүгийнхээ даавууг индүүдэж сурсан нь дээр байлгүй. Ийм сайхан залуу өөрөө ороод ирдэг сонин л хэрэг. Эхнэр авах хархүү чинь эм хүнд таалагдахын тулд юм, юм л хийдэг биз дээ?

Намар их ойд болсон самар авахын тулд эхлээд өндөр ургасан хуш модыг зөөлхөн түншиж үздэг шиг л Ерөө, Бадраагийн хүн биеийг туршин үзэх сэн энэ үгийн зориглон хэлж билээ. Түүнийг багад ядуу амьдралдаа нэмэр болгох гэж аав нь дагуулан хээр ойд самарт явсан удаа бий юм. Чингэж түншин үзэх төдийд самрын том боргоцойнууд бороо шиг асгарч байвал сайн болсны шинж бөгөөд бас чиг гэж авахад амархан нь мэдэгддэг ажээ.

Ерөө индүү залгаж, даавуунуудыг хажууд нь тавин, хуучин бүтээлэг дэвсчээ. Бадраа саяхны хэлсэн Ерөөгийн үгэнд зовсхийн зогссоноо хайш хэрэг, гадуур цамцаа тайлан өвдгөн дээрээ цомцойн суув. Удсангүй сайн хатаагүй даавуу халуун индүүнд хайруулан шаржигнах сонсдон, хүүхдийн нялхын үнэр хамар цоргин анхилжээ.

"Энэ залууг аргалж болох хүн байна" гэж Ерөө урамшин бодов. Чингээд хол явах хүн байна даа аягахан хоол идье. Өчигдрөөс хойш хэлэн дээрээ юу ч тавьсангүй гэж бодон хөргөгчөөс мах гарган хөшиглөв. Хүү нь хоолоо идэж, одоо орон дээр тарвалзан, юуг ч юм хөгжилтэй шулганах ажээ.

Хүн зорилготой амьдрах ёстой гэдэг байхаа? Алийн болгон хувь заяаны эргүүлгэнд орж, түүний эрхээр явах сан билээ. Одоо амьдралаа өөрөө шийдэн, хувь заяагаа дагах биш, харин өөрийн ухаанаар залах цаг минь ирэв бололтой. Төрсөн ээж минь уучлаарай. Охин чинь энэ

гэрээс бүрмөсөн явлаа. Явах явахдаа бүр алс Сөүл хүртэл зайлан одох нь ээ... Эхийн зарлиг тушаал хатуу боловч би гэдэг амьтан өөрийн бодолтой, өөрийн хүсэл хайрандаа үнэнч явья даа. Охиндоо та хар буруу санаагүй нь магад. Гэвч таны амьдралдаа сурсан зан, ухаандаа шингээсэн амьдрах ёсны ном сургаалаас би зөрөхөөс л аргагүй нь... Таны ном өөр, миний ном өөр ажээ. Одоо чинь шинэ зуун, шинэ мянган гарчихаад, аливаа хүний эрхийг зөрчсөн хүчирхийллээс салах гэж нийгэм даяараа хичээж байна шүү дээ.

Би эхийн эрхт ёсонд сохроор захирагдан, хамаг хувь заяа, хайр сэтгэлээ зөвхөн танд л мэдүүлж, хуучин цагийн деревенд хэн дуртай хүний дор номхон хүлцэнгүйгээр хэвтэж чадашгүй нь...

Ерөөгийн дотоод сэтгэл ингэж хашгирч байлаа... Халуун зууран дээр тавьсан шөл дэврэн асгаж, хиншүү хярвас ханхлав. Ерөө бушуухан хэдэн гоймон хийж галаа заслаа.

Бадраа сурмаг нь аргагүй хүүхдийн даавуунуудыг ёстой л гялс манас индүүдээд эвхэн тавьжээ. Тэр даавуунуудыг Ерөө авч бааданд боов. Чингээд хэдэн мөч өнгөрөхөд Ерөө, Бадраа хоол аягалан, өөрөө хийж аваад хөлсөө чийхруулан идэж гарав. Залуу эр түүнийг шохоорхон, хүслэнт нүдээр харах ажээ. Хэрэв ихээхэн нүүр өгвөл одоохон дараад авахад ч бэлэн бололтой. Өдий том болж, цэргийн алба хааж чийрэгжсэн эр хүний өсөлтөнд эм хүний шим шүүс нэмэр болоогүй гэх аргагүй. Харин яагаад гэрлээгүй юм бол? Ерөө түүнийг цаашлуулмаар санагдаж,

-Эхнэр чинь яасан бэ? Бодвол хүүхэдтэй л биз дээ? гэж асуув.

-Хм...гээд Бадраа санаа алджээ.

-Яасан? Арай эхнэртээ хаягдчихсан юм биш биз дээ? Бадраа аягатай хоолоо тавиад босоод ирэв. Ерөө тоглоомгүй айжээ.

-Хүүе чи яах нь энэ вэ? гэхийн зуургүй залуу эр түүнийг тэврэн үнсэв. Харин түүний амьсгаанаас архи, тамхи үнэртсэнгүй. Шүдээ угаагүй бололтой нялуун үнэр ханхийжээ. Залуу цааш нь даварч даруйхан эзэгнээд авах гэсэн шиг хар ажлын эвэртэй хатуу гар нь хормой хот сөхөн, өвдөг илээд авахад Ерөө

-Чи байз л даа. Хэзээ гэгээн цагаан өдрөөр тэгж байсан юм бэ? Би ичиж үхнэ шүү. Шөнө... Орой ирээрэй... Би хүлээнэ шүү! гэж шивнэлээ.

Энэхүү найр тавьсан үг Бадраагийн цээжинд найдварын гал бадраав бололтой тэр хүүхнийг оролдохоо больж, хөөрч ирсэн амьсгаагаа даран зогсоход хэлсэн үгээ батлан үнэхээр шөнө түүнийг хүлээх болно гэсэн шиг Ерөө хацар дээр нь зөөлхөн үнсэв.

Хориод минут өнгөрөхөд Ерөө хүүхдээ Бадраад тэврүүлэн, өөрөө цүнх, баадантай даавуу шаавуугаа бариад гэрээс гарч одлоо.

-Шинэ Дарханд очоод ирье. Нэг хүнтэй уулзах хэрэг байна. Хэдэн цаас авах ёстой юм. Хэрэв мөнгө бүтвэл чамд ганц гожин авч өгнө шүү. Уух балгах дуртай л биз дээ? гэж Ерөө хэлжээ.

Балга тагш юмны сургаар Бадраагийн төвөнх дээш доош гүйн шүлсээ залгихыг үзвэл архинд үйлийн үргүй дуртай бололтой.

"Энүүнд чинь ганц шил юм авч өгчихөөд зайлж болох юм шиг байна" гэж Ерөө түүний байдлыг хараад олзшаав. Тэр даруй такси авч шинэ Дархан өөд хурдлан давхилаа. Хүсэл зорилго нь биелэх цаг ойртох тутамд Ерөө догдолж байна. Яаж энэ амьтнаас салах билээ? Хот явах унаа хаа сайгүй бэлэн л байгаа даа. Дагуул эрийг аргалж гэм, ганцаараа унаа аваад явчихсан нь дээр... Очсон хойноо үнэнээ хэлэхэд Батбаяр, Ууганаа эгч хоёр төлөөд л өгнө...

Замын хажуугийн ногоорон буй модод жирэлзэн өнгөрнө. Нээлттэй цонхоор хавар оройн салхи үсээр наадаж байна. Залуучуудын театрын сүрлэг байшин хажуугаар өнгөрөх шиг болов. Өчигдөрхөн Батбаярынхаа дууг сонсон уйлсан олон хотын ярианы шугамтай Дарханы холбооны урдуур такси хурдлан гарав. Удсангүй зам урагшаа эргэхэд гэнэт Ерөөд "Энэ такси хувийнх юмсанж. Гуйвал яваад өгөхгүй байгаа даа?" гэж санаанд оржээ.

-Алив та зогсоодхооч!

Такси зогсов. Олон хүн гарч буй үйлчилгээний төвийн дэлгүүр тээр тэнд харагдаж байна. Ерөө цүнхнээсээ мянгатын гурван дэвсгэрт гарган Бадраад өгч,

-Алив чи гүйгээрэй! Нэг шил сайн архи аваад ир. Бид хүлээж байя! гэлээ. Архины сургаар хөл нь хөнгөрсөн Бадраа мөнгийг авч дэлгүүр рүү гүйв.

-За ах минь дөрвөн хүн суухад хэдэн цаас төлдөг вэ, бүгдийг бэлэн төлнө. Хүү бид хоёрыг Улаанбаатар хүргээд аль! гэж Ерөө гүйв.

-Бензин л авах байхдаа. Тэрнээс биш явахад бэлэн л байна гэж жолооч зөвшөөрөн толгой дохижээ.

-Бушуухан хөдлөөрэй. Энэ хүн нойтон хамуу шиг салахгүй дагаад байгаа юм. Миний эр нөхөр ч биш, танил ч биш... Учрыг би замдаа хэлэмз...

Мөнгө л гэвэл өөр юуг ч үл сонирхох хижээл эр даруйхан тэргээ асаан хөдлөв. Бадрааг дэлгүүрээс гарч ирэхээс өмнө Ерөө хуучин хорооллын орон сууцнуудын урдуур гарсан замаар хурдлан холдсон байлаа.

Алдагдсан бүсгүй

Бадраа дэлгүүрт дугаарлан зогсч байв. Хүн ихтэй оочир нэн удаан урагшилж байх шиг санагдана. Сайхан бүсгүйтэй хамт наргин, хатуухан архиар хоолойгоо норгож, цэнгэн жаргана гэж бодоход хөл газар хүрэхгүй баярлаж байлаа. Хөрш айлын хөгшин тэднийхээр орох тоолондоо охиноо магтсан билээ. Үнэхээр ч сайхан хүүхэн гэдгийг нь хашааны завсраар ажаад Бадраа үнэмшжээ. Эхийн хуучин дээлийг өмсч, түлээ хагалан тэвэрч гэртээ оруулах юмуу, угаасан даавуу хэцэнд өлгөж байгаа бүсгүйд нүдээ ухаж өгчих шахан, эр хүний нь шунал тачаал хөдлөж билээ.



Ийм сайхан амьтантай хөтлөлцөөд явж байх сан гэж Бадраа хармагцаа л боджээ. Харин хангайн согоо шиг ариун дагшин бөгөөд ихэмсэг бардам харагдах бүсгүйтэй яаж ойртон танилцахаа Бадраа мэдэхгүй байлаа.

Тэднийх Увс нутгаас нүүж ирээд удаагүй, ганц жил л болж байв. Зуданд хамаг байдаг малаа үхүүлж, хотоо харлуулаад, эх эцэг санаагаар унаж, цаашид яаж амьдрахаа мэдэхгүй байхад харин Сагиль нутгийн олон айл хот хүрээ бараадна гээд нүүжээ. Том охин нь хүнтэй суугаад Дарханд амьдрах тул түүнийгээ бараадан энэ хотод нүүж ирсэн билээ. Эцэг энд тэнд жижүүр манааны ажилд орж, харин Бадраа цэрэгт байсан тул халагдаж ирээд боломжийн ажилд орж тэжээх буйзаа хэмээн хүлээжээ. Охин энэхүү деревен хэмээх хаяа хотод хашаа авч өгснийх, хөдөөгийн хүмүүсийн зангаар айл аймгийнхаа хүнтэй ний нуугүй танилцъя гэж Бадраагийн хөгшин эх байгаагаас жаахан борцоо цаасанд боон Хорлоогийнд орж билээ.

Ашгүй хамар хашааны хөгшин сайхан зантай нэгэн байж, тэр даруй Бизъяа хэмээх нүүдэлчин авгайтай танилцаад зогссонгүй, эжий ахай болж, сургуульдаа цэвэрлэгч болгож орхив. Тэр цагаас хойш Сагиль нутгийн Хар модон хэмээх газрын дөрвөд авгай Бизъяа, деревен хорооллын олон хүүхэдтэй Даариймаа хөгшин хоёр салахыг байв.

Бадрааг цэргээс ирэхэд эх нь хүүтэйгээ танилцуулсанд, биерхүү том сайхан хүү байна гэсэн үгээр Даариймаа шагнасан нь, хэрэв хот яваад сураг тасарсан том охин байгаасан бол үг дуугүй эхнэр болгоод өгчих сөн гэмээр л аашилж билээ.

Аливаа залуу эрийн ёсоор Бадраа цэргээс ирмэгц хоног төөрүүлэх айл, татаж чангаах хүүхэн хайж, хийчих ажил олдохгүй дэмий л нэг тэнэж хэдэн сарын өнгөрөөхдөө хааяа Хорлоо гуайнд орж хоёр хөгшний түлээ модыг хагалан өгч, саянаас үдэш оройд бага багаар янзлах болсон ногооны нь талбай дээр шороо тэгшлэн, суваг шуудуунд хурсан хогийг хаман өгч байлаа. Тэгэнгээ айлын хоолыг буудах бөгөөд жаазанд байгаа улаан хацартай, нүдэнд дулаахан жаахан охины зургийг шохоорхон хардаг байжээ.

Хэдэн сарын дараа өнөөх охины харин хүүхдийн хамт эх нь хотоос аваад ирэв. Нүд алдам сайхан бүсгүй Ерөө залуу эрийн хүслийн галыг бадраажээ. Угаас бүсгүй хүнтэй сэтгэлийн нарийн торгон утсаар холбогдож явсангүй тул яахан уулзаж нүүр хагарах билээ хэмээн Бадраа шүлсээ залгин байж ядав.

Алба хаан Улаан хуаранд байхдаа хал цэрэг дагаж хичнээн эрийн ч дор хэвтэхээс ч үл буцах "цэргийн бор" хэмээх янхан хүүхний амтыг анх үзэж билээ. Бадраа бүсгүй хүн хараад л хамаг байдаг шим шүүсээ алдчих гэдэг, заримдаа хүүхний өвөрт ормогцоо зорилгоо ч биелүүлж чадахгүй өмдөө норгочих шахдаг дэндүү тачаалтай цочиромхой нэгэн болжээ. Анх удаа олон дайчны нэг болж айлд ганц "цэргийн бор" дээр очирлож эр хүнийхээ хүч чадлыг шавхсан бол, сүүлдээ мөнөөхөн бэлэн хүүхэнтэй сэм уулздаг болж, чухамдаа тэр хүүхэн л Бадрааг шөнийн жаргал цэнгэлд сургаж өгч билээ. Тэр явдал бол ороо нь орсон агсан тайлаг, эсхүл бухан бярууны явдал бөгөөд зүгээр л нэг биеийн чилээг гаргаж, сэтгэлийнхээ шар-хирааг арилгах арга хэмээн басхүү тэр бэлэн эмээс Бадраа анх удаа сонсчээ.

-Чи намайг удахгүй мартана. Би бол зөвхөн чиний түр зуурын дэвсгэр, олон сайхан хүүхэнд хүрэх дамжлага төдий л юм... Чамд жинхэнэ хайр дурлал ирнэ Бадраа минь. Тэр цагт олон

цэрэгт, ганц бөндгөр талх, нормын хоолноосоо илүү-чилсэн шавхруугаар биеэ өгч байсан насаар гуч гарсан хөгшин хүүхэнтэй юу гэж заваарч явав даа гэж чи гэмших болно. Чиний над дээр нөхдөөсөө нуугдан ирдэг чинь хайр биш, зүгээр л эр хүний түр зуурын зугаа цэнгэл төдий юм... хэмээн эр эрхтнийг нь атган, илбэн байж эгчмэд хүүхэн хэлдэг байжээ. Тэр хүүхний хэлдэг хичнээн үнэн болохыг одоо л Бадраа амсч байна. Ерөөг хараад тэр хамаг ухаанаа алдсан билээ. Ерөө бол хаа дуртай цагтаа дараад унаж болдог цэргийн бор биш байлаа. Хэн ч халдашгүй онгон дархан, чухамдаа л ихэмсэг гэгээн Ерөөтэй уулзана гэхээс ч Бадраа ичиж айж, барааг нь хараад байж ядан хэд хонохдоо Даариймаа авгайн амнаас эх Бизъяагийн чихэнд унасан үгсийг сонсчээ. Учир нь гайхал охин нь хот хүрээ явчихаад хүүхэд шуухадтай болж завхарсан хийгээд эмийн сайндаа л Ерөөг хүүхэдтэй нь олж ирсэн нь Даариймаагийн сана-сандаа хүрсэн явдал ажээ.

-Улаанбаатарын харцууд хэцүү. Муу охины минь толгойг эргүүлсэн нэг гайхал цаана нь байгаа... Мэдээжээр тэр нь баян цаггалан амьтан, авгай хүүхэдтэй биз. Охиныхоо амьдралыг тэгж үрүүлэхгүй шүү. Одоо Ерөөг гэрээс нь ч гаргахгүйгээ ээжийн хувьд мэдье. Төрсөн гэрт нь торгоож байгаад өөрс-дийнхөө зиндааны хэр тааруу үеийн хархүүтэй суулгаад үргэлжид хажуудаа байлгах минь... Би чинь эр хүн, гэр орныхоо хувь заяаг би л мэднэ. Харин Хорлоо ямар дуугарах биш, миний үгнээс гарах биш... гэж Даариймаа ярьсан ажээ.

Хөгшин эхийн хэлээд байгаа тэрхүү Ерөөтэй суулгах хэр тааруу нэг зиндааны азтай залуу хэн юм бол? Тэр нь би байж болохгүй юм болов уу? Бадраа яаж Даариймаа хөгшний цээжинд өөрийн орон зайг оруулах билээ гэж ихэд мөрөөдсөн билээ. Гэтэл хувь заяа нэг л өглөө Бадраад үүдээ нээв. Чухам өнөө өглөө л Даариймаа авгай тэднийд орж, тэнэж явчихаад болохгүй байгаа Ерөөг харж цагдуулахаар Бадрааг гуйв... Тэднийд ороод бүсгүйг талтай байхад нь хоол идэхийн завсар сэтгэлээ дийлэхгүй Бадраа барьж авч үнссэн билээ. Тэгээд цааш даврах гэхэд хүүхэн түүнийг өөрөө үнсч таалаад, үдэш орой ирэхийг чинь хүлээе гэжээ. Энэ үг бол би чинийх боллоо гэсэнтэй чанар нэг гэж ойлгоод Бадраа хэргээ бүтээчихсэн мэт баярлаж байтал Ерөө архинд явуулжээ.

Өглөө эрт, дэлгүүр сая л онгойсон тул хүн ихтэй, кассанд ч, архины тасагт ч дараалал дийлдэхгүй хэцүү байлаа. Арайхийн мөнгөө тушааж, олон хүнд шахуулан оочирлосоор сая л нэг шил АПУ архи аваад Бадраа гүйхээрээ дэлгүүрээс гарч ирэв. Мэдээж энэ архийг түүнд л зориулсан хэрэг. Сайхан бүсгүйтэй хундага тулган, өдөржингөө дэргэд нь байж сүрчиг, анхилуун энгэсэг ханхалсан хүүхэн биеий нь үнэрт согтон хамт байна гэж бодоход азын тэнгэр түүнийг ивээж байх шиг санагдана.

Гүйхээрээ гарч ирсэн Бадраа зогсоол дээр мөнөөхөн сууж ирсэн такси харагдсангүйд гайхасхийсэн боловч нэг их сандарсангүй, холдоогүй биз, зогсоол чөлөөлөн замын хажууд гарч зогсоо биз... гэж бодон хайн гүйв. Замын нөгөө талд явах хүн хүлээн хоёр ч такси байв. Тэнд Ерөө байсангүй. Ойр хавь өөр унаа харагдсангүй. Үгүй энэ чинь... Тэр хүүхэн яачихдаг байнаа?

-Зогсоол дээр түрүүхэн байсан шар өнгийн таксиг харав уу? гэж Бадраагийн амьсгаа ихдэж ирээд жолоочоос асуужээ.

-Мэдэхгүй. Намайг энд ирэхэд юу ч байгаагүй шүү. Харин хот ордог замаар нэг шар такси

замд зөрнө билээ...

“Хот ордог замаар...” гэсэн үг гэгээн өдөр аянганд цохиулсан аятай Бадрааг муужруулах шахав.

-Алдчихжээ. Одоо яана?

Залуу эр хамар дороосоо авааль эхнэрээ алдсны дайтай сандрав. Хамаг биеийн хар хөлс сул асгарлаа. Зүрх базлан, сэтгэл гунигаар дүүрч ирэхэд тэрбээр замын нөгөө талд гарч сайхан бүсгүйг өвөртлөх заяагүйдээ гомдсноо тайлах гэсэн шиг ийш тийш харжээ. Гарт нь шил архи л байв. Одоохон түүнийг задлан, амандаа орсон тосыг алдчихсан гаслан зовлонгоо нимгэлэн шилээр нь хөнтрөхөөс аргагүй нь...

Бадраа машины зогсоолоос бяцхан холдоод лонхны бөглөөг шүдээрээ мэргэ онгойлгов. Чингээд дотор муухай оргитол шилээр нь доторхийг залгилжээ. Нүд харанхуйлан, дотор шатах шиг болов. Тархи маналзан тэр даруй хамаг биеэр архины галт урсгал тарах шиг боллоо.

-Ай бас гай яа! хэмээн ганцаараа ярьж Бадраа шилтэйг харвал хэдийнээ талаас доогуур болжээ. Юунаас ч үл айх, хэнээс ч үл ичих мансуурал нүдийг нь бүрхэж ирэв.

-Ай тэр сайхан хүүхэн байсан шүү. Даариймаа гуай түүнийг надад зүгээр өгсөн байтал би хамар дороосоо алдчих гэж байх уу? Үгүй дээ тэр хүүхнийг би олох ёстой. Бүр заавал шүү. Тэр хүүхэн өнөөдөр намайг заллин шил архиар хуурч хот руу зугтсан ч гэсэн, би түүнийг олж авах л ёстой... За тиймээ. Эхэд нь хэлж, Улаанбаатар руу явах нь мөн.

Бадраагийн булингартсан ухаан цэлмэх шиг болов. Архины эхний бие халаалтын дараа ухаан гэнэт цэлмэж, туйлын авхаалжтай, юунаас ч үл буцах үе байдаг шүү дээ. Яг л тэр үед цэцэн мэргэн үг аманд орж, эрэлхэг зориг буй болдог билээ. Ялангуяа шизо өвчтэй хүн чухам тэр үед л хүн хүнээс илүү ухаалаг болон харагддаг. Бадраа ч одоо яг л тийм болов. Тэрбээр тал шил архиа ус мэт залгилаад өвөр түрийгээ ухан, үнгэгдсэн хуучин зуутын дэвсгэрт гарган ирж, таксины зогсоол өөд явлаа.

# АРВАН НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Хөгшин эхийг хонгил цэвэрлээд ид завгүй байхад гадаа үүдэн дээр хүн уулзъя гэж байна хэмээн дууджээ. Даариймаа явдал дундаа шал угаасан нойтон гараа арчсаар хоёр дугаар давхраас бууж ирэв.

Үүдэн дээр түүнийг Бадраа хүлээж байлаа. Тэрбээр бага зэрэг гуйвах ажээ.

-Дарий эгчээ, алдчихлаа! Гэж Бадраа дуу алдав.

-Юу?

-Ерөө хот руу явчих шиг боллоо Уг нь намайг хүлээнэ гээд дэлгүүр рүү архинд явуулсан байхгүй юу... хэмээн Бадраа болсон явдлыг ээрч барин, архинд согтож дультаатан байж ярьжээ.

-Ээ харлаж хоцор...

Даариймаагийн зүрх базлах шиг болов. Эхийн үгнээс зөрж, хажууд нь тавьсан харуул манааг заллин амжсан охиндоо уур нь хүрэв.

-Юу гэсэн хэл вэ! Би чамайг сахин хамгаал гэж итгэж найдсан байхад... Ерөөг олж ирэхгүй бол болохгүй. Тэр бүр замаа алдана шүү гэж хэлэхдээ хөгшин эх нэгэнт л завхуул зайдан охиноо аюулаас аварч авчирсан гэж үзэх тул, дахиад их хотын тоосон дунд алдвал, Ерөө эх, эцгийнхээ чихийг халуу-цуулсан эм хүний бусармаг замд орно гэж булай айв. Одоо яах билээ? Хойноос нь явахгүй л болохгүй. Тэр хөөрхөн жаахан зээ хүүгээ эхтэй нь бүр явуулаад сураг тасарч болохгүй...

-Би хойноос нь явъя. Ерөөг олоод ирж чадна. Та харин надад Улаан-баатарын хаанаас түүнийг олж болох газрыг зааж өг! хэмээн Бадраа хэлжээ. Тэр залуу овоохон балгасан нь илт. Одоо бүр согтох тийшээ хандсан нь ил байв. Гэвч эр хүн хэзээ сайхан хүүхнээс буцаж байлаа. Залуу хүн байна, энэ лав аваад ирж чадах даг шүү. Яахав даа, Ерөөгийн ав гэсэн архийг л уучихаа биз. Охинд хөл алдаад, гэнэт зугтчихсанд нь гомдоод балгачихаа биз...

-Намайг явуулчих л даа. Хаягийг нь заагаад аль. Би ямар ч аргаар хамаагүй Ерөөг аваад ирье. Харин надад замын зардал алга... Аавын цалин буух болоогүй. Би ямар ажил албатай биш... Хэрэв та Улаан-баатар очих зардал өгдөг юм бол би одоохон гарахад ч бэлэн байна...

“Энэ хархүүг явуулахаас л аргагүй болж дээ” гэж Даариймаа бодон дан дээлийн-хээ өвөрт гараа хийв. Тэрхүү хуучин дан дээлийн дотор энгэрт бяцхан халаас хийн мөнгөө түүнд нуусан байлаа. Даариймаа хэдэн цаас гаргаж өгөөд,

-Чи эр хүн байна даа, цаадахаа олоод ирж чадна гэж итгэе. Эхийн өврөөс гарч үзээгүй нялхаараа шахуу амьтан юм шүү. Битгий зодож нүдээрэй. Эвийг нь олоод Ерөөг хүүтэй нь аваад ирдэг юм бол чамаас би юугаа ч хайрлахгүй шүү! гэж Батбаярын байрыг яаж олохыг зааж өгөв.

-Хэрэв цаадах чинь ирэхгүй энээ тэрээ гээд байвал зээг минь аваад ирэхийг бод. Харин замдаа сайн асарч үзээрэй! Тугалыг нь туугаад ирэхэд үнээ дагаад л ирдэг юм. Хүүгий нь аваад ирэхэд тэр дагахгүй хайчих вэ! гэжээ.

Хөгшин эхийн ярьсан зүйлийн дотроос энэхүү “юугаа ч хайрлахгүй шүү” гэсэн үг, өглөөхөн “Залуу улс танилцана дотносоно биз” гэж хэлсэнтэй нийлээд охиноо чамд өгнө шүү гэсэн утгатай үг болох шиг санагдахад Бадраагийн согтуу толгойд, тэрхүү нүд алдам сайхан авхайг өөрийн болгох цаг минь ирэв хэмээх хүсэл бадарч, баярлаад гарч гүйжээ.

Хүн янз янзаар согтдог. Зарим нь даруй унтаад өгдөг байхад зарим нь унан унатлаа салдархийлэн гагцхүү нэмж уухын донд автан тэнэдэг. Бадраа бол сүүлийнхэд нь хамаарах бөгөөд барагтай бол унахгүй. Айхтар сүрхий агсан согтуу тавихгүй болов чиг, маргааш нь хаана явсан, юу хийснээ санаж чадахгүй. Гадна талаас нь харахад Бадрааг жаахан халамцсан болохоос биш, ухаанаа алдчихсан явна гэж хэн ч үл анзаарна. Чухам ийм дээрээ л одоо Бадраа ухаангүй согтуу хэрнээ хүний хийдгийг хийж, ярьдгийг ярьж явлаа.

Тэрбээр сургууль дээр Даариймаа хөгшнөөс хэдэн цаас салгаж аваад гарахдаа ахиад нэг шил архи авахаа ч мартсангүй. Түүнийгээ шимэн уусаар бүр больсон гэвч унасангүй, харин галт тэрэгний буудал дээрээс тасалбар авч, одоохон ирэх вагоныг хүлээх завсраа ихэд өлссөн тул гудамжнаас хэдэн хуушуур авч идэв.

Халаасанд нь талаас дээхнүүр архитай лонх байв. Хааяахан түүнээсээ балгаж, согтуу гөлийсөн нүдээр эргэн тойрноо харах ажээ. Энэ хотод таних хүн олонгүй билээ. Цэргээс ирээд удаагүй байв. Ажил төрөлд ороогүй, үе тэнгийн танил залуучуудтай ходийрхон балга тагшийг хувааж уусангүй уджээ. Халаас хоосон тул яалтай билээ дээ...

-За яахав. Ерөө чамайг би олоод ирнээ. Тэр цагт дахиад зугтаад үзээрэй. Ээж чинь надад өгөх биз. Нэгэнт эхнэрээ болгоод авчихсан хойно чамайг алдана гэж гонж...

Аливаа согтуу залуу эрийн хуял тачаал хөдөлж ирдэг нь зан тул, Бадраагийн хамаг бие залуу сайхан Ерөөг санах тутам бадайран байж тэсэхийн аргагүй болгож байв. Хэрэв энэхэн үед мөнөөхөн “цэргийн бор” тааралдсан сан бол Бадраа юу ч бодохгүйгээр түүнийг дагах байсан биз ээ. Бадраа сандал дээр суун түр зуур зүүрмэглэж аядаад, босч холхисоор байтал галт тэрэг ч ирж, тэрбээр архиныхаа сүүлчийн шавхрууг долоох нь халаг хөнтрөөд аян замдаа гарав.

xxx

Хөлсний тэрэг толийсон сайхан замаар хурдлан байлаа. Хавар оройн урихан зөөлөн салхи санчигны үс хийсгэн үлээнэ. Дарханаас холдож хуучин сангийн аж ахуйн хажуугаар гарахдаа сая л Ерөөгийн дотор онгойж муухан инээмсэглэх аядав.

-Ашгүй дээ... Ямар ч гэсэн замдаа гарчих шиг боллоо! гэж бодохуй, энэ хорвоод хамгийн хайртай хүндээ үрийг нь тэврэн очиж яваа шүү гэсэн бардам бодол толгойд нь орж ирэв.

-Гар чинь чилэхгүй байна уу? Хойт талд тухлаад хүүгээ суудал дээр тавихгүй юу даа? Зам

сайхан, донсолгоо барагтай л бол гарахгүй. Хүү чинь унтаад л явах, уйлахыг мэдэхгүй баатар эр юм... гэж жолооч аж ахуй өнгөрөөд морь харахдаа хэлжээ

Ерөө буув. Гадуур хувцсаа тайлж, хүүгээ арын суудалд тавин ивж өгөөд биеэ сул орхин тааваараа болов. Машин цааш довтолгон одлоо. Хүний амьдрал таагдашгүй оньсого юм. Ээж яахлаараа намайг замаа алдсан завхуул гэж бодоод байгаа хэрэг вэ? Бүр гомдмоор гээч... Хүүхдийн эцэг хэн бэ гэж асуухад нь намайг тоймтой юм хэлээгүй болохоор хоноцын хүүхэд гэж ойлгов уу? Аль нэгэн эрд биеэ өгч явдаг замбараагүй амьтан болжээ гэж бодов уу?

Гэвч сэтгэлд байгаа хамаг нарийн нандин нууцаа Ерөө дэлгэхээс айж байлаа. Дарханаас ирээд Бат-баярынд хонохдоо зээ хүүгээсээ салаагүй ээж нь тэр жаахан амьтан гэрийн эзэнтэй яасан адилхан юм бэ гэж бодоогүй өнгөрсөн гэвэл худлаа. Харин ч сайтар ажигласнаар барахгүй, гэргий ханьтай хүний хүүхдийг гаргаад хажууд нь юу ч болоогүй юм шиг сууж байгаа охиндоо зэвүүрхэн учиргүй яаран буцсан ч байж болох шүү дээ.

Гэртээ хариад Ерөө ээждээ үнэнээ хэлье гэж хэд дахин оролдсон боловч эх нүүр өгсөнгүй тул яаж ч чадсангүй. Эх нь ч охиныхоо үгийг сонсьё гэж бодохгүй гагцхүү буруутгах талаас нь дэндүү хялайн харж, нарийн зовлонг нь сонссонгүй. Тэгээд ч зогсохгүй Ерөөг буцааж явуулахгүй хэмээн заналхийлж, бараг л Бадраа мэт хар хүүд хүчээр өгөх ухааны юм боджээ. Тэр бол гэртээ байхдаа нэгэнтээ Ерөөгийн бодсноор, эхийн эрхт ёсонд хэт шүтсэн ээжийн хуучны ухаан, хүүхдийнхээ сэтгэлийг үл ойлгон гагцхүү өөрийн туулсан амьдралд тархи толгойд нь бат нотоор шингэсэн эртний үзэл онолтой нь холботой байлаа. Хуулийн дээдэд хагас дугуу боловч суун, багш нарын хичээлээс хүний эрхийн тухайд зөрчигддөг наад захын зүйлийг олж мэдснийхээ хувьд Ерөө тийм дүгнэлтэд хүрэхээс аргагүй байлаа. Үе цаг өөр болж шүү дээ ээж минь...

Таны ухаан таныхаар дуусч, шинэ үе бидэнд өөрийн жам хуулиа зааж байна биш үү? Гэж тэгэхэд ерөө бодсон сон. Тэгэхдээ айлын эзний нууц амраг нь болж, хань бүлтэй хүнээс хүүхэд олсноо зөвтгөсөн хэрэг биш гэдгээ ерөө мэдэж байлаа.

Ээжийн нь шүтэн биширдэг бурхны номонд хүн гээч амьтан зөвхөн амин хувиа бодож болохгүй, ертөнцийн хүний төлөө буян хийх ёстой гэж айлддаг биз дээ? Хэрэв тэгж л хүн буян хийх ёстой нь үнэн юм бол, би яагаад хайртай болсон хүнийхээ сэтгэлийн гунигийг тайлан, насаараа мөрөөдсөн үрийг нь төрүүлж болохгүй билээ? Тиймээ, би батбаярыг л бодсон... би түүнийг үрээ тэвэрч жаргаасай гэж хичээсэн... хэрэв би өөр хүнээс хүүхэд олсон бол, хотод өдий төдийгөөрөө байгаа үр хөнддөг эмнэлэгт очоод урагаа задруулж болох л байсан...

Хот руу хар хурдаараа давхиж яваа тэргэнд бодол болон явсаар нэг мэдэхэд ерөө түр боловч үүргэлээд авчээ.

-охин минь хоёулаа хоол иднэ байгаа? Хүүхдээ ч хуурайлах цаг болсон болов уу? Одоо улаан-баатар юухан байхав... гэж жолооч сайхан зантай хижээл ах ерөөг сэрээжээ.

-бид хаана ирчихээд байна? Гэж ерөө нойрмог-дуухан асуув.

-борнуурын аж ахуйн хавьцаа ирээд байна. Эндээс хот зуу гаранхан км шүү дээ. Хөгшин ахын нь цай холдоод толгой ангалзаж, нүд бүрэлзээд болох биш... аяга сүүтэй цай уугаадхая. Чи хоол идмээр бол ороорой. Гуанзанд хүн цөөхөн байх шиг байна... гээд жолооч тэрэгнээсээ буув. Энэ сацуу баянболд сэрж уйлагнажээ. Ерөө хүүгээ өвөр дээрээ авлаа. Хамаг нүүр нь хөлс болжээ. Их халууцсан шинжтэй байв. Ерөө даавуу бэлдэж санаанд ч орсонгүй шууд өлгийг нь тайлан задгайллаа. Хүүгийн даавуу нойтон байв. Өглөөхөн бадраагаас нууж цүнхэндээ хийсэн угжийг авч хөхөлтийг нь амандаа хийв.

-ээж нь чамайг одоохон хуурайлаадхая. Тэгээд гуанзанд орж сүүг чинь халааж өгье. Ээж нь ч юм идмээр л байна... гэж хүүтэйгээ ярьсаар даавууг сольж, буцааж өлгйдөөд угжийг авч хоолны газарт орлоо.

-охин минь наашаа суу. Би та хоёрт хоол захиал-чихсан. Их сайхан хийцтэй цайтай юм... гэж жолооч ах найр тавин угтаж

-алив угжийг нь өгчих. Би гуйгаад халаагаад өгүүж... гээд авав.

Хагас цаг өнгөрөхөд ерөө хүүгээ тэврэн суусан хөлсний тэрэг улаанбаатар ордог замаар цааш хурдлан давхиж явлаа. Баярболд хөвгүүн үе үехэн уйлагнана. Анхандаа ерөө тоосонгүй. Хол замд машин дотор гэдэс нь зайлагдсан юм болов уу гэж таав. Уг нь нялх хүүхдийг хол авч явахад тарианы жижигхэн шилэнд ус хийн өлгийнөөс нь зүүвэл хүүхдийн гэдэс зайлагдахгүй гэж ээж нь хэлдэг, дүү нарыг ийш тийш багад нь авч явахдаа чингэдэг байсныг ерөө одоо саналаа. Бас харанхуй шөнөөр авч гарахдаа айгуужин хэмээн хамрыг нь хөөгөөр буддаг ч ёс бий. Тэр бүхнийг ерөө мартжээ. Өнөөдрийн хувьд бадрааг аргалж зугтах гэсэн болохоор юун тарианы шилэнд ус хийхтэй манатай яаран гарчээ.

Ер нь одоо бодоод байхад ерөө бусдын үүрэнд өндгөө тавьж бусдаар даруулдаг хөхөө-ний үлгэрээр, төрсөн үрээ өөрөө бага асарчээ. Төрөх газраас гарснаас хойш ууганаа эгч л хамгийг хийн жаахан хүүг асарч бөө-цийлсэн билээ. Тэднийд байхад сүүл сүүлдээ овоо нэг хөөрхөн инээх болсон үеэсээ ерөөг эхийгээ гэж маасганахгүй, харин уу-ганааг хараад дэгэж дэрвэн гараа сарвалзуулан түүн рүү тэмүүлдэг болсон билээ. Дарханд очсон хойноо ч ерөө хүүгээ нэг их авсангүй. Ээж нь л бөөцийлж, дүү нар нь ээлжээр гар дээрээ аваад ерөөд амар байжээ. Одоо гэтэл яг цаг тулаад ирэхэд эхийн хувьд хүүхдээ өвөр дээрээ асрах болоход ерөө аргагүй л юм юмыг нь мэдэхгүй самгардахад хүрэв.

-наад хүүхэд чинь яагаад уйлагнаад байна? Уг нь уйлдаггүй баатар эр шиг билээ? Гэж жолооч ах санаа зовов.

-харин тийм байна... за гайгүй байлгүй дээ. Хот ч дөхлөө... асрагч ээжид нь л бушуухан хүргэхээс...

Үнэхээр машин шар хөвийн дөрөлжийг давж, газрын уруу хурдлан давхисаар нэг л мэдэхэд их хотын бараа харагджээ. Тэр өдөр батбаярын даяхан баруун тийш тонгойсон наран дахин эргэж мандсан шиг бөөн баяр хөөр, аз жаргал авчран, хүсч мөрөөдөж байсан нялх хүүгээ тэвэрсээр хөлсний тэрэгнээс ерөө бууж ирсэн билээ. Харин баярболд хөвүүн үе үехэн уйлагнасаар л байлаа...

Ерөөг улаанбаатар хотод ирсний маргааш галт тэрэгнээс бадраа бууж билээ.

\*

Хүүхэд уйлагнаад шөнө-жин тавиулсангүй. Ерөө, ууганаа хоёр ээлжлэн тэвэрсээр шөнө нойргүй хоножээ. Духыг нь дарвал халуун байв. Ер бие гар хүрэх төдийд худалч хүнд түлчихмээр халуун гэж жигтэйхэн... баярболд хөвгүүн уухилан амьсгаадаж, өвдсөндөө уйлагнах ажээ.

-ээ та минь эмч дуудна байгаа... хатгаа, ханиад туссан юм уу хэн мэдлээ дээ. Эртхэн эмчид үзүүлсэн нь ононо шүү. Одоохон түргэн тусламж дуудаад өгье.

Ерөө, ууганаа хоёроос дутахгүй сэтгэл зовж бараг цурам хийлгүй хоносон батбаяр сандрав.

-миний охин замдаа хүүгээ задлаж хуурайлсан уу? Гэж ууганаа аядуухан асуулаа.

-бор нуурын цаахна, замын гуанзанд хоол идээд уйлаад байхлаар нь машин дотроо задлаж хуурайлсан юм. Тэргэнд халууцаад жигтэйхэн хөлөрчихсөн, даавуу нь нойтон байсан... гэж хүүгээ өвтгөсөнд буруутан болов хэмээн аяархан, гэмшингүй өнгөөр ерөө хэлжээ.

-салхи цохиулж дээ. Аягүйд бол хатгаа авснаас зайлахгүй. Хөлстэй байхад задладаг чинь л буруу болж дээ. Барагтай бол ингэж уйлагнадаггүй баатар хүү шүү дээ миний хүү чинь... юу ч гэсэн тариад үзье! Гээд ууганаа гэрийн эмийн сангаас ханиадны тариа авч, нэг удаагийн тариур бэлджээ.

Хүүгээ тариулахад их өвдөнө гэж бодоод хулчийсхийн батбаяр нөгөө өрөөнд оров. Ерөөд тариа аймшигтай байсан боловч хүүгээ барьж өгөхөөс л аргагүй болов. Зүү маханд нь ормогц хүү часхийн чарлаж билээ. Яг энэ үед хаалгыг хэн нэгэн хүчтэй чангаар бөмбөрдөн цохив. Хүүхэд тариулж байхад хэн ирдэг билээ гэсэн шиг ууганааг гайхан харахад батбаяр үүд рүү явснаа гэргийнхээ сэрэмжилсэн харцтай тулгарч хүлээнэсхийв.

“хэн ч байсан битгий хаалгаа онгойлго. Хүүхэд өвдчихөөд байхад, тэгж зочин гийчин урьж оруулаад байх хүсэл алга” хэмээн ууганаа нүдээрээ хэлж байлаа.

Гэмт хэрэгтнийг эрж яваа цагдаагийнхан л ингэж хамаа бусаар хаалга үүд цохидог байх. Хөгшин ээж нь ерөөгийн хойноос хүн явуулсан юм биш биз? Ямар ч л гэсэн үгэнд нь орохгүй наашаа яваад өгсөнд ээж дуртай байгаагүй нь мэдээж... тэр мөртөөсөө бүр хүнээр харуулж цагдуулаад байхад ерөө “оргочихсон” болохоор дэлбэртлээ уур-лаад хэн нэгнийг зарж, тэр охиныг хүүхэдтэй нь олж ир хэмээн явуулсан ч байж болох... ингэж бодсон учраас ерөө хаалгаа тайлж өгөөгүй батбаярын зүг талархан харсан ажээ.

Хаалганы цаана зогсоо хүн хэдэнтээ хаалга балбаад, хүнгүй байна гэж бодсон уу тэгэсхийгээд яваад өгөв бололтой чимээ тасрав.

Ахиад нэгэн шөнө өнгөрлөө. Хүүхэд цагаар тариулсан боловч засрал авсангүй. Уйлагнах нь улам их болж, заримдаа царай нь хөхрөн нэг удаа таталт өгөх шиг болов. Ерөө зовлон үзээгүй



залуу бүсгүйн зангаар тэрхүү аймшиг түгшүүр дохиолсон таталтыг мэдсэнгүй. Харин үхэл, хагацалд ойр олон удаагийн тийм явдлыг сувилагчийн ёсоор үзэж туулсны хувьд ууганаа сэтгэл зүрхээрээ мэдэрчээ. Тэр битүүхэндээ, далд сэтгэлдээ ухаангүй айв. Юм үзээгүй гэнэн цайлган ерөөг айлгаж цочоохгүйсэн л гэж бодлоо.

-аль вэ батаа минь түргэн дууд. Эмнэлэг бараадсан нь дээр юм шиг байна. Би л аваад хэвтэхээс яахав... хэмээн ууганаа санаа зовов.

Батбаяр тэр даруй л түргэн тусламж руу хонходлоо.

-хүүхдийн нэр хэн бэ?

-баярболд...

-овог?

-овог уу? Овог... гээд батбаярыг түгдрэхэд ууганаа утас авч,

-батбаярын баярболд гэдэг юм аа хүү минь... хатгалга туссан шиг байна. Түргэлж л үзээрэй гэлээ.

-би авч хэвтдэг юм бил үү? Гэж эхийн хувьд сэтгэл зовж ерөөг дуугарахад ууганаа одоохон түүнээс өрсөөд жаалыг тэврэн түргэний тэргэнд орчих нь уу даа гэсэн шиг сандрал

-юу гэсэн үг вэ. Би авч хэвтэнэ. Өнөө маргаашгүй элчин яаман дээр ярилцлага болох гэж байхад... Чи охин минь ажлаа л бод. Хүү бид хоёр дажгүй! Гэжээ.

Энэ гурван хүн нэгэн үзүүрт сэтгэлээр бяцхан хүүгийн төлөө сэтгэл зовж байлаа. Баярболд халуурч бүлээрэн өвдснөөрөө уу-ганаагийн зүрхийг зүсэн алдам сандралд оруулав. Тэрбээр одоохон хүрээд ирэх түргэн тусламжаар хүүг тэврэн явахад бэлдэж, хувцсаа солин, хөнгөн шаахай, гэрийн халаад, толгой боох алчуур сэлт, ойр зуур хэрэглэх юмсаа цумжуулав. Түүнийг эмнэлэгт хэвтсний араар энэ гэрт юу болохыг тэр төсөөлөх ч сөгөө байсангүй. Энэ хорвоод түүнийг гэж ирсэн бяцхан үрийг л өвчин зовлонгоос нь салгаж гэм, бусад нь ч яамай юу даа гэж бодов. Болдог юм хэдийнээ болоод л өнгөрсөн. Тэр хүүтэй болох л гэж сэтгэлийн шаналгаа бүх-нийг давж туулсан... нөхөр ханьдаа ч хэлэх үгээ ойлгуулсан.

Ууганжаргалд ганцхан хүсч мөрөөдсөн хүн нь энэ бяцхан үр шүү дээ. Батбаяртай үйлийн үргүй адилхан жаахан амьтан гэнэт өвдсөн нь ууганааг ухаан алдатлаа аяхад хүргэсэн... түргэн тусламж бушуухан л ирээсэй. Хүү минь л эрүүл саруул болбол өөр юу ч надад хэрэггүй...

Ууганааг ийнхүү бодол болон сандарч, юм юманд хүрч алдан, сэтгэл гэгэлзэж, хөгшин хүн шиг уймарч байхад батбаяр харин түүнээс дутахгүй зовж, дэмий л гараа нужигнуулан байн байн хуруугаа атгаж, шархтсан баавгай шиг өрөөн дотуураа нааш цааш алхах ажээ. Тэрбээр цонхоор шагайн түргэн тусламж ирж буй эсэхийг харж байлаа.

Өөрийн яс махны тасархай, нууцаар боловч олдож, эрүүл мэнд төрсөн атал одоо зуурдын

өвчинд нирвэгдсэн нь батбаярын сэтгэлийг зовоохгүй байж яахан болох билээ. Хэрэв азаар олдсон үрээ өвчин зовлонгоос болж алдахад хүрвэл батбаяр галзуурах буй заа.

Ерөө энэ мэт хүүхдийн өвдөхийг эх хүний хувьд олонтаа үзээгүй болохоор, өөрийн арчаагүйн харгай-гаар баярболдыг өвдүүлэв хэмээн биеэ харааж барахгүй байлаа. Энэ өвчин зовлон эхийн үгэнд орохгүй оргон зайлсны гай биш байгаа даа гэж хүртэл бодож үзэв. Тэрбээр дарханаас холдож, хонгорын сангийн аж ахуйн хажуугаар гарахдаа л сая санаа амарч билээ.

-батбаяр минь би эрх чөлөөтэй болов. Хүү бид хоёр чинь чам руугаа довтлон хурдалж явна. Ямар их аз завшаан бэ? Хэдхэн цаг давхиад л чинийхээ хонгор сайхан царайг харна. Бид хоёрыг гэнэт хүрээд очихоор батбаяр яасан их баярлах бол? Үрийн мөрөөдөл болсон ууганаа эгч хүүг минь их санасан байгаа даа...

Ерөө сэтгэл бадрангуй явсан. Харин тэрбээр сэтгэлийн хөөрөлдөө автаад болгоомж алдан машин дотор хүүгээ хуурайлж салхи цохиулжээ. Одоо яана? Ууганаа эгч аваад хэвтэг дээ. Сэтгэл нь дэвтэг дээ зайлуул. Тэр хоёрыгоо гарч иртэл би эргэж тойрч, ууганаа эгчид хоол зөөж хүлээхээс...

Сэтгэлийн хямрал, өөрийгөө буруутгасан зэм-лэл нь ерөөг ядрааж орхив. Удсангүй түргэний тэрэг дохиогоо хангинуулсаар ирж гадаа зогсох дуулджээ. Ерөө эмчид цай өгөх гэж аяга угаан, батбаяр яахаа мэдэхгүй гараа базлан зогсч, ууганжаргал хүүгийнхээ өлгийний бүсийг тайлав.

Шатаар өгсөх хүний хөлийн чимээ сонсогдсноо хонх дарав. Батбаяр гүйх шахам очиж хаалгаа нээлээ. Цагаан халаадтай түргэний эмч баярболдыг үзчихээд

-хоёр уушгиндаа хат-гаатай байна. Эртхэн дуудахгүй яасан юм бэ? Одоохон хэвтүүлэхгүй бол болохгүй гэжээ.

Баярболдыг тэврэн ууганааг гарахад ерөө цүнхийг нь барин, харин батбаяр эмчээс хаана аль эмнэлэгт, чухам аль тасагт хэвтэхийг асуусаар шатаар урууджээ. Тэд түргэний машины хажууд очин, ууганаа хүүгээ аваад суув. Эмнэлэг рүү хамт явмаар байсан авч түргэний тэргэнд сахираас өөр хүн суулгасангүй тул батбаяр, ерөө хоёр үлджээ. Яг энэ үед ерөөгийн гарч ирэхийг отон хүлээж байсан бадраа байшингийн булангаас гарч ирэв.

Хүний хөлийн чимээнээр эргэж хараад Ерөө, Бадрааг шууд л таньжээ.

- Явъя! Такси аваач! Ерөө хашгирах шахам хэлж одоохон Бадраа түүнийг бариад авах вий гэсэн шиг Батбаяраас зуурав.

Батбаяр гайхасхийн түүний зүг харснаа холгүйхэн байх автобусны буудал өөд Ерөөг хөтлөн гүйлээ. Бадраа ч хойноос нь ухасхийв.

Ашгүй буудлын наахна хажуу замаас орж ирж буй такси тааралджээ. Батбаяр гараа дохин зогсоож мань хоёр бушуухан суун давхиж одлоо.

Эх нялхсын төв рүү чиглэсэн замаар хурдлаж яваа такси дотор суусан Ерөө үе үе эргэн харж Бадрааг хойноос хөөх вий хэмээн сэрэмжлэх ажээ. Залуу бүсгүйн хүүхэн хараа томорч, юунаас ч юм айсан шинжтэй байхыг Батбаяр ажаад “Энэ минь хүүдээ сэтгэл нь зовоод байна уу даа? Аргагүй ээ аргагүй” гэж боджээ. Тэрбээр хүүхнээ тэвэрч, тайвшруулсан үг хэлэн үнсэж таалмаар л байв. Гэвч такси дотор танихгүй жолоочийн дэргэд яалтай билээ дээ. Дэмий л нүдээрээ энхрийлэн “Зүгээр. Битгий зов. Хүү эмнэлгийн бараа харсан тул дажгүй” гэж харцаараа хэлж явлаа.

Тэднийг Эх нялхсын төвд буугаад дотогш ороход түргэн тусламжийн эмч зөрөн гарч ирэв.

- Хүүхдийг хэвтүүлчихлээ. Одоохон тариа хийнэ. Гайгүй биз... гээд эмч Ууганаагийн хүүгээ авч хэвтсэн тасгийн ноймрыг хэлжээ.

Ерөө уйлав. Сүүлийн хэдхэн цагийн дотор болсон үйл явдлууд залуу эхийг ядрааж орхижээ. Тэрбээр хүүдээ сэтгэл зовж байлаа. Түргэний эмч үзчихээд хоёр уушгиндаа хатгаатай байна гэж хэлсэн нь Ерөөг цочролд оруулж билээ. Нялх үрээ ийм болгосон гол буруутан би шүү дээ гэж бодохлоор Ерөө байж ядна. Тэр уг нь нялхыгаа эхийн хувьд аваад эмнэлэгт хэвтдэг ч байж уу даа гэж бодов. Тэгтэл сэтгэл санааны тэрхүү хямралыг сэдрээн Бадраа гэнэт гараад иржээ. Гэрийн гадаа Ерөөг бариад авах шахсан шүү. Бадраа яах гэж ирэв? Хэн түүнийг явуулсан хэрэг вэ? Ерөөгийн байгаа газрыг хэн хэлж өгөв? Мэдээж ээж л түүнийг явуулсан байж таарна. Үг сүггүй зугтсан охиноо ээж олж ир хэмээн залуу эрийг явуулж шүү дээ. Одоо яана? Хүүгээ яах билээ? Бадраад баригдахгүй яаж зугтах билээ?

- За тайвшир. Нэгэнт эмнэлгийн бараа харсан юм чинь хүү одоохон эмчилгээнд ороод гайгүй болох биз... хэмээн Батбаяр хүлээн авах газар Ууганаа байхгүй, хэдийнээ тасаг руу одсоныг мэдээд уйлж охилсон Ерөөг тайтгаруулан мөрөөр нь тэвэрч гарахдаа хэлэв. Үүднээс бяцхан холдоод Ерөө хүн амьтангүй газар хайртай хүнийхээ цээжинд нүүрээ наан мэгшиж гарлаа.

- За битгий уйл. Тайвшир л даа. За... Алив би чамайгаа үнсье... хэмээн Батбаяр өчнөөн хоног санасан сэтгэлээ илчлэх гэсэн шиг залуу сайхан амрагийнхаа нойтон хацар, зөөлхөн уруулыг үнсчээ.

Хайртай хүний нь сайхан үнсэлт нэг ана боловч Ерөөг тайтгаруулав. Залуу бүсгүйн эрхлэнгүй том алаг нүдээ арчин Батбаярт улам лав тэврүүлээд санаа алдав.

- Хоёулаа одоо харья. Ууганаад цай, хоол бэлдэхгүй бол болохгүй. Тасгийн нь утас байгаа юм чинь хүүгийнхээ биеийг асуугаад байж болно шүү дээ. Сая сандраад мартчихаж. Ууганаадаа гар утсаа өгдөг байж... За явья...

Батбаярт хөтлүүлэн явж байхдаа Ерөө бүр тайтгарсан байлаа. Одоо л тэр үг хэлэх тэнхээтэй болжээ. Хайртай хүндээ шулганан ярих юм нэн их байв. Гэвч сэтгэлийн мухарт мөнөөхөн Бадраа аймшиг төрүүлэн харагдах шиг болсоор байлаа. Хулгайч шиг байшингийн булангаас гэнэт гарч ирсэн Бадраагийн царай баргар, одоохон Ерөөг барьж аваад зодохоос ч сийхгүй байх шиг санагдсан билээ. Хамар дороос нь шил архиар хууран алдагдсан залуу бүсгүйд Бадраа өс хонзон санаагүй гэр газаргүй. Ээж юу ч гэж хэлж явуулсан юм билээ? гэхээс аймаар байв. Батбаяртайгаа хөтлөлцөн явж такси бариад гэрийн зүг давхин одлоо.

Тэр хоёрыг Бадраа хараад л алдав. Уг нь хүлээн авахын өрөөнөөс гарч ирэхэд нь шууд очиж Ерөөгийн бугуйн дээрээс барин:

- Аа чи ингэж явдаг хүн бий? Эх чинь чамайг олж ир гэсэн. Одоо явнаа хө! гэж хэлмээр байсан боловч хамт яваа хүн нь эмнэлгээс алхам холдмогц тэврэн халуун дотноор үнссэнд Бадраа яаж ч чадсангүй. Тэр хүн Бадраагаас олон ах, тэгээд ч түшмэл царайтай, сүрдмээр эр байлаа. Бадраа сайхь эрээс сүрдэн зог тусчээ. Дарга маягийн хүнээс тэрбээр айжээ.

- Энэ хэн гэгч вэ? Ерөөгийн юу нь болоод үнсэж үлгэж байна вэ?

Даариймаа гуайн хэлснээр Ерөөг тэр мэдэлдээ оруулах эрхтэй болсон гэвч, эрхбиш хөдөөний хүн, тэгээд ч багаас эцэг эхээс өгсөн хүмүүжилтэй тул ахмад хүний өөдөөс цор цор хийхээс айв. Удсангүй бие биеэ хайрлан үнсэлцсэн хоёр хүний хөлсний тэргэнд суугаад яваад өгөв. Бадраа түрүүнийх шигээ мөн унаа авч араас нь явья уу гэснээ болив.

Чухам энэхэн үед Даариймаа гуайн хэлсэн үнээ, тугалын тухай үг санаанд оржээ. Нээрээ л тугалыг хөтлөөд явчихаар үнээ дагадаг шүү дээ. Ямар азаар унаа олж ашгүй би хүүхдийн энэ эмнэлэг рүү дагаж ирсэн билээ? Одоохон саяын хэвтсэн хүүхдийн тасгийг мэдэж авдаг хэрэг.

Бадраа эргэж хүлээн авах тасаг руу харайв. Хаалгыг угз татан орж ширээний цаана ганцаараа юм бичин суугаа эмч хүүхэнд дөтлөн очлоо.

- Сая дөнгөж энд ирсэн нялх хүүхэд аль тасагт хэвтсэн бол? гэж Бадраа амьсгаагаа дотогш татан аль болохоор тайван аядуухан асуув.

-Хүүхдийн нэр хэн билээ?

Эмчийн асуултад юу хэлж хэлэхээ мэдэхгүй Бадраа духаа илэв. За байз хэн билээ? Ерөө хүүгээ нэрээр нь дууд луу?

Эмч, залуу эрийн түгдрэхийг мэдэж өмнөө дэлгэсэн данс юугаа шагайн:

- Баярболд уу? Нярайн 11 дүгээр тасагт хэвтсэн байна... Сахиурыг нь Ууганжаргал гэж байна. Та яах гэсэн юм? Сая дөнгөж хэвтсэн тул эргэлт оруулах болоогүй. Та эргэлтийн цонхоор очиж хүүхдийн биеийг асууж болно шүү. Утсаар асуусан ч болно. Май номер нь энэ... гэж тэмдэглэсэн цаас өгчээ. Бадраа аваад:

- Баярлалаа хэмээгээд гарч гүйв.

Тэрбээр автобусны буудал өөд алхлаа. Бас чиг яах вэ, муугүй олзтой шүү. Өчигдөр галт тэрэгнээс буучихаад хаашаа явах, юу хийхээ мэдэхгүй мангартаж байсныг бодоход одоо бол Ерөөгийн байгаа газрыг, байшинтай нь, орц, тооттой нь мэдчихсэн, хүүхдийн хэвтсэн тасгийг олчихсон байна. Бадраа ажлаа эхлэхэд бэлэн болжээ гэсэн үг. Харин одоо нэг сайхан наргиж, айлд ядаргаагаа гартал унтмаар байна даг...

Өвөрт нь Ерөөгийн ээжийн өгсөн овоо хэдэн цаас байв. Бадраа зүүн зүг явах автобусны зогсоол дээр унаа хүлээн зогсохдоо Шар хадны эмнэлгийн наахна цэргийн нөхөр Цэрэнгийнх бий шүү дээ гэж саналаа. Хоолой чийглэх ундаа, ганц нэг лонх юм аваад тэднийд буучихдаг хэрэг. Сайхан хоол идэж, цэргийн найзтайгаа хуучлан өнөөдөр сайхан наргин цэнгэе. Маргаашнаас Ерөөтэй уулзахыг бодноо. Тэр оргодолтой ширүүхэн үзэлцээд авахад үгэнд орохгүй хаашаа зайлах вэ. Хэрэв их зан гаргах гээд байвал “тугалыг нь аваад зугтахад үнээ нь дагаж” л таарна шүү дээ... Хэ хэ.

Бадраа найман номерын троллейбус ирэхэд бушуухан суув. Сэтгэл нь хөдлөж байна. За яах вэ, өнөөдөр Ерөөг гартаа оруулж чадсангүй ч гэсэн түүнийг олоод авдаг нь их юм. Даан чиг сайхан амьтан даа. Түүнийг өвөртөө хийчихээд чихний нь омог дээрээс үнсээд, хааяа хааяахан зөөлөн хазаж үзэх сэн... Хүүхэн гэдэг амьтан энхрийлэлд дуртай шүү. Цэргийн бор яадаг байлаа даа. Ай багш минь...

Цэргийн найз Цэрэнтэйгээ хоёулаа халамцуухан очоод, эгчмид хүүхнээр зугаагаа гарган өвөрт нь ээлжээр орж, нүцгэн шалдан хамт архидаж байснаа санаад “Ерөөг бол харин түүнд өгөхгүй шүү. Тэр бол минийх юм чинь... Хэзээ авгайгаа сайн нөхөртөө ч гэсэн өгч байлаа даа” гэж боджээ.

## ҮРИЙН ХҮСЛЭН, ЯНАГИЙН ХАЛУУН

Ерөө бараг ухаан тавьжээ. Ойрд тэрбээр чингэж биеийн жаргал эдэлсэнгүй. Хайртай хүн нь түүнийг үнсэж таалан, цэцгийн баланд шунасан зөгий лугаа адил идчих шахав. Тэр хоёроос өөр хэн ч үгүй байлаа. Элсэн цөлд хичнээн хоног ангаж цангаж яваад арайхийж говийн нүдэн булаг олж салж хагацахын аргагүй шунагаар ус залгилах адил, хоёр нууц амраг бие биедээ уусан шингэх гэсэн шиг уруул уруулаараа озолцон, хэл хэлээ соролцон, хамаг бие хөлрөн байж шим шүүс юугаа бие биедээ харамгүй өгөх шиг болов. Ерөөгийн алтан хундага Батбаярын омогт түлхэлтэнд дүүрч, залуу бүсгүй тамирдан туйлын тааламжтайгаар:

- Ай яасан сайхан юм бэ! хэмээн дуу алдав.

Батбаярын бие суларсан авч, сэтгэл ханаагүй тул хүүхнээ үнсэн таалсаар л байна.

- Хүүш ээ, бид хоёрыг хүн дагаад байгаа шүү. Ээж миний хойноос хүн явуулсан шиг байна... хэмээн сая л хүйтэн ундаа залгилаад юм ярих тэнхээтэй болсон хойноо Ерөө нүцгэн биенийхээ доод талыг орны цагаан даавуугаар ороон хэлжээ.

- Юу?

- Тийм ээ. Ууганаа эгч хүүг авч эмнэлэг рүү явах үед унаа авья гэж миний сандран хэлснийг санаж байна уу? гээд Ерөө орон дээрээ босч суун болсон бүх явдлыг ярив. Тэгэхдээ Дархан хотод төрөлх гэртээ очсон өдрөөс л ээж нь хэрхэн түүнийг өөр нүдээр харах болсныг, орон гэрээсээ гаргахгүй хэрхэн хорьсныг, багын үерхдэг Оюунаа яаж түүнийг хөгшин хүний өвөрт хийх гэснийг, тэндээс зугтан өөртэй нь, Батбаяртай ярьснаа цөмийг юу ч үлдээлгүй ярьжээ.

- Чамдаа зориулсан ариун биеэ хэнд ч өгч бузарлуулахгүй гэж би хатуу шийдсэн байлаа. Намайг орой болтол тэнэв гэж ээж Бадраа гэдэг залуугаар цагдуулсан. Тэр нь эзгүй гэрт намайг эзэмдэх гэж бас дайрсан. Би түүнийг шил архинд явуулаад зугтчихсан юм... хэмээн Ерөө үнэнээ уудлан хэлж, энэ бүхний цаана ээжийн эрхт ёсыг эрхэмлэсэн эхийн хатуу сэтгэл байгааг ч нуусангүй. Ээж хүний ухаанаар бодвол, охин нь хэнээс ч юм хүүхэд олоод эцгийг нь нуугаад байгаад бухимдсан нь зөв л байх. Гэвч ээж сэтгэл гаргаж эв зүйгээр охиныхоо дотоод сэтгэл рүү өнгийж зовлонгийг нь сонсч болох л байсан шүү дээ. Харин тэгэхийн оронд элдвээр хавчин, хүнээр мануулж, өөрийн зиндааны хүнтэй суулгана гэх зэргээр хэлсэн нь Ерөөг хэрхэн гомдоход хүргэснийг залуу бүсгүй хайртай хүндээ шулганан ярив.

Ерөө урьд хэзээ ч ийм хөөрхөн, гоё, сэтгэл татам сайхан харагдаж байгаагүй шиг Батбаярын зүрхийг уяруулж байна. Сормуус нойтон том алаг нүд нь үе үе анивчин, хацар нь улайсхийгээд ув улаахан товчтой чанга хатуу хөхөө хагас нуугаад эрвээхэй цэцэг гэж андууран суумаар нимгэхэн ягаан уруул нь аяархан хөдлөн ярьж суугаа энэ жаахан бүсгүй эр хүний шунал тачаалыг өөрийн эрхгүй хөдөлгөх ажээ.

Батбаяр түүгээр цангаж, тэр хүүхнийг хэдэн хоног хүсч мөрөөдсөн тул шөнөжин ноолсон ч ханамааргүй байв. Гэвч болохгүй... Бүр болохгүй. Хүү минь хатгалга тусаад хэвтэж байгаа

шүү. Ууганаа нь бяцхан амьтныг тэврэн эмнэлгийн өрөөнд магадгүй шөнөжин бүүвэйлэн цурам хийхгүй хонож байгаа ч юм бил үү?

Батбаяр босоод явчихав. Хөргөгчөөс виски гаргаж, шилэн аяганд хийн балга-лаа. Ерөө түүний хөдөлгөөн бүхнийг ширтэн нааш ир л дээ гэсэн шиг талимааран орон дээр суусаар байв.

- Ерөө минь... Хонгор охин минь. Чамтайгаа ингэж жаргах яасан сайхан юм бэ. Би үнэхээр л аз жаргалтай байна. Гэвч бид хоёр хүн чанараа янаг амрагийн явдлаас болж гэж болохгүй. Хүү яаж байгаа бол? Ууганаа өдийд аягүй бол унтаагүй л байгаа... Хүү уйлагнаад тавиулахгүй, цаадах чинь тэврээд өрөөн дотуураа бүүвэйлээд л явж байгаа даа. Тэгэхэд бид хоёр... Ингэхэд бодууштай юм их байна. Тэр Бадраа гэгч аягүйд бол гай тарьж мэдэх л бий вий. Ямар ч зан араншинтай хүн юм билээ. Зарим харцуул бүдүүлэг шүү. Хотод хаа нэгтээ тааралдаад чамайг зодох нүдэх ч юм уу хэн мэдэх вэ. Хүчээр машинд суулгаад Дархан өөдөө давхичихвал яах юм бэ? Чамайг ээж чинь одоо бол бүр гэрээс гаргахгүй. Тэгээд санаснаараа хэн нэг хүнтэй, магадгүй цэргээс ирээд удаагүй байгаа тэр Бадраа гэгчтэй суулгаж ч мэдэх шүү дээ. Иймд тун сэрэмжтэй байхгүй бол болохгүй нь... Солонгос явах ажил үйлээ түргэвчлэх хэрэгтэй болох нь... Элчин сайдын яаман дээр хэзээ ярилцлага болох юм бол? Ерөө минь хүүдээ бүү зов. Ууганаа аваад хэвтсэн юм чинь, тэгээд ч Эх нялхсын төвийн эмнэлэг үйлчилгээ сайн, нэртэй эмч нартай юм чинь хүүг эдгээгээд л өгнө...

Батбаяр виски шимсээр хажууд нь суухад аюулт мангасаас аврах баатар эрийг түшсэн хааны гүнж лугаа адил өөрийгөө зүйрлэн санаж Ерөө хайртай хүнийхээ цээжинд нүүрээ наан хүзүүгээр нь тэвэрчээ.

Үнэхээр тэр шөнө Ууганаа цурам ч хийсэнгүй билээ. Хүүхэд нь бүлээрээд тэрбээр гар дээрээ авч тасаг дотор нааш цааш алхсаар үүр цайлгав. Өглөөний тариа хийсний дараа л сая Баярболд бага зэрэг тайвшран унтжээ. Халуун нь буусан байв.

Ууганаагийн нүд анилдан нойр нь ч хүрч байсан боловч, тоохгүй байх гэж хичээн хүйтэн усаар нүүрээ угаачихаад хүүгийнхээ дэргэд суужээ. Хүү нь гайгүй болж байвал түүний ядрах нойрмоглох ч яамай юу даа. Азаар олдсон үрээ л алдчихгүй хүн хийгээд авчихвал хорвоогийн бусад гай зовлон, хувь сэтгэлийн шаналгаа бүгд чухам “яамай л” байлаа. Хүүхэд уйлагнахгүй хааяа нэг унтах шиг болсон цагт тэрбээр ар гэрт юу болж байгаа бол хэмээн эм хүний хувьд бодсон удаа бий.

Мэдээж шүү дээ. Эр нө-хөр нь тийм сайхан, залуухан нууц амрагтайгаа үлдчихсэн юм чинь... Айх ичих юмгүй одоо ч ёстой нэг жаргалаа эдлэж байгаа биз. Гэвч Ууганаа нөхөртөө буруу өгч чадахгүй, Ерөөг ч хатуу ширүүнээр шүүх гэж бодохгүй байлаа. Эхийн хувьд хүүхдээ аваад эмнэлэгт хэвтэе гэж Ерөө хэлсэн явдал бий. Харин тэгэхээс Ууганаа айж бушуухан л Баярболдыг авч түргэний тэрэг өөд яарсан шүү дээ.

Чингэхээс өөр аргагүй байсан... Энэ нялх амьтан минийх... Насан туршийн минь хань нөхрийн яс махны тасархай. Би л түүний ээж байх ёстой... гэж бодоход эм хүний нь сэтгэлд түрэн орж ирсэн хардлага сэрдлэг бүхнийг хүчээр мартахыг Ууганаа хичээж байлаа.

Энэ бүх явдал надаас л эхтэй. Аливаа юманд учир шалтгаан бий гэж багш хичээл дээр заадаг байсан. Хэрэв Ууганаа үр төрүүлэх байсан сан бол иймд нөхөр нь хүрэхгүй л байхсан... Тэгэхээр эм хүний хувьд өврөө Ерөөд булаалгасныхаа гай зовлонг би биеэрээ эдлэхээс биш яая гэхэв. Хохь чинь ээ, хохь чинь...

Өглөө эрт Батбаяр, Ерөө хоёр сайхан өтгөн сүүтэй цай, хэдэн бууз өгүүлснийг сувилагч эргэлтийн цонхноос аваад ирэв. Шөнө нойргүй хоносон Ууганаа унтаж буй хүүгээ хажуугийн хүнд захиад эргэлтийн өрөөнд босон суун яарч байж хооллов. Түүний хамаг биеийн хөлс цувжээ.

“Хүү унтаж байна. Шөнө тавиулсангүй. Халуун нь буусан. Одоо ч гайгүй биз. Та нар сэтгэл бүү зов. Ажлаа хөөцөлдөхийг бод” гэж Ууганаа бичиж халуун савтай нь явуулчихаад хөлсөө арчин хүүгийнхээ хажууд суув. Түр боловч дуг хийгээд авмаар... Нүд анилдан, өөрийн мэдэлгүй үүргэлж байна. Гэнэт тэр дотор муухайрч ирэхийг мэдэрлээ. Самсаа нь шархирч, юу юугүй огих нь ээ. Ууганаа:

-Хүүг минь харж байгаарай! гэж хэлээд бие засдаг газар руу гүйв. Тэрбээр дөнгөж л тосгуур руу тонгоймогц саяхан идсэн уусан бүхнээ бүгдийг шавхан амаараа гаргажээ. Нүдийг нулимс бүрхэн, хамар ам шархиран өвдөж, дотор бачууран бөөлжсөөр байлаа. Юу болох нь энэ вэ? Ядарсандаа болов уу? Ганц шөнийн нойр даахаа болив гэж үү? Эмнэлэгт шөнөжин жижүүрлээд, хүнд өвчтөнд тариа хийн нааш цааш гүйсээр л үүр цайлгасан минь тоо алдсан биш үү? Гэтэл хүүгээ тэвэрч нэгхэн шөнө унтсангүй гэж ходоодоо эргэтэл бөөлждөг ямар ёс вэ? Амьдралд сурсан хатуужлаа умартан, идэх унтахаас өөрийг чадахгүй, сэтгүүлч Батбаяр гэдэг хүний эрх танхил авгай болчихсон хэрэг үү?

Ууганаа нуруугаар өвдөж буйг мэдэрчээ. Хэсэг зуур нүдээ анин суугаад шаазан тосгуурын усыг татаж бослоо. Нэг үеэ бодоход дотор муухайрах нь намдсан шиг... Тэрбээр ахиад нүүрээ хүйтэн усаар угааж, духаа шавшаад хүү рүүгээ яаран очив. Хүү нь харин сэрсэнгүй.

Юу гээч болов оо? Яагаад дотор муухайрав аа? Өөр хүүхэн, залуухан бүсгүй сэн бол хүүхэд олчихоод анхны дохио ирж байна уу даа гэмээр л... Гэтэл өөр хэн ч биш, хүсээд насаараа хүлээгээд үр олоогүй, хүүхэд багад сав суулгаа моринд өшиглүүлж гэмтээсэн Ууганжаргал шүү дээ. Өөрөө үрийг нь төрүүлж чадахгүйгээ мэдээд огт танихгүй залуухан сайхан бүсгүйг оролдон жирэмсэн болгоход битүүдээ баярлан, арга буюу амьдралын бэрхшээлийн өмнө сөхөрч, бууж өгсөн Ууганаа чи мөн биз дээ? гэж өөрөөсөө асуумаар байлаа. Тэгэхээр эм хүний бие шалтгаантай болох тухай ойлголт Ууганжаргалд байхгүй мэт... Тэгвэл яагаад?...

-Ууганжаргал эгч эргэлтээ аваарай.

Хөөрхөн ааштай сувилагч бүсгүй бага зэрэг хир суусан торон саванд хийсэн халуун савтай хоол, цай бариад дууджээ.

-Минийх биш байлгүй. Саяхан манайхаас эргэл ирсэн шүү гээд Ууганаа тоосонгүй.

-За мөн дөө, танд л өгөөрэй гэсэн юм... гээд сувилагч тортойг гарт нь бариулаад цааш одов. Гайхсан хүүхэн цай, хоолыг авч эргэлтийн өрөө рүү орохоос аргагүй болжээ. Гэвч тэрбээр



хоолны үнэр авч чадахгүй байлаа. Нөгөөтэйгүүр огт танихгүй хүний хоолыг яаж идэх билээ. Магадгүй адилхан нэртэй бас нэг хүүхдийн сахиурын эргэлтийг сувилагч андуураад авчирсан ч байж болох шүү дээ. Ууганаа хоол, цайнд ам хүрсэн ч үгүй, сувилагчийн ирэхийг хүлээжээ.

Ерөө туйлын сэтгэлийн хөөр баяртай гэр өөдөө явж байлаа. Баярболдын халуун намджээ. Хэд хоног өнгөрсний хойно хуучин хэвдээ орж, шулганан ярьж, Ууганаа эгчээс салахгүй энгэр өөд нь асах нь өхөөрдмөөр байлаа. Хүүгээ гайгүй болсон гэхэд нь орж үзмээр санагдаад Батбаярт хэлэв. Цаадах нь ерөнхий эмч дээр орж байгаад зөвшөөрөл авч өгчээ. Чингээд Ерөө дуртай цагтаа хоол, цай бариад хүү дээрээ ордог болов.

Ууганаа харин ядарчээ. Царай нь харлаж, шанааны нь яс товойгоод турж эцсэн шиг харагдана.

-Би хүүгээ харж өнжье. Та хариад хувцсаа сольж усанд ороод сайхан амраад ир! гэж Ерөө хэлсэн авч Ууганаа үгэнд орсонгүй.

-Эмнэлгийн дотоод журам нарийн шүү дээ Ерөө минь. Намайг өрөвдөж, амраая гэсэн сэтгэлийг чинь ойлгож байна. Гэвч эмнэлэгт сахиурыг тэр болгон солиод байдаггүй. Би яах вэ. Хүү минь л эдгэж байвал, миний ядрах зүдрэх юу ч биш. Харин чи ажлаа л хөөцөлд. Виз зөвшөөрөл чинь бүтвэл явахаа бодсон дээр. Хүү бид хоёр чамайг ирэхэд танигдахгүй том болсон байх вий.

Ууганаагийн хэлж буй үгийг сонсоход Баярболдын хувь заяа нэгэнт шийдэгдээд, өсгөж хүмүүжүүлэх хүн нь Ерөө биш, харин тэр эмэгтэй болжээ гэж хэнд ч ойлгогдохоор байлаа.

“За тэр нь ч дээр дээ. Анхнаасаа миний хүүг хар нялхаас нь гар дээрээ авсан хүн Ууганаа эгч л юм чинь... Ийм хүнд хүүгээ орхиод Сөүл явахад би санаа зоволтгүй ээ” гэж Ерөө өөртөө хэлэхдээ төрөх газарт уулзсан лам ах буянтай эцэгт нь хүүгээ өгч өсгүүлсэн дээр гэж хэлсэн үгийг санаж билээ.

Батбаяр, хүү гайгүй болов хэмээн Ерөөг дагуулж “Заг” компанийнхантай уулзуулав. Цаадуул нь нэртэй сэтгүүлчийн захисан хүн гэж их л санаа тавьж, эхний ээлжинд ярилцлаганд орох хүмүүстэй хамт өнөөдөр Өмнөд Солонгосын элчин сайдын яаман дээр дагуулж очжээ. Өчигдөр, уржигдар компаний нэгэн сайхан зантай эгч, түүнд баахан зөвлөгөө өгөв. Тогтмол тавьдаг асуултанд нь юу гэж хариулах, биеэ хэрхэн авч явах, монгол хэлтэй солонгос хүнтэй бүсгүй хүний хувьд яаж харьцвал зохих зэргийг хэлж өгчээ. Ерөө өнөөдөр ярилцлаганд түүртсэнгүй. Бүх явдал санасан ёсоор болж, Ерөө өнөөдөр солонгосын виз дарсан гадаад паспортаа хүлээн авчээ.

Хол газар яваад өгнө гэж бодоход нэгэн талаар хөл хөнгөрөм баяртай, нөгөө талаар хайртай хүнээ, нялх үрээ орхин одно гэхэд ялимгүй гунигийн сэтгэл төрөх ажээ. Гэвч яана гэх билээ. Нэгэнт л өөрөө зорьсон юм явахаас л аргагүй...

Сөүлийн бүсгүй Сэрчмаа түүнийг хүлээж ядсан байлаа. 5 сарын 26-ны өдөр явна гэж товлоод онгоцны билет авчихсан байснаа Дарханаас Ерөөг ирээд утасдахад:

-Чи тэгвэл удахгүй явах нь... Хоёулаа нэг онгоцоор хамт л явъя. Би захиалгаа хойшлууллаа гэжээ.

Сэтгэл бадрангуй, хөөрч догдолсон Ерөө ярилцлагад амжилттай орж виз авснаа Батбаярт утсаар хэлсэнгүй. Одоохон харьж шив шинэхэн паспортаа үзүүлэх сэн л гэж яарч билээ. Тэр хүн яасан их баярлах бол? Тэгээд хоёулаа тэмдэглэнэ дээ. Түүндээ сайхан хоол хийж өгөөд эртхэн ор засч хоёулаа жаргана даа... Дуртай вискийг нь авч өгөх юмсан. Надад чинь мөнгө юу сан билээ?

Автобусаас буугаад Ерөө сэтгэл баяраар бялхан, өөр ямар ч хар хорын сэтгэлгүй гэр өөдөө гүйв. Өрөөнд нь орны ширдэг дор хэдэн цаас нь бий. Түүнийгээ бушуухан авч, ойролцоо дэлгүүрээс хайртай хүнийхээ шимэн уух дуртай дарсыг нь авч, даруй хоол бэлдье. Ажлаа тараад ирэхэд нь ширээ засчихсан байя.

Хүүхэд шиг баярлан орцны хаалга татан орох гэтэл Бадраа гэнэт гарч ирээд бугуйн дээрээс нь бариад авав.

-Аа муу оргодол... Ингэж явдаг бий...

Бугуй өвдтөл базан Бадраа бахь шиг гараараа чингэж Ерөөг өөр рүүгээ татаад:

-За хө явнаа. Эх чинь чамайг олж авчир гэсэн хэмээн чанга гэгч хэлэв.

-Байз л даа. Ёо ёо. Гар хугаллаа. Тавиач! гэж аль болохоор эвийг нь олох санаатай Ерөө дуугарчээ.

-Яалаа гэнээ? Архи авчир гэж явуулчихаад зугтана гэнээ? Одоо чи баригдсан, мэдэв үү? Чамайг тавина аа л гонж. Одоохон надтай хамт явахгүй бол би тэнэг мангар хүн шүү. Хүч хэрэглэнэ л гэж мэдээрэй! гээд Бадраа түүний гараас хөтлөн хаашаа ч юм явах гэв.

Ерөө гэдрэг цахлав. Нүдний булангаар ийш тийш аврал тусламж эрэн харлаа. Гай болоход хэн ч хажууд байсангүй. Жил гаран нэг байшинд амьдарсан айлын хүмүүс гараад ирэх болов уу гэж хараад ч нэмэр алга.

Бүргэдийн саварт атгуулсан хунгийн дэгдээхэй шиг Ерөө бахим хатуу гартай Бадраагийн гараас гарч чадахгүй болов гэж бодоход аймаар байлаа. Чухам яг энэхэн үед л сайхан амрагийн нь сэрэмжлүүлэн хэлсэн “Чамайг барьж аваад машинд хүчээр суулган Дархан өөд давхичихвал яах юм бэ?” гэсэн үг санаанд нь оржээ.

-Намайг тавь. Би хашгирлаа шүү гэж Ерөө зөрүүдлэн хэлэв. Үнэхээр бүсгүй хүнийхээ эцсийн аргыг хэрэглэн тэр хашгирч орилон тусламж гуйхаас өөр яах билээ. Ерөө гараа суллах гэж, Бадраа тавихгүй зууралдан нэгэн хэсэг ноцолдов. Салхин талд Бадраа гарахад амнаас нь хэд хоног архидсны дотор муухайрам угаар үнэртэж Ерөө эгээтэй л огисонгүй.

-Бүү санаарх! Намайг дийлнэ гэж санасны чинь гарз. Мэдэв үү? За хө явнаа... Бадраа гав шиг эвэр ургаж хүнийх гэхээсээ төмөр шиг гэмээр хатуу болсон алгаараа бугуйг нь өвтгөн

лавшруулж бариад автобусны буудал руу явах гэв.

-Үгүй, үгүй...Би явахгүй.

Ерөө гэдрэг цахалсан хүчиндээ чингэв үү, эсвэл бүдрэв үү ар дагзаараа шороотой газар мөргөн унаж орхив. Бадраагийн уур ихэд хүрэх бололтой түүнийг унасан чигт нь хэсэг чирэв. Нэгэн мангардуу залуу, сайхан бүсгүйг газар унаган чирч байхыг хараад зэргэлдээ орцны хэдэн хүн гайхан зогсчээ.

-Яаж байгаа нь энэ вэ? Гэгээн цагаан өдрөөр хүн дээрэмдэн хүчирхийлэх нь үү?

Цангинасан дуутай бүсгүй хүний дуу гарлаа. Энэхүү энхрий дотно дуун Ерөөгийн сэтгэлийн чандах аймшгийг үлдэн хөөв. Харь дайсанд баригдаж яваад хатан ээжтэйгээ тааралдан, өмгөөлүүлсэн гүнжийн адил Ерөө дуу гарсан зүг рүү мөлхөөгөөрөө зүтгэжээ.

Чимгээ гүйн ирж Ерөөг түшин босгов. Гэнэтийн энэ явдалд цочсон уу, амьтан хүнээс эрхбиш айсан уу, Бадраа бүсгүйг тавьжээ.

-Чимгээ эгч ээ, авраарай!

Ерөө аврагчаа тэврэн охилов. Чимгээ бүсгүйн шороо болсон хувцсыг гөвж, толгойг нь илээд үнсч Бадраад,

-За чи явна аа. Тэр машинд суу. Хаа газрын дээрэмчин гэгч вэ? Цагдаа дээр очноо!

Эрс шийдэмгий хэлсэн энэ үгийг сонсч, түрүүнээс хойш залуухан бүсгүйг газар унаган чирэх зэргээр аашилж байхыг нь харж гайхсан хүмүүс сонирхон шавж ирэв.

-Зөв. Цагдаад өгөх нь мөн. Яасан зэрлэг нөхөр вэ?

-Энүүхэнд эргүүлийн цагдаа байгаа даа, дуудчих уу?

Хэрэг хаашаа эргэж буйг мэдээд Бадраа:

-Эх нь энэ бүсгүйг аваад ир гэсэн юм. Би Дархан хотоос Ерөөг л аваачих гэж зориуд ирсэн... гэж тайлбарласан боловч

-Хулгайч дээрэмчин юу ч гэж худлаа хэлж мэднэ шүү. Цагдаа дууд, дууд! гэж хэн нэг нь чанга гэгч хэлжээ.

-Та минь сэргийлэхэд энэ танхай эрийг хүргэлцээд аль. Тэр унаанд суулгачих! гэж Чимгээ хэлэв. Бадраа цагдаад баригдахыг юунд хүсэх билээ. Тэр гэв гэнэт огло үсрэн зугтаав.

-Бариад аваарай. Хөөгөөрэй...

Хойноос нь хүмүүс ингэж хашгиралдсан боловч харин хэн ч Бадраагийн араас гүйсэнгүй билээ.

-За гэртээ ор доо дүү минь. Сүйд болох нь байна шүү. Чамайг дээрэмдсэн үү, яасан бэ? Хармаа хотыг чинь ухсан уу? гээд Чимгээ бүсгүйг хүүхэд шиг хөтлөн орцны хаалга татжээ.

Ерөөгийн хамаг бие салгалан чичирсэн хэвээр л байлаа. Чимгээ түүнийг хөтлөсөөр явж дээд давхарт гараад Ерөө хаалганыхаа түлхүүрийг хийх гээд чадахгүй салгалж байхад:

-За битгий сандар. Тэр муухай амьтан зугтчихсан шүү дээ. Ямар азаар би ирэв ээ? Ууганааг эмнэлэгт хэвтсэн гэж дуулаад эргэх гэж яваа минь энэ. Би япон явчихаад дөнгөж өчигдөр ирсэн байхгүй юу. Чамайг хүү дээрээ очвол аваад явъя гэсэн юм... хэмээн нүд нээн хэлжээ.

Гэртээ орсон хойноо ч Ерөө тайтгарч чадахгүй байлаа. Чимгээ утсаар Батбаярыг дууджээ.

Аюул болох нь байна шүү. Ээж чинь явуулсан байж болно л доо. Гэхдээ хүн хэлээрээ мал хөлөөрөө гэдэг шүү дээ. Үнэнээ хэлээд хүний ёсоор харьцаж болно доо. Тэгэхэд хулгайч дээрэмчин шиг, бүсгүй хүүхдэд дээрэлхэж, бүр газар унагаачихаад чирч байгаа юм даа.

Батбаярыг ирэхэд хэдийнэ цай чанаж, ширээн дээр идэх уухыг өрөн гэрийн эзэгтэй шиг нүүрэмгий байж Чимгээ нөгөө хоёрыг суулгаад ярьж билээ. Хорвоод хайрлаж ханахгүй сайхан хүнээ ирэхэд Ерөө тэврэн авч хамаг зовлонгоо ярин уйлмаар байсан авч этсэв. Батбаяр Чимгээ хоёрыг ямархан нэгэн далд холбоо бие бие рүү нь дуудаад байх шиг Ерөө битүү далд сэтгэлдээ тааварласан тул ийм үед биеэ барихаас болохгүй гэж боджээ. Цай ууж, Батбаяр Чимгээ хоёрын тайтгаруулсан үгэнд Ерөө одоо л нэг цээж онгойж үг хэлэх чадалтай болжээ.

Тэрвээр ярилцлагад амжилттай оролцоноо, солонгосын виз дарсан гадаад паспорт гардан авснаа хэлж бичиг баримтаа гаргаж ирэв.

-Удахгүй явна гэсэн...

Бадраа ахиад ирэхгүй гэх газаргүй. Одоо хаа нэгтээ тааралдвал Бадраа мангар зангаар цохиж унагачихаад машинд ачихыг хэн байг гэх юм бэ?

Энэ бол зөвхөн Ерөөгийн бодол биш. Батбаяр ч, Чимгээ ч ингэж л санаж байлаа. Болзошгүй аюулаас сэргийлэх ганц арга бол даруйхан хөдлөх л байлаа. Ерөөг нэгэнт зорьсондоо хүрч Сөүл рүү нисэн одсон хойно хэн яах юм бэ?

Сүүлийн хэд хоног Батбаяр Чимгээ хоёр залуу бүсгүйн авч явах юмыг бэлдэн ийш тийш дагуулан давхисаар байтал таарав. Ерөөг сайхан хувцаслаж, халаасанд нь оъвоо хэдэн ногоон цаас хийж өглөө. Батбаяр гар татсангүй билээ. Дасалт бяц хан хонгор найзаа гэж тэр хөл алджээ. Харин үр хүүхэдгүй эхнэр нөхөр хоёрт хүүгээ үлдээн явж буй энэ жаахан бүсгүйд хамгаа зориулаарай. Харь газар хэцүү шүү. Очоод хэд хоног ч болсон сэтгэл зовохгүйгээр амьдрах мөнгө төгрөг гаргаарай гэж Ууганжаргал нөхөртөө захьсан билээ. Ууганаа уг нь Ерөөг явахаас нь өмнө гарахсан гэж бодовч эмчлэгч эмч нь хүүгийн уушгинд ялимгүй хэржигнүүр байна. Яарах юу байхав. Нэг мөсөн урхаггүй болоод гарсан нь дээр гээд зөвшөөрсөнгүй.

Орой Чимгээ тэднийд удаан суув. Өөрийн гараар хоол унд хийж, архи дарстай, чанасан

махтай, өргөт хэмх байцаатай, махан зууш таваглан бууз жигнээд, туйлын өнөр баян ширээ засаж, хол явах сайхан бүсгүйг дайлан үдэлтийн хоол идэцгээв.

Маргааш явна гэхээс Ерөөгийн сэтгэл догдлон байлаа. Өмнөөс нь харж суугаа янаг дотно хүнээ орхин одох хэцүү санагдана. Ойрд мөд уулзахгүй шүү дээ. Санах гэгч залуу бүсгүйд байж боломгүй мэт санаанд бууж өгөхгүй байв.

Бадраагаас Чимгээ аварч, хэдэн өдөр дэлгүүр зах эхсэн давхисан ааг амьсгаагүй цаг хугацаа ард үлджээ. Ингэж өдөрт гадуур бяц хан давхиад, харин шөнөд хайрт хүнтэйгээ хожуулхнаа гал бутартал ноололдон жаргах сайхан байв. Тэр мөчийг Ерөө өдөржин хүлээдэг байсан.

Бушуухан орой болж хайрттайга үлдэхийг тэр яарч, заримдаа ч өчнөөн тус болсон Чимгээг гэрт удаад байхаар бушуухан яваад өгөөсэй гэж боддог байснаа нуух юун.

Амьдралын зорилго гэж нэг чухал юм бий. Ерөө одоо бол зорилготой амьдрал өөд, харь газарт гав ганцаараа шуурга сөрөн явах гэж байна. Эх хүний хувьд тэрээр хорвоод заяасан ганц үрээ эмнэлэгт авч хэвтээгүй, хэдэн өдөр боловч тэврэн нойргүй хонож бүүвэйлээгүйдээ өөрийгөө зэмлэх авч, ямар ч байлаа гэсэн тэр хамгийнхаа хайрт хүндээ үрээ үлдээн явах гэж буйгаа буян хэмээн тооцохоос өөр аргагүй хэмээн бодож байлаа.

Ер нь анхнаасаа л Ерөө эм хүний хувьд Батбаярыг өрөвдөн, насаараа үрийн мөрөөдөл болсон түүнд үр төрүүлж өгнө хэмээн амласан шүү дээ. Нэг биеэ хоёр болгож, нялх үрээ түүнд өгөх нь сайхан эр хүний тусыг хариулж байгаа хэрэг биш үү. Ухаантай лам хүн чухам л ингэж буянтай эцгийг нь дагуулбал хүү нь эрүүл саруул өсч торнино гэж айлдсан бус уу? Санаж бодсон бүхэн биелж буйд Чимгээ сэтгэл хангалуун байлаа. Ар гэртээ ч бараг харихгүй шахам Ерөөд үйлчилж хэдэн юмыг нь бэлдэн, өдөрт гадуур давхиж, хоол унд хийж байхдаа Чимгээ залуу бүсгүйн эр хүсэмжилсэн харцыг андахгүй мэдрэн, гэнэн цайлган сэтгэлээ нууж чадахгүй Ерөө Батбаярыг хайрлан ширтэж, заримдаа аяархан чимхээд авах юм уу, ширээний цаана суугаад хөлөөрөө хөлийг нь оролдож буйг анзаардаг байв. Олон жил нууц амраг нь явсан хүнийг нь ийнхүү залуу бүсгүй хэт ихээр хүсэмжлэхийг нь харах анзаарах гэдэг Чимгээд тэсэшгүй явдал байсан ч тэр шүд зуужээ. Өглөө болгон өд шиг хөнгөн босч сэтгэл санаа сэргэн, бие сэргэлэн угтдаг Ерөөгөөс эр хүний тачаалын үнэр ханхлах шиг болоход Чомгээ галзууран алдаж, одоохон Батбаяртайгаа ноололдох дур хүрч, эм хүний нь сэрэл хамаг биеийг нь зовоох авч, тэрээр худлаа инээмсэглэх аядан Ерөөг үнсч, түр суун хөөрч ирсэн амьсгаагаа дараад ажилдаа ордог байв. Ерөөгийн энэ ааш аяг ердөө л хэдхэн хоногийн хугацаатай юм. Тэгээд залуу бүсгүйн шилийг бид хоёр харна. Тэгсэн цагт л миний жаргал ирнэ. Ууганаа эмнэлгээс мөд гарахгүй биз... гэж шүд зуун бодоод, өөрөө л гадагшаа явахдаа юу юу бэлдэж, чемодан савандаа яаж хийдэг, хэдэн ногоон цаашаа бүхэлдүүлэн хаанаа хадгалдаг тэр л ёсоор Ерөөд бүгдийг нь жин тан болгож өгчээ.

Батбаярын хувьд шим шүүс дүүрэн амтат сайхан жимс одоохондоо олдохоо байж, хайртай Ерөөгөө харь газар үдчихээд ганцаараа өвдгөө тэврэн үлдэнэ гэж бодохуй сэтгэлд гуниг төрж байлаа. Амьдралд амсаагүй хэдхэн сайхан хоногийг хувь заяа түүнд үүлэн чөлөөний наран шиг л өгч дээ. Ерөөтэй хожуулхнаа өнгөрөөсөн энэ хэдхэн хоног хувь заяа түүнд өгсөн шагнал байсан буй заа. Санаснаар болдогсон бол ингээд л Ерөөтэйгөө нэгэн гэрт жаргаж, насаараа ноололдон суумаар... Гэвч хувь заяаны төөрөг нэгийг нь Сөүл рүү хөөжээ. Явуулахаас биш

яалтай. Нэг гэртээ суувал Батбаяр хуучин шигээ тайван сууж, ханийнхаа араар тавин нууцаар нөхцөж чадахааргүй болтлоо жаахан бүсгүйд дасчээ. Тэгтэл Ерөөг нь авч явах гэсэн аюул хажууханд нь хаа нэгтээ отоож суугаа. Тэр балмад залуу Чимгээгээс айн зугатаад тэр чигээрээ алга болсон гэж итгэх арга алга байлаа.

-Ерөө минь мөнгө цаастайгаа хэнд ч хэлж болохгүй шүү. Одоо үед харь газар өөрөөсөө өөр хэнд ч итгэж болохгүй болсон цаг. Хүний газар нэг хэсэгтээ л чамд хэцүү байх биз. Гэвч Заг компанийн шугамаар явсан хэн боловч газарддаггүй л гэлцдэг. Гэр ёсоор байр сууцанд оруулж ажлаар хангадаг гэсэн. Чи алзахгүй ээ.

Чимгээ хүүхдээ л хол газар явуулах гэж байгаа мэт захиасаа хэлж суулаа. Батбаяр вискигээ шимэн сууж Ерөөг хайрлан ширтэх ажээ.

-Би хүүгээ үнсчихээд явах юмсан.

Ерөө гэнэт ингэж хэлэв. Эх хүний нь сэтгэл түүнийг зовоов уу гэлтэй байлаа.

-Тэгэлгүй яахав. Онгоц хөдлөхөөс хоёр цагийн өмнө Буянт-Ухаад очсон байх ёстой. Маргааш тав дахь өдөр, онгоц 11 цагаас ниснэ шүү дээ. Эртхэн гарч эмнэлгээр дайраад явъя. Ерөөсөө би харьялаа. Замдаа машиндаа бензин хийх ёстой юм байна. Өглөө найман цаг гэхэд та хоёр бэлэн байж бай гээд Чимгээ цүнхээ шүүрэв.

Хаалга хаагдан, шатаар уруудан гүйж яваа Чимгээгийн хөлийн чимээ холдоход залуу бүсгүй Батбаярыг тэврэн:

-Ингээд би явлаа шүү дээ хэмээв.

Батбаяр хүүхнийг тэврэн өрөө рүү нь явлаа. Сандан мэндэн хувцсаа тайлан хаяцгааж хоёр амраг янаглалын халуун хөнжилдөө шурган оржээ. Нэгэн хэсэг эр хүний тааламжтай уухилах, эм хүний гиншин дуугарахаас өөр авиа чимээгүй болов. Хайр хайртайгаа учран золгож, бие биетэйгээ уусан нийлэв.

Тэр шөнийг хоёр хайртай хүн сүүлчийн удаа гал бадартал янаглан өнгөрөөхөөр шийдсэн байлаа. Залуу бүсгүй алтан хундага байн байн тосч, нас бие жигдэрсэн эр хүн хүсэл бүгдийг нь бадраан шим шүүс бүхнээ түүндээ шавхан өгөхөөр дайрчээ.

Маргааш өглөө эрт Ууганаа босоод хүүгийнхээ хамаг даавууг угааж хатаав. Сүүлийн үед нэг удаа хэрэглэх живхтэй болсон тул бэлдэж байтал Ерөө гүйгээд ороод ирэв. Тэр танигдахгүй гоё бүсгүй болсон байлаа.

-Явлаа шүү дээ Ууганаа эгчээ. Алив хүүгээ үнсье гээд Ерөө, Баярболдыг тэвэрч өргөн хамар дух дээр нь үнсэв.

-Та намайг гаргаж өгөхгүй юм уу гэж Ерөө хүүхэд шиг тунирхангуй дугарав. Ууганаа хажуугийн хүнд хүүхдээ захиж өгчихөөд энүүхэн үүдэн дээр гарчихаад ирье хэмээн явав.

Чимгээ эмнэлгийн үүдэн дээр тэргээ арчаад зогсож байлаа. Дотроос Ууганаа гарч ирэн

Ерөөг машинд суулгаад:

-За миний охин сайн яваарай, утсаар дандаа ярьдаг юм шүү. Ээж аавдаа санаа бүү зовоорой, бид дандаа эргэж тойрч байна... гэж даруй Ерөөг үнсээд машин хөдөлмөгц хүүдээ яарах тул буцаж оров.

Ерөө минь яваад өглөө. Аян зам нь өлзийтэй л байгаасай даа. Одоо хүү бид хоёр үлдэв. Миний хүү сайхан хүү болж өснө дөө. Ээжийгээ сүүлд ирэхэд нь танихгүй том хүн болсон байна даа... гэж Ууганаа шатаар өгсөхдөө бодож улам яарчээ. Түүнийг тасагтаа ирэхэд нь хүү алга байлаа.

Хүү... хүү хаана байна? гэж Ууганаа хашгирах шахам асуув.

таныг хүүхэд аваад ир гэсэн гээд нэг эрэгтэй хүн тун саяхан аваад гарсан шүү дээ! гэж хүүг итгэж орхисон эмэгтэй гайхан харжээ.

Юу?

Та явуулсан юм биш үү? Цагаан халаазтай биерхүү том залуу байсан. Баярболдын ээж гадаадад явах гэж байгаа гэж та яриа биз дээ? тэгээд эх хүүхдээ үнсэх гэж аваачих хэрэг болсон юм гэж бодлоо...

Ээ чааваас. Хүүг минь алдчихжээ гэж Ууганаа машинд харамсан дуу алдаад ухаан алдан унав.

## АРВАН ГУРАВДУГААР БҮЛЭГ

Хүүхэд тэвэрсэн Бадраа нөгөө талын хаалгаар шадмаг нь аргагүй гарч ирээд холгүйхэн зогсож байсан цэргийн найзаа дуудав. Хөлсний тэрэг аажуухан ирж хажуу зогсоход Бадраа хүүгийн уйлах орилхыг ч эс тоон тэврэн сууж машин хөдлөн одлоо. Тэрээр энэхүү далим гарах торгон мөчийг хүлээсэн билээ. Хэд хэдэн удаа хүүхдийг хулгайлах гэж оролдоод бүтсэнгүй. Эхнийхэд эмнэлэгийн хүнд хөөгджээ. Цагаан халаад өмсөөгүй, байдаг л хувцастайгаа тасагруу орсон хүнийг сувилагч хөөн гаргасан билээ. Дараа нь цагаан халаад олж эмнэлэг рүү нэвтэрсэн боловч хүүгийн сахиур алхам ч холдохгүй байлаа. Харин өнөөдөр л далим гарчээ. Тэрвээр Ерөө, Ууганаа хоёрыг шатаар уруудахад нуугдан үлдээд зөрч тасагруу орсон байлаа.

Тугалыг нь авлаа, Үнээ нь мөөрөөд хойноос дагана даа гэж сая хэрэг бүтэн санаа амарсан Бадраа халааснаас тал шил архи гарган амаар нь залгилжээ.

Нярай жаал алга болов хэмээн эмнэлэг даяар шуугиан дэгдэв. Хүүхэд тэвэрсэн сэжигтэй эрийг олох гэж давхар бүхнийг нэгжсэн авч усанд уусч, салхинд хийссэн мэт хүүхэд хулгайлсан этгээд ор мөргүй алга болжээ. Яг энэ үед Буянт-Ухаагийн нисэх буудлаас өмнө зүгийг барин олон суудалтай том онгоц өндөр аван хөөрч байлаа.

Ууганаа өвджээ. Бяцхан үр нь олдсонгүй. Цагдаад тэмдэглүүлсэн авч хүүхдийн сураг гарсангүй удлаа.

Улаанбаатарын болон Дархан хотын цагдаагийнхан хүүхдийг, аман зургаар сэжиглэсэн этгээдийг эрж хайж байлаа. Мөнөөхөн Ерөөгийн гэр орноор очиж нялх хүү тэднийд байгаа эсэхийг битүү тандсан авч хулгайч хүүхдийг хүргэж өгсөнгүй бололтой. Ерөөгийн хөгшин эхэд дуулгахаас аргагүй болсон гэлцэнэ. Тэр хөгшин хүүхэд алга болов хэмээн үсээ үгтээн уйлан дуугарсан гэх. Сэтгэл санааны уналт цөхрөлөө дийлэхгүй ямагт уйлах хөөрхий гэргийгээ өрөвдөж ядаад Батбаяр яах юу хийхээ мэдэхээ болив. Ямар гай дайрах нь энэ билээ? Амьдралын хамаг гэрэл гэгээ бөхөх шиг болов. Одоо ханиа л эдгээж авахгүй бол эр ганцаараа Батбаяр хэцүүдэх нь ээ. Ашгүй тэгтэл Чимгээ үерхдэг хүүхнээ үзүүлэх гэж нэр алдартай нэгэн бариач эмгэнийг дагуулж ирэв. Тэр хүнийг ирэхэд Ууганаа бие засдаг өрөөнд ходоодоо эргэтэл бөөлжин зогсож байлаа. Чимгээ эмгэнээс бяцхан зовж, үерхдэг хүүхнийхээ гар нүүрийг угаалган үнэртэн түрхээд орон дээр нь хэвтүүлэв.

Хүүхэд минь яагаав? Дотор муухайраа юу? гэж эмгэн хажууд нь суугаад асуужээ.

Хоол зохихоо болиод байгаа юм...

Батбаярын үгийг анхааралтай сонсоод эмгэн гэдсийг нь илж үзсэнээ,

Та хоёр гадаа гарч бай. Би энэ хүүхнийг сайн үзээд өгье. Урьд би чинь эмэгтэйчүүдийн тасагт эмч хийж байсан хүн шүү гэлээ.

Нөгөө хоёр даруй гарав. Эмгэн эм хүний үздэг үздэггүйг гэдэс хээлийг базлаад



Хүүхэн минь чамд өвчин алга. Ертөнцийн жам ёсоор хүүхэд олжээ гэжээ.

Юу? Та юу гэж хэлэв ээ?

Тиймээ хүүхэн минь. Хүүхэд олоод сар гаран болжээ. Бодвол дөчөөд л настай байх даа чи... өдий насандаа үр олсондоо баярламаар биш үү? хэмээн шүдгүй амаа ангайлган бариач эмээ инээв.

Эмээ минь би чинь хүүхэд байхдаа моринд чирэгдэн сав суулгаа хазайлгаад үр тогтохгүй болсон хүн шүү дээ гэж эмээгийн хэлсэнд эргэлзэн байж Ууганааг дуугарахад

Тийм явдал байдаг. Бие илааршаад эр эм хүн үнэн сэтгэлээс хүүхэдтэй болохсон гэж хичээвэл саванд байтугай савнаас гадуур ч жирэмсэн болдог ёс бий шүү дээ...

Ууганаагийн нулимс сул асгарч нөрөө дуудлаа. Гаднаас Батбаяр, Чимгээ хоёр уралдах шахам орж ирлээ.

Дорнын тэнгэрт гав ганцхан онгоц шувуу шиг дүүлэн нисэж байлаа. Тэртээ дор зулсан хөвөн шиг үүлс хорвоогийн амьдралд байх эрээн бараан, бүхнийг Ерөөгөөс далдлан нуух гэсэн шиг цайран харагдана. Ар гэрт юу болж, бяцхан үр нь хаана зовж явааг огтхон ч үл мэдэх залуу ээж мөнөөхөн Сэрчмаа руу үе үе харж инээмсэглэх ажээ.

- Сөүлд сайхан шүү. Чи очоод мэднээ. Нэг аятайхан залуутай танилцаад авсан нь дээр байдаг юм. Бие сэтгэл зовохгүй амар шүү дээ. Харьд хичнээн ч жил болох юм билээ. Зарим хүүхнүүд Солонгос эзнийхээ нууц амраг болчихсон байдаг юм. Залуухан, хүчтэй, сайхан Солонгос эзэнтэй нэр холбогдоод авахад ядаж нэмүүлнэ шүү дээ... гэж Сэрчмаа сонин болгон шулганах аж. Гэв гэнэт Ерөөгийн хөх часхийн хатгах шиг болов. Яагаад ч юм бэ, хүү минь зүгээр байгаа даа гэж Ерөө сэтгэл зовон боджээ.

# АРВАН ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Ингэж зүрх өвдөн, сэтгэл харанхуйлж уйтгар гунигт автсан дорвол болдог сон бол үхээд өгөөсэй ч гэж бодсон удаа бий шүү. Одоо гэтэл ямар байна, хар. Чи азтай хүүхэн юм. Хэн ч ингэж хагацал зовлонгийн дараа бэлэн зэхээ үртэй болж цээж хөнгөрөн зүрх амраагүй билээ... Бурхны хишгийг сайн тогтоо Дэлгэрмаа минь...

Зүлэг ногоо сайхан ургасан заримдаа шороотой, заримдаа хөлд ногоо гишгэгдсэн Түнхэл тосгоны гудмаар залуу эх явж байв. Хэт их догдолсноос болов уу, ам нь цангах ажээ.

Чингэтэл сав саяхан хөхсөн энэ нялх амьтныг хуурайлмаар... Надад чинь даавуу шаавууны юм юу сан билээ? Нээрээ түүнд юу байх вэ дээ. Нялхынхаа хамаг даавуу, живхийг Баруун Наранд мөнөөхөн газар дээр хайрцаганд хийгээд орхичихсон юм чинь... Харин мөнгө юу билээ? Дэлгэрмаа өврөө уудлах гэж хүүг тавьчихмаар газар эрэх мэт ийш тийш харав. Тэрүүхэн цаана эгнүүлж барьсан хашаануудын нэгний гадаа урт сандал харагдана. Дэлгэрмаа тэр зүг гүйхээрээ очлоо. Айлын хашааны гадаах сандал дээр хүүхдийг эвтэйхэн нь аргагүй тавьж, гар цүнхээ уудлав. Учир нь халаасанд өглөө галт тэрэгний тасалбар авахдаа хариултанд ирснээс хадгалсан цөөхөн хэдэн цааснаас өөр юм байсангүй. Гар цүнхэнд бүр боодолтой таван мянгатын цоо шинэ дэвсгэртүүд гар эсгэх шахам хадгалсан байлаа. Ухаан дэн дун байсан болохоор Дэлгэрмаа энэхүү мөнгө хаанаас гарч ирснийг үл анзааран далд хийсэн бололтой юм. Ерөөсөө Дэлгэрмаа овоо мөнгөтэй байжээ. Саяхан Токиогоос нөхөр нь мөнгө явуулсан байлаа. Үхэл хагацал тохиолдов хэмээн ажлын газрынхан, танил найз нөхөд дугтуй, дугтуйгаар мөнгө өгчээ. Хэдхэн сартай байсан жаахан амьтанд юу их юм орох билээ. Тэгээд одоо цагт хуучных шиг машинаар ус зөөж, зуурмаг хийн, цементээр булш бунхан хийн нүсэр оршуулга хийх биш, тэгсхийгээд л газарт шингээж, хөрсөөр нь хучсан болоод ажил явдал дуусдаг юм чинь... Харин ч зарим хүн эртний хүүхэд хөдөөлүүлэх ёсыг бодож, цагаан уутанд боов, чихрийн хамт хийгээд амьтны унтаа өглөө эртний цагаар энгэр газар “гээчихье” гэснийг Дэлгэрмаа зөвшөөрсөнгүй билээ. Ямартай ч байсан яс махны минь тасархай. Эцэг нь ирээд гай зовлон болсныг мэдэж шарил дээр нь очье гэхэд үзүүлэх овгор шороогүй бол би яах билээ гэж бодоод Баруун Наранд боловсон ёсоор оршуулжээ.

Тэр явдлыг санах тутамд залуу эх шаналан зүрх базлах тул мартахыг хичээв. Тэрвээр цээжээ даран унах гэж гуйвж ирэхэд,

-Хүүе та яаж байнаа? Дотор чинь муухайрав уу? хэмээн нэгэн залуу түшиж авав.

-Зүгээр... зүгээр... Баярлалаа.

Дэлгэрмаа сандал дээр суув. Залуу бүсгүйн хүйтэн хөлс цувжээ. Нар аажмаар шингэх гэж бөгчим халуунд ялаа батгана бужигнаж байлаа. Хэн нэгэн түүнийг зүслээд авах вий. Хүүхэд тэвэрсэн тийм царайтай, тийм хувцастай хүүхэн тэгж ингэж явсан гэж цагдаад мэдүүлэх вий. Юу болоод толгой эргэж унах шахав даа байз? Миний цусны даралт бага шүү. Сэтгэл санааны хямралаас болж даралт бүр буучих вуу яав?

Дэлгэрмаа хүчлэн босч хүүхдийг тэврэн цааш зугтах мэт холдлоо.

-Хүүе эгч ээ та манайд орж хүйтэн цай залгилахгүй юм уу? гэж аравдугаар ангийнх болов уу

гэмээр залуу хөвгүүн хойноос нь хашгирахыг ч тэр сонссонгүй... Дэлгэрмаа гүйхээрээ явж, албаны конторууд зэрэгцүүлэн барьсан төвийн хаа нэгтээ байх дэлгүүр рүү яарав. Ашгүй тэнд хүн цөөхөн байлаа. Залуу бүсгүйн эрээн даавуу, жаахан хөвөн боолгож, амныхаа цангааг тайлах гэж хоёр шил том савтай алимны хүйтэн ундаа торонд хийлгэж аваад гарлаа. Тэрбээр хүмүүсээс холдон, айлуудаас зайтай байх түргэн урсгалт голын эрэг дээр хүрээд сая санаа амарч зүлгэн дээр унан тусав... Яг энэ үеэр хүүхэд сэржээ. Тэр хөвгүүн уйлсангүй, харин ч эрүүл агаарт гарсандаа, сайн ээж түүнийг согтуу зээрхэг эрээс авран хамгаалж мөөмөө хөхүүлэн авч ирсэнд баярласан мэт аяархан, тэгэхдээ шувуу жиргэх шиг энхрий дуугаар юухныг ч юм ярих шиг болов.

-Иш хөөрхөн үр минь сэрчих вүү? Уйлдаггүй баатар эр юм гээч хөөе. Аль вэ ээж нь чамайг хуурайлаад өгье. Энэ мөчөөс эхлээд би чиний төрсөн ээж, чи миний заяасан үр боллоо. Мэдэв үү? гэж Дэлгэрмаа нүдэндээ нулимстай, хоолойгоо чичрүүлэн хэлж хөвгүүнийг үнсэн таалав. Чингээд өмсч явсан шинэхэн гадуур цамцаа тайлан дэвсч, хүүхдийн өлгийг задалжээ. Бяцхан хөвгүүн хэдийнээ живх, даавуугаа норгосон байлаа. Залуу эхийг тийнхүү өлгийг задлан, нойтон даавууг сольж, саяхан дэлгүүрээс авсан шинэхэн эрээн даавуу цуулан дэвсч, дээр нь тавихад аль өглөөнөөс хойш баглаатай байсан нялх амьтан сая л нэг дураар тарвалзан, хөл гараа тэнийлгэн чилээгээ гаргажээ.

Дэлгэрмаа баярлаж ханахгүй байв. Хичнээн удаа харах тутам, энхрийлэн үнсч таалах тутам бяцхан хөвгүүн түүнд улам улам дотно санагдан, залуу эх түүнд ээнэгшин дасах шиг болов.

-Ай хонгор хөөрхөн үр минь... Ямар хөөрхөн хүү вэ? Аль вэ тамхи татъя! хэмээн Дэлгэрмаа хэлж, гар хүргэн хамартаа үнэрлээд,

-Аапчихий! хэмээн алиалж инээв. Залуу ээжийн алиалан хэлсэн үгийн ойлгосон аятай мөнөөхөн жаал ход ход инээх нь тэр.

Энэ хүү нялх амьтны ямар ч хар сэжиггүй ход ход инээх дуун Дэлгэрмааг бүр уяруулчихав. Тэр дуун үрийн нь дуун байлаа. Тэрхүү ход ход инээх чимээг сонсох гэж л энэ хорвоод Дэлгэрмаа үр төрүүлсэн шиг санагдана. Тэрбээр аз жаргалтай инээж буй хүүгээ байгаа чигээр нь дахин дахин харах гэж хичээдэг байсан. Инээхгүй ямар нэгэн юм харах гэж харцаа тогтоон, мойл хархан нүдээрээ мэлтийн ширтэж байхад нь ход ход инээлгэх гэж гижигдэн үнсэж таалдаг сан... Хүүгийн нь үнэртэй, хүүгийн нь инээдтэй энэ жаахан амьтан хэний үр төл байлаа ч гэсэн одоо бол хорвоо түүнд хайрласан хишиг буян, золоор олдсон хайр мөн шүү гэж бодоход Дэлгэрмаагийн сэтгэл уужрана.

Үрт амьтан бүхэн л үрээ ингэж хайрладаг байх даа. Моодгорхон сүүлээ сөхөн өхөөрдмөөр янцгаах унагаа эх гүү чингэж хараад, дууг нь таниад л баярладаг байх даа. Эсвэл бутанд зассан үүрэндээ бяцхан ангаахай нь жиргэн донгодохыг сонсоод эх болжмор яаран нисч ирдэг байх даа. Амьтны үр ялгаа юу байх вэ. Нүдээ нээгээгүй гөлөг ямархан хөөрхөн амьтан байдаг билээ дээ. Аяархан гийнаж, эхийн сарвайсан олон хөхийг олох гэж тэмтчин буй гөлгөө гичий нохой яаж долоон энхрийлдэг сэн билээ дээ. Тэгэхээр үр төл гэгч ямарваа амьтны жаргалын мэлмийг баярлуулагч амьтан мөн шүү.

-Хонгор жаахан үр минь чи хэний хүүхэд байлаа ч ялгаагүй нэг эхийн өвөр дээр л дэгэж

дэрвэж өснө. Чамайг минь хайртай ээжээс чинь хортой муу санаатан хулгайлж, хаа нэгтэй хүргэх гэж явсан ч юм уу хэн мэдлээ. Хотын захад, найгүй архичин ганц шил архинаас төрсөн нялх үрээ зарчихаж гэнэ гээд л шар сонинд бичсэн байсан шүү. Тэр согтуу залуу шил архинаас биш юмаа гэхэд овоохон мөнгөөр нялх амьтныг зарах гэж эхээс нь хулуусан ч юм уу бүү мэд шүү дээ. Хэрэв тэгж явсан бол би энэ жаалыг аварсан болж таарч байна. Үнэхээр би буян хийж тэнэг мангуу архичнаас хүүхдийг салгаж чадсан бол өөрийн гараар өсгөх эрх надад байх л ёстой... Харах царайнаасаа архичин байрын тэр залуу хүүхдийг хүргэх газраа хүрэхээс наана аманд нь балга сүү өгөхгүй байсаар харангадуулж мэдэх хүн байна билээ. За ямай, ямай... Хүү надад олдсон нь л их юм... Сэтгэлээ сатааруулах үртэй болсондоо л баярлаж явахаас...

-Охин минь чийгтэй зүлгэн дээр хүүхдээ нүцгэн тарвалзуулж болж байгаа юм уу? гэж настай хүн хэлэхэд Дэлгэрмаа цочин эргэж харлаа. Зүлгэн дээр хэвтэх аргал түүн хормойлж буй настай эмээ энэ үгийг хэлсэн ажээ. Гэмт хүн гэлбэлзэнэ гэгчээр, Дэлгэрмаа айх шиг болж бушуухан хүүхдийг өвөр дээрээ авав.

-Одооны багачуул та нар ийм л болчимгүй. Наад хүүхэд чинь чийг авбал өвдөж хавдана. Тэгээд ч өдийд дэлэнч гарчихаад хүүхэд бүү хэл зэлэн дээр үнээ саалгахгүй байхад... гээд хүүг хээ шаагүй үнсэж,

-Ээ гэгээн. Ямар мариалаг амьтан гэх ч вэ? Ээжийгээ ч харин нэг яг хуулж төрж дээ. Уйлдаггүй, цовоо цолгин сайхан хүү байна... Чи манай эндхийн охин биш шиг... Хотоос яваа юу? гэж эмээ үгэнд дурлав.

-Тиймээ би хотоос яваа... Модны хоёрдугаар бригад руу явж очдог бол? Унаа явдаг л байх даа? гэж Дэлгэрмаа асуув.

-Хөрөө арааман дээр оч. Тэндээс унаа тасардаггүй юм... гэж эмээ хэлээд явахдаа,

-Өлгий нь зузаан юм байна. Одоо ч зун цаг... Нимгэн хөнгөхөн л өлгийдсөн дээр дээ... гэжээ.

Эмгэн аргалаа түүн хормойлсоор холдов. Нээрээ дороосоо чийг авч, шинэ хүү нь өвдөх вий хэмээн Дэлгэрмаа ухаан гартлаа айв. Тэрбээр хүүг өлгийдөн бушуухан л унаа хайхаар явах гэж яарав.

Билэгжаргал, Дэлгэрмаа хоёр амьдралын уудам хөндийд гал голомтоо бадраагаад таван жилийн нүүр үзэж байлаа. Уулын инженерийн мэргэжилтэй нөхөртэйгээ тэрбээр геологчдын нэгэн баярын үеэр танилцжээ. Урьд нь би биеэ мэддэг л байв. Билэгжаргал өнгөт чулуу олж, түүнээ шинжлүүлэх гээд их хотын баруун дүүрэгт байх Геологийн төв лабориторт дандаа л ирнэ. Өнгөт чулууны тасгийг хариуцдагийн хувьд Дэлгэрмаа эх орны сэтгэл татам хөдөө нутгийг үнэр ханхалсан тэр чулуунуудыг хүлээн авч, сорьцыг шалган, аль галавын үед тогтсон ямар чулуулгаас үүссэн хийгээд, юунд зориулан ашиглаж болохыг тодорхойлон бичиж өгнө. Залуухан инженер, тэр мөртөөсөө тасгийн дарга бүсгүйн гараас үнэт чулууныхаа шинжилгээг авсаар байгаад Билэгжаргал дасчихсан ч байж магадгүй. Бүсгүй хүнийхээ нүдээр хөдөөнийх шиг энгүүн энэ бор залууг ажин, ичимтгий бүрэг дарууг нь

мэдэж нууцхан өхөөрдөхдөө Дэлгэрмаа анхандаа энэ хорвоогоос олох ёстой, учрах ёстой хань нь энэ мөн гэж огтхон ч бодоогүй билээ. Ажлын хүмүүс зүгээр л тоглоом тохуу хийн уулзацгааж, ажлаа л ярьцгааж, шинжилгээний газрын дөрвөн давхар байшингийн шатан дээр тааралдвал мэндэлцгээж, хааяахан өнгөт чулуугаа өгчихөөд Билэгжаргал дагуулан уудам том танхимтай хоолны газар хооллож байхдаа ч хайр сэтгэлийн ямархан нэг шинж бие биедээ мэдүүлээгүй билээ. Чингэтэл Ноён ууланд алтны хайгуулд Билгээ явах болов. Зүгээр нэг геологийн журмаар ч биш, харин шинээр эмхлэн байгуулж буй хувийн компанийн захирлын алба хашихаар явах болжээ.

-Манай тэнд хэдэн жил ажиллаад үзэхгүй юу? Хөлс цалин гайгүй олгоно. Хэрэв алтны гарц сайн байгаад ашиг орлого их бол нэмэгдэл ашгаасаа хувь хүртээнэ. Байгаль сайхантай, өвөлд дулаахан, цас багатай, зун сэрүүхэн, тун сайхан нутаг шүү гэж Билгээ инженер нэг удаа ирээд зориуд Дэлгэрмаатай хамт зоогийн газар хооллохдоо хэлжээ.

Тэр үед зах зээлийн шинэ тогтолцоонд шилжээд, Геологийн төв шинжилгээний газар зарим тасгаа цомхотгон, олон хүн ажлаасаа гарч, зарим нь наймаанд шогшин, зарим нь хөдөө нутаг тийш алтны уурхай, хайгуулын анги руу явцгааж байлаа. Яг үнэндээ Дэлгэрмааг хална, өөрчлөнө гээгүй боловчиг, тэрбээр дээрээс ирсэн шахалтанд орж тасгаа татан буулгаад овоо нэртэй, сайн ажилтай инженер, лаборантуудаа халах солиход хүрээд байжээ. Тэднийг ажил амьдралгүй болгочихоод зүгээр цалингаа авч суух эрх түүнд байхгүй хэмээн Дэлгэрмаа бодож, өөрөө яаж ийж байгаад боломжийн ажил олоод хийчих юмсан гэж бодох болжээ. Хэрэв тэгж гэмээ нь нэг нь ч гэсэн ажилтай үлдэж, харин Дэлгэрмаа олон хүн халав солив гэжэ сэтгэл өвдөхгүй амар байх сан...

Билэгжаргалын үг ёстой л загатнасан газар маажих шиг болов. Үгүй нээрэн хөдөө явж азаа туршвал яасан юм бэ? Одоохондоо ямар хань ижилтэй болж үр хүүхдэд шавуулчихсан биш... Нас ч залуу байна. Алтны уурхайд азаа туршаад үзвэл яасан юм?

Тэр нэг их удаан бодсонгүй шууд л шинжилгээний газрын даргадаа учраа хэлэв. Танил уулын инженер алтны уурхай байгуулаад уриад байгаа тул ар талдаа татлаа түлхээгүй дээрээ Ноён ууланд очиж алт шинжилье гэсэн хүсэлтээ хэлэв. Хүнээ багтааж шингээх гэж ядаж буй лабораторийн даргад Дэлгэрмаагийн үг хужир байлгүй яахав.

-Уг нь би чамайг боловсон хүчний хувьд өөрийнхөө нөөцөнд бодож байсан юмсан... Хэдэн жил тасаг хариуцлаа. Хүнтэйгээ ажиллаж сурсан хүн шүү дээ чи. Гэвч яая гэхэв. Жолоо цулцуурыг чинь эвхэж тавихаас биш... Насны залууд газар үзэж, хөдөө хөхөрч, гадаа гандах муу ч юм биш. Тэгж явтал алтан дээрээс амьдралынхаа алтыг олоод авах ч юм уу хэн мэдлээ... гэж дарга нь тоглоом наргиан хослуулан хэлжээ.

Ноён уулын өвөрт нэг их сайхан хөндийд зөвхөн гар цүнх, пүүгээ дэвсгэрээс өөр хогшил хөрөнгөгүй Дэлгэрмаа машинаас буув. Тэнд ердөө л хоёр гэр, нэг майхан байсан нь алт олборлох компани сая дөнгөж эмхлэн байгуулагдаж байгаагаас тэр ажээ.

-Дэлгэрмаа инженер бүхнийг ойлгож байгаа биз. Одоохондоо байр сууц тааруухан л байна. Энэ таван ханат гэр ажилчдын нийтийн сууц... Тэнд орж олонтойгоо бужигнаж амьдрах уу? Эсвэл өдөрт албан контор болчихдог, шөнө миний нойр авах газар болдог энэ жижиг гэрт

орно уу, өөрөө мэд! гэж Билгээ хэлэв. Дэлгэрмаа харин баахан шийдэмгий ааш гарган, гар цүнхээ бариад албан конторын хаалга татан орж явчихав.

Эхний тэр өдрөөс л Дэлгэрмаа танилынхаа идэвхтэй туслагч болжээ. Тэгэхээс ч өөр аргагүй байв. Өдөржингөө алтны уурхайд хэрэгцээтэй элдэв багаж, усан буу, тосгуур сэлтийг бараг ганцаараа шахуу ачсан Билэгжаргал туйлын их ядарсан байлаа. Тэд оройн нар шингэсний дараа Ноён ууланд ирсэн болохоор юухан хээхэн идэж аваад амрахаас өөр яах сан билээ. Билгээ ачаагаа буулгаж байх хооронд Дэлгэрмаа өөрт оногдсон эм хүний ажлыг хийхээс л аргагүй болжээ. Залуу бүсгүй даруй зуух галлан, тогоо тавьж цай чанав. Гэрээс авч гарсан борцоо нүдэн, бэлэн гоймонгоор хоол хийв. Чингээд хамаг ачаагаа арайхийн буулгаж уурхайдаа байрлуулсны дараа худалч хүнд бараг ядарсандаа гуйвах шахсан Билгээг ирэхэд албаны нь ширээн дээрхийг зайчлан, сайхан цай, борцтой хоол тавьж өгөв. Бас зүгээр ч үгүй, миний ажлын гараа өнөөдөр эхэлж байгаа шүү дээ гэж бодон шил архи задлан хундагалжээ.

-За хоолоо ид, цай уу! Их ядрах шиг боллоо доо. Май ганц хундага тогтоочих! хэмээн Дэлгэрмаа гэрийн эзэгтэй шиг л аашлав.

-Өө яах нь вэ дээ. Манайхан хоол хийчих л байсан... Зочноороо хоол хийлгээд миний байж байгаа царайг дээ... гэж Билгээ дуу алдах авч, чингэж өөриймсөг сэтгэл гарган, хамаг бүхнийг бэлдсэнд туйлын баярласан нь ил байлаа.

-Ямар юмны зочин байх вэ. Энд зорьж ирснийх хоолоо ч хийгээд идчихэлгүй дээ...

Чухам энэ үг л Дэлгэрмаагийн амьдралыг шийдсэн билээ. Дараачийн хэд хоног нэг гэрт амьдарч, ажлынхаа төлөө чөлөө завгүй зүтгэх Билгээгийн хоолыг хийн, хог шороог цэвэрлэж албан конторт яг л гэргий хань шиг нь халамжилж байхдаа залуу бүсгүйн сэтгэлийн далд дахь лац ломбо аажмаар ханзарчээ.

Уурхайн ажил эхлээд удаагүй байсан тул бэлэн зэхээ шинжилчихээр алтан элс тийм ч ихээр гарсангүй тул Дэлгэрмаа усан буу угсралцаж, хөрс хуулалтан дээр зүтгэн, хамаг ажилд ганцаараа зүтгэх Билгээгийн хоолыг хийж, хувцсыг базан нэгэн ёсондоо гэргий ханийн үүргийг гүйцэтгэх болов.

Билгээ бол ажлын төлөө л зүтгэсэн дэндүү гэхээр ажилсаг, хэн нэгэнд дарга, захирал хэмээн ихэрхэх зангүй, хоол унд голохгүй маш энгийн даруу хүн болохыг залуу бүсгүй аажимдаа ойлгов. Архи дарс барагтай бол уухгүй, нөхөдтэйгээ дарвин амслаа ч гурван хундаганаас хэтрэхгүй, харин тамхийг бол овоохон татчихдаг эр ажээ. Гуч дөнгөж л гарч буй насны энэхүү эр хүн харин шөнөөр ороо зэрэгцүүлэн засч унтах мөртлөө Дэлгэрмаагийн янзыг үзэн ядаж толгойг нь илсэн удаагүй. Үнэндээ нэг гэрт хоёулахнаа унтдаг болохоор бүсгүй хүнийхээ хувьд тийм явдал болж магадгүй хэмээн Дэлгэрмаа сэтгэлдээ хүлээж байсан авч, Билэгжаргал хажууд нь зассан орон дээрээ дэрэнд толгой тавимагц унтаад өгдөг нь сонин байлаа.

Ингэх нь нэгэн талаар Дэлгэрмаад амар байсан боловч, шөнө эр хүний хурхирахыг сонсох, содон соргог үнэрийг нь авч нойр хүрэхгүй тийчлэхдээ эм хүний нь сэрэл хөдлөн байж ядна.

Энэ ер нь яасан сонин эр вэ? Түүнд эр хүний хүсэл бадрах үе байдаг болов уу? Эсхүл би түүнд эм хүнийхээ хувьд гологддог юм болов уу? Билгээ ер нь хүнд дурлаж үзсэн үү? Энэ идэрхэн эр хүн хүүхэн гээч амьтантай өвөртөө орж байсан уу? хэмээн залуу бүсгүй гайхан бодох авай. Тэдний дунд үл үзэгдэх ямар нэгэн хөшиг татаастай байх шиг санагдаад удлаа. Эр хүний нь хувьд халамжлан тойлсоор, хоол хошийг нь хийж, хувцас хунарыг нь угааж, гэр орныг нь цэвэрлэсээр Дэлгэрмаа түүнд дасч орхив. Үнэнийг хэлэхэд нэг л шөнө Билгээ нь хөнжлийн сэжүүрээс болгоомжтой нь аргагүй татаад өвөрт ороод ирэх юмаа гэхэд Дэлгэрмаа ер гайхахгүй, харин ч эм хүнийхээ хүсэл тачаалыг дийлэхгүй тэврэн авахад бэлэн байлаа. Тэр бол Дэлгэрмаагийн хувьд шинэ юм биш, тэртэй тэргүй үнэрийг нь авч, халуун амьсгааг нь сонсч, хувцаснаас нь ханхлах ямарваа архины угааргүй үнэрт дасчихсан болохоор номтой юм, номоороо болж байна л гэж бодох сон биз... Гэтэл ийм явдал болсонгүй удлаа. Хүмүүс Дэлгэрмааг уурхайн захирлын гэргий л гэж боддог бололтой юм. Өдий хэрийн нас биенд хүрсэн эр, эм хүмүүс нэг гэрт зүгээр хононо гэж байхгүй дээ. Билгээ захирал дэндүү бүрэг даруудаа л үгээ хэлэхгүй, ханьтай болсноо нуугаад байна гэж бодох бололтой.

-Нөхөр чинь байна уу? Хайчсан юм бол? гэж сураглах,

-Түнхэлийн модны аж ахуйн хамтын ажиллагааны гэрээнд гарын үсэг зурмаар байна гэж бидний хүсэлтийг хар хүндээ дамжуулчихаарай! гэж хүмүүсийн хэлэх бол ердийн хэрэг болов.

-За нөхөр бидэнтэй хамт явнаа. Зуны цаг зургаа биш дээ. Хөрсөн дор байгаа алт ямар ус шиг урсаад явчих биш. Ойрд уулзсангүй. Ганц өдөр сайхан амрая. Энэ бүсгүй чинь үзсэн хүн байх шив. Гэргийгээ найздаа танилцуулаач! хэмээн бага зэрэг архи үнэртүүлсэн геологч залуу ирээд хэлжээ.

-Миний гэргий юу... Юу л даа хө, чи таних л ёстой. Геологийн лабораторийн хар нүдэн Дэлгэрмаа чинь энэ шүү дээ. Хөдөөнөөс шороо шинжлүүлэх гээд лаборатороор зөндөө л ороо байлгүй. Тэндхийн урдаа барьдаг сайхан хүүхнүүдийн нэг, өнгөт чулууны тасгийн сайн дарга гэвэл санаанд чинь юм орж байна уу? гэж Билгээ ийм сайхан амьтныг авчирсан би мундаг байгаа биз гэсэн шиг хэлжээ.

-Үгүй тэрээ хөөе. Манай геологийнхний ам амандаа цуураад байдаг хар нүдэнг мань хашир суга татаад аваад ирж... Дуугүй хүний юу, ямар гэдэг билээ? Ичимтгий царайлж байгаад манай Билэгжаргал их аргатай хүн байх нь ээ... За юмаа бэлд. Би ямаа захисан... Замдаа айраг олж аваад Ноён уулынхаа ар бие рүү хүрч цэнгээд авдаг хэрэг гэж залуу шавдуулав.

-За “гэргий” минь юмаа бэлдэж дээ. Сейфэнд хоёр шил архи байгаа... Тэндээс мөнгө аваад мухлагаас зугаалганд хэрэглэх жаал жуул юм зэхчих. Би энэ нөхөрт уурхайгаа үзүүлээд орхё. Алтны компани байгуулж байгаа хүн юм байна. Надад хэлж өгөх туршлага ч байгаа биз...

Билэгжаргал ямархан нэг тоглоом шоглоомгүйгээр чингэж хэлээд түлхүүрээ өгөв. Дэлгэрмаад энэ үг тун тааламжтай сонсогдож билээ. Хэзээнээс эхлэн өөрийг нь Билгээ чингэж гэргий ханиа гэж боддог болсныг хэн мэдлээ. Түүний үгний цаана залуу бүсгүйд итгэсэн халуун итгэл найдвар байна гэж ойлгоод Дэлгэрмаа хүүхэд шиг хөөрч, зугаалгын юм зэхэхээр ханцуй шамлан оров.

Зуны сайхан өдөр Ноён уулын ард, бүр Хараа гол хүрч баймааж тэд бууцгаажээ. Зугаалганд тэднийг “уруу татсан” эр хоёр жаахан хүүхдээ, эхнэртэйгээ авч явав. Эрчүүд ямаа боох гэж, хүүхнүүд гэдэс дотор арилган, цай цуй чанаж, том бэржээнх дээр дэлгэн тавьсан чихэр, жимснээс хоёр жаал дураараа авч идэн, шугуй бургасаар нэг инээд шуугиан болцгоов.

Жаргалтай цагийн инээд хөөр, баяр баясгалан үе зэргэмжээ насны хоёр бүсгүйг дотносуулжээ.

-Танай хар хүн сайн хүн шүү! гэж танилын авгай ам нээв.

-Эд нар хар багаасаа найзалсан улс гэнэ билээ. Манай хүн хааяа балгах дуртай, харин Билгээ амсахаас цаашгүй. Түүгээрээ л таардаггүй байх... Манай хар хүн уухлаараа бас ааш муутай. Тэгэхдээ эхнэр, хүүхдээ дарамтлаад байдаггүй. Олон үгтэй болж шалчиганах нь л хэцүү. Энэ хоёр хөдөө хайгуулд олон ч жил хамт явсан даа. Геологийн ажил хэцүү. Дандаа уул, даваа хэдрэн хэсч явдаг болохоор наад зах нь хувцас тэсэхгүй. За тэгээд эрснээ олбол түүн шиг жаргал тэдэнд байдаггүй юм билээ. Билгээг хань ижилтэй болоосой гэж бид их хүлээсэн... Ашгүй чи хүрээд ирж... Хайрламаар сайхан хүн шүү... хэмээн гэдэс сурмагаар арилгаж байхдаа үеийн хүүхэн ярих ажээ.

-Үгүй би ч яахав дээ энд зүгээр л нэг шинжээч инженер төдий... гэж Дэлгэрмаа цааргалахад,

-Арай үгүй байлгүй дээ. Чамайг чинь Билгээтэй минь ханилж гэж бид их л баярлаж байгаа шүү. Нээрээ та хоёр үгээ олж чадаагүй яваа гэж үү? хэмээн өнөөх хүүхэн гайхжээ. Чингээд зогссонгүй элдвээр шалгаасаар байгаад үнэн учрыг хэлүүлж билээ.

-За тэгнээ тэр. Манай Билгээ гэж ийм л бүрэг даруу амьтан шүү дээ. Та хоёр яг таарна. Чи ямар өөрт нь сайн болов хэмээн хойноос нь гүйж үгээ баралтай биш. Хэзээ бүсгүй нь гуйж байлаа. Найз нь та хоёрын хувь заяаг шийдүүлээд өгье. Түүнд хайртай чинь үнэн л юм чинь...

Хоёр жаахан хүүхдээ эрхлүүлэн, хооллож, усанд умбуулж шумбуулан, өөрсдөө ямааны халуун боодог идэн айраг ууцгааж, сурсан сурснаараа ганц нэг хундага тогтоон, наранд шарж, бас чиг хөзөр тоглосоор үдэш болоход яалт ч үгүй майхан барьж хонохоор болцгоов. Хээр газар, зун цагт хэнээсээ айж ичих вэ, гадаа хоёр хүүхэдтэйгээ унтацгаая гэцгээн нөгөө хоёр бургасны ёроолд ороо засацгаав. Харин Билгээ, Дэлгэрмаа хоёрыг хучих илүү дутуу хөнжил гудас алга хэмээн нэг оронд хүчээр шахуу оруулж билээ. Тэр шөнө Билэгжаргал анх удаагаа Дэлгэрмаагаа тэвэрсэн сэн... Хорвоогоос олох ёстой хүн нь Билгээ мөн байсанд бүсгүй үнэхээр баярлажээ.

-Харж ханашгүй сайхан хүү төрүүлж өгөөрэй...

Хожим юунаас ч ичиж зовохгүйгээр нэг гэртээ нэг орон дээр жаргал эдлэн хэвтэж ахуйдаа Билэгжаргал хүүхэндээ чингэж захидаг байж. Ханилан суугаад хэдэн жил өнгөрөхөд тэр хоёр хүүхэдтэй болсонгүй. Хэдэн жил алтны гарц сайнтай газар олборлолт сайн байсан тул аж ахуйн хувьд ч уурхай нь бэхжиж, ар гэрийн амьдрал санаснаас илүүгээр дэгжээд ирэв. Уул уурхайн сайн инженер Билэгжаргалыг мэргэжлээрээ хэдэн жил Японы нэгэн уурхайд ажиллана уу гэж урьжээ. Билгээ явах дургүй байсан болов чиг харин Дэлгэрмаа,



-Чи минь явж үз. Тэр хөгжилтэй оронд ямар маниас туршлага авна л гэж урив гэж үү. Гадаад оронд бүгд техникжсэн болохоор гар хурууны үзүүрээр, хар биеийн хүчээр хийх ажилд хүн олддоггүй юм гэнэ билээ. Тэр ажилд нь зүтгээд хэдэн жил яахав дээ, юм үзээд ирсэн дээр! гэжээ.

Билгээ эхнэрийнхээ үгнээс зөрсөнгүй. Уурхайгаа найдвартай хүнд өгчихөөд, хотод гурван өрөө байр авч гэрээ тохижуулан, алсын далайн зүг нисэн одов. Токиод төв нь байрладаг уул уурхайн чиглэлийн том компанид нөхөр нь ажиллах болов. Үнэхээр хар бор ажилд ч Билгээг зарж, тэрбээр овоохон шиг ногоон цаасны цалинтай, Токиод байртай, хойт Японд уурхай хэсч явдаг ажилтай хүн болов.

Жилд нэг удаа Билгээ хүрээд л ирнэ. Ханилж суугаад удаагүй хоёр амраг гал бадартал уулзацгаан, хэдэн хоног хамт жаргацгаана. Ханиа өвөртлөн хэвтэж байхдаа Билгээ үе үехэн санаа алдах нь бий. Чингэх бүр Дэлгэрмаа санаа нь зовж орхино. Нөхрийн нь сэтгэлийн шаналгаа бол үр хүүхэдгүйдээ гутарсны тэмдэг хэмээн Дэлгэрмаа ойлгож байлаа.

Ингэж байтал, ноднин зун Билгээг амраад буцсанаас хойш хоёр сарын дараа Дэлгэрмаад хоол зохихыг болив. Бүсгүй хүнийхээ зөнгөөр, хүсээд байсан нь хүрээд ирэв үү хэмээн сэм баярлажээ. Тэр нь ч үнэн байлаа. Хүүхдээ гаран гартал Дэлгэрмаа нөхөртөө баярт мэдээг дуулгасангүй билээ. Харин төрөхөөс гараад хэдхэн хонож байхад нь Билэгжаргал өөрөө утасдан сэтгэл нь хөдлөхдөө уйлах шахан,

-Хүү мөн үү? гэж дахин асууж байлаа.

-Тиймээ чи бид хоёр хүүтэй болсон... гэж Дэлгэрмаа ам дүүрэн хэлжээ.

-Бушуухан л харих юмсан... Чамдаа их баярлалаа.

Билгээ үрээ үзэхсэн гэж туйлын их хүсч байв. Хүүтэй болсноо мэдснээс хойш тэр бараг өдөр болгон шахуу утсаар ярьж гэргий, хүүхэд хоёрынхоо амар мэндийг эрэх болов.

Хэдэн сар өнгөрчээ. Хүү ч овоо том болж, ганганан гунганан, мойл хархан нүдээрээ юуг ч харах гэж харцаа тогтоон, үе үе эхийн сэтгэлийг уяруулан ход ход инээнэ. Үртэй болсон эхийн сэтгэл үертэй гол шиг бялхаж цалгин, зүрх нь Дэлгэрмаагийн цээжинд багтаж ядах мэт булгилан догдолж байлаа. Багцаагаар бодоход Билэгжаргал ирэх дөхжээ. Хавар хэдийнээ ирж, бургас гөлөглөн, дууч шувууд цонхон дор жиргэх нь сонсогдоно. Тэр шувуудын нэг нь гэрт ороод ирсэн аятай, бяцхан хүү нь өөжиндөө шулганан, юуг ч юм өөрийн хэлээр ярихад,

-Тийм ээ миний хүү.. Аав нь өнөө маргаашгүй хүрээд л ирнэ. Аз болоход тэндэх албаа дуусгаад бүрмөсөн ирэх ч юм бил үү? Тэгвэл аавтайгаа гурвуулаа ёстой л гэр бүлийн аз жаргалд умбана даа... гэж Дэлгэрмаа сэтгэл догдлон хэлэх нь бий.

Шинэ уурхай нээх гээд зав чөлөө муутай тул намраас нааш очиж чадахгүй нь хэмээн Билгээг хэлсний дараахан нэг орой хүү нь жигтэйхэн халуурав. Залуу эх ухаан алдах шахан гэрт байсан эмээ өгч, элдвээр аргалж ядаад өрхийн эмнэлэгт үзүүлбээс,

-Наад хүүхдээ авч даруй эмнэлэгт хэвт. Шинж тэмдэг нь цахилгаан мененгет хэмээх өвчинтэй төстэй байна. Шинжилгээ хийлгээд өвчний нь оношийг тодруулсан дээр... хэмээн залуухан эмч бүсгүй хэлжээ.

Дэлгэрмаа энэ үгийг сонсоод эгээ л ухаан алдаж унасангүй. Тэр даруй түргэн тусламж дуудсан боловч, манайхны ажил бүтэх биш дээ, бараг хоёр цаг болж баймааж нэг юм ирэв.

Түргэний тэргэн дотор хүүгээ тэврэн сул асгарах нулимсаа арчих ч сөгөөгүй явахдаа Дэлгэрмаа хэдхэн хоногийн дараа Гандангийн дэнжээс гав ганцаараа толгойгоо унжуулан буцах юм гэж зүүдэлсэн ч үгүй билээ. Айхтар хурц өвчин чингэж газар дээр олдсон ганц эрдэнийг нь, яс махаа яйруулах шахан гаргасан ертөнц дээр санаж сарвайх энхрий үрийг нь булаав. Хэн нэгэн ухаантай зохиолчийн хэлснээр ёстой л “Хорвоо чи хүний зовлонд цадах болоогүй юу” гэж тэгэхэд хашгирмаар л байлаа.

Ухаан санаа дэн дун байж, найз нөхөд, хамаатан садныхаа дэмжлэгээр хүүгийн ажил явдлыг дуусгасны хойно, гэрт ганцаар үлдэх туйлын хэцүү болж ирэхэд, үеийн бүсгүй хэд хоног хөдөө гарсан дээр гэж зөвлөжээ. Хаашаа явах билээ? Дэлгэрмаагийн аав, ээж хэдийнээ бурхан болжээ. Харин Билэгжаргалын нас өндөр болсон хоёр хөгшин Түнхэлд, модны аж ахуйд ажиллах охиноо бараадан буусан байлаа. Тэдэнтэй ойрдоо уулзаагүй тул очих нь мөн гэж бодов. Хэзээнээс бэрдээ амиа тавьдаг аав, ээжид нь очиж, үнэнээ л хэлж сэтгэл цайрахаас өөр аргагүй гэж бодлоо. Чингээд л Улаанбаатараас Дархан-Сэлэнгийн галт тэргээр гарчээ.

Үрийн нь үрийг үхүүлчихээд яаж хоёр хөгшний царайг харах билээ гэж сэтгэлдээ шаналан явтал нэг мэдэхэд унтчихаж... Хүүхэд жигтэйхэн шаналгаатай уйлагнахад зүүд нойрон дунд өөрийн хүүг л гэж бодон үсрэн босчээ. Гэтэл...

Бурхан түүний хувь заяаг өөрийнхөө зарлигаар шийдэж өгөх шиг боллоо. Түүний гар дээр одоо алга болсон үрийн нь оронд, яг түүнтэй адилхан, мариалаг жаахан хөвгүүн нойрсч байна. Олон цагаар чинэсэн хөх нь саамширч, хүүг харах бүрийд ивлэн, дотуур нимгэн гуржваа захтай цамцны энгэрийг нь норгох ажээ.

Энэ чинь нээрээ юу вэ? Хэн нэг нь түүгээр даажин тохуу хийгээгүй биз? Хадам хөгшид дээрээ юу гэж хэлж очих билээ?

Хүний хүүхдээр гайхуулж очих бил үү? Үнэнээ хэлнэ гэхэд, энэ нялх амьтныг хаанаас олсон байж таарах вэ? Галт тэргэнд хүүхэд хулгайлсан гэвэл хөгшчүүл ухаан алдаад уначих байлгүй.

Жаахан хүүхэд тэвэрсэн царайлаг бүсгүй хөрөө араамын хашааны үүдээр орж ирэхийг залуухан жолооч ачаагаа буулгачихаад үүд рүү зүглэж явахдаа харав.

-Аятайхан биетэй дамшиг юм даа... гэсэн шүү юм бодож явтал хажуугаар өнгөрөх үед бүсгүй гараа өргөжээ.

-Хүүхэн гуай сайн уу? Юу гээв?

-Та модны хоёр руу явахгүй биз? хэмээн аль болохоор залуу эрийн анхаарлыг татах гэсэн шиг бүсгүй дур булаам инээмсэглэн асуужээ.

-Явбал юу гэж?

-Дорлигийнх гэж айл тэнд байна уу? Охин нь тоо бүртгэгч хийдэг Сайханаа гэж...

-Байлгүй яахав... Та тэднийд очих гэсэн юм уу? хэмээхдээ залуу жолооч, сайхан зантай, хэзээ ч орсон аяга цайтай байдаг хоёр хөгшнийг санах. Энэ бүсгүй бэр нь байх. Хүү нь Японд байдаг юм гэсэн... гэж бодож амжив.

-Би хоол идээд хөдөлнө дөө. Машинадаа тос, шатахуун нэмэх ч ажил бий.

-Би ч гэсэн хоол идмээр байна. Саяхан галт тэрэгнээс буучихаад...

Залуу жолооч нөгөө талынхаа хаалгыг онгойлгож өгөөд гараа сарвайв. Уртын мод ачдаг өндөр, том краз машины бүхээг рүү Дэлгэрмаа жолоочийн гараас татан гарч ирлээ. Хувь заяаны нь эгэл бус явдлыг үүгээр энэ удаад таслан зогсооё гэсэн шиг хүнд төмөр хаалга чимээтэйгээр тасхийн хаагджээ.

Дэлгэрмаа тос, шатахуун үнэртсэн жолоочийн бүхээгт ороод сая л санаа амарч уужимхан санаа алджээ.

“Юу л болбол болог. Ямартай ч байсан би элгээ дэвтгээх үртэй л хүн” хэмээн бүсгүй бодож билээ.

# АРВАН ТАВДУГААР БҮЛЭГ

## АЯНГА

Бадраа суудлын галт тэрэгний зоогийн газарт удаан суув. Ширээн дээр хэдийнээ сулласан шар айрагны хоосон шилнүүд хөглөрч байлаа. Тэрбээр халаасаа ухав. Бадраагийн гар хуруунд тэмтрэгдэх ганц улаан зоос ч байсангүй. Тэр их согтжээ. Одоо л нэг хэдэн цагийн ядаргаа арилж байна уу даа гэмээр санагдана. Хүүхэд хулгайлсан тэрбээр анхандаа зүгээр нэг баадантай юм аваад явахын дайтай ямар гэнэхэн бодож вэ? Хүүхэд гэдэг чинь амьд хүн л юм болсон хойно мөөмөө нэхэж, өлгийгөө норгоод уйлж охилон Бадрааг сандаргаж, ёстой нэг “махыг нь иджээ”. Түүнд жаахан хүүг угжчих угж, сүү байсангүй. Хуурайлах даавуу шаавуу ч мэдээж юу байхсан билээ. Эмнэлгийн тасгаас авч гарахад унтаж байсан хүүхэд нэгэн хэсэг овоо чимээгүй байснаа уйлж гарав. Угаас хүүхэд авч байгаагүй залуу эр яах ухаанаа олохгүй сандарчээ.

Бадраа шууд галт тэрэгний буудал дээр ирж тасалбар аваад явах цаг болоогүй тул зоогийн газарт оров. Ямар ч гэсэн үгэнд эс орж, түүнд үл дийлдсэн Ерөөгийн хүүхдийг хулгайлж чадсанаа тэр тэмдэглэн, хоёр зуун грамм архи авч нэг амиар хөнтрөв. Хүүхэд уйлсаар байлаа.

-Наад хүүхэд чинь ээрч уйлаад яасан хэцүү юм. Эх нь яасан юм бэ? хэмээн зоогийн газрын зөөгч хэлэв.

-Ээж нь юманд явчихаад... Би түр авч байгаа нь энэ... гэсхийн Бадраа өөрийнхөө ходоодыг халаах уушийг залгилж байхдаа хэлэхчээ аядав.

-Эсвэл наад жаал чинь өлгий нь нойтон, хуурайлуулах гээд байна уу? Аль вэ та нааш нь өг. Овоо болсон хүүхэд байна шүү дээ. Бор хоол иддэг юм уу?

Өөрөө хүүхэдтэй эх хүн болохоор зөөгч бүсгүй ээрч мууртлаа уйлаад байхад сэтгэл зовсон бололтой хүүхдийг нь авав. Чингээд зөлгөөн хар цай уулган, гал зуухны газраас нялх хүүхэд идчихмээр цагаан будааны чанамал авчирч, сандал дээр суулгаж байгаад хооллов. Хүүхэд нойтон өлгийнөөсөө салж, эрхбиш сайхан сэтгэлтэй эх хүний халамж тавьснаар будаа идэж, цай уугаад нэг ана боловч тайвширчээ.

Ингэж зөөгч бүсгүй тус болсон нь Бадраад тун таатай сэтгэл төрүүлэв. Яаж хүүхдийг Дархан хүртэл авч явна даа гэж байтал үйлчлэгч туслаад өгөхөд, ер монгол хүүхнүүд хүүхдүүдэд сайн тул, гал тэргэнд ч гэсэн хэн нэг бүсгүй жаалыг нь хооллоод, хуурайлаад өгөх байлгүй гэж боджээ.

Зоогийн газраас гарахдаа Бадраа өвөртөө ердөө л ахиад нэг шараа тайлах төдий мөнгөтэй үлдсэн байв. Тэрбээр архи уух хорхой нь ид асч байсан боловч, галт тэргэнд хоосон явахаасаа айгаад ахин нэмсэнгүй. Гадуур баахан явж, цаг хугацаа төөрүүлэн, өлгийтэй нялхыг тэвэрсэн гар нь чилэхэд сандал дээр тавин хэсэг зуур амарчээ. Түрүүхний уусан шилэн аяга дүүрэн архины ааг одоо мань эрийг хатгаж жүтгэн, дотор арзганаж архи уух хүсэл оргилж байвч шүд зуув. Бушуухан шиг л хөдлөхсөн хэмээн тэсч ядан байсаар арай гэж суудал олж тусалж авлаа. Чингэхдээ согтуу хүн сохор ухаантай гэгчээр цагдаа нар үзэгдэх вий, хойноос нь нэхэл дагал

болоод хүмүүс ирэх вий гэж ихэд айж, аль болохоор амьтны нүднээс далд байхыг хичээв.

Гадаа гудамжинд удаан байхын аргагүй ажээ. Халуун дулаан цаг тул духны хөлс цувж, агаар дугах шиг амьсгаа давчдаж байлаа. Магадгүй тэр ууснаасаа болоод уухилж, амьсгаадсан ч байж болох юм.

Энэ жаалыг л хүргээд өгчихвөл хамаг хэрэг бүтэх юм шиг Бадраа бодож байв. Тэрбээр Ерөөг авч явж дийлсэнгүй. Орцны нь үүдэн дээр барьж аваад таксинд чихэж зугтадгийн даваан дээр нэг муу хүүхэн ирж цагдаа энээ тэрээ гэж бархиран хамаг ажлыг нураажээ. Ерөөг хамгаалах, түүнд халдсан хэнийг боловч цагдаад бариад өгөх хүмүүс байгаа бололтой. Хэд хоног Бадраа, Ерөөг ойртож ч чадсангүй. Эцсийн эцэст хүүхдийг нь аваад зугтчих юм бол, тугалаа булаалгасан үнээ шиг араас пөг пөг шогшоод ирэх байлгүй гэж бодоод гагцхүү Даариймаа гуайн зааж өгсөн аргыг л хэрэглэх гэж тохиромжтой цагийг хүлээжээ. Цаагуураа ямархан нэг юм болж, Ерөөг хүмүүс гоёж гоодон, дэлгүүр хоршоогоор оруулан юм хүм авч өгч буйг хараад залуу эр далд сэтгэлдээ чухам юу гэгч болох гэж байгааг тааж ядсан билээ. Энэ хүмүүс Даариймаагийн Бадраад өгнө хэмээн амласан сайхан хүүхнийг өөр эрд өгөх гэж зэхээд байна уу? Тэгвэл нэгийгээ үзнэ дээ. Энэ хүүхэн минийх л байх ёстой гэж бодовч, цаадуулаасаа арай нүүрмэг, ер яахаас ч буцахгүй тэр Чимгээ гэгч авгай Ерөөгөөс ер салахгүй байх тул ойртож эс чадав. Чингэсээр байтал байнгад хүүхэд хулгайлах ашигтай цагийг хүлээн байсан Бадраад завшаан тохиолдож өглөө эрт Ерөө мөнөөхөн Ууганжаргал хүүхнийг дагуулан гарснаар тасагт нь нэвтрэх боломж олдов. Хүүхдийг хажуугийн хүнээс нь залилж аваад гарч гүйхдээ ч, өөр хаалгаар бүр гадагшаа гарч, түүнийг хүлээн байсан Цэргийн нөхөр Цэрэнтэйгээ хоёулаа машин дотор балга тагшийг уун хэрэг бүтсэнээ тэмдэглэхдээ ч, дараа нь нилээд халамцуу эр галт тэрэгний буудал хүргүүлэхдээ ч халаасны хулгайч ядуу хүүхний сүүлчийн талхны мөнгийг суйлчихаад тэнэг бүдүүлгээр хөх инээдээр инээн баярлан явдаг шиг л байснаас биш, хүүхэд хулуусны жинхэнэ гор гарч, үйлээ үзнэ чинээ бодсонгүй билээ.

Галт тэрэг хойт зүгт хөдлөөд цаг ч болоогүй байхаас эхлээд л өлгийтэй жаал уйлж эхлэв. Зоогийн газар сайн сэтгэлт үйлчлэгч хүүг хооллосон нь үнэн боловч, харин өлгийг хуурайлаагүй билээ. Хуучин даавууг нь хатаах цаг ч гарсангүй, тэгэх ухаан ч Бадраад байсангүй.

Чөлөө завгүй орилох хүүхдийг дэмий л бүүвэйлэхчээ аядаж, нийтийн суудлын вагон дундуур нааш цааш явахад хүмүүс хүүхдээ дуугүй болгож чадахгүй, угжих угж, сүүгүй, солих даавуугүй яваа залуу эрийг зэмлэцгээж бүлгээ. Бадраа бүр арга нь барагдав. Яаж ч үнсэж таалаад, яаж ч сэгсэрч бүүвэйлээд хүүхдийг тайвшруулж эс чаджээ. Олон амьтанд зэмлүүлэн, туж хүүхэд тэвэрсээр гар нь өвдсөн Бадраагийн нүд анилдан нойр хүрч эхлэв. Түрүүний уусан архи одоо л гарч буй бололтой. Дотор муухайрч, яг энэ мөчид хорвоогийн хамаг хараалыг хамж шимэн хэлж, гартаа байгаа зулбасгыг хаана ч хамаагүй хаячихаад зоогийн газар руу Бадраа хараймаар байлаа.

Хэрэв чингэж сандал дээр, уйлж орилсон жаалыг орхичихоод гараад ирэх юм бол вагон дүүрэн энэ олон хүмүүсийн дотор байгаа хүүхнүүдээс нэг нь авч хуурайлж таарна даа. Магадгүй нэг нь хооллоод өгөх ч юм бил үү? Буудлын ресторанд гуйгаагүй байхад зөөгч хүүхэн жаалыг хооллоод л өгсөн шүү.

Бадраа ийш тийш харж байгаад сандал дээрээ хүүхдийг тавиад морь харах гэсэн царайтай үүд рүү явав. Хүүхэд бүр чангаар уйлжээ.

-Хүүе залуу хүүхдээ аваарай. Чи арай уйлж байгаа нялх амьтныг хаячихаад зугтах гэж байгаа юм биш биз? хэмээн хажуугийн суудлын хижээл эр дууджээ.

-Үгүй би морь харах гэж... хэмээн тэсэхгүй байгаагаа харуулах гэсэн шиг өмднийхөө захаас барин Бадраа эргэж ирэв.

Нөхөр нь ч, хүүхдүүд ч гадуур хоол эрээд байхгүй өдөр гэртээ ирж боорцгоо идэж сүйтэй ч бай, хар ч бай цайгаар гэдсээ дүүргээд л болоо... Өөрөө ч гэсэн бусдын адил гуанзанд орж тансаглахыг үл мэднэ. Чингэж бүх юм тооцоотой, бүх ажил хэрэг, гэрийн хамаг л нууц бүхэн Даариймаагийн гарт атгаастай байх нь сайхан санагдана. Тэр эхийн эрхээ эдэлж буй нь тэр бөгөөд говийн ихэнх айлыг эм хүн л авч явдаг тэрхүү бичигдээгүй хууль тэднийд тогтжээ гэвэл болох юм. Даариймаа мөнгөндөө нэн харам билээ

Хүүхдээ ч, өөрсдөө ч гол төлөв гурилтай хоол, боорцгоор хооллоцгоон, арай нэг мөрөө улалзуулахгүй шиг явбал барж хэмээн тэрбээр бодох авай. Даариймаа насаараа торго дурдан хэрэглэж байсангүй. Наадмаар өмсдөг ганц цайны дээл нь бүр залуудаа, Хорлоотой нийлэхдээ хийлгэсэн цэнхэр пүүсүү тэрлэг бөгөөд одоо бол хуучирчээ. Нас ахиад тараг тэвээрэг авч бүдүүрсэн тул пүүсүү тэрлэг нь багтахыг байв. Тэглээ ч гэсэн Даариймаа шинэ дээл хийлгэх гэж яарсангүй. Ер аливаа дэмий шахуу юманд мөнгө үрэх тэр маш дургүй. Ис тоос болсон, ямар ч хулгайч харах царайнаас нь үл тоох хөлийн хар авдарт Даариймаа мөнгөө хадгална. Юм авч дэмий үрснээс мөнгөө хааяа үзэн нүдээ баясгаж суух сайхан санагдана.

Даариймаагийн мөнгө үрдэг ганц зүйл гэвэл ар гэрийнхнээ даатгаж ном уншуулах... Тэр ихээхэн шүтлэгтэй. Болж өгвөл сардаа нэг хурал номын газар очиж, Ерөөдөө, хүүхдүүддээ, өвгөндөө гэж нэр цохон хийморийн сан тавиулна. Сайн ламаар хувь төөргөө мэргэлүүлэх удаа ч бий. Чингэж бурханд хамгаа даатгасны ачаар аж амьдрал нь овоо явна уу даа гэж сүсэглэн бодно. Гэр орныхон гарын дор хөдөлж, аж амьдралаа тэрбээр галын бурхан аятай жолоодож санаандаа хүрч явтал харин гэр бүлийн тэрхүү дэг журмыг том охин л эвджээ. Сургууль ном гэж Улаанбаатар руу явчихаад Ерөө жил гаруй хөгшин эхийг шар махтай нь хатаав. Тэгэхнээ минь гараас дөнгөж гарч, гэрээс дөнгөж холдов уу үгүй юу, хэнтэй ч юм бэ нөхцөж, бүр хүүхэд шуухадтай болсон байхад эх үнэнээсээ уурлажээ. Тийм явдал гэж байх уу даа? Завхарч л яваагийн шинж хэмээн Даариймаа ихэд зэвүүцэв. Үртэй хүүхэдтэй болсноо зовоод эхдээ хэлсэнгүй дээ гэж бодоход, хүүхдээ гаргаад, тэврэн эхдээ өөрөө ирэх нь яав? Харин тэгтэл огт танихгүй хөндлөнгийн нэг хүүхэн Ерөөгийн тухай хэлж ирсэнд авгайн уур хилэн хөдлөжээ. Тэрбээр даруйхан хотод очоод мөнөөхөн баян цатгалан айлд ганц хонохдоо хамаг нарийн учрыг ойлгох шиг болжээ. Гэр бүлтэй, тусдаа амьдралтай тэрхүү Батбаярын харцнаас, охиныхоо ааш авираас хөгшин эх нэгийг мэджээ. Харваас нас тогтсон томоо тохьтой энэ хар хүн л охиныг нь уруу татаж, хүүхэдтэй болгосон байж магадгүй нь... Даариймаа зөн билгээрээ тэгж тааварласныг нялх хөвгүүний Батбаяртай үйлийн үргүй адилхан царай зүс батлах шиг болжээ. Харваас тийм нүгэл тарьсан байхад айлын эхнэр Ууганжаргал юу ч болоогүй юм шиг аашлах нь хачин санагджээ. Сувай сударган бөгөөд хэзээ ч нялх нойтон сормуустай амьтан үнэрлэж яваагүй шинжтэй тэр хүүхэн зээ Баярболдыг долоочих шахан энхрийлж, хөгшин эхтэй булаацалдах нь халаг байхад дургүй хүрэв. Тийм ч

учраас Ерөөг хүүтэй нь авч тэрбээр бушуухан Дархан өөдөө буцсан билээ. Чингэснээр Ерөөг аварлаа гэж Даариймаа бодсон... Завхарч яваа эмийг гэртээ түгжин хашрааж, эхийн үгнээс гарахгүй болгоё гэж тэр шийджээ. Говийнхны л зангаар эх өөрөө мэдэж, томоо тохьтой боломжийн эр олж охинтойгоо суулгаад өөрийнхөө эрхийг эдлэн санаснаараа хувь заяаг нь залж чадна гэж Даариймаа бодсон билээ. Гэтэл юу болов оо? Заяа нь хаямар харин оргож зугтжээ. Бадраа түүнийг олоод ирэхгүй хаачих ваа? Чамайг одоо нэг барьж авдаг юм бол гэрээсээ гаргана байгаа даа... гэж авгай шүд зуун бодож билээ.

Ерөө яваад хэд хонов. Ямар ч сураг ажиг гарсангүй. Бадраа ч бас чимээ өгөлгүй алга болов. Юу болох нь энэ вэ? Яагаад хоёрын хоёр хүн чимээ сураггүй болчихдог байнаа?

Чингэтэл нэгэн жин үд дээр хорооны цагдаа үл таних өөр нэгэн хүнтэй хамт ороод ирэв. Даариймаа үдийнхээ цайг ууж, боорцог хөшиглөн идэж, хөлсөө урсган сууж байлаа. Сая дөнгөж ирсэн Хорлоо цайгаа уух гэж гараа угааж байтал нь гадаа хашааны хонх дан дан гэж дуугарчээ. Хорлоо гараад цагдаа нартай хамт орж ирэв.

-Цай уу хүүхэд... хэмээн Даариймаа цай аягалав.

-Танай охин Ерөө хаачсан бэ? гэж цагдаа цаанаа ямар нэгэн юм нуусан шинжтэй битүү асуулт тавив.

-Улаанбаатар л явсан юмсан... Яасан? Уулзах хэрэг гараа юу?

-Үгүй л дээ зүгээр... Тэгээд хэзээ ирнэ гэсэн юм бэ?

-Харин л дээ хүүхээ. Уг нь сургууль ном үздэг охин шүү дээ. Хүүхэд гаргаад хичээлдээ явж чадаагүй юм билээ. Бодвол шалгалт энээ тэрээ гээд завгүй яваа биз... Юу болоо вэ?

Үнэхээр ямар нэгэн хэрэг явдал болж хэмээн хөгшин эхийн зүрх ёгхийх шиг болов. Зүв зүгээр байж байгаад хорооны цагдаа үл таних хүн дагуулан ирж Ерөөг асуумааргүй дээ...

-Үнэнийг нь хэлчих хүү минь... Охин минь яасан юм бэ? Ямар нэг буруу хазгай явдал болоо юу? гэж Даариймаа сандрав.

-Чухам яасан юм бэ? Манай охин хэрэг төвөгт холбогдоо юу? Би хаа нь муудаа юу? гэж Хорлоо гуай сандран дуугарав.

-За зүгээр дээ... Даариймаа гуай та охиноо юм уу, зээ хүүгээ олж ир гэж эндээс хүн зарж явуулсан явдал байна уу? хэмээн мөнөөхөн үл таних хүн асуужээ.

-Би юу даа? Үгүй л дээ... Юунд тэгэх билээ. Манай охин Ерөө чинь өөрөө том болсон биеэ даасан хүн... гэтэл

-Танай зээ хүү Баярболдыг хүн хулгайлсан байна. Нааш нь авчирч өгөөгүй биз гэж л бид сураглаж яваа юм. Албан ёсоор цагдаагийн газарт мэдэгдсэн болохоор улс даяар хүүхдийн эрэлд гараад байна. Хэрэв та ямар нэгэн хүн зарж тэдний хойноос явуулсан бол үнэнээ хэлбэл эх мухаргүй эрэлд хатаж байгаа бидний ажилд тус нэмэр болох сон...

Даариймаагийн дотор харлаж ирэв. Цагдаагийн үг гэгээн өдөр гэнэт цахилсан аянга болон хөгшин эх дээр буув.

-Ээ бурхан минь! хэмээн чангаар хашгираад Даариймаа ухаан алдан унажээ.

-Ерөө яасан бэ? Хүүхдийн эх нь зүгээр үү? хэмээн хөгшнөө сэхээх гэж энгэрийг задгайлсан ус шүршиж байхдаа Хорлоо гуай асуужээ.

-Түүнийг би мэдэхгүй юм байна. Баярболдыг Эх нялхсын төвд Ууганжаргал гэдэг эмэгтэй сахиж байгаад түр гарах хооронд нь хулгайч авчихсан юм билээ... За бид явъя. Хэрэв зээг чинь хүн хүргэж ирвэл даруйхан энэ утсаар Дархан хотын цагдаагийн газарт мэдэгдээрэй гээд хоёр цагдаа гараад явчихав.

Даариймаа удаж байж сэхжээ. Ухаан алдснаа мэдэхгүй гайхсан нүдээр гэр доторхоо харж толгойгоо илээд өндийн суув.

-Хөгшин минь чи Ерөөгийн хойноос хүн явуулсан юм уу? гэж Хорлоо аядуухан асуулаа.

-Юу гэнээ?... Манайд үнэхээр цагдаа нар ирсэн хэрэг үү? Баярболд хүү минь нээрээ алга болчихсон гэж үү? Тэр бүхэн хар дарсан зүүд биш байх нь уу?

Хорлоо хүйтэн цай хөгшиндөө залгилуулж, саяхан толгой дээр нь тавьсан нойтон алчуураа мушгин норголоо.

-Үнэн л юм байна даа. Зээ хүү минь өвдчихөөд, Ууганжаргал гэдэг хүүхэн сахиж байж шүү дээ. Сахиурыг түр гарах хооронд хулгайч хүүг минь аваад явчихжээ. Цагдаа нар Ерөөг чухам яасныг хэлж мэдэхгүй байна. Эсвэл муу явдал болоод биднээс нуугаад байна уу? гэж Хорлоо санаа алдан хэлжээ.

-Охин минь яачихав? Яагаад өөр хүн хүүхдийг сахиж эмнэлэгт хэвтдэг билээ? Хот хүрээ рүү яарч яваад машин тэрэгний осолд орсон юм биш байгаа даа? Ээ энэ өгөр толгой юу. Ёстой нэг өтөлтлөө ухаан суухгүй, өлтөртлөө шөл гарахгүй гэдэг шиг л... Бурхан минь надаас болж энэ бүх хэрэг гарлаа гэж үү? Төрсөн эх би охиндоо муу юм хийе гэж бодоогүй шүү дээ. Аль вэ өвгөн минь хувцас бэлдээд аль одоохон би хөлсний тэрэг аваад ч хамаагүй хот руу явах минь... Охиныхоо барааг харахгүй бол тэсэхгүй нь... хэмээн Даариймаа сандран босч ирэв.

-Үгүй чи байз... Тэр Батбаярынх гэдэг чинь утастай гэсэн биз дээ? Юу ч болохноо утсаар ярьж сургийг нь гаргаад орхъё. Хот хүрээ явах хэрэгтэй бол хоёулаа явсан дээр. Чи битгий бачимд даа хө. Аажуу уужуу бай даа. Наад бие чинь тэсэхгүй шүү хэмээн аль болохоор тайвшруулсан үг хэлж бие хааг нь барилан, хуян шар усыг нь тараах мэтээр нурууг дарж өгөв.

Даариймаа бослоо. Нүүрээ угааж, санаа алдан байж гайгүй шиг хувцсаа өмсөв. Хөгшнийгөө хамар хашааны дөрвөд авгайтай их л ходийрхон, хотод “завхарсан” охиноо цэргээс халагдсан тэдний том биетэй залууд өгөх бололтой юм цухуйлгасныг Хорлоо одоо санав. Ер гайхал хөгшин нээрээ хот руу Ерөөг явчихсныг мэдээд, хойноос нь тэр хархүүг явуулсан юм биш байгаа даа? Тэр залуу нь Баярболдыг хулгайлж, замдаа осол зэхий явдалд орсон байвал яах



билээ?

Хорь гучин минутын дараа хоёр хөгшин захын хорооллоос холдон автобусны буудал руу явж байв. Эхнэрийхээ цочмог уурыг төвөгшөөх тул асууя гэсэн үг аман дээр гарч ирээд байсан боловч, Хорлоо зүрхэлж хэлсэнгүй. Уурлаад нэг үглэхээрээ Даариймаа салдаггүй яншаа билээ. Түүнтэй мар мар хийж үг хаялцаж явснаас дуугүй мөрөөрөө байсан нь дээр санагдана.

Ээ дээ Даариймаа л Ерөөгийн хойноос хүн явуулсан даг шүү. Тэгээгүй бол сэргийлэхийн хүмүүс юу гэж тэднийхээр хүүхэд сураглаж ирэх билээ? Энэ хүүхнүүд адгуу... Гэртээ хамгийг захирч суудаг хөгшин аягүйд бол үгнээс нь зөрөөд хот явчихсан охинд уурсаж, түүнийг олоод ир хэмээн Бадрааг явуулчихсан байхад үгүй гэхийн газаргүй.

Хорлоо энэ бодлоо, хөгшнийхөө ихэд бодлогошрон байн байн санаа алдаж, өөрийгөө зүхэх аястай үг хэлсэнтэй нь холбон бодов. Хамаг хэрэг түүнээс үүдэлтэй болохоор нүгэл бүхнээ өөртөө хурааж, ёстой л нэг далан таваар бууж өгөн, хувь заяаны өмнө хүлцэл өчихөд бэлэн ч байж болох шүү дээ. Гэвч өвгөндөө бууж өгөх хэзээний дургүй Даариймаа Холбооны байшин хүртэл юу ч хэлсэнгүй. Утсаар ярьдаг бүхээг хүнгүй сэлүүхэн байв. Залгагч тэр даруй л Улаанбаатарыг дуудлаа. Даариймаа утас авч, хэн нэгэнтэй бага зэргийн уцаартай боловч биеэ барьсан шинжтэй ярьжээ.

-Юу? Тэгээд бүр нисээд явчихсан хэрэг үү? “Заг” компаний шугамаараа?... Солонгост удах уу? Хүүхдээ алга болсныг мэдэхгүй гэнээ? Яагаад хүү өвдчихсэн юм бэ? Хатгалгаа тусаад аа? Хүүхэн минь чи сахисан хэрэг үү? Овоо гайгүй болсон... Эмнэлгээс гарах гэж байсан гэв үү? Хэн хулгайлсан гэж? Бадраа гэсэн нэрээ? Орцны үүдэн дээр Ерөөг барьж авсан... Хойноос нь дагаж мөрдөөд байсан... Үгүй ер өө... За хүүхэн минь зээг минь олж өгөхийг л хичээж үзээрэй...

Утсаар ярьж дуусаад нааш эргэхдээ Даариймаагийн царай зэвхийрэн одоохон унамаар шинжтэй болсон байв. Хамаг биений нь хүйтэн хөлс, нулимс цувж хөгшин эх байж сууж чадахгүй унах шахахад Хорлоо түшиж авлаа.

Би л охиноо иймд хүргэжээ. Гайтай хөөтэй миний аашнаас болж Ерөө минь гэрээсээ төдийгүй, бүр төрөлх эх орноосоо харь газар явжээ. Гэтэл би гэдэг хүн чингэж эм хүнийхээ эрх дарханд хэт эрдээд муу охиноо хотоос авчирснаас янагш яаж хатуурхан эх хүнээс гарамгүй зан гаргалаа даа? Цаанаа үнэн хайртай хүн байхад нь тэнэг зөрүүд зан гарган гэртээ хорьж, том болсон хүүхнийг багынх шиг нь зодож сэтгэлд сэв суулгаснаас л боллоо. Миний энэ муу араншин уу? Хажуу айлын дөрвөд задугаар харуулж мануулдаг минь ч юу билээ? Охиныхоо хойноос өөрөө явахын оронд харин Бадрааг зарсан минь ямар алдас болов оо? Тэр залуу тэнэг мангар зан гаргаж зээ хүүг минь хулгайлсан байж таарлаа. Хөөрхөн зээ хүүг минь аятайхан авч явж чадахгүй замдаа зовоон, харангадуулж, үйлийг нь үзсэн бол яана вэ?

Даариймаа бүр байж ядав. Бадрааг хот руу явуулчихсныхаа дараахнаас Даариймаа чингэж сэтгэлээр шаналж эхэлжээ. Ерөөг хүүгээ аваад алга болсныг мэдээд өвгөн нь баахан зэмлэнгүй,

-Чи ер нь хүнээ байж байгаа амьтан юм. Монгол эхийн жудаг ёс чамд алга. Төрсөн үрээ хайрлах эхийн сэтгэл зүрх ч наад цээжинд чинь үгүй болжээ. Чи бидэн шиг хөдөөний бүдүүлгүүд биш, шинэ цагийн эрдэм номтой том охиноо чи яаж өөрийн эрхэнд байлгах гэсэн юм бэ? Чи ямар хаа байсан Аяга, Шанагын говьдоо байгаа биш... Тэнд ч гэсэн залуу хүүхэн, идэр эрчүүд эцэг эхийн үгээр биш, өөрсдийн дур тааллаар л амьдрах болж байгаа шүү. Чиний хатуу гарт баригдаад сууж байх хэн байх сан билээ? Ингэж хүүхдээ тэврэн чамаас зугтаж нааш цааш гүйсээр ямар нэгэн осол зэхий явдалд орвол яах билээ? хэмээн зэмлэсэн билээ.

Эр хүн цаанаа л өөр. Бодож санах нь ч илүү байдаг юм байна. Нээрээ сонсохгүй... Ганц удаа боловч өөрөөр нь бодол санааг нь яриулсан сан бол... Би нээрээ дэндүү хуучнаа барьж, Ерөөгийн сэтгэлийг үл ойлгон муйхарлав уу? Өвгөний хэлдэг ч үнэн шүү... Одооны залуучууд эцэг, эхийн үгээр биш, харин өөрийн хүссэнээр амьдрах болж, ханиа ч өөрсдөө л сонгож байгаа шүү... Тийм байхад миний мунхаглан муйхарласны гайгаар охин харьд явж, хайртай жаахан зээ хүү минь алга болжээ. Одоо би чинь яадаг билээ? Хамгийг чадагч нигүүлсэнгүй бурхан минь аварч туслах арга чарга байна уу?

Шинэ Дарханаас гэртээ харих замдаа Даариймаа өвгөндөө үнэнээ л хэлэв. Хар гэртээ хаанчлан суух гэсэн бодлоосоо болж л ийм аймшигт хэрэг хийжээ хэмээн уйлан дуугарч явлаа...

Хоёр хөгшнийг гэртээ ирэхэд хашааны үүдэн дээр зэргэлдээ айлын дөрвөд авгай Бизьяа хүлээж байлаа.

-За та минь юу л болоод байна Бизьяа минь... Ерөө минь харьд одоод, зээ хүүгээ бараа сураггүй алдаад... Танай Бадраа үзэгдээгүй биз? хэмээн үеийн хөгшнөө хараад Даариймаа мэлмэрүүлжээ.

-Харин гэм... Сая л шал согтуу амьтан ирээд унтаж байна. Царай зүс гэж авах юмгүй. Ингэтлээ ногоордоггүй юмсан. Яачих нь энэ вэ? Юм асуугаад мэдэж байгаа ч сөгөө алга. Тэр золиг танай зээг авч яваад алдчихсан юм биш үү? хэмээн сэтгэл зовсон хөгшин амандаа бувтнажээ.

-Юу?!...Зээ хүүг минь алдчихаа юу? Ээ гэгээн бурхан минь өршөө! Ямар гай түйтгэр бидэнд тохиолдох нь энэ вэ? хэмээн Даариймаа дуу алдав. Тэд хамар хашааны айлд гүйлдэх шахуу орцгоолоо. Ухаангүй согтуу залуу эр өмнө нь түмпэн тавьсан орон дээр хувцастайгаа хэвтэж байлаа. Хамаг нүүр нь хавдар болж, хаа нэгтэй унасан буюу хэн нэгэнтэй зодолдсон шинжтэй зовхи нь хөхөрч шарх сорив тогтжээ. Хичнээн дугтраад ч Бадраа сэрсэнгүй...

## СОВИН ЮУ ХЭЛЭВ?

Жаахан хөвгүүн Баярболд олдсонгүй удлаа. Энэхэн буурал газар дэлхий дээр тэр бяцхан амьтан амьд мэнд байгаа юу, үгүй юу гэдгийг хэн ч үл мэдэх ажээ. Цагдаагийнхан төмөр замын дагуух бүхий л газраар сураг ажиг тавиад олдсонгүй. Өлгийтэй нялхын зургийг олон хувилаад өндөр шан харамж амлан газар сайгүй тараагаад ч тусыг эс олов.

Мөнөөхөн Даариймаа авгай Дархан хотын цагдаагийн газар ирж үнэнээ хэлсэн дуулдлаа. Хотоос ирээд хэд хоног харилгүй танилуудаараа хэсч архидсан Бадрааг даруй баривчилжээ. Тэрбээр Даариймаагийн л захиснаар хүүхдийг хулгайлсан гэдгээ хүлээсэн боловч, чухам хаана, хэн гэдэг хүүхэнд Баярболдыг хөхүүлэх гэж орхисноо халамцуу согтуугийн эрхээр мэдсэнгүй. Яах аргагүй л хотоос гараад хэдэн цаг явсны дараа, Түнхэлд бил үү, Зүүн Хараагийн хавьцаа бил үү тэр явдал болсон гэж хэлсэн авч, Бадраагийн үгэнд итгэхэд хэцүү байлаа. Учир нь тэрбээр чухам ямаршуухан газар хүүхдээ үл таних хүүхэнд тэврүүлж орхисноо ажигласангүй. Гагцхүү бушуухан балга тагшийг уух гэж ресторан руу зүтгэснээс бус өөр бусдыг харах ажиг ухаан байсангүй. Уйланхай хүүхдийг авч явах гэж хэдэн цаг гараа чилээж, бие ядарсан байсан тул бушуухан салахын түүс болсноор үл барам, зоогийн газар уусаар согтоод ширээ түшин унтаж цагдаад баригдсан гэжээ. Түүний үгээр бол зоогийн газар олон цаг болоод эргэж ирэхэд нь нийтийн вагонд хамт явсан хүмүүсийн олонх нь бууцгаасан байжээ. Харин нэг нөхөр Бадрааг таньж, хүүхэд тэвэрсэн бүсгүй хаа ч билээ буух болчихоод залуу эрийг эрэхээр гарсан, бодвол вагон ресторан руу явсан биз гэжээ. Ингээд хүний хүүхэд хулгайлан авч яваад алдчихсандаа гутран, бас Даариймаа болон ар гэрийнхнээсээ айж, Увсын Сагил сумнаас Дарханд ирж суурьшсан айлуудаар хэсч гуйхдаа гуйж, зээлдэхдээ зээлдэн архи уусаар шал согтуу хэд хоносноо Бадраа цагдаагийнханд хэлсэн хэмээн Батбаяр сонсч билээ. Үнэндээ бол тэр залуу өөрийн дураар биш, харин хөгшин эх Даариймаагийн үгээр л хүүхдийг хулгайлжээ. Тэгэхээр хэрэгт холбогдуулах аргагүй мэт... Гагцхүү тэр этгээд замдаа хариуцлага алдаж, архи уун согтуурч, хүүхдийг өөр хүнд өгч алдсан нь л гайтай хэрэг мөн. Энэ бүх явдал ар гэрийнхнээ хатуу гараар эрхэндээ байлгах гэдэг Даариймаа авгайн зан араншингаас үүдэлтэй гэж цагдаагийнхан үзэж буйг ч Батбаяр сонсчээ. Хорвоо ертөнц дээр санаж сарвайх ганц сайхан үртэй болоод алдаж орхисон эцэг хүний сэтгэл ямар байх сан билээ дээ? Хүүгээ санах дутмаа л Батбаярын гол өөд нэгэн аймшиг хөөрөн ирэх шиг болж байлаа.

Ямар гай зовлон нүүрлэх нь энэ билээ? Манайд заавал ийм хагацал ирдэг нь юу билээ? Бодоод байхад энэ бүх явдлыг хэн нэгэн хатуу зарлигаараа төөрөг төөргөөр нь хуваарилж өгсөн шиг... Баярболдыг өвдүүлэн Ууганжаргалаар сахиулж, Ерөөг Солонгос руу явуулахын хамт, хүүг хулгайлуулан, ор сураггүй болгож, харин энэ бүхний эцэст Ууганжаргал гэдсэндээ үртэй болсноо мэдэн үлдэх нь хувь заяанд тохиромжтой байсан юм шиг...

Батбаяр өөрийн нь яс махны тасархай авааль гэргийн ариун саванд бүрэлдэн өдрөөс өдөрт томорч буйд баярлахгүй байж хэрхэн чадах сан билээ. Угаасаа бурхан чингэж түүнд үр заяах байсан юм бол эртхэн шиг, элдэв нүгэл хилэнц үйлдэхээс нь өмнө хүүхэд хайрлачихгүй дээ... Үртэй болохын мөрөөдлөөсөө болж л Батбаяр би бээр жаахан охиныг гэртээ авчирч

Ууганжаргалыг гомдоох үйлийн үрийг хийсэн шүү дээ. Магадгүй тэр явдал нь анхнаасаа нас тогтсон эрийн хувьд буяны гэхээсээ, бузрын буруу үйл байсан ч байж болох. Бурхан чухам түүнийг болгоон насны амьдралд санаж сэрэг хэмээн дохио санамж болгон, зүй бусаар олдсон Баярболдыг түүнээс холдуулж, харин оронд нь жинхэнэ үрийг нь түүнд заяасан ч байж болох...

Бурхан шүтдэггүй болов чиг Батбаяр сэтгүүлчийн хувьд, дор хаяад боловсролтой уншигчийн хувьд эрдэмтэн мэргэдийн бичээд байгаа мөнөөхөн зөв совин гэгчийг ихэд сонирхон, тэр нь ор үндэсгүй зүйл биш гэдэгт итгэх болсон билээ. Ертөнцийн аливаа үзэгдэл юмс өөрийн дотоод учир зүйгээр зохицуулагддаг нь үнэн ч байж магадгүй. Муухай хар нүгэл хийсэн хэн боловч тэр үйлийнхээ горьг амсдаг гэдэг. Сайхан сэтгэлт эхнэрээ араар нь тавьж, бараг нүдэн дээр нь ил шахуу залуухан хүүхэнд сээтэгнэн түүнээс үр хүүхэд төрүүлсэн Батбаярыг бурхан гэсгээн цээрлүүлж анхны нь үрийг чингэж түүнээс төөрүүлэн холдуулав уу?

Хоног хугацаа цаашлах тутам Батбаяр гэмээ мэдэн дотроо гэмшин, сэтгэл санаа тавгүйдсээр байлаа. Тэрбээр эцэг хүний хувьд Баярболддоо дэндүү дасчээ. Түүнийг санахгүй байх мөч сэтгүүлч эрд үгүй байлаа. Хамгийн шаналгаатай нь хүү ор сураггүй алга болсонд л байлаа. Үр нь амьд уу, эсвэл хорвоогоос аль хэдийнээ алга болж, сүнс нь эцгийгээ эрэн хаа нэгтэй төөрөлдөн тэнүүчилж явна уу?

Болсон бүхий л явдлыг сонсоод Батбаяр гэргийдээ хэлье үү, байя уу гэж эргэлзжээ. Анх удаагаа хөл хүндтэй болсон гэргийн бие сайнгүй, бариач эмгэн хийгээд эмч нар түүнийг айлгаж цочоож болохгүй, аль болох тайван байлгаарай гэсэн байлаа. Хэрэв зээ Баярболдыг хулгайлсан этгээд, дамаа галт тэргэнд үл таних бүсгүйд өгөөд алдчихжээ гэж Ууганжаргал сонсвол, аюул болж мэднэ хэмээн амаа татасхийн байтал, харин ажлаас оройтон ирэхэд гэргий нь уйлж охилсоор угтжээ.

-Яасан бэ? Юу болсон бэ? Бие чинь муудав уу? хэмээн Батбаяр сандрав.

-Үгүй дээ би зүгээр... Харин хүү минь алдагдчихжээ. Сая Ерөөгийн ээж ярилаа. Хулгайлсан хүн нь шал согтуу харьсан гэнэ. Хүүг галт тэргэнд танихгүй хүүхэнд орхиод дахин барааг нь харалгүй алджээ. Ингээд би гэдэг хүн хүүгээ амьд мэнд барааг нь харахаасаа өнгөрөв бололтой...

-За битгий уйл... Сэтгэлээ барь. Ямар үхэж үрэгдлээ гэсэн биш, хэн нэг хүүхэн аваад л вагоноос буучихаа биз. Амьд хүн аргатай гэдэг шүү дээ. Эрт орой хэзээ боловч хүүг олохоо л олно харж байгаарай. Цагдаагийнхан газар сайгүй зарлал тараан хайж байна. Тэр өдөр хойт зүгт явсан хүмүүсийн хаана хаана буусныг тодорхойлох гэж ядацгааж байна. Ямар нэгэн сураг гарах нь гарцаагүй... Бүү сэтгэлээ зовоо!

Эр нөхөр нь толгойг илж духан дээр нь уруулаа хүргээд тэврэхэд Ууганжаргал нялхамсан эрхлэх мэт толгойгоороо түүнийг налж, гарыг нь авч гэдсэн дээрээ тавилаа. Батбаяр доошоо суун гэргийнхээ гэдсэнд чихээ наан чагнав. Түүний үр төл өөрийгөө мэдүүлэх гэсэн аятай, гэдэс хээлэн дотор битүү шуугиан гаргах шиг болов.

-Хөөрхий муу хүү минь хаана яваа бол доо? Ээж намайгаа санаж сүйд болж байгаа даа...

Надад дэндүү дассан нялх амьтан шүү дээ! хэмээн Ууганжаргал санаа алджээ.

Баярболдыг эмнэлгээс алдсны гол буруутан гэж өөрийгөө Ууганаа хараасаар яваа билээ. Сав саяхан элгэндээ тэвэрч байсан нялх үрийн нь үнэр одоо ч гэсэн биенээс нь салаагүй байна. Ууганааг хараад ход ход инээдэг нь, юухныг ч юм шулганан, шувуу шиг жиргэн задгайлсан өлгий дотроо тарвалзанхан байдгийг нь санахаар тэрбээр байж сууж эс чадна.

-Ээ мөн тэнэг болчимгүй хүн шүү. Ерөөг гаргаж өгөөч гэхлээр юунд хүүгээ орхиж явсан билээ? Тэврээд л гарах байсан биш үү? Тэгэхэд бүтэл нь хазайсан хажуугийн хүүхэнд захиж орхин гардаг минь ч юучив. Ээ халаг. Ийм муухай явдал болохыг зөв совин минь надад хэлсэн ч болоосой...

Ууганаа өөрийнхөө зөн совинд итгэдэг билээ. Ер сэтгэлд ойр ямарваа нэгэн явдлыг тэр зөнгөөрөө мэдээд байх шиг санагддаг. Ээж, аав өвдөх юм уу, дүү нараас хэн нэг нь халуурсан байхад Баяндэлгэр сумын дунд сургуулийн дотуур байранд шөнөжин урваж хөрвөн, сэтгэл тавгүйдан нойр хулжсан нь олонтаа. Тэгээд багшаасаа чөлөө авч Дунд Байдлаг өөд явган нүцгэн ч хамаагүй явсаар хүрэхэд нээрээ л нэг нь өвдсөн байдаг сан.

Нөхрөө өөр бусадтай нөхцөв үү дээ гэж бодоход тэр нь үнэн л байдаг. Чухам эмнэлгийн урт шөнө тасаг тасагт тариа хийх гэж тэвдэн гүйж явахдаа тэрбээр гэв гэнэт нүдэндээ Ерөөгийн өрөөнд итгэж үл болох үзэгдэл болж буйг харах шиг болж билээ. Авааль нөхөр оюутан охины дээр гарчихсан, үнсэж таалан, эр хүний жаргалаа эдлэж байгаа нь яг л өнгөт сүүдэр шийн дүрс шиг тов тодхон харагдаад өнгөрчээ. Чухам ямар ид шидээр, юу гэгч тэгж нүдэнд хий үзэгдэл болон харагдсныг Ууганаа ойлгосонгүй. Ямархан нэг явдал ар гэрт түүний эзгүйгээр болов уу даа гэж дэмий нэг таамаглаад л өнгөрчээ. Ууганжаргал өөрийгөө их хартай хүүхэн гэж боддоггүй боловч, харин биед хүрсэн оюутан бүсгүй, сайхан царай зүстэй, дөч шахсан гэхэд ямар ч эм хүний нүдийг булааж чадах эр нөхөр хоёрыг гэртээ зүгээр нэг байж чадах болов уу, үгүй болов уу гэж эргэлзэх санаа төрсөн нь үнэн юм. Батбаяр хэдий хормой хот нь хамжааргатай, барагтай бол хүүхнүүдийн банзалтай зууралдаад байх сонирхолгүйг мэдэх авч, их олон жилийн туршид Чимгээ тэр хоёр зүгээргүй дотноссон гэдэгт эргэлздэггүй билээ. Түүгээр жишээд бодвоос Ерөөг тэр зүгээр нэг сайн сэтгэлээсээ туслах ганцхан зорилготой авчирсан гэхэд бас л эргэлзээтэй. Сонин хэвлэлээс уншиж байхад үнэн хайртай, салж хагацахын аргагүй гэр бүлийн эхнэр, нөхөр хоёр хүүхэд олохгүй удахдаа эсвэл, айлаас өргөж авдаг, эсвэл, эр нөхрийнхөө нуудгайгаас өөрийн нь хүүхдийг үрчилдэг гэжээ. Харин үр хүүхдийн мөрөөдөл нь Ууганжаргалын хардлага сэрдлэгийг хазаарлан барьжээ. Ерөөг жирэмсэн болсноос хойш, энэ бүсгүйн гэдэс хээлэнд манай хүний үр бүрэлдэн тогтсон шүү дээ гэж бодоод, өөрөө хүүхэд гаргах хувь ерөөлгүй юм чинь, Ерөөгийн жаалыг л өсгөж өгөхөөс, болбол үрчлэн авч хүн хийж авахаас өөр аргагүй хэмээн эм хүний дотор арзагануулсан хор шараа хүчээр таягдан номхон хүлцэнгүй байж чадсан билээ.

Ууганжаргал нөхрөө сүрхий архидав гэдгийг яах аргагүй мэддэг билээ. Хамарт архины нясуун үнэр ханхалах шиг болж, зүрхээр нэгэнтээ хатгуулаад унавал “За манай хүн балгаж дээ” хэмээн тэрбээр боддог билээ. Зөн совин нь Ууганааг хэзээ ч хуурч байсангүй. Хэтэртлээ согтоогүй гэхэд, сүрхий халамцсан Батбаяр оройхон хир дуулах шахуу их л баяр хөөртэй ирдгээрээ тэр зөн совин батлагддаг билээ.

Одоо бол Баярболдыгоо алга болжээ гэдэгт итгэн сэтгэл нь туйлын шаналж байсан боловч, харин яагаад ч юм бэ, хайртай хүүхдээ амьд мэнд байгаа гэсэн далд найдвар сэтгэлийг нь зогоож байлаа. Тиймээ, тийм хүү нь хаа нэгтэй хөдөө айлд гэдэс цатгалан, мах мариа нь шуугдаагүй хэвээр байгааг Ууганаа харах шиг болж байв.

-Миний хүү! Алив ээж рүүгээ хар даа! хэмээн Ууганаа шивнэхэд Баярболд харин бишүүрхэх мэт түүнийг тоохгүй, хайчилсан үнэг, хонх, элдэв тоглоом зүүсэн хүүхэд саатуулах зүйл унинаас дүүжилснийг мойл хар нүдээрээ харах шиг...

-Ээж та намайг яах гэж хулгайчид алдсан бэ? Тэр хүн чинь намайг харангадуулан алах шахсан шүү. Харин азаар энэ ээж намайг аварч, одоо би танихгүй айлд дасч, танихгүй ээжийн мээм хөхөөд, танихгүй орон дээр тарвалзаж байна. Би таньдаа мөд очиж чадахгүй байхаа даа. Та харин миний дүүг бушуухан төрүүлээрэй. Намайг гэсэн сэтгэлээ тэр хүүд өгч, яг л намайг яаж энхрийлэн эрхлүүлж байсан бэ, түүн шигээ хайрлаарай...

Далд ухааны шивнээ юу? Зөн билэг хүүгийн нь заяаг түүнд хэлж байна уу? Ийм нэгэн дүр зураг нүдэнд харагдаж, аяархан шивнэх хүүхдийн нялхын дуун Ууганаад сонсогдох шиг болов.

Бурхан минь би нээрээ ингэсээр галзуурах байх шүү гэж бодтол, зүрхэн дор нь өөрийгөө мэдүүлэн, хүүхэд нь анх удаагаа мэдэгдэхүйц чангаар тийчлэн хөдлөх шиг болов.

-Гэгээн тэнгэр минь... Үр минь наддаа дохио өгч байна уу? За за... Ойлголоо доо. Алдагдсан хүүгээ эргээд ирнэ л гэж итгэе. Хэдхэн сар болоод мэндлэх бяцхан үр чамайгаа ариун хэвлийдээ хайрлан хайрлан өсгөе. Чи миний нар болон намайг гийгүүлэх билээ.

Өдөр хоногууд хуанлийн хуудсууд өөрөө тасран унах шиг хурдан хурдан өнгөрсөөр л... Ууганжаргал хорвоод нэгэнт төрөөд түүнээс хулжин одсон жаахан хүү Баярболдыгоо санан санасаар, өдөр бүрий хэвлийд нь томорсоор байгаа үрээ бушуухан үзээсэй хэмээн яарсаар л...

xxx

Их далай зөөлөн давалгаална. Аварга том халимнууд нуруун дээрээ мөнгөн цэцэгс тээн авчрах шиг, далайн сүртэй том давалгаа мөнгөлөг хөөс уралдуулан эргийг ирж мөргөхөд, мянга түмэн сувд хэлхээ тасран унах шиг усан дуслууд цацагдан бутрана. Тэнгэр цэлмэг, наран доогуур Номхон дөлгөөн далайн их усан нэлий алсын алс тийш цэнхэртэнэ.

Чэжү арлын хавь энэ газар эргийн дагуу өнгө өнгийн цэцэг зай завсаргүй тарьсан лугаа адил эрээн мяраан сүүдрэвч, майхан сэлт алаглан харагдаж, шоргоолж шиг олон хүн амьтан чухам нэг жаргалаа эдлэн, усанд биеэ үйн, далайд нэгэнтээ умбаж шумбан, нэгэнтээ халуун элсэн дээр тэрийн хэвтэж нарлацгаах ажгуу.

Сэрчмаа, Ерөө хоёр Чэжү арал дээр ирээд хоёрхон хонож байв. Солонгос эзэндээ их л найртай ханддаг Сэрчмаа үеийн бүсгүйгээ дагуулан хуучин ажиллаж байсан оёдлын үйлдвэрт очиж билээ. Сэрчмаа хэдийнээ оёх дамжлага дээр цахилгаан машины ард суун дадсан сурсан

ажлаа хийж, харин эзэндээ хэлж баймааж эхний сард Ерөөг гадаадад гаргадаг хувцасны баглаа боодлын, тодруулбал, машинаас бэлэн зэхээ үйлдвэрлэн гаргаж буй цаасан хайрцгуудыг хураах ажилд оруулчихав. Даанч ганц хором нуруугаа амраах завдал өгдөггүй нь хэцүү болохоос биш, ядуу амьдралын хар бор ажил бүхнийг хар нялхаасаа хийгээд сурчихсан Ерөөд машинаас бэлэн зэхээ шошго хадан, аливаа хувцас савлахад бэлэн гаргаж буй цаасан хайрцгуудыг авч хураах ажилд түүртэх юм байсангүй. Гэхдээ л сүүлийн жил хүүхэд гарган, боломжийн амьдралтай Батбаярындаа хийх юмгүй эрх дураараа байж баахан бие эмнэгшснээ Ерөө ажилд орсон даруйдаа мэдээд шүд зуун тэвчихээс өөр аргагүй гэж бодож билээ.

-За яахав, чи минь ингээд хайрцаг хураагаад сайн ажиллаж л бай. Би эзэнд хэлж чамайг оёдлын ямархан нэг дамжаанд дадлагажуулахыг бодноо. Хэдэн сар авхаалжтайхан байж солонгос хэлж сурахыг бод. Хэлээ сайн мэддэг гадаадын цагаачдад зориулсан сургалт, түр дамжаагаар оёдлын нарийн мэргэжлийн хүн бэлддэг юм шүү. Хичээгээрэй! хэмээн Сэрчмаа хэлжээ.

Өдөрт арав, арван хоёр цаг ажиллаад Ерөө анхандаа их ядардаг байсан боловч, сүүлдээ дасчээ. Үдээр өгдөг халуун ногоо нь хэл дарвигануулсан хоол, кимчи хэмээх ногоон дарш сэлт, заримдаа ширээн дээр өрөх далайн загас, байцаа, хавч, нэрийг үл мэдэх хачин хачин усны амьтдаар хийсэн хоолыг идэж чаддаггүй байснаа сүүлдээ дасав.

Зургаан сар гарснаас хойш халуун гэж тамтаггүй болоход хамаг амьтан далай руу явцгааж байна гэлцэх болов. Оёдлын үйлдвэрт Сэрчмаа, Ерөө хоёроос өөр монгол хүн байсангүй. Хааяа хааяа дуулдах ууж согтуурсан монгол залуу эрчүүд тэнд үл үзэгдэнэ. Хаашаа л харна солонгос хүмүүс, юу л хийнэ тэдний хэлээр ярих хэрэг гарах тул Ерөө эхний сарын дохио зангаанаасаа аажим аажмаар холдож хэд гурван үгээр ямартай ч байсан хоолоо олоод идчихтэй болов. Сэрчмаа түүнтэй хамт ганц өрөө байранд нь хоёрхон хоноод хаашаа ч юм нүүгээд явчихав. Чухам хаана очсноо Ерөөд хэлсэнгүй.

-Чи ганцаараа амьдарсан нь дээр. Би хажууд чинь байвал бид хоёр монгол хэлээрээ чалчсаар байгаад хэл сурахад чинь саад хийх болуужин... Би солонгос найзындаа очлоо гэж л хэлжээ.

Харийн газар гав ганцаархнаа үлдээд айх шиг ч болж, нойр хүрэхгүй тийчлэн хоносон анхны шөнө гэв гэнэт хүүгээ санаад уйлж билээ. Хүү нь зүгээр нэг санагдсан бус, эмнэлэгт дахиад муудаж, өнөөх л халуурдгаараа халууран, Ууганаа эгч нь байж сууж чадахгүй сандарч байгаа шиг бодогдоод залуу ээж нойргүй хонов. Тэрбээр гэртээ сэн бол гараад гүймээр л байлаа. Эх орондоо сон бол унаа унаш олоод хүүгийнхээ хэвтэж буй эх нялхсын төвд хүрээд л очих сон... Даан чиг тэгж дураараа гарч явах төрөлх нутаг биш, хүний газар яалтай билээ. Нойр муутай хоносон тул маргааш нь шинэ дутам орсон ажилдаа ихэд ядарсан боловч, Ерөө хүнд муугаа үзүүлэхгүй хэмээн шүд зуужээ. Амаргүй ажилдаа түүртэн, олон цагийн хүнд хөдөлмөрийн дараа гар өвдөж, бушуухан шиг л орондоо орохоос аргагүй зүтгэсээр сэтгэлийн зовиураа залуу хүн аажмаар гэв.

Сарын цалин гэж овоо хэдэн вон авч, Ерөө хэнд ч хэлэлгүйгээр хав дарсан нилээд тооны ногооны цаастайгаа нийлүүлээд,

-Сиймхий ч гэсэн гэр минь, сэгсгэр ч гэсэн ээж минь гэж... Ээж таньдаа би мөнгөө явуулнаа.

Та нарыгаа би тэжээнээ! гэж амандаа шивнэж билээ.

Чингэтэл Сэрчмаа гүйгээд ирэв:

-За миний хүүхэн ядарч байна уу? хэмээн тэр Ерөөг үнсч,

-Маргааш хоёулаа далай явж амарна. Эзэн бид хоёрт чөлөө өгсөн. Эхний сар чамайг тун сайн ажилласан гэж шагнаж байгаа нь тэр шүү дээ. Одоо чинь халууны улирал эхэлж байна. Сөүлд барагтай бол хүн үлдэхгүй. Бүгдээрээ далай руу явцгааж байна. Аль вэ чи хувцсаа бэлд. Ингэхэд усанд орох хувцас бий юу? За яахав очоод авчихна биз. Бид хоёрыг Чэжү аралд очоорой гэж эзэн хэлсэн. Тэр аралд чинь эрт урьдын цагт монголчууд амьдарч байсан юм гэнэ билээ. Одоо хүртэл монгол морь тэнд байдаг... Манай циркийн хэдэн залуу тоглолт хийдэг гэсэн шүү. За түргэлж үз хэмээн Сэрчмаа шавдуулжээ. Чингэж л Ерөө Номхон дөлгөөн гадаад их далайн эрэгт ирсэн билээ.

Сэрчмаа усанд сайн сэлдэг ажээ. Түүний толгой шоволзон олны дунд орохыг Ерөө харж суув. Далайн усанд цагаан, хөх, ягаан, алаг, хар олон бөмбөг хөвүүлж байх шиг олон хүн зэрэг орчихоор толгой нь цухуйн ямар сонин харагдана вэ? Ерөө саяхан мухлагаас авсан хүйтэн ундаа ууж, усан үзэм амандаа хийж суухдаа гэнэт Батбаярыгаа санаад орхив. Тэр минь энд байсан сан бол... Хайр гэдэг хачин зүйл ажээ. Хүний газар, бүү хэл монголынхоо онгоцонд Сөүл орохоор нисч хоёр ч удаа сайхан хоол идэхдээ, үйлчлэгчийн өгсөн бяцхан шилтэй дарсыг авахдаа Батбаярыгаа санаж, хоёулаа ингээд явж байсан сан бол юутай сайхан бэ гэж бодсон удаа бий билээ. Хэрэв ингэж хайртай хүнтэйгээ хамт яваа сан бол аманд нь сайхан хоолноос халбагадаж өгч, бяцхан шилтэй дарсыг амсуулах байсан даа. Тэгээд хоёулаа далайн эрэгт ирсэн сэн бол... Амтат усан үзэм аманд нь хийж, далайн бүлээн усанд умбуулан нурууг нь угааж өгч, хүйтэн ундаагаар цангааг нь тайлах сан даа. Даан чиг энэ бүхэн боломжгүй юм гэдгийг санаад Ерөө санаа алдав.

Сэрчмаа ус дуслуулсаар гараад ирэв. Хажууд суун халуун элсэн дээр хэвтэж тааламжтайяа дуу алдлаа.

-Хүүшээ чи юу яахсан гэж бодохгүй байна уу? гэж тэрбээр аальгүйтэн инээв.

-Хм...

-Ерөөгийн ичингүйрхсэн царайг харж Сэрчмаа түрүүхэн хажууд нь орхисон гадуур цамцнаасаа америкийн нэг долларын үнэтэй тамхи гарган асааж,

-Нэрлэхээд яахав дээ. Чи хүсч л байгаа шүү дээ. Хүний газар хэндээ гэж биеэ тавьж хичнээн хоногоор эр хүнийг хүсэмжлэн тарчилж суух ч юм билээ. Тийм биз дээ? Хагссан хувин шиг ид залуудаа хатчихъя гэж чи бодоогүй юм байгаа биз дээ? гэж инээв. Ерөө дуугарсангүй. Батбаяр нь л хамгаас илүү бодогдож байв.

-Өнөө орой чи бид хоёрыг хоолонд урьсан. Наад үс зүсээ сайхан янзлаарай. Миний франц сүрчиг цацахад зүгээр... Хувцас бол яахав дээ болно. Энд ямар бүжиг хийх биш, хувцасны моод үзүүлэх биш гоёж гоодоод яахав. Харин хоол хамт идэх таних, танихгүй хүмүүст бүсгүй



хүний сайхан инээмсэглэлээ харуулж, монгол хүүхэн ямар байдгийг үзүүлж өгвөл болох нь тэр.

Ерөө онгоцонд Сэрчмаагийн хэлж байсан үгийг санах. “Нэг аятахан залуу-тай танилцаад авсан дээр байдаг юм. Бие сэтгэл зовохгүй амар шүү дээ” гэж тэгэхэд хэлж билээ. Ерөө тэгэхэд нэг их анхаарахгүй сан. Гэтэл одоо юу хэлэх нь энэ билээ? “Монгол хүүхэн ямар байдгийг үзүүлж өгвөл болох нь тэр” гэсэн нь ямар утгатай үг юм болоо? Ерөө үгний нь утгыг гадарлан дургүй нь хүрсэн боловч өөрт тус болсоор байгаа Сэрчмаагийн үгнээс татгалзах эрхгүйгээ мэдэж байлаа.

Наран шингэсний хойно Сэрчмаа түүний үс зүсийг янзлан, дагуулж гарлаа. Далайн эрэгт тулгаж барьсан гоёмсог зоогийн газарт тэд очицгоов. Монгол хүүхнүүдийг ирнэ гэж хүлээсэн шинжтэй нэгэн залуухан хаалгач бөхөлзөн дохилзон угтаж дагуулан дээд давхарт гаргажээ. Тэнд идэх уухыг өрсөн том ширээний цаана Ерөөгийн ажилладаг үйлдвэрийн эзэн хижээл эр, хятад царайтай нэгэн залуутай сууж байлаа...

-Ай сайхан бүсгүйчүүд сууцгаа. Хоол идэж, амныхаа цангааг гарган хүйтэн ундаа ууцгаа. Хэдүүлээ нэгэн үдшийг сайхан өнгөрөөе хэмээн солонгос эзэн найр тавив. Энэ үгний цаана ямар утга оршиж буйг Ерөө хэрхэн мэдэх билээ. Тэгээд ч эзэн найр тавьж дайлах гэж байхад үгүй хэмээн зугтаалтай биш, усыг нь увал ёсыг нь дага гэсэн үг бий шүү дээ. Хөнгөн хөгжмийн аялгуу сэтгэл хөдлөм хангинаж байв. Том шилэн цонхны цаана үдшийн далай зөөлөн давалгаалах ажээ. Солонгос заншлаар гарыг угаалган, намбалаг зузаан сандалд тухлуулаад, шар айраг хийж өгч, дараа нь далайн элдэв амьтны мах, гахайны махтай болон цагаан будаагаар хачирласан хэдэн янзын хоол орж ирэв.

-Сэрчмаа тэр бүгдийн амтархан идэж, үе үе Ерөө өөд нүдээ ирмэх нь ийм сайхан завшааныг алдаж болохгүй шүү гэх шиг. Энэ бүхний цаана ямархан нэг үйл явдал болох юм шиг Ерөөд санагдана. Тэр нь бол далайн эрэг дээр Сэрчмаа сонин асуулт тавьсантай холбоотой байлаа.

Хөнгөн хөгжмийн аялгуунд хятад царайт залуу Ерөөг авч бүжиглэв. Харваас сайхан л залуу юм. Дорно зүгийнхний гоёогоор гоёж, цав цагаан өмд цамц өмсөөд, дэгжин том бэлзэг зүүсэн энэ эр түүний зүг талимаарсхийн харж солонгосоор ажил нь хэр хүнд байгааг, авдаг цалин хөлс ямрыг асуужээ. Ерөө сурсан хэдэн үгээ эвлүүлэн байж, ажил тийм ч хүнд биш, цалин гайгүй хэмээн хариулав.

-Хэрэв та хүсвэл цалин өндөртэй, тийм ч хүнд биш үйлчилгээний ажилд оруулж өгч болно шүү хэмээн өөрийгөө Жан хэмээн нэрлэсэн шинэ танил нь хэлжээ. Энэ үг тийм ч эвгүй сонсогдсонгүй. Учир нь угаасаа хэдэн цаас олох л гэж энэ харь газар ирсэн юм чинь дээ.

-Манай Жан Гонконгийн тэргүүн баячуудын нэг. Ерөө бол ажилд идэвхитэй, эхний сарууддаа сайн ажиллаж, цалингаа нэмүүлсэн, амралтанд явах эрхээр шагнуулсан хүүхэн болохоор залуу хүмүүс танилцан бие биеийнхээ амьдралд тус боно гэж найдаж байна. Хэдийгээр “Заг” компанитай бид хатуу гэрээтэй боловч, хэрэв манай ажиллагсадаас хэн нэгийг цалин өндөртэй, хангамж сайнтай үйлчилгээ-ний хүрээний ажилд оруулна гэх юм бол бид татгалзах зүйлгүй шүү хэмээн Ким эзэн хэлжээ.

-Дуулав уу Ерөө? Энэ чинь сайхан боломж шүү. Манай Ким эзэн ийм л сайн хүндээ хэмээн Сэрчмаа тэднийхний хэлээр дуржигнуулав.

-За идэцгээ, ууцгаа. Сайхан наргицгаа хэмээн Ким эзэн хэлээд цагаан алчуураар амаа арчиж

-Та нарын насан дээр цэнгэн жаргаж л явлаа. Нас ахиад ирэхээр идэх юманд төдгүй, шар айраг, вискийг бол ам хүрэхээс цаашгүй л болох юм... гэв.

Ямарваа нэгэн шөнийн зугаа цэнгэл, ор хөнжлийн явдал болсон нь үгүй. Жан Ерөөг таалан үнсэх юм уу, дор хаяад гарыг нь халуун дотноор атгасан ч үгүй. Оройжин сууж сайхан хооллоод, бага зэрэг бүжиг эргэн, сайхан хөгжим сонсоод л тарцгаав. Жан хоёр бүсгүйг далайн эрэгт тулгаж барьсан гоёмсог байранд нь дөхүүлж өгөөд салж явахдаа

-Бид дахиад уулзах байх гэж найдаж байна гэжээ.

-Бид ч гэсэн манай эзэн болоод тантай үдшийн зоог барьсандаа хязгаартай баяртай байна. Та нээрээ ямар ч хүүхэн нүд алдмаар сайхан эр хүн юм... гэж Сэрчмаа хариу үг хэлжээ.

Энэ явдал Ерөөгийн ухаан санаанд нэг их тод мөр үлдээсэнгүй. Залуу бүсгүйн урмыг бодож сайхан үг хэлсэн буй заа. Жан ч гэсэн баячуудын тал зассан үгээ хэлээд л өнгөрсөн биз хэмээн боджээ. Харин Сэрчмаа ойрд үзэгдсэнгүй. Ер тэр хүүхэн тийм зантай. Зангий нь мэддэгийн хувьд Ерөө үерхдэг хүүхнээ эзэн Кимтэй зүгээргүй байх, ямар ч л гэсэн сэтгэлийн холбоо бий. Магадгүй солонгос найзындаа очно гэсэн нь худлаа, эзэн л түүнийг байранд оруулсан биз гэж боджээ. Тэр нь нэг удаа батлагдав. Гэрээгээр ажилладаг монголчууд солонгос оронд хаа дуртай газраа чөлөөтэй явдал тул нэгэн өдөр хоол ундны юм цуглуулах гэж гараад эзэн Кимийг нилээд согтуу, бас яггүй халамцсан Сэрчмааг мөрөөр нь тэврэн нэгэн зочид буудал руу машинаас буун орохыг Ерөө харав. Чингэж харсан нь Ерөөд их юм бодогдуулав. Тэр хамгаас хайртай Батбаярыгаа санаж эхэлсэн байлаа. Аль ч талаар бодсон Ерөө бол энэ хорвоод ганцхан хүнд ариун биеэ тушаан, түүндээ хүү төрүүлж өгсөн билээ. Тэр хайр насан туршдаа ариунаас ариун хэвээр байж, Ерөө өөр хэнтэй ч марзагнахгүй гэсэн хатуу бодолтой болсон байв. Тэр бүсгүй гар утас худалдан авч, хааяахан Улаанбаатар руу ярина. Түүний олж мэдсэн нь гэвэл Ууганаа эгч нь жирэмсэн болсон, хэзээ мөдгүй төрөх гэж байгаа ажээ.

-Баярболдтой ярья гэж хүүгийнхээ дууг сонсохсон гэсэн сэтгэлээ дийлэхгүй Ерөөг асуухад Ууганаа

-Баярболд Дархан өөд явчихсан шүү дээ... гэснээс өөр үг хэлсэнгүй.

“Яагаад чингэдэг билээ? Ээж хөөцөлдсөөр санасандаа хүрэв үү? Эсвэл, өөрөө жирэмсэн болж, хэзээ мөдгүй төрөх шахсан тул хүүг минь зориуд тийш нь өгч явуулав уу?” гэж Ерөө гайхаад л өнгөрөв. Үнэндээ бол одоо болтол олдохгүй байгаа нялх үрийг нь алдаж төөрүүлсэн гэж хэлэх юм бол залуу эх маш хүнд байдалд орно гэж бодоод Ууганжаргал, Батбаяр хоёр нэг хэсэгтээ хүүгийн нь дуулгаад хэрэггүй. Нэгэнт орон даяар алдагдсан хүүхдийн зургийг тараан, эрэн сурвалжилж байгаа болохоор ямар ч байсан сураг гарах байлгүй гэж хүлээжээ.

Утсаар ярьсны маргааш нь гэнэт Сэрчмаа ажил дээр нь хүрээд ирэв. Тэр сайхан зантай байж

-Миний хүүхэн сайн уу? хэмээн үнсээд

-Чухал яриа байна гаръя.... хэмээв.

-Яасан бэ? Би ажлаа орхиж болохгүй биз дээ? гэвээс

-За зүгээр дээ зүгээр. Эзэн чамайг уулзъя гэж байна гэжээ.

Юу болсон юм бол? Ингэж ажил дээрээс дууддаггүй л сэн гэж гайхан бодоод Сэрчмааг дагаж гарлаа. Ажлын газрын үүдээр гармагц Сэрчмаа зогтусан

-За найзаа эзний үгнээс гарч болохгүй шүү. Чамд маш чухал ажил өгөх гэж байна. Тэгэхдээ энд Сөүлд биш, харин Гонконгод... Бидний танил өнөөх Жан бий шүү дээ. Тэр чамайг Гонконгод аваачиж үйлчилгээний ажилд тавих юм байна. Сардаа 2000-4000 долларын цалинтай тийм ажил олдохгүй шүү. Эхлээд үйлчилгээний дамжаанд суулган, бас хэлний дадлага хийлгээд тусгай байранд хоол, байр үнэгүй байх юм гэнэ. Чи ядуу даржин аав ээжээ бод. Нялх хүүгээ бод. Монголд ч, хятад, солонгост тийм ажил олдоно гэж гонж. Миний хүүхэн “За” л гэж хэлдэг юм шүү.

Энэ явдал даан чиг гэнэтийн зүйл байсан болохоор Ерөө юу ч хэлж эс чадав. Сэрчмаа ч түүнээс хариу нэхсэнгүй хөтлөсөөр эзний өрөөнд оржээ. Тэнд эзнээс гадна мөнөөхөн Жан сууж байлаа.

-Ай, Ерөө. Ойрд би Гонконг яваад элдэв ажил амжуулах гэсээр хэл сураггүй болсныг өршөөн хэлтрүүлээрэй. Хамгийн гол нь чамд амласнаараа үйлчилгээний ажилд чамайг оруулах гэж хөөцөлдсөөр удлаа. Гурав дөрвөн мянгын цалинтай үйлчилгээний ажилд орохоос чи татгалзахгүй биз дээ? Дээр нь байр, хоол үнэгүй хэрэглэнэ гэж Жан хэлжээ.

-Монголчууд та нар ядуу. Ар гэртээ л хэдэн цаас олох гэж гадаад оронд ирдэг шүү дээ. Миний бодоход ийм сайхан завшааныг алдаж болохгүй. Манай Сөүлд ч үйлчилгээний ийм өндөр цалинтай ажил тэр болгон олдохгүй шүү.

Гурван талаас нь ятган шахаж байхад Ерөө татгалзаж чадсангүй. Үнэндээ ч тэр их мөнгөний тоо сонсоод ухаан алдах шахав. Төгрөгөөр яривал тэрбээр сардаа 3-4 сая төгрөгийн цалин авах нь байна. Хүсээд хүсээд олдохгүй тэр их мөнгийг ээж нь ганц удаа боловч гартаа барьж үзээгүй шүү дээ. Гартаа барих нь байтугай, зүүдлээ ч үгүй байлгүй. Тэгээд хоол, байр үнэгүй гэхлээр авдаг цалин бүгдээрээ л түүний орлого болох нь...

Манай Ерөө дуртай байх шиг байна. Одоо явах бэлтгэлээ хангах л үлдлээ гэж Сэрчмаа хэлжээ.

-За тэгье хэмээн Ерөө сулхан шиг дуугарав.

-Маргааш өглөө хоёулаа онгоцоор гарна. Мэдээжээр онгоцны зардлыг би өөрөөсөө гаргана. Бэлдэж цөхөөд байх юм юу байхав. Хуучин муусайн хувцсаа орхивол таарна. Үйлчилгээний

ажилчдад тусгай хувцас тавьж өгдөг юм шүү дээ.

Чухам ямархан хувь заяанд өөрийгөө барьж өгснөө гэнэхэн залуухан монгол бүсгүй хэрхэн мэдэх сэн билээ. Ядуу зүдүү хичнээн олон монгол охид чингэж хувь заяаны догшин эргүүлгэнд орсныг тоочин хэрхэн барах билээ. Тэднээс гарч явахдаа Ерөө Жангийн хэлсэн “Үйлчилгээний ажилчдад тусгай хувцас тавьж өгдөг” гэсэн үгийг санаж билээ. Арай намайг Зүүн өмнөд Азийн орнуудад элбэг байдаг цэнгээний газар буюу эрчүүдэд үйлчлэх цагаан байшинд өгөх гэж байгаа юм биш байгаа даа гэж бодсон авч, нэгд ийм буурь суурьтай хүмүүс тийм муухай юм юу гэж хийв гэж дээ хэмээн бодож, нэгэнт за гээд зөвшөөрчихсөн юм чинь цаад учир шалтгааныг нь мэдээгүй байж, үгүй гэж хэлэхээсээ бүрэгшин зовжээ.

Маргааш өглөө байрны нь гадаа сунагар урт америк хийцийн “Ягуар” машин ирж зогсов. Жан өөрөө орж ирэн

-Унаа бэлэн, явцгаая гэв. Ерөө жижиг чемоданаа барин гарлаа. Сэрчмааг ирэх болов уу, гаргаж өгөх байлгүй гэж бодож сэтгэлдээ хүлээзнэсэн боловч түүний бараа ч харагдсангүй. Үерхдэг хүүхний хувьд Сэрчмааг ирээгүйд бяцхан гомдол төрж хоолой нь зангирсан боловч, миний явах цагийг мэдээгүй биз. Энэ Жан хэлээгүй ч байж болно доо хэмээн цайлган сэтгэлээр бодож “Ягуар” машины арын суудалд суулаа.

Машин онгоцны буудал дуу хөдлөх энэхэн мөчид хүний газар, харь хүмүүсийн дунд чи ганцаараа боллоо доо гэж санав. Тэгж санахад Чимгээ эгчийн болон Ууганаагийн захисан “Хэнд ч итгэж болохгүй. Хэдэн ногоон цаасаа ямар ч хүнд үзүүлж болохгүй шүү” гэсэн үгийг санажээ.

Жан олон юм ярьсангүй. Машин ногоон одтой цэцэрлэгийн дундуур гарсан замаар хар хурдаараа давхихад халуун бүлээн салхи цонхоор үлээн санчигийн үсийг илбэж байлаа.

Батбаяр над руу ярих л байхдаа. Би хэл мэдээ өгсөн үгүй шүү дээ. Уг нь Гонконг явах болсноо дуулгасан бол зүгээр байсан. Гэнэт чимээгүй болчихоор гайхацгаах нь мэдээж. За яахав шинэ газар очиж байгаад гар утас худалдан авч ярихад оройтох юун...

Сөүл-Гонконгийн онгоц цагтаа нисэв. Жан онгоцонд суухын өмнө уучлалт хүсч

-Би нэртэй бизнесмений хувьд, бас Гонконгод Худалдаачны намын даргын хувьд онгоцны эхний салонд байрладаг юм. Харин чи энгийн суудалд сууна. Очоод уулзацгаая. Сайхан аялаарай гэв.

Ерөө цаг тутам ааш нь өөрчлөгдөж байгаа Жангийн байдлыг гайхасхийн бодов. Гэлээ гээд яалтай билээ дээ. Харин онгоцонд орсон хойноо арын суудлын хоёр залуу монголоор ярихад эргэж харав.

-Сайн байцгаана уу? хэмээн Ерөө эгэл даруухан мэндэлжээ.

# АРВАН ДОЛДУГААР БҮЛЭГ

## ЗҮРХНИЙ ХИЛЭН

Тэр нэгэн шөнө Дэлгэрмаа буурал хадам эхийн элдэв зүйл шалгаахад нь тэссэнгүй шөнө мэгшижээ.

-Охин минь чи яагаад байна хэмээн хадам эх лаагаа асаан дээр өргөөд асуув.

-Зүгээрээ... Явган их яваад тэгэв үү хөл өвдөөд... гэж Дэлгэрмаа хариулсан сан.

-Алив хөлийг чинь давстай хар цайгаар шавшаад өгье хэмээн Гапилмаа өрөвдөн дуугарч гал түлэх гэв.

-Та унтаж амар даа. Ингэсхийгээд зүгээр болох байлгүй.

Гэвч хөгшин эх унтсангүй. Хар цай чанаж сиймхий даавуунд уусган боож өгөв. Урваж хөрвөсөөр үүр цайлгамагц хадам эвийлэн хөөрхийлөн дуугарч хүүхдийг үнсэн таалж өөрийн дур тааллаар өлгийг задлав...

-Үгүй энэ чинь юу вэ? Манай хүүхэд биш юм биш үү? гэж хадам эх дуу алдав.

-Мөн шүү дээ...

-Биш л байна даа. Шөнө үнэр нь өөр байсан... Одоо үзвэл өгзөгний нь мэнгэ алга. Тэр мэнгээр нь би өөд болоод удаагүй байгаа буурал аавыгаа чамд эргэж төрж гэж билэгшээсэн юм. Би талийгаач аавынхаа өгзгөн дээр тавьсан тэмдэг ёсоороо байсан... Дэлгэрээ чи үнэнээ л хэл. Ач хүү яасан бэ? Би хүүхдээ, ач, зээ нараа үнэрээр нь л таньдаг. Надад байгаа онцгой мэдрэмж тэр юм. Ер үхэр малд хүртэл тийм мэдрэмж байдаг шүү. Зунгагий нь үнэрлээд л хонь үр төлөө таньдаг. Нохой шиг үнэрч амьтан гөлөгнүүдээ үнэрээр нь л таньдаг байлгүй. Нэг л явдал болж... Ач хүүгийн минь мэнгэ тийм ч амархан арилах ёсгүй...

-Чи юу гэж хүүхдийг хоргоогоод байгаа амьтан бэ? Холоос арай гэж ирээд байхад нь халамжилж асрахын оронд элдвээр хэлж үглэж дуулдаг чинь юув? хэмээн Дорлиг гуайн адуунд өшиглүүлсэн хөлөө янгинаад байхад барилан үзэж хэлэв.

-Эхийн сэтгэл андуурахгүй шүү. Ямар нэг осол зэхий явдал болсныг сэтгэл минь хэлээд байна. Хэрэв гай барцад болсон аваас хадмын хувьд бид тэр гай зовлонг хуваалцах ёстой шүү.

Ёстой нэг яаж ч болдоггүй юмтайгаа Дэлгэрмаа учирч дээ. Үнэнээ хэлье хэцүү, үгүй гэхэд бас зовлонтой явдал болж дээ. Нээрээ эхийн сэтгэл нэгийг мэдсэн бололтой. Би тэгвэл яагаад энэ хүүг үнэрлээд талийгаачийнхтай яг адилхан гэж бодсон юм бол? Надад хүүгээ үнэрээр нь таних тэр мэдрэмж гэгч үгүй байгаа хэрэг үү? Одоо би яах вэ?

Хадам эхийн зүрхний хилэн хөдлөв бололтой. Энэ хорвоод санаж сарвайх ганц үрээ алдчихаад, тэнгэрт хэлье хол, газарт хэлье хатуу, элэг зүрх өвдөж хагацал харууслын хар

уйтгар цээжийг мэргэж явсан өдөр түүнд бий. Энэ жаахан амьтныг галт тэргэнд согтуу залуугаас авч, чинэсэн хөхөө амраан, хөхүүлж суухдаа сэтгэл яаж амарлаа даа. Тэгээд Түнхэл өртөөнд буугаад мөнөөхөн согтуу ирсэнгүйд баярлан хүүхдийг авч зугтахдаа, элэг нь яаж дэвглээ дээ. Тэр гэмт хэрэг хийсэн нь үнэн болов чиг үрээ алдсан эх ингэхээс өөр аргагүй л байсан даа. Гэтэл тэгж зовж зүдэрч баймааж үрийнхээ оронд олж авсан бяцхан амьтныг ад шоо үзэх гэж үү? Үгүй, үгүй... Юу л болбол болог. Жаахан хүүтэйгээ үүрд үлдье. Надад хараал зүхэл, юу ч ирлээ гэсэн азаар олдсон бяцхан хүүгээсээ л салж хагацахгүй байя. Харин Билэгжаргалыг ирэхэд үнэнээ л хэлсэн дээр. Тэртэй тэргүй хадам ээж түүнд бодсноо хэлэх байлгүй.

Чингэж сэтгэлийн зовлонд унасан залуу бүсгүй, гай зовлонгоосоо холдож, хөдөө хэд хоноё гэсэн биш хүүхэд олж баярлаж нэг үзэж, үнэр, мэнгээр нь өөрийн ач хүү биш байна гэж сэрдэх хадмын зүрхний хилэнд шатан алдав.

Дэлгэрмаа удалгүй буцлаа. Түүнийг хүүхдээ тэврээд явахад хадам ээж хорьж цагдсан ч үгүй. Харин ч энэ гай хөө үрийн минь үрийг алдсан буюу сольчихоод огт өөр хүүхэд тэврэн ирсэн болохоор харахаас дургүй минь хүрч буй тул, бушуухан зайлаасай гэсэн шинжтэй байлаа.

-Хөгшин минь чи юу л хийгээд байна даа? Энэ хүүхэд манай л бэр шүү. Юу тохиолдсон байлаа ч гэсэн бидний зовлон нэг биш гэж үү? Ямар ч байсан үнэрлэх үр тэврээд ирсэн нь бидний л аз... Овоо торниун сайхан хүү санж. Бор хоолонд орчихсон юм байна. Хүн хийгээд авбал ашгай юу даа. Дэлгэрмаагаа хэд хоног амрааж, хүүхдийг нь авч өгдөг ч болоосой. Тэгэхэд чи ишгээ голсон гондрон ямаа шиг л аашлах юм. Мал хүртэл өөр зүсмийн үр төлийг ээнэгшээд л авдаг шүү. Болдог сон бол чамд ботгоо голсон ингийг яаж сайн хуурчин сайхан хуурдан хөөсөлж байгааг үзүүлэх сэн. Тэгж сайн хуурчин хөөс хэмээн уянгалуулсаар ингийг уярааж, нэг л мэдэхэд хоёр том нүднээс нь нулимс сул асгардаг шүү. Тийм хуурчин авчирч чамайг аргадуулдаг ч байж уу даа хэмээн Дорлиг гуай өвчтэй хөлөө илэнхэн уурлах, ёжлохын хооронд хэлж билээ.

-Ээж арай дэндүү юм. Бэргэн эгчийг явуулж яах нь вэ? Юу л гэж үрээ алдсан бол бидэнд дуулгахгүй өнгөрөв гэж дээ? Яалаа гэж хаанаас ч юм өөр хүний хүүхэд авчирав гэж дээ? Өвчин зовлон ээрээд ч юм уу, тэр мэнгэнээс болж гай зовлон тохиолдоод эмнэлэгт арилгуулсан ч юм уу? Үнэн үгийг нь сонсохын оронд элдвээр хардаж сэрддэг тань хэтэрч байна. Бүсгүй хүнд чинь бас зовлон байдаг шүү. Аавын хэлдэг үнэн шүү дээ. Танайд байх нь төвөгтэй байгаа бол манайд хэд хоног байг. Царай зүсийг нь хар. Ямар их ядарч вэ? Би асарч тойльё хэмээн Билгээгийн дүү хүүхэн Сайханаа хэлжээ.

-За яах вэ. Та нарын сайхан сэтгэлийг ойлгож байна. Хадам ээжийн уурлаж уцаарладаг зөв ч байж магадгүй. Би буруу өгч чадашгүй нь. Эцсийн эцэст үрийн мөрөөдөл болсон бидэнд энэ хүүхэд номоороо л ирсэн. Эргэх цаг хэний маань буруу зөвийг хэлж өгөх байлгүй. Хотод хийх ажил надад их байна. Хүүгээ асарч, хүүхэд саатуулах газар өгөөд ажлаа хиймээр байна. За баяртай. Сайн сууцгаагаарай...

Дэлгэрмаа хүүгээ тэврэн гарав. Нүдний нь нулимс сул асгарч байсан боловч, тэр хэнээс ч өмгөөлөл эрсэнгүй билээ. Хорвоо гэдэг хатуугаа хүрвэл даан чиг хатуу ажээ. Хүнд эрс шийдэмгий зан хэрэгтэй гэж Дэлгэрмаа боддог билээ. Юу ч болог, яаж ч амьдрал хатуурхаг,

азаар олдсон хүүгээ л гараасаа салгахгүй. Энэ бол хорвоогоос надад өгсөн шагнал. Буян хишиг ч гэсэн болно. Бурхан хагацал үзсэн түүнийг ивээж энэ үрийг явуулсан юм. Тиймээ миний хүү ээ?

Мөнөөх л уртын модны залуухан жолоочийн бүхээгт суугаад хажуугаар жирэлзэн өнгөрөх хус, нарсны өнгөнд нүд сэргэн сэтгэл уужирч явахдаа нэг ёсондоо хадмын гэрээс холдон нисч яваа хун шувуутай өөрийгөө адилтган бодож билээ. Багадаа уншсан нэг үлгэрт чингэж хун шувуу нисч чадахгүй байгаа дэгдээхэйгээ хошуундаа зуун нутгийн цэнхэр нууран дээгүүр элин халин одсон тухай уншнаа санав.

Үгүй нээрэн өндөр даваанаас аажуухан буух краз машин хэдийнээ агаарт хөөрөөд доошлож байгаа ч шиг, хамаг байгаль дэлхий дөрвөн аварга дугуйны нь доогуур жирэлзэн өнгөрч, гол ус тэртээ дор гялалзаж гялтганан урсч, хаврын эрээн цэцэгс түүнд баяр хүргэн сэтгэл тайвшруулан найгаж байх шиг санагдана.

Би нисч байна. Тохиолдсон гай зовлон бүхэн ард үлдээд, өөр хүнийх байлаа ч гэсэн надад ирсэн энэ бяцхан хүүтэйгээ аз жаргал өөд нисч явна. Хувь заяа минь цаашид юу болбол ч болог. Ай сайхан, сайхан.

-Хүүхэн гуай царай чинь гийгээд, хамаг зовлонгоосоо салсан хүн шиг баяртай инээмсэглэж явна уу даа? Бүсгүй хүн ингэж сайхан инээмсэглэхэд хэний ч хайр татам гоё болдог шүү. Гол дээр очоод түр амрах уу? Сайхан цай чанаж уусан ч болж л байна. Надад сайхан хүйтэн ундаа байгаа л даа. Жаахан мах байна. Шорлог хийж идвэл зүгээр дээ хэмээн жолооч залуу хэлэв.

Өтгөн хар хөмсөгтэй, чийрэг хүрэн бор царайтай, харваас нүдэнд дулаахан аятайхан залуу юм. Иймэрхүү эрчүүд гүндүүгүй байдаг даа. Гарын нь булчингууд бөх хүнийх шиг товойж, халууцаж цамцаа тайлан цээжээ нүцгэлсэн нь үлгэрийн баатар шиг л харагдана.

Хорь гучин алдын уртын гуалан ачсан аварга том тэрэг өгсүүр замаар аажуухан уруудсаар голын эрэг рүү бууж зогсов. Шувууд жиргээд, голын урсгал шоржигонон, сэтгэлд тун тааламжтай сайхан өдөр байв.

Жолооч бүхээгнээсээ буухдаа бяцхан хивс авч голын эрэгт дэвсэв. Чингээд гал түлэв. Дэлгэрмаа саяхан сэтгэлд байсан гунигаас түр боловч холдон, хадамдаа ад үзэгдсэн уур хилэнгийн үгсийг мартан хүүгээ тэвэрсээр бууж зүлгэн дээр дэвссэн хивсэн дээр хүүгээ хуурайлав. Жаахан хөвгүүн суниаж, хөөрхөн гар, хөлөө хөдөлгөн эвшээв.

-Миний хүү мээмээ хөхчих. Харж ханашгүй сайхан үр минь...

Дэлгэрмаа сэтгэлийн хөдөлгөөнд автав. Тэрбээр хэн нэгнийг хайрлан үнсмээр ч шиг, тэврэн дотносмоор ч шиг болж ирэв. Сэтгэл дотор бяцхан шувуу жиргэх шиг болов.

-За хүүхэн гуай хүйтэн ундаа уу. Шорлог зоогло. Эр хүний жаргал эзгүй хээр гэдэг юм. Өнөөдөр мөн сайхан өдрөө дөө. Хоол идэж, жаахан амар даа хэмээн хадмындаа Дэлгэрмааг тавгүй өнгөрөөн, хоол хош ч олигтой идээгүйг мэдсэн мэт сайхан эр хүн халамж тавив.

-Баярлалаа.

Дэлгэрмаа өлсч буйгаа сая л мэдэв. Тэрбээр эрээлж цээрлэхгүйгээр шорлог идэн, ундаа ууж залуу эрийг налан хэвтэж зүүрмэглэв. Үдшийн бүрий болох үеэр залуухан хүчирхэг жолооч түүнийг таалан үнсэхэд Дэлгэрмаа цааргалаагүйгээр үл барам, харин ч хариу үнсч, түүний хүссэн бүхнээ хийхэд биеэ сул тавьж өгөв. Нөхрөө хүлээсэн он жилүүдэд тэр биеэ хэт барьж, эхнэр хүнийхээ сахилыг үл мартан, хэнтэй ч энгэр зөрүүлээгүй билээ. Энэ сайхан ойд, хээр газар голын эрэгт халамж тавьсан эр хүнтэй жаргал эдлэхдээ хадам эхээсээ хариугаа авч байна даа гэж бодож байлаа. Залуу эр ямар хүчтэй байна вэ? Түүнийг гурил шиг эдлэх л шахав. Дэлгэрмаагийн бие сэтгэлийн шаналгаа тайлагдан, ойрд үзсэн бүхнээ түр боловч мартан тэрбээр цэнгэлийн сайханд өөрийн эрхгүй дуу алдаж билээ. Хажууд жаахан хүү нь үнэгчлэн нойрсч байлаа.

\* \* \*

Сөүл гар утсанд хариу өгсөнгүй. Урд өмнө олонтаа ярьсан тэр л хуучин дугаараараа хичнээн залгаад ч Ерөө агаарт шингэж, усанд ууссан аятай ямар ч хариу өгсөнгүй. Яах нь энэ билээ?

Батбаяр бүр гайхаж орхив. Гар утсаа хаячихав уу? Өвчин зовлон тусаад эмнэлэгт хэвтэв үү? Өвдөж хавдаад хэвтсэн байлаа гэхэд гар утсаа биенээс салгамааргүй...

Батбаяр цөхрөөд дэмий л толгойгоо сэгсрэв. Урд өмнө олонтаа ярьж Ерөөгийнхөө дууг сонсон ихэд санасан сэтгэлээ дэвтээж болоод л байсан. Ямар ч үед өглөө, орой хэдийд ч залгахад Ерөө шууд л хариу өгдөг байсан... Түүнийг явснаас хойш бяцхан амрагаа санаад болохгүй үедээ чингэж утсаар хэдхэн хором шулганалдаад өнгөрөхөд сэтгэл амарч, түүнийгээ эх орондоо байхад түр зуур боловч уулзаад авсны дайтай л сайхан санагддаг байсан. Ерөө өөрөө ч түүний гар утас руу байн байн залгаж түүнгүйгээр харь хүний нутагт уйтгарлан суугаагаа хэлдэг байсан. Заримдаа бүр уйлж байгаад ярина гээч.

-Эхний саруудад сайн ажилласан гээд шагнуулж далайд ёстой гоё амарсан. Бүлээхэн сайхан далайн эрэг дээр чамайгаа бодож, эзний дайллаган дээр олон төрлийн сайхан хоол идэхдээ, чи минь энд байдаг ч болоосой гэж бодсон шүү. Хэрэв чамайгаа энд байсан сан бол далайн усанд оруулан нурууг чинь угааж өгөхсөн гэж бодсон... Тэр олон гоё амттайхан хоолноос амсуулдаг сан бол юутай сайхан гэж санасан...

Сүүлчийн удаа Ерөөгийн ярьсан үгс тэр чигээрээ чихэнд сонсогдох шиг... Энэ чинь ердөө л долоохон хоногийн өмнө шүү дээ. Гэтэл яагаад одоо утсандаа хариу өгдөггүй билээ?

Батбаярын сэтгэл түгшүүртэй болов. Нээрээ юу болох нь энэ вэ? Янз бүрийн л юм дуулддаг... Японд очсон монгол охидыг хөдөө тосгонд аваачаад харанхуй өрөөнд хорьж, элдэв шахалт дарамт үзүүлж байгаад биеийг нь үнэлүүлэхэд хүргэсэн гэж саяхан сонинд бичсэн байсан...

Хаана ч гэлээ царайлаг монгол бүсгүйг ажил дээрээс нь хулгайлан өөр оронд баян цатгалан хөгшин хүний олон авгайн нэг болгосон гэж бас дуулдсан... Ерөө бол гоё сайхан бүсгүй шүү дээ. Эхний төрөлтийн дараа бие нь төлжөөд ямар ч эр хүн хараад дуу алдмаар сайхан хүүхэн болсон шүү. Хэрэв ашиглах санаа төрж гэм хамгийн түрүүн өртөх тийм л гоо үзэсгэлэн



Ерөөд бий.

Энэхүү тавгүй бодол Батбаярыг бүр байж суухын аргагүй болгов. Тэрбээр өрөөнөөсөө гарч мөнөөхөн хааяахан очдог Улаанбаатар зоогийн газрын зүг алхав. Гадаа халуу шатаж байлаа. Нимгэн цамцтай явмаар атал тэр пиджакаа өмссөн нь хамаг биений хөлс урсгах шиг санагдахуй тайлав. Тэглээ гээд нэмэр алга. Хөлс нь цувж, барагтай бол өвддөггүй зүрх нь салганан чичрэх шиг болов. Нэг л муу ёрын зөн совин татаад байх шиг...

Ашгүй нэг зоогийн газар хүрээд ирэв. Тэрбээр яаран хаалгыг татан оров. Гадна халууныг хөөх гэсэн шиг урдаас нь сэнгэнэсэн сэрүүхэн агаар Батбаярыг тосч авах шиг болов. Дассан өрөөндөө орж тухлав. Муу пиджакаа өлгүүрт өлгөв.

Энэхүү бяцхан өрөөний юм бүхэн дурсгалтай. Анх удаа Ерөөгөө энд л авчирч, хуучин хавар намрын хөх пальтог нь чухам энэ өлгүүрээс л өлгүүлж, энэхэн улаан арьсан бүрээстэй түшлэгтэй сандалд суулгаад хооллож байсан нь санаанд оров. Чингэж хуучнаа сэргээн санахуй дотор бачимдан, хоолой зангирч ирэв. Урьд ер тэгдэггүй атал аньсага нь нойт оргиж хамрын угаар шархираад ирэв.

-Үгүй би чинь яах нь энэ вэ?...

Зөөгч залуу түүний занг хэдийнээ мэдэх болохоор аяга дүүрэн виски авчирч дув дуугүй өмнө нь тавиад явчихав. Хорь гучин минутын дараа тэр эргэж ирээд

-Ямар хоол захих вэ? гэж асууна гэдгийг Батбаяр мэдэж байв.

“Юунд би Ерөөгөө харь газар явуулчихлаа даа.”

Батбаяр хэзээ ч тэгдэггүй атлаа харин энэхэн мөчид зөөгчийн авчирч өмнө нь тавьсан шилэн аяга дүүрэн дарсыг нэг амиар ус шиг залгилж орхив. Гал халуун дарс толгой маналзуулан, хоолой халуу оргиулан цааш одохыг тодхон мэдрэн, тун амархан согтмоор болж ирэв.

-Юу болох нь энэ вэ?

Ямар нэг осол зэхий явдал болсон шиг зүрх шивнээд байв. Хайртай хүмүүс амь нэгтэй байдаг. Үнэн хайртай л бол зүрхнээс зүрхэнд дохио өгдөг гэдэг. Энэ талаар маш зөнтэй хүн бол Ууганжаргал билээ. Нөхрийнхөө хамаг л нууцыг тэр далдаас хараад байх шиг санагддаг. Наад зах нь одоо яг ингээд санаа сэтгэлийн хүнд байдалд орж архи ууж суухыг тэр мэдсэн дээ. Ерөө тэр хоёрын нууц амрагийн явдлыг Ууганаа бүр эхнээс нь зөнгөөрөө мэдсэн л байсан... Удаан ханилсан хүмүүст үл үзэгдэх тийм совин байдаг бөгөөд түүгээрээ болж буй явдлыг яг тэр агшинд нь телепат гэгч сэтгэлийн дохио хэлсэн л байдаг гэлцдэг. Дайнд нөхрөө амь үрэгдэх тэр мөчид гэргийн зүрх мэдэрч холын холоос зөн совин нь хэлж өгсөн байсан.

Яг л түүн шиг Батбаяр өөрийнхөө хамгийн хайртай бяцхан амраг юугаа санаж төсөөлснөөс өөр ямархан нэгэн явдалд орохыг мэдрэх шиг болов. Харин чухам юу гэгч болов доо?

Энэхүү сэтгэлийн далд түгшүүр сая дөнгөж эхэлж байгаа юм биш. Хэд хоногийн өмнөөс

нэгэн аймшигт зүүдэнд Ерөөг тун чиг царай муутай байхыг харсан тэр шөнөөс эхэлсэн гэвэл болох юм.

... Шөнө ид нойрон дунд хэн нэгэн Батбаярын мөрнөөс татаж сэрээх шиг болов. Тэрбээр урд өдөр нь бага зэрэг балгасан, тэгээд ч ажил ихгэй байсан тул үхсэн мэт дугжирчээ.

Чингэтэл хэн нэг хүн түүний мөрнөөс сэгсрэн гараар түлхэн сэрээх гэсэнд жаахан хүүхэд шиг нойроо харамлан унтсаар байв.

-Батбаяр аа. Хайрт минь сэр л дээ.

Энэ дуу Ерөөгийн дуу байв. Маш бүдэгхэн, туйлын гунигтай, цөхөрсөн дуугаар Ерөө чингэж хамгийн хайртай хүнээ дуудах шиг...

Батбаяр нүдээ нээх шиг болов. Согтуу нойрмог нүдэнд нь үс нь сэгсийж, нулимсанд хамаг нүүр нь нов нойтон болсон, унтлагын хувцаснаас өөр хувцасгүй Ерөө орны нь хажууд чичрэн зогсч байлаа.

-Хүүе, Ерөө минь...

Батбаяр байдгаараа хашгирав. Тэр Ерөөгөө тэврэн авах гэж ухасхийлээ. Одоохон халуун хөнжилдөө оруулахгүй бол Ерөө даарч, чичрээд байх шиг. Тэр минь яачих нь энэ вэ? Хамаг хувцсаа яасан юм болоо? Яагаад үс нь сэгсийн арзайж, царай нь цонхийн, юунд ингэж уйлнам бэ?

Батбаяр бушуухан Ерөөгөө тэвэрч, тайтгаруульа хэмээн хоёр гараа сарвайн зүтгэх агшинд

-Батбаяр аа чи яаж байнаа? Хүүе сэрээч! гэх Ууганаагийн дуу гарчээ. Нөхөр нь гэнэт хашгиран Ерөөг дуудаж, харанхуй өрөөнд орноосоо босоод хоёр гараа сарвайлган явахад Ууганжаргал дуудав. Гэрэл асаасны дараа, хацрыг нь зөөлхөн алгадаж баймааж сэрээсний дараа Батбаяр сая л зүүд биш, бодит байдлыг согтуу нойрмог нүдээр харан гайхаж байхад Ууганаа

-Яав? Муухай зүүдлээ юу? гэж аядуухан асуужээ.

-Харин тийм ээ. Ерөө маш эвгүй хачин царайтай зүүдэнд ороод...

-Би ч гэсэн Ерөөд сэтгэл зовоод л байна. Муу охин минь зүгээр л байгаа даа?

Батбаяр бүр сэргэв. Ерөөг дуудаж зүүдлэн босч давхисан нь тун эвгүй явдал боловч, тэр тухайд Ууганаа зэмлэсэнгүй, харин ч өөрөө Ерөөгийн талаар зовсоор байгаагаа хэлжээ.

Батбаяр хөргөгчөөс дарс аягалан уугаад

-Ямар нэг явдал болоогүй байгаа даа гэж бодох юм. Яагаад ойрд наашаа ярьсангүй вэ? гэв.

-Харин тиймээ. Уг нь яримаар л... Гадаадад байгаа хүмүүсийн тухай сонинууд янз бүрийн л

юм бичих юм. Саяхан Сөүлээс ирсэн нэг хүүхэн тэнд байгаа нөхөргүй хүүхнүүд маш их дарамтанд ордог гэж ярьсан байна лээ. Чи үүнийг уншаач гэж “Хувийн амьдрал” сонины нэг дугаарыг гаргаж өгөв.

Батбаяр “Монгол охид Солонгост нохой шиг амьдарч байна” гэсэн гарчигтайг шимтэн уншлаа.

“Тэнд ганц бие нөхөргүй очсон монгол хүүхнүүдийг элдвээр ичээж дарамталдаг нь нууц биш. Эзэн нь татаж чангаагаад хэрэв үгэнд нь орохгүй бол цалин хөлс өгөхгүй, ажлаас хална, цагдаад хэлнэ гэх мэтээр сүрдүүлнэ. Тийм учраас монгол залуухан бүсгүй хүний эрхэнд орохгүй гэж ажлаасаа гарч өөр үйлдвэрүүд дамжина. Тэнд нь мөн ялгаагүй тийм л байдал угтана. Шуудхан хэлэхэд Солонгост монгол хүүхнүүдийн нилээд хэдэн хувь нь янхан маягаар амьдарч байна.”

Эдгээр мөрүүдийг уншаад Батбаярын нуруу хүйт оргих шиг болов. Бурхан минь, ийм л явдал Ерөөд бүү тохиолдоосой.

-Чи бид хоёр ч хүний мөсөөр тааруухан улс юм даа Батбаяр минь... Тэр муу охины хойноос сайн хөөцөлдөж болох л байсан шүү дээ.

Юуны төлөө чи нэртэй сэтгүүлч билээ дээ. Чамд нэр байна. Албан тушаал байна. “Заг”-ийнхантай яриад цаана чинь юу болоод байна? Манай явуулсан хүн яасан бэ? Бүх ажил төрөл, амьдрал нь хэвийн үү? гэж асууж болноо доо. Би гэж нэг заяа нь харласан эм хүүхдийг нь алдчихаад дэмий л гаслаж хэвтэхээс цаашгүй. Тэр цагдаагийн газраар ч явдаггүй. Өнөө муу хүүгээ ч сурагладаггүй...

Сүүлийн үгээ хэлэхдээ Ууганжаргал бүр уйлан дуугарчээ.

Түүний үг үнэн байлаа. Маргааш нь Батбаяр “Заг” компанийнхантай уулзаж Ерөөгийн байдлыг мэдэж өгөөч гэж гуйв.

-Зүгээр байлгүй дээ. Солонгосын талын хүлээсэн үүрэг бий. Тэд монголоос гэрээгээр очиж ажиллаж байгаа хүмүүсийн аюулгүй байдлыг бүрэн хариуцах хатуу заалт гэрээнд бий. За яах вэ бид Сөүл рүү ярья. Хэд хоногтоо та хүлээзнэж бай гэж тэндхийн хүмүүс хэлжээ.

Чингээд л Батбаяр Ерөөгийн гар утас руу байн байн залгах болсон билээ. Утас хариу өгсөнгүй... Тэрбээр бас цагдаагийн газар очиж Баярболдын эрэлд ямар нэг ахиц байна уу, үгүй юу гэж сонирхов. Сэтгэлд гэрэл гэгээ өгөх ямархан нэг сураг дуулсангүй.

Сэтгэлийн далд түгшүүр намар цагийн хатсан өвсөнд авалцсан түймэр шиг улам бие сэтгэлийн дотор шатсаар л байлаа. Одоо эргээд бодоход хэрэвзээ ямар нэгэн осол зэхий явдал гардаг юм аа гэхэд түүний гол буруутан нь Батбаяр л байж таарах... Энэ хамаг хэрэг, шаазгайн суусан овоог хамгийн түрүүн босгосон хүн чи шүү дээ. Хэрэв чи тэр охиныг нэгэн намар гэртээ авчраагүй сэн бол... Хэрэв чи түүнийг эхнэрийн эзгүйгээр эрхэндээ оруулаагүй сан бол... Хэрэвхүйеэ Батбаяр чи Ерөөг жирэмсэн болгож дараа тохиолдсон олон олон ээдрээт хэргийг эхлээгүй сэн бол хатуу хахир ч гэсэн эхтэйгээ зүв зүгээр л байхсан биш үү?

Лев Толстойн нэгэн зохиолд Нехлюдов билүү дээ, нэг дээд зиндааны хүн гардаг. Тэрбээр арван хэдхэн настай хөдөө тосгоны охиныг ашиглан завхруулснаас хөөрхий тэр бүсгүй сүүлдээ янхан болдог бил үү?

Монголын орчин цагийн Нехлюдовыг ол гэвэл чамайг л заах хэрэгтэй болж дээ. Тиймээ тийм, гарцаагүй үнэн гэвэл энэ л байна. “Сэхээрэлт” романы гол баатар оросоос чи юугаараа өөр юм бэ? Тэр мөн л чам шиг худлаа гаслаж, нүглээ наманчлан шоронгоос мөнөөхөн янхан хүүхнийг суллах гэж явдаг шүү.

Уусан архи толгойд гарч, сэтгэлийн бухимдал, цөхрөл туйлдаа хүрээд Батбаяр өөрийн эрхгүй ёолон зүрхээ дарж

-Бурхан минь би юу хийчих нь энэ вэ? гэж дуу алдлаа.

Энэ үгийн цаана Ерөөгийн амьдралыг үрсэн, хүү Баярболдыг хулгайд алдсан хийгээд урагшгүйгээсээ болоод амьдралд тохиолдоод байгаа хүндрэл бэрхшээл бүхнийг ялан давж гарах чадал тэнхээгүйдээ гомдсон сэтгэлийн цөхрөл, өөрийгөө түмэнтээ зэмлэх утга нуугдаж байлаа. Батбаяр зоогийн газар удаан суув. Хоол ч захисангүй. Харин виски нэмэн уусаар сүрхий согтжээ. Түүний булингартай ухаан дэн дун болов.

... Ууганаа байж ядав. Нүдэнд нь Батбаяр согтуу харагдаад болох биш. Тэрбээр зоогийн газрын ширээн дээр духаараа ширээ мөргөн тонгойж суугаагаараа унтаж байх шиг... Ингээд ирэхээр Ууганжаргалын совин үнэн байдаг билээ. Нөхөр нь ухаангүй согтжээ. Одоо яах вэ?

Сүүлийн хэдэн хоног Батбаяр сэтгэлийн далд түгшүүртэй явааг Ууганаа мэдэхийн цаана мэдэж байлаа. Тэр үнэхээр Ерөөд хайртай ажээ. Жинхэнэ хайр л хүнийг ингэж сэтгэл зүрхнийхээ дотно хүний төлөө шаналахад хүргэдэг. Үнэхээр Ерөөд ямар нэгэн явдал тохиолдоод тэрнийг Батбаярын совин мэдсэн учраас ч байж ядаж байна. Тэгвэл Батбаяр, Ерөө хоёрын явдал зүгээр ор хөнжлийн явдал биш байх нь ээ? Эр, эм хүмүүсийн бүсэлхийнээс дооших зугаа цэнгэлээр л тэр хоёр уулзаж учирч байгаа. Ууганжаргал бол Батбаярын гол амраг нь, сэтгэл зүрхээ бүрнээ өгсөн хэзээ, хэнээр ч сольшгүй авааль гэргий, ууган хайр нь гэж төдийгөөс өдий болтол бодсон минь худлаа байх нь ээ? Боловсон хүн болохоороо Батбаяр насны ханиа гомдоохгүй сэн гэхдээ л энэ гэрт тогтож, хуурамчаар инээвхийлэн, халамж тавьж байгаа болохоос биш, угтаа бол намайг сэтгэлээсээ аль хэдийнээ таягдан хаясан нь байх нь ээ?

Ууганаа яагаад ч юм бэ ингэж бодов. Сүүлийн жил болсон бүх явдлууд нүдний нь өмнүүр сүүдэр шийний түргэвчилсэн дүрс шиг жирэлзээд өнгөрлөө. Тэрбээр далд сэтгэлдээ үр хүүхэдтэй болох сон гэсэн нөхрийнхөө сэтгэлийг бодож, хэрэвээ Ерөөгөөс хүүхдийг нь аваад өсгөж өгөх юм бол энэ гэрт Батбаяр нь үлдэх аргамжаатай болно. Хэрэв эс тэгвэл залуухан хүүхэн дагаад яваад өгч магадгүй хэмээн арчаагүй байж, түүнээсээ болоод өөрийгөө зольж, болж буй бүх хэрэг явдлын өмнө бууж өгснөө одоо санав.

Гэтэл санаж төсөөлснөөс бүх явдал зуун наян хэм эргэв. Хувь заяа Ууганааг эм хүний хувьд хүүхэд гаргах чадалтайг харуулан жирэмсэн болгож, харин өсгөж өндийлгөө гэсэн Баярболдыг нь хулгайч аваад зайлжээ.

Үр нь хэвлийд өдөр өдрөөр томорч, үе үе цээж доргитол зүрхэн дор тийчлэх нь мэдрэгдэж байхад Ууганаа эх хүний хувьд баярлаж ханахгүй байв. Тэгэхэд харин Батбаяр шөнөд Ерөөг зүүдлэн, харанхуй өрөөнд хоёр гараа сарвайлган залуу бүсгүйг дуудан босч ирж байгаа юм даа. Тэгээд ч зогсохгүй цаг зав, мөнгөө хайрлахгүй Сөүл рүү гар утсаараа залгаж залуу бүсгүйн төлөө нэгэн ёсондоо галзууран алдаж байгаа нь сонин санагдана. Одоо бүр болохоо байгаад зоогийн газар мангууртлаа уужээ. Нөхрийнхөө согтуу байгааг Ууганжаргал мэдсэн авч, чухам хаана, аль зоогийн ширээн дээр толгойгоо ганзагалан хэвтэж буйг яаж мэдэх сэн билээ. Одоо бол дэмий л хүлээхээс өөр мэхгүй ажээ.

Энэ айлын амьдрал цаашдаа юу болохыг төсөөлөхийн аргагүй. Нөхрийнхөө сэтгэлийн орон зайд л ямар ч гэсэн Ууганаа өөрөө бараг багтахгүй болсон бололтой. Яах аргагүй нэг гэрт байгаа нь үнэн. Ямарваа нэгэн юмнаас болж хэзээ ч хэрэлдэж муудалцдаггүй, гаднын хүний нүдээр харвал хамгийн эвсэг, хайртай дотно энэ гэр бүл, угтаа бол аль хэдийнээ дундуураа ан цав үүсээд, яагаад ч тэр гагнаасыг дахин эвлүүлэх аргагүй болжээ гэдгийг Ууганаа өнөөдөр бүр яс махандаа шингэтэл ойлгох шиг болов.

Гэтэл хэдхэн сар болоод зүрхэн дор тийчлэн өөрийгөө сануулж байгаа энэ бяцхан хүн төрнө. Тэр хөөрхөн амьтан Батбаярт баяр жаргал авчрахгүй юм гэж үү? Үрээ үзчихээд эцэг хүний хувьд Батбаяр түүнийгээ хайрлахгүй байж чадах уу даа?

Ээ мэдэхгүй. Авааль эхнэрийн нь гэдэс томорч, сараар биш, өдрөөр төрөх цаг нь ойртоод байхад Батбаяр ер тоож байгаа ч шинж алга... Харин ч өдөр ирэх тутам залуу амрагаа санан мөрөөдөж, түүнийхээ төлөө зовж, сэтгэлээ чилээн, тэр тухайгаа ханиасаа ч нуухгүй байна. Ерөөгийн төлөө бүү зовог. Тэр нь ёсонд хазгай явдал гэж Ууганаа бодсон юм биш. Ууганаагийн совинд Ерөө бол өөр замаар орчих шиг, муугаар төсөөлбөл “Заг” компанийхаа шугамаар явснаараа жирийн хөдөлмөр хийгээд явах тэр замаасаа хазайчих вуу даа гэмээр санагдаад байлаа. Өөрийнхөө зөн совинд Ууганаа итгэдэг билээ. Чингэж зам харгуй нь ялимгүй хазайсанд хүний хувьд Ууганаа сэтгэл зовж л байлаа. Тэр тухайгаа ч Батбаярт хэлсэн. Тэгэхдээ Ерөө амь насаа алдах юм уу, өвчин зовлонд баригдсан хэрэг биш байлаа. Тэр бүсгүй хэзээ нэгэн цагт эргээд л ирнэ. Харин тэр цагт Батбаяр бол Ууганааг гэхээсээ илүү түүн рүү гүйх хүн болжээ гэдгийг Ууганаа сүүлийн хэд хоногийн хэрэг явдлаас болж ойлгов. Тэгэхээр Батбаярын сэтгэлийн орон зайд өөрөө нэгэнт үгүй болсон учир бушуухан хүүхдээ гаргаад эрүүл саруул торниулан, өөрийн биеэ ч тэнхрүүлж аваад цаашдынхаа хувь заяаг өөрөө шийдэх хэрэгтэй болжээ. Насны нар бас чиг хэвийчихээгүй байна гэж Ууганаа бодлоо.

Тэрбээр Баярболддоо хайртай билээ. Өчнөөн хоног сараар үүрч дүүрч, чухам үргүй хүнд олдсон ганц эрдэнэ хэмээн хайрлаж өсгөсөн болохоор түүндээ хайртай байлгүй яах вэ. Муу хүү минь хаана яваа бол гэж бодоход эхийн зөн совинд хүү харин эв эрүүл, сайн хүний гар дээр дэгэж дэрвэж байгаа шиг нүдэнд харагдах авай.

-Миний хүү хаана явна? Аль вэ ээж өөдөө хараад ход ход инээгээч. Уухайс даа... Миний хүү дүүтэй болно. Дүү чинь миний мөөмийг хөхөж барахгүй дээ. Миний хүү ээждээ хүрээд ирээрэй. Дүү чинь барахгүй юм чинь өрөөсөн мөөмийг нь чи хөхөөрэй...

Ууганаа сэтгэлээрээ чингэж Баярболд хүүтэйгээ уулзах авай. Чингэтэл бүр хачин совин татав. Нэгэн өдөр түр зүүрмэглэхийн зуурт халуун амьсгал санчигны үс эрвэгнүүлэн, нэгэн

жаахан амьтан хацраа хацарт нь наах шиг болов.

-Баярболд оо. Миний хүү! хэмээн чангаар дуудаж Ууганаа өөр рүү нь гараа сарвалзуулан зүтгэсэн нялх хүүгээ тэврэн авах гэж ухасхийв. Гэвч түүний гарт нялх хүү нь биш, харин хүйтэн дэр баригджээ. Ууганаа сэрээд удтал тайвширч чадсангүй билээ. Энэ явдал Ууганаагийн зөн совинд Баярболд хүү нь хол биш, бүр хажууд байгааг хэлээд байх шиг... Тийм ээ хүү хөдөө биш, энэ хотод л байна уу даа гэж тэрбээр боджээ.

....Тэр шөнө Батбаяр ирсэнгүй. Ууганаа хүлээж ядаад нойргүй хонож, дэмий л цонхон дээр зогсоод харуулдсан авч ямар нэгэн бараа сураг харагдсангүй. Ууганаагийн нүдэнд шөнөөр Батбаяр огтын тааламжгүй, үл таних газарт шав шалдан согтуу хэвтэж байгаа шиг харагдахад Ууганаа тун зэвүүрхэв. Ямар муу ёрын юм бэ?

Арайхийж өглөө болоход Ууганжаргал нөхрийнхөө төлөө зовж, согтуу яваад машин тэргэнд дайруулав уу, аль нэг таньдаг айлдаа хонов уу гэж гайхан, айж түгшив. Чингэтэл өглөөний наймаас хорин минут өнгөрч байхад угас дуугарлаа.

-Байна уу?

-Та Ууганжаргал гуай юу?

-За тийм байна. Юу гэсэн бэ?

-Танай нөхөр сэтгүүлч Батбаяр гуай урд шөнө гадаа гудамжинд согтуу уначихсан байхад нь манай цагдаагийн эргүүлийнхэн олж эрүүлжүүлэхэд авчирч хонуулсан юм. Та нөхрөө ирж авна уу...

Ууганжаргал бушуухан хувцсаа өмсч гарлаа.

# АРВАН НАЙМДУГААР БҮЛЭГ

Дэлгэрмаа хүүгээ хуурайлж, нүцгэн чигээр нь унтуулав. Хүү зүүдэндээ ход ход инээн унтаж байлаа. Хэрэв тэнгэрт хальсан хүү нь уйланхай нэгэн байсан бол харин энэ хүү ер уйлахгүй, авахуулах гэж зүтгэхгүй ёстой нэг амар хүүхэд ажээ. Хүүгээ унтуулчихаад хөхөө нэгэнтээ хөвөнгөөр арчин далд хийж Дэлгэрмаа гал зуух руугаа оров.

Гадаа харанхуй хэдийнээ нөмөрч, зуны бүдэг одод тэнгэрт сүүмэлзэн гялалзаж байлаа. Аяга ус буцалган өтгөхөн шиг кофе хийж уугаад Дэлгэрмаа,

-Цаашдаа яаж амьдрах билээ? гэж хэнээс ч юм чанга гэгчээр асуув.

Тэрбээр Түнхлээс модны машинаар гарч хотод оройхон иржээ. Амьтан хүнтэй тааралдах вий гэж айж түгшээр орц руугаа ороход харин азаар хэн ч гарч ирсэнгүй. Саяхан л уй гашуу болж, үрээ хөдөөлүүлсэн Дэлгэрмааг нялх хүүхэд тэврээд явж байхтай хэрэв танил хүн тааралдвал гайхах байлгүй. Зарим нь бүр цочих ч магадгүй. Хүүхдээ алдсныг нь танил найзууд цөм мэдсэн... Баруун Наранд бас чиг чамгүй олон хүн хүүг нь сүүлчийн замд үдсэн... Гэтэл хүүгээ оршуулаад сар ч болоогүй байхад айлаас хүүхэд өргөж авсан гэвэл энэ Дэлгэрмаа галзуурчээ гэхсэн байх... Яах аргагүй шороонд булахыг нь харсан олон хүн Дэлгэрмаагийн хүүхдийг амьд мэнд гэж итгэхгүй л лав. Одоо тэгээд яалтай билээ? Согтуу залуугийн хүүхдийг аваад зугтчихсан юм гэж хэлэлтэй ч биш дээ.

Дэлгэрмаа ямар чиг л байсан азаар олдсон энэ жаахан амьтнаас хагацмааргүй байв. Харин амьтны хэл амыг яах билээ? Танил хүмүүст болохоор энэ хүүхдийг өргөж авлаа л гэе. Тэгэхдээ одоохондоо болоогүй. Юу ч гэсэн талийгаачийн дөчин есөн хоног өнгөрөг. Харин тэр болтол гэрээс гарахгүй байсан дээр үү? Яавал дээр вэ?

Хүүхэд олж аваад маш их хөөрөн баярласан нь үнэн. Тэгж явахдаа дараа нь юу болох вэ гэдгийг бодсонгүй. Яг цаг дээрээ тулахаар юм гэдэг тийм ч санаан зоргоор бүтчихдэггүй ажээ. Хулгайн юм, хулгайнх л байдаг аж. Буруу замаар олж авсан болохоор одоо энэ бяцхан амьтантайгаа олны өмнө айж түгших юмгүй яаж амьдрах билээ гэсэн айхтар ноцтой асуулт гараад ирэв бололтой. Ёс жудгаа бодсон ч, олны хэл амнаас болгоомжлох нь зүйтэй гэж бодсон ч жаалхүүг нэг хэсэгтээ ил гаргаж болмооргүй. Одоо яасан дээр вэ?

Тэр бодон бодсоор дунд сургуульд үерхэж байсан үеийнхээ нэгэн хүүхнийг санав. Тэднийх тавдугаар хороололд байртай. Зун болохоор Дамбадаржаад зуны байшинтай, ногооны газартай уудам том хашаатай тул тэндээ гарчихдаг. Хааяа нэг уулзахаараа сүйд болдог. Арга ч үгүй биз, аравдугаар ангид байхад хөвгүүд “холбоотой хоёр” гээд шоолдог байсан юм чинь... Ажил, амьдралаас болж холдчихсон болохоос биш, хэрэв нэг дороо үүрд үлдсэн бол одоо ч гэсэн холбоотой, мориор юм бол хүзүүгээрээ хэрээтэй л явахсан биз. Багын найздаа болсон явдлыг дуулгаагүй нь яамай. Одоо нэг уулзаад уйлж байгаад зовлон жаргалаа ярих сан. Намайг өрөвдөж хайрлана даа. Тэднийх дэрсхэн хоёр хүүтэй гэсэн... Нөхөр нь бурхан шиг амгалан хүн байх юм билээ. Тавдугаар баазын нэртэй сайн жолооч... Үзмээ өөрөө төрөх газар их эмч хийдэг... Ямар ч гэсэн нярайн талаар жинхэнэ мэдлэгтэй хүн. Түүнтэй л уулзъя. Хамтаараа зөвлөвөл нэг аятайхан шийд гаргаж болох байгаа...

Маргааш нь Дэлгэрмаа эрт гэгч босоод хөлсний тэрэг авч Дамбадаржаа өөд давхилаа. Үзмээг ажилдаа явчихаас нь өмнө “барьж авья” гэж боджээ. Том төмөр хаалгыг аяархан нүдэв. Нохой хуцах дуулснаа удсангүй, цээж нүцгэн булиа, хүчирхэг эр үүдээ нээв.

-Та хэнтэй уулзах гээ вэ? гэж өлгийтэй хүүхэд тэвэрсэн хүүхнийг гайхсан бор нүдээр харж асуужээ.

-Үзмээ байгаа болов уу?

-Байна... Ор, ор! гэж булиа эр найр тавив.

-Хэн бэ өвгөөн? гэсээр цаанаас Үзмээ гарч ирснээ

-Хүүе. Миний хүүхэн хүрээд ирж. Ямар сонин хүн бэ, орооч хэмээн дуу алджээ. Багын хоёр найз тэврэлдэн үнсэлцэв.

-Миний яриад байдаг Дэлгэрмаа чинь энэ шүү дээ. Чамайг хөдөө явчихсан, эзгүйгээр ноднин нэг ирсэн юм даг... Би чамд хэлж байсан даа... гэж ярьсаар Үзмээ Дэлгэрмааг хүүхэд шиг хөтлөн зуны модон байшиндаа оруулжээ.

-За өвгөн минь сайхан хоол хийгээрэй. Бид хоёрт ярих юм их бий...

Үзмээ ингэж хэлсэн боловч түүний урсгал зөөлөн хар нүд Дэлгэрмаа сая орж ирэхдээ орон дээр тавьсан жаахан хүү рүү гайхсан харцаар ажих шиг болов. Үзмээ үнэндээ ангийнхнаасаа Дэлгэрмааг, үр хүүхдийн мөрөөдөл болж болж ганц сайхан хүүтэй болоод тэрнийгээ саяхан алдчихсан гэж дуулсан байжээ. Тийм учраас хүүхэд тэврээд ирэхэд нь гайхснаа нууж чадахгүй байв. Ямар өөрөөс нь асуултай биш дээ. Үерхдэг багын найзаа айлгаж ичээх вий гэж хүлээзнэсхийв.

-За миний хүүхэн наад гадуур цамцаа тайлчих. Манайх сэрүүхэн л дээ. Гэхдээ л хувцсаа хөнгөлсөн нь ононо. Чи яарахгүй юм байгаа биз дээ?

-Чи ажилдаа явахгүй юм уу?

-Найз нь амралтаа авсан... Хэд хоног хөдөө явах санаатай... Өвгөний нутаг Архангай... Өнөөх алдартай Хорго чинь манай өвгөний нутаг шүү дээ. Хажууд нь Тэрхийн цагаан нуур гэж сайхан газар байна. Хадмых сарлагтай. Цагаан идээн дээр гэдсээ цайлгаж хэд хоновол аштай юу. Би ч хадамдаа эрхэлчихсэн танхил бэр шүү.

Тэр хоёрын яриаг чагналгүй Жамц гадаа зууханд мод зэрэглэн саяхан төхөөрсөн хонины мах эвдэж чанав. Төмс арилган хийж, жаахан гурил элдэн бэлджээ. Хүүхнүүд юу ярих нь Жамцад юуны хамаа...

Тэрбээр хоол буцлахыг хүлээх зуураа баруун талд байгаа гараашийн үүдэнд зогсох УАЗ 469 машиныхаа хажууд очиж дугуйг нь нэгэнтээ өшиглөж үзснээ, хамрыг нь сөхөж бензин нацосыг авах гэж түлхүүрээ гаргав.



Хоёр хүүхэн ангийнхан, ер сургуулийн найзууд хаана байгаа, охидоос хэн нь хэдэн хүүхэдтэй, хэн нөхрөөсөө салсан, бас нэг сургуулийнхнаас хоорондоо хэн хэн суусан зэргийг тоочин ярьцгааж, дараа нь Үзмээ авдар, ханын шүүгээгээ уудлан хамаг л гоёо, шинэ хувцсаа үзүүлэн удаан сууцгаав.

Хүүхдийн тухай асууя хэмээн хэл нь загатнаж байсан боловч Үзмээ арай л гэж тэсчээ. Тэгтэл нялх жаал сэрэв. Уйлж орилсонгүй, харин өхөөрдмөөр эвшээн эхдээ чимээ өгөх шиг болов. Үзмээ хүүг гар дээрээ авч хэнтэй адил юм бэ дээ гэсэн шиг нүүр өөд нь хараад энэ үгийг санаандгүй мэт хэлчихэв.

-Чамтай адилхан уу, эцэгтэйгээ адилхан уу? Хүү бол эцгийгээ хуулсан юм шиг дууриасан байгаа даа...

Дэлгэрмаа цочсон мэт түүн рүү хараад юм хэлсэнгүй. Үзмээ өлгийг нь задалсан тул хүүг аваад бушуухан хөхөө аманд нь хийхдээ нэг их уртаар санаа алджээ.

-Яасан бэ найзаа?

Дэлгэрмаа уйлчихав. Эхлээд хоолой нь зангирч, хамрын угаар шархиран юу юугүй нулимс нь асгарав.

-За тайвшир. Яасан бэ? Би эвгүй юм асуусан уу? гээд Үзмээ үеийн хүүхнээ өрөвдөн толгойг нь илэв. Энэхүү энхрийлэл, тайтгаруулсан үг Дэлгэрмааг бүр цурхитал уйлахад хүргэв. Бүсгүйн сэтгэлд олон хоног хуримталсан гомдол, гаслан, хагацлын хар гунигийн үүл задрах шиг болов. Магадгүй сэтгэлд бугалж бугшсан бүхнийг Дэлгэрмаа өчнөөн хоног дэндүү хав дарж, дотроо тэр нь хуримталсаар байгаад итгэж найддаг багын найз энхрийлэн толгой илэхэд дэлбэрсэн ч байж болох юм.

-Май хүйтэн юм залгил. Биеэ барь даа хүүхэн минь... Юу гээч болох нь энэ вэ? хэмээн үнэн голоосоо найзаа өрөвдөн хүйтэн ундаа хийж өгөөд гарыг нь атган хажууд нь суув. Тэгснээ босч цээжинд нь зүрхний тайвшруулах иллэг хийж, хүзүүг атган, гар хурууны мэдрэлийн цэгүүдэд дарав.

-Үйлээ л үзэж явна даа. Үзмээ минь... гэж сая бага зэрэг тайвшраад Дэлгэрмаа аяархан дуугарчээ. Тэрбээр хүүгээ хөхүүлж цатгаад өлгийдөн орон дээр тавив.

-За хүүхнүүд минь хоол идэцгээ. Аль вэ зочин ирсэн юм байна даа хө Үзмээ хоолон дээр амсах юм гарга! хэмээн түмпэнтэй мах уур савсуулан Жамц авчирч тавив. Энэ үг цагаа олсон үг байсан болохоор Үзмээ цагаан морины зурагтай далайн орны хатуу хүрэн дарс ханын шүүгээнээс гаргаж ирэв.

-Нэг танил маань англи яваад авчирч өгсөн юм. Манай өвгөн ямар уух биш. Шүүгээнд байгаад л байсан чинь Дэлгэрмааг ирэхийг л хүлээж байж гээч хэмээн Үзмээ хэлж дөрвөлжин шилтэй сайхан дарсыг задла хэмээн нөхөртөө өгөв. Жамц тэр даруй бөглөөг авч гурван болор хундаганд дүүргээд

-За сайн сайхны төлөө гээд өргөчих үү? гэв. Гурвуул хундага тулгаж хоёр хүүхэн эхнийхийг ярвайсхийн хөнтөрч орхив. Хэрэв Дэлгэрмаад бага зэрэг тайвшрахад нь дарс хэрэг болно гэж бодогдсон ахул, Үзмээ найзыгаа ямар ч байсан уулгачих санаатай өөрөө дугтарч орхижээ. Тэгээд хоол идэцгээв. Мах ганц нэг огтолж, хоёр хүүхэнд хонины шинэ шөл аягалж өгснөө Жамц

-За тэгээд авхай нар дураараа идэж ууцгаа. Удахгүй хөдөө явах тул би машиндаа хийх юм байна гээд гараа арчин гарч одов.

Хоёулахнаа үлдсэн нь завшаан гэж Үзмээ бодоод ахиад хундага дүүргэсэн боловч харин энэ удаа Дэлгэрмаа амссан ч үгүй, мах идэж, шөл ууж гараа арчаад ахиад л санаа алдав.

-Чухам юу болсон юм бэ хүүхэн минь найздаа яриач...

-Тамхи байна уу? Яагаад ч юм тамхи татмаар санагдчихлаа... гэж Дэлгэрмаа гуйв.

-Би татдаггүй л дээ. Өвгөний хааяа тансагладаг янжуур байна уу, үгүй юу... гээд Үзмээ хайснаа сая дөнгөж задалсан тамхи гаргаж ирэв. Дэлгэрмаа янжуур авч эв дүй муутайхан асаахчаан болж нэг сорсноо хахаж цацан ханиав.

-Үр хүүхдийн мөрөөдөл болоод хэдэн жилийн нүүр үзсэн юм. Нөхөр ч надаас үр хүүхэд гарах болов уу гэж хүлээсэн шинжтэй удлаа.

Тэр маань Токиод байгаа л даа. Тэгж тэгж сая нэг эм хүнийхээ жаргалыг эдлэв. Эрүүл саруул ямар хөөрхөн амьтан байсан гэж санана даа...

Дэлгэрмаа санаа алдан, үе үехэн нулимсаа арчиж байж бүхий л үнэнээ Үзмээ найздаа ярьжээ. Ганц ч юм үлдээсэнгүйн адил бас ширхэг ч юм нуусангүй.

-Ингээд л хорвоогоос олсон аз жаргалаа алдчихаад, эцэст хүний хүүхдээр сэтгэлээ зогоож, чинэсэн хөхөө хөхүүлээд явж байна даа. Намайг хүүхдээ алдсныг олон хүн мэдсэн... Энэ нялх амьтныг тэврээд олон дунд орох хаашаа, орохгүй байх бас хаашаа... Ядаж талийгаачийнхаа дөчин есөн хоног өнгөртөл ил гармаагүй. Монгол ёс байна даа. Хоригийн хугацаа өнгөрөхлөөр олдмол хүүгээ тэврээд гадаа гарахад танил найз нөхөд надаас асуухгүйгээр учрыг ойлгох биз. Зайлуул энэ хүүхэн үрээ санаад болохгүй болохоор хүүхэд өргөж авч дээ гэцгээнэ л биз... Би өөрөө яаж шийдэхээ мэдэхгүй чамтай зөвлөе гэж бодоод өглөө эрт ирж байгаа минь энэ... Чи эмч хүн, миний багын найз яахыг шуудхан хэлээд өгөөч. Би чиний үгнээс гармааргүй байна.

Дэлгэрмаа долоон булчирхайгаа тоочиж дуусаад муухан инээмсэглэх аядав.

-За тийм байдаг байж...

Үзмээ ингэж хэлэхдээ хэцүү л асуудал байна даа гэсэн аялгаар хэлжээ. Тэр явган ширээн дэр байгаа хундагыг дарсаар дүүргээд

-За нэг тогтоочих. Архи муу нэртэй идээ боловч сэтгэл засдаг сайн талтай шүү. Үрээсээ

хагацахын гашуун зовлонг эм хүний хувьд би ч бас амссан л хүн. Бид хоёрын гурав дахь хүүхэд бүтээгүй юм шүү дээ... хэмээн санаа алджээ.

-Чиний хэлдэг зөв өө. Сав саяхан нялхыгаа нутаглуулчихаад нулимсаа хатаагүй байхад хүүхэд үрчлэв гээд тэврээд олны дунд явах нь тун зохимжгүй... Нэг хэсэгтээ амьтан хүнд үзэгдээд хэрэггүй байх... Харин энэ хүүхдийг алдав гээд өдийд цагдаа сэргийлэхэд бүртгүүлчихсэн, баахан эрэл сурал болж байж ч мэдэх юм... Энэ утгаар бодвол чи гэмт хэрэг хийсэн болж таарч байна. Эх хүнийхээ хувьд аргагүй байдалд орсон ч гэлээ эцэст чамайг олдог юм бол, хүүхэд хулгайлсан гэдэг ял зайлшгүй тулгаж таарна шүү дээ. Гээд яалтай. Нэгэнт л чамд гээд олдсон энэ нялх амьтныг ямар гудамжинд гаргаж хаялтай биш. Өө яахав. Өвгөн бид хоёр маргааш хөдөө явна. Жаалуудаа түрүүлээд аль хэдийн танил жолоочоор явуулчихсан юм. Хадмындаа бараг сар болох байлгүй. Чи манайд хүрээд ир. Юутай ч гэсэн сар манайд бай. Бид ч гэр орондоо зовох юмгүй сайхан... Манай гэрийг сахиад хүүтэйгээ энд сар бол доо хө. Тэгж байтал дөчин есөн хоног нь ч өнгөрнө. Элдэв дуулиан шуугиан ч намдана. Биднийг ирсний хойно хүүгээ тэврээд нүүр бардам харьж болох байлгүй...

Үзмээгийн хэлсэн нь Дэлгэрмааг баярлуулав. Яаж ч бодсон өөрөөр шийдэх аргагүй байлаа. Харин энэ хугацаанд Билэгжаргал утасдах юм уу, амьтан хүнээр юм хүм хэлүүлбэл л хэцүү байна.

Жамцад, Үзмээ өөрөө Дэлгэрмааг ятган гэрээ сахиулахаар болов хэмээн хэлжээ.

-За хө айлын гэр сахина гэдэг чинь их хариуцлагатай шүү. Хөлс мөнгийг нь өгөх учир бий. Тэгэхээр чиний үерхдэг хүүхэн юмсан хойно итгэл үзүүлээд, хоол ундыг нь, ядаж идэх махыг нь сайн бэлдэж өгөөд явдаг хэрэг. Өөр юу хэрэгтэй юм бол? Хүүтэйгээ хоёулаа хоол унд хийж идээд сэтгэл амар сууж байвал ашгай юу. Бид ч ар гэртээ сэтгэл зовох юмгүй... хэмээн Жамц хэлжээ. Чингээд зах орж сайхан тарган хонины мах авчирч эвдэж жижиглэж хөргөгчид хийж өгөөд, гурил, будаа базаав.

Дэлгэрмаа хүүгээ Үзмээд түр орхиод гэртээ харьж зайлшгүй хэрэгтэй солих хувцас, хүүхдийн даавуу шаавуу, живх тэргүүнийг авчрав.

Маргааш өглөө нь худалж хүнд бараг гэгээ ороогүй шахуу үүрээр Жамц, Үзмээ хоёр холын аяндаа мордов.

-За миний хүүхэн сэтгэл зовох юмгүй сайн сууж байгаарай. Гэрээ сайн сахиарай. Хоол унд биднийг иртэл дөнгөх байлгүй. Та хоёр хоёулаахнаа юм чинь юун их юм орохов дээ гэж Үзмээ найзыгаа тэврэн үнсээд хэлжээ. Тэднийг үдэж явуулчихаад хашааны төмөр хаалгыг дангинатал түгжин, зуны модон байшинд орохдоо Дэлгэрмаа “Ингээд би амьтан хүнээс далд энд суух болж дээ. Нэг ёсондоо муугаар бодвол хүүхэд хулгайлсан хүүхэн айлын гэрт цагдаагаас нуугдаж үлдэх нь энэ байж”... хэмээн гуниглан бодлоо.

Хэдийгээр Дамбадаржаад таних хүнгүй, өдөрт гэр гадагшаа хэзээ ч гардаггүй боловч сэтгэлээс далд түгшүүр үл сална. Тэр бол хүүхэд алдагдав хэмээн цагдаад хэлж, сэргийлэхийнхэн энд тэндгүй эрэл сурал тавьж байж магадгүй гэж Үзмээгийн хэлсэн үгтэй холбоотой байлаа. Нээрээ тэгж байгаа бол эрт орой хэзээ нэгэн цагт Дэлгэрмаа илчлэгдэн

баригдана гэсэн үг. Тэр цагт олдсон үрийг нь булаагаад авчихвал яанам бэ? Хичнээн өдөр элгийг нь дэвтээн, чинэсэн хөхийг нь хөхөж дотор уужруулсан энэ бяцхан хүнээ өөр хүнд өгөхөд хүрвэл би яанам билээ?

Үгүй, үгүй... Дэлгэрмаа юу ч боллоо гэсэн хүүгээ өгөхгүй. Дахиж тэгж голоо харлуулахаа больё чи минь...

Гэвч ингэж бодох нь дэндүү хувиа бодсон хэрэг гэдгийг Дэлгэрмаа ойлгож байлаа. Энэ хүүхэд төрсөн эхтэй. Хүүгээ ор мөргүй алдчихаад хэн нэгэн эх хүн зовж шаналж байгаа... Хүүхдээ харсаар байж нүд аниулсан Дэлгэрмаа хагацлаас болж яаж галзууран алдлаа даа? Тэгвэл огтын эрүүл саруул үрээ амьд мэнд байхад нь хулгайчид алдчихаад, хаана байгааг мэдэхгүй тарчилж байгаа тэр эх ямар байх нь ойлгомжтой... Энэ ерөөсөө л хулгайлагдсан хүүхэд... Тэр нэг согтуу хар юм хүүхдийг хулгайлаад яах гэж явсан бол доо? Арай л зөрж архидах гээгүй байлтай... Тэр хөлчүү залууг бодохоор анх түүнээс зулран зугтахдаа бодсон нь одоо Дэлгэрмаад санагдаад ирэв. Хэрэв зээ хэрэг илэрч түүнийг олдог юмаа гэхэд Дэлгэрмаа хэлэх үгтэй шүү.

“Тийм ээ би яасан юм. Нялх амьтныг харангадаж үхэх аюулаас аварсан хүн нь би. Хэрэв би чинэсэн хөхөө хөхүүлээгүй бол энэ жаал яах аргагүй харангадаж үхэх байсан... Би хүүхдийг хөхүүлээд Түнхэл дээр буун буутлаа залууг хүлээсэн боловч ирээгүй. Саяхан хүүхдээ алдсан байсан болохоор би хөхөө хөхүүлээд аваад явахаас өөр аргагүй байсан... Тэрнээс хойш хэн ч хүүхдийг гэж сураглаж ирээгүй шүү”

Дэлгэрмаагийн үг гэвэл энэ л юм. Харин “саяхан хүүхдээ алдсан байсан” гэж хэлээд хэрэггүй ч юм уу даа. Зориуд далимдуулан хүүг хулгайлжээ гэж ойлгож магадгүй юм. Зүгээр л согтуу залууг ирэхгүй болохоор аваад буусан гэж л хэлье...

Ингэж бодоод Дэлгэрмаа бага зэрэг тайвшрав. Чингээд хувь заяаныхаа төөргийг дагахаас аргагүй гэж шийджээ.

xxx

Цагдаа ирээд Бадрааг баривчлан авч одов.

Хүүг нь цагдаа авч одмогц эх нь Хорлоогийнд гүйн орж ирлээ.

-Хүүг минь бариад явав. Одоо яалай? Ээ хөх тэнгэр... Ийм үйлтэй юм гэж байх уу? хэмээн тэр эх уйлан дуугарч үсээ үгтээв.

-Яалаа гэж барьж байгаа юм бэ? хэмээн Ерөөгийн ээж гайхжээ.

-Тэр хүүхдийг хэнд өгсөн гэж асуусан... Шил архинаас хүүхдийн зарчихсан байж магадгүй гэж сэжиглээд байгаа бололтой. Ийм ч явдал болох гэж дээ Даариймаа минь... гэж хэлэхдээ энэ бүхэн чамаас л болов. Хэрэв хүүг чи л хот руу хүүхдээ олж ир гэж явуулаагүй сан бол хүү баривчлагдах хэрэг хийхгүй байсан гэсэн өнгөөр хэлжээ. Даариймаа юу хэлэхээ мэдсэнгүй. Зээ хүү амьд үхсэн нь мэдэгдэхгүй алга болчихоод, төрсөн охин нь харь газар яваад өгсөн

байхад цээжнийхээ махыг баран алдаж толгой гудайлган яваа хөгшин эх айлын хүний зэмлэлд юу гэж хариулах сан билээ.

-Үйлийн лай минь дуусах болоогүй ажээ. Өөрийн хүүхдүүдээ алдаад одоо өрөөлийн хүүхдийг шоронд хийн амьтны хараал идэх нь... Одоо яалтай билээ?

Гэвч цагдаад баригдах хэргээ Бадрах өөрөө л хийсэн. Тэр л Баярболдыг минь согтуу галзуугийн эрхээр танихгүй хүүхэнд өгчихөөд өөрөө зоогийн газар согтон ширээ түшин унтаж, цагдаад баригдсан гээ биз дээ? Хэрэв хүн шиг яваад хүүг зүгээр авчраад өгчихсөн бол юунд л ийм явдал гарахсан билээ. Бадраагийн согтууг гарсан хойно Даариймаа болсон бүх явдлыг шалгаан хэлүүлж авч билээ. Тэгэхээр тун итгэлгүй хүнд Даариймаа найдсан байх нь... Бадраагаас олигтой хүн байсан бол... ээ чааваас.

Хүнд хүн хэрэгтэй. Хүүхдийг нь хөхүүлнэ гэж авсан тэр хүүхэн ямар ч хүн байсан юм билээ. Ямар ч л гэсэн хөхүүл л амьтан байж... Үрийн мөрөөдөл болсон хүүхэн тааралдаад, Бадрааг ирэхгүй болохоор олзшаан авч явсан ч байж болох... Тэгвэл хүүг нь эргүүлж өгөхгүй, тэгээд өнгөрөх нь энэ. Хамгийн гайтай нь Бадраа тэр хүүхнийг хаана чухам буусныг мэдэхгүй байгаа нь юм. Хэрэв Зүүн Хараад ч юм уу, Баруун Хараад, ер тэнд буусан гэж яг хэлж чадсан бол цагдаагийнхан баримжаагаар тэр хавийн айлуудыг шүүрдэж, хэнийд нь хотоос хэн ирэв гээд сураглаж болох л байсан... Гайтай нь Бадраа тэр тухайд хэлж мэдэхгүй байлаа.

-За гайгүй биз. Бадраагаар хүүхэд авсан хүүхний тухай хэлүүлэх гэж байгаа биз... Уг нь Бадраа тэгж их уулгүй шиг, хүүхдийг биенээсээ салгалгүй аваад ирж болох л байсан. Архи хэзээ хүнд хэрэг болж байлаа хэмээн Даариймаа санасанаа хэлжээ.

-Ерөөсөө чи хүүг хот руу явуулдаг буруу байсан... Чамаас л болж ... хэмээн дөрвөд хөгшин чангарав.

-Миний явуулсан буруу байж болно... Гэвч өөрөө хүн шиг байсан бол яалаа гэж иймд хүрэх билээ.

-Хүүхдийг нь хулгайлаад ирээрэй гэж чи хэлсэн байх чинь билээ. Тугалыг нь аваад ирвэл үнээ нь дагана гэсэн юм биш үү?

Даариймаа яг тэгж хэлсэн нь үнэн юм. Эргээд л хийсэн нүгэл толгой дээр буух нь энэ... Хөгшин эх юу ч хэлж чадахгүй эг маг хийв. Тэгэхээр хүүхдийг хулгайл гэж хэлсэн хүн өөрөө болохоор аягүйд бол Даариймаа ч цагдаагийн газар дуудагдах нь ээ?

-За чи хэдэн цаас өгөөдөх. Би шоронд очиж хүүгээ эргэх минь. Хоол ундгүй хорьдог гээ биз дээ. Хоол өглөө ч адууны гэдсээр хийсэн бантан өгдөг гэсэн дэг... Хоол цай хийж аваад цагдаагийн газар руу явах минь...

Энэ бол далим байлаа. Дөрвөд авгай хүүгээ баригдсаныг далимдуулан Даариймаагаас мөнгө саахаар шийдэв бололтой. Даариймаа өврөө ухаж ухаж, хожим хэрэг болуужин гэж дан дээлийн дотор халаасанд хадгалсан хэдэн цаасаа гарган, таван мянгатын дэвсгэрт хоёрыг сугалан Бадраагийн эхэд өгөв. Дөрвөд авгай Бизъяа мөнгө аваад бушуухан гарчээ.

Сэтгэлийн далд түгшүүр Даариймааг зовоосоор байлаа. Нээрээ ингээд зээ хүүгээ олохгүй бол яана? Ерөө нь хэзээ нэгэн цагт ирдэг юм аа гэхэд хүүг нь алдчихсан өгөр царайлаад сууж байх уу? Энэ цагдаа сэргийлэхийнхэн хүүхдийг минь олохгүй юугаа хийж байдаг улс вэ?

Даариймаа цай ууж хамаг хөлс нь цуваад арчих ч сэхээгүй сууж байтал хаалгаар хүн ороод ирэх шиг болов. Өөрийн банди нараас л ирэв үү дээ гэж бодож,

-Цайгаа уу. Боорцог дуусах нь дээ. Үдээс хойш гурил зуурахыг бодоорой гэвэл харин огт өөр хүн,

-Сайн байна уу та? гэж мэндлэх нь тэр.

Намхан шиг нуруутай, сэргэлэн нүдтэй, охиноос нь нэг их олон эгч биш болов уу гэмээр бүсгүй үүдэнд инээмсэглэн зогсч байлаа.

-Наашаа суу охин минь. Цай уу. Чамайг чинь манай хүүхдүүдийн нэг л орж ирлээ гэж бодоод... хэмээн Даариймаа дуу алджээ.

-Та Ерөөгийн ээж Даариймаа гуай мөн үү? Энэ чинь Хорлоо гуайнх биз дээ? гэж бүсгүй асууж байна.

-Мөн мөн. Ерөөтэй уулзах гэсэн юм уу? Солонгос явчихсан шүү дээ гэж Даариймаа цай аялгалангаа хэлэв.

-Би Ерөөгийн тэндээс ирсэн хүн. Танайд захиа авчирсан... гэж бүсгүй халуун цай оочлон тавиад цүнхээ уудлан захидал гаргаж ирэв.

-Ээ ашгүй. Хэзээ ирээ вэ? Охин минь тэр газар сайн уу?

-Сайн, сайн. Саявгар далайд амраад ирсэн гэсэн. Энэ захиаг өгчих л гэсэн юм. Дотор нь зуун доллар байгаа, та тоолоорой. Энэ жаахан чихэр, печень дүү нартаа явуулсан.

-Иш муу охин минь яах нь вэ дээ. Хүний газар өөрт нь мөнгө төгрөг хэрэгтэй л байгаа...

Даариймаа чичирч салгалсан гараараа дугтуйг задлав. Тэндээс захиа, хэдэн ногоон цаас гарч ирэв. Амьдралдаа анх удаагаа тэрхүү хүн болгон яриад байдаг доолуур гэгчийг Даариймаа гартаа атгаж барьж үзэв. Чингэмэгц, би охиноо яаж гомдоолоо доо. Хүний эхээс гармааргүй ааш гаргаж, яаж харааж зүхэж, бүтэл муут Бадрааг зарж, хойноос нь явууллаа даа? Тэр золиг зээ хүүг минь алдчихаад одоо би Ерөөгийн өмнө ямар гай тарьсан байгаа билээ дээ? гэж бодоход өөрийн эрхгүй нулимс нь сул асгарчээ.

Болсон явдлын цаад нарийн учрыг үл мэдэх бүсгүй хөгшин эх охиноо их санасан учраас л уйлж сууна даа хэмээн өрөвдөн бодоод босч,

-За би явъя даа, эгчээ. Ерөө бүр аминчлан захисан болохоор хотоос өнөөдөр гараад явж байна. Дарханд бас надад хөөцөлдөх ажил ч байна ... гэжээ.

-Үгүй охин минь аяга шөл ч болохноо хийлгэж идээд явна байгаа даа.

-Зүгээрээ эгч ээ. Би яарч байна...

-Ээ энэ зөнөг эмийн байж байгааг... Охиныхоо сургаар уймраад хамаг юмаа мартаж, аяга хоол ч хийж өгөлгүй гаргачихлаа даа.

-Та битгий зов. Би хоол идмээргүй байна. Тэгээд ч надад яаралтай хөөцөлдөх ажил байна. За баяртай.

Бүсгүйг гараад явчихсан хойно Даариймаа бүр цурхиртал уйлав. Миний байж байгаа царайг хар. Гэтэл охин минь мөнгө, захиа зангаа явуулсан байдаг... Өөрийн үр хүүхэд цаанаа л өөр. Хөгшин эхдээ гомдвол гомдохоор болсон. Тэгэхэд үгүй шүү. Мэндийн захиагаа, зуун доолууртай явуулж гээч.

Хаалга дуугарав. Энэ удаад бага хүү хүрээд ирж.

-Алив миний хүү эгчийнхээ захиаг дуудаарай. Сая хүн ирээд явлаа. Эгчээс чинь захиа, баахан ногоон мөнгө явуулж... хэмээн Даариймаа хүүгээ захирав.

Хүү захиаг өндөр дуугаар уншлаа. Ерөө аав, ээж, дүү нарынхаа амар мэндийг асууж, охин нь та нартаа хэлэлгүй Сөүл гэдэг газар ирчихээд ажиллаж байна хэмээжээ. Та нарыгаа их санаж байна хэмээн дурьдаж сүүлд нь хүүг минь үе үе эргэж тойрч байгаарай. Сайн хүмүүсийн гар дээр Баярболдыг орхисон тул зовох юм алга. Гэвч багаасаа хүү минь эмээ, өвөөгөө, ах нараа мэддэг болж өсвөл дээр шүү дээ гэх зэргээр бичжээ. Захидлын завсраас нэгэн гэрэл зураг гарч ирэв. Даариймаа гараараа дурандаж хараад үлгэрийн орон шиг далдуу модтой нэг их сайхан газар зогсч байгаа охиноо олж харав. Цаана нь хөх цэнхэр далай давалгаалж байх шиг. Охин нь жаахан тураа юу даа... гэж бодоход ахиад л нулимс нүдийг бүрхэж ирэв.

Тийнхүү энэ гайхмаар баяр, гомдол зэрэгцсэн өдөр хөгшин эх Даариймаа уйман нэг уйлж, нэг инээж байтал цагдаагийн газраас дуудлага иржээ. За баларлаа. Ингээд шоронгийн тав болох үйлтэй байжээ хэмээн Даариймаа бодож тэр газар хүйтэн зоорь шиг байдаг юм гэнэ билээ хэмээн гадаа халуун байхад хөвөнтэй дээлээ өмсөөд гарч машинд суув.

-Намайг ингээд явчихлаа гэж аавдаа хэлж дуулга хэмээн бага хүүг аав руу нь гүйлгэв.

-Та битгий сандар. Таныг баривчилж байгаа юм биш. Мөрдөн байцаагч асууж тодруулах юм байгаа учраас аваад ир гэсэн юм... хэмээн цагдаагийн дүрэмт хувцастай жолооч залуу хэлж билээ. Тэглээ ч гэсэн Даариймаа хамаг бурууг би хийсэн болохоор аваачаад зооринд хийчих л байх даа гээд жолоочийн үгэнд итгэсэнгүй.

Дархан хотын цагдаагийн газрын үүдэнд машин зогсоход жолооч залуу настай хүний нь хувьд түшиж буулгаад үүдэнд нь Бадраа уруу царайлан сууж байгаа мөрдөн байцаагчийн өрөөнд дагуулж оров.

Гэмт хэргийн учир Даариймаа хэзээ ч хуулийн байгуулгын хаалга татсан удаагүй. Одоо

хүртэл үйл нь ирсэн хулгана муурын сахлаар оролдоно гэдэг шиг, зүв зүгээр байсан охиндоо гай тарьчихаад хэрэгтэн лугаа адил дуудагдан ирэв гэж хөгшин эх булай айв.

-Сайн байна уу та? Суу даа...

Харваас нүдэнд дулаахан залуу мэндэлж ширээний эсрэг талд зайдуухан тавьсан сандал руу заав. Даариймаа дуулгавартай нь аргагүй заасан сандал дээр суулаа.

-Та Ерөө гэдэг охиноо хот явуулахгүй, үүдэнд суугаа залуутай суулгана гэж хэлсэн явдал байна уу? хэмээн мөрдөн байцаагч асуужээ.

-Үгүй одоо... Өөрийн хүүхэд хот газар завхарчихвий гэж гэртээ байлгах гэсэн нь үнэн л дээ. Харин Ерөөг энэ хүүтэй суулгана гэж шууд хэлсэн нь юу л бол... Ерөөг хот явчихдаг өглөө охиныг харж манаж бай гэж гэртээ дагуулж ирсэн явдал бол бий...

-Тэгвэл охиноо хот руу явчихаар та Бадраад замын зардал өгч хойноос нь явуулахдаа, хэрэв Ерөө ирэхгүй гэвэл хүүхдийг нь хулгайлаад ирээрэй гэж хэлсэн юм биш үү?

-Хулгайл гээгүй л дээ. Зүгээр Баярболдыг аваад ирээрэй л гэсэн...

-Тугалыг нь аваад ирвэл үнээ нь дагаад ирнэ гэсэн чинь таны үг юм байгаа биз дээ?

Даариймаагийн хамар дээгүүр хөлс бурзайж ирэв. За тэр дээ. Хулгай хий гэж заасан хүн нь би болж таарч байна.Ээ халаг.

Энэ бол эхийн сэтгэлд байсан далд түгшүүр батлагдсаны жишээ байлаа. Хэнийг ч барьж аваад шийтгэж болно. Ямар ч аавын хүүг өргөст тортой хашааны чанад гяндангийн бүдэгхэн гэрэлтэй өрөөнд хорьж болно. Гэвч бүхий л насаараа өөрийгөө хараан зүхэж, сэтгэлдээ шархтай өдөр хоног өнгөрөөхөөс илүү шийтгэл байдаггүй бололтой.

-Та явж болно. Хүүхэд хулгайлан замдаа согтуурч явж алдсан хүн бол Бадраа мөн болов чиг, овоо босгоогүй бол шаазгай юунд суух вэ гэгчээр та анхнаасаа охиноо тэгж хэт хатуу цагдаж, хүнээр сахиулан, хот руу зугтаад явчихсан хойно нь мөнгө өгч Бадрааг явуулаагүй сан бол энэ бүх хэрэг гарахгүй л байсан. Хэрэв хүүхэд эрэн сурвалжлаад үл олдоход хүрэх юм бол зээ хүүгээ үүрд алдсны нүгэл хилэнцийг өөр хэн ч биш, хөгшин эх та л үүрэх болно...

Даариймаа дуу алдан орилсоор тэр газраас гарч ирсэн ажгуу. Гадаа зогсч байсан цагдаагийн жолооч залуу Даариймааг өрөвдөн гэрт нь хүргэж ирэв. Хаалгаар хамраа цухуйлгав уу, үгүй юу хөгшин эх дахиад л дуу тавин бархирч, орон дээрээ нам унав. Хүүхдүүд нь сандарч толгой дээр нь хүйтэн жин тавиад аавыгаа дуудахаар бага нь үйлдвэр өөд гүйв.

Энэ явдлын маргааш хотоос хаягийн дуудлага ирсэн нь Батбаяр утсаар ярих гэсэн хэрэг байлаа. Даариймаа уухчин сандарсаар холбоон дээр очив.



# АРВАН ЕСДҮГЭЭР БҮЛЭГ

-Байна уу? Та Даариймаа гуай юу? Би Батбаяр байна. Таньж байгаа биз дээ? Таны бие тэнхээ сайн уу? Танайхан бүгд сайн биз дээ?

Холуур тойруулан мэнд мэдэж элдэв юм асууж байгаа энэ хүн ямархан нэг түгшүүрт хэл өгөх нь үү гэж Даариймаа далд сэтгэлдээ бодоод айх шиг болов. Ямар л аймшигтай хэл дуулдаг бол доо?...

Чингэтэл утасны нөгөө үзүүрээс:

-Ерөө ойрд ярив уу? Түүнээс ямар нэг хэл чимээ байна уу? гэж асуух нь Тэр. За энэ чинь яахаараа Батбаяр охиныг асуудаг билээ? Ямар над шиг хөдөөний зэрлэг биш, орон хотын юмтай бол юмтай, утастай бол бүр гар утастай арга чаргатай хүн шүү дээ.

Чухам энэ хүнд л манай охин хайраа өгч үрийг нь төрүүлсэн биш үү? хэмээн хоромхон зуурын дотор хөгшин эх бодож амжлаа.

-Үгүй шүү. Ер ярьсангүй. Манайх, гэртээ ямар утас байх биш. Яасан бэ? Та нар ярьдаггүй юм уу?

Даариймаа чингэж хэлэхдээ охиноос нь захиа, мөнгө ирсэн гэж хэлье үү гэснээ хэлээ хазаад тэсэв. Мөнгөний хувьд Даариймаа ямагт нуудаг зантай тул, энэ удаад ч гэсэн зуун дойлууртай болсноо хэнд ч хэлсэнгүйн адил одоо ч мөн Батбаярт хэлээд хэрэггүй гэж боджээ.

-Ерөө ор мөргүй алга болчихлоо. Сөүл рүү гар утсанд нь залгаад ямар ч хариу өгдөггүй. “Заг” компаний шугамаар явсан болохоор тэднийхнээр шалгуулсан чинь ажлаасаа гараад явчихсан байх юм. Ажиллаж байсан үйлдвэрийн нь эзэн тоймтой юм хэлсэнгүй гэнэ. Ахиухан цалинтай ажилд орно гээд Тайвань юм уу, Гонконг руу явчихсан байж магадгүй гэжээ. Би ямар сайндаа сургийг нь гаргах гэж арга барагдаад, гэр рүүгээ тань руу ярьсан байж магадгүй гэж бодохов. Тэгээд Ерөө яриагүй юм биз дээ? гэж Батбаяр утасны цаана санаа алдах нь тодхон дуулджээ.

-Юу юу гэнээ? Би нэг л сайн ойлгосонгүй. Охин минь тэр Сөүл гэгчээсээ их мөнгөтэй ажил эрээд явчихсан хэрэг үү?

-Тийм ээ. Ажлаасаа гарсан байна гэж л “Заг”-ийнхан хэллээ. Гэхдээ хүний газар байгаа тул бүрэн сайн лавыг нь олоогүй байж болно. Гайгүй биз дээ. Тэгж байгаад Ерөө хэл мэдээ өгөх байлгүй... Та битгий зов. Харин манайх руу хааяа ярьж байгаарай. Ууганаа жирэмсэн, гэртээ байгаа...

Утасны тасалданги дуун дийд дийд хэмээн сонсогдоход Даариймаа чагнуурыг тавьж орхиод гарав. Ахиад л аньсага нойт оргиж хариугүй уйлах нь ээ... Сүүлийн үед тэрбээр дэндүү ч уймраа болчихов уу даа. Сав л хийвэл уйлах гээд байх болж...

Хувь заяа ахиад л хөгшин эхийг муурч унатал алгадах шиг болов. Яахаараа охин нь ор мөргүй

алга болдог билээ? Одоо Даариймаа яах ёстой вэ? Ерөөгөө хаана байгааг яаж мэдэх вэ? Хэрэв тэгж санаснаар болдог сон бол хөгшин эх харь газрын зүг мээмээрээ даллан охиноо дуудан ирүүлэх сэн...

Хамгийг харж, далдын түмэн мэлмийгээрээ тольдон хэний ч хувь заяаг хэлээд өгдөг бурхан багш яг энэ мөчид санаанд орлоо. Охины нь тухай багш ламтан юу гэж айлдах сан бол? Мэргэ төлгөнд юу гэж буух бол?

Даариймаа холбооноос гараад шууд л бурхны хурал номын газар руу яаран оджээ.

xxx

Эгэл даруухан боловч, юм юмтай тохилогхон ч гэмээр байранд Ерөө төвхнөжээ. Гонконгийн хамгийн олон хүн бужигнаж байдаг хуучны маягийн зочид буудалд залуу бүсгүйг оруулаад Жан хэдэн доллар өгч

-Одоохондоо үүгээр хоол авч идэж бай. Чи хэл мэдэхгүй. Гадуур гараад төөрөхийн нэмэр. Бэлэн хоол идээд байж бай. Би ирнэ. Чамайг аваачна гэжээ.

Эхний өдөр Ерөө өрөөндөө хэвтэж өнжив. Анх уулзаж байснаасаа Жан их л өөр, албаны хүйтэн царайтай болсон нь гайхаш төрүүлнэ. Ерөөгийн хувь заяа цаашид ямархан зүг рүү эргэх бол? Жангийн яриад байгаа тэрхүү үйлчилгээний ажил гэж чухам юуг хэлээд байгаа хэрэг вэ?

Гэрийн мухар сахиж, хүний газар таньж мэдэхгүй олон амьтан шоргоолж шиг бужигнасан энэ газар тэр дэмий л гэж үзэхээс биш өөрөөр яаж ч чадсангүй. Чингэх дээр тулахад онгоцонд монголоор ярьж Ерөөг баярлуулсан хоёр залуу бодогдоод ирэв. Ерөө төрөлх хэлээрээ ярихыг сонсоод эргэн харж тэгэхэд эгэл даруухнаар мэндэлж билээ.

-Хүүе та чинь монгол авхай байх шив дээ? Аль вэ наашаа суучих? Онгоцонд хүн цөөхөн байна. Сул суудал зөндөө... Монгол хүмүүс, нутаг нэгтэн байна даа. Гангар гунгар гэж явья. Нааш ир.

Найр тавьсан үгэнд нь орж Ерөө хоёр залуугийн дэргэд очиж суув.

-Май өчигдөрхөн Улаанбаатраас гарахдаа чанаж авчирсан юм. Сайхан тарган үхрийн өөх, мах алагласан хавирга байна. Ид ид. Харь газар байгаа та нар махаа санадаг л биз... За тэгээд энүүхнийг амсчих. Нутгийн идээ гэрээс хол явахад сайхан санагдана даа хэмээн аяганы дундуур цагаан архи хийж өгөв.

-Баярлалаа. Та хоёр хаа хүрч яваа улс вэ?

-Бид үү? Бид бизнес хөөцөлдөж яваа наймаачид гэх юм уу даа. Сөүлээр дамжин Гонконг орж явна. Тэгээд цаашаа хэд хэдэн орноор орох санаатай. Хямдхан машин боломжийн үнээр аваад ачуулчихна. Сэтгэлд таарсан түнш олдвол гэрээ хийчих санаа бий. Намайг Зоригоо, уг нь Батзориг л доо, манай найзыг Болдоо, жинхэнээрээ бол Ганболд гэдэг. Би Бээжингийн их

сургууль төгссөн. Энэ маань Улаанбаатарт ТИС төгсөөд Сингапурт технологийн дамжаа дүүргэсэн. Хэрэв хотод ажил олддог сон бол манай Болдоо технологийн сайн мэргэжилтэн. Харин би бол хэл зохиолын мэргэжилтэй. Ингээд хоёр найз эх орондоо ажил олдохгүй болохоор бизнес хөөцөлдсөн хэрэг. Ингэхэд Явуухулангийн шүлгэлснээр, нүд алдам ялдамхан бүсгүй энэ газар юу хийж явдаг билээ? Бодвол бас л тав гурван цаас олж, ар гэрээ тэжээх гэж яваа буй заа...

-Тиймээ би уг нь Сөүлд гэрээгээр ажиллах гэж ирсэн хүн. Хэдэн сар боллоо. Арай ахиухан цалинтай ажил бий гэхээр нь Жан гуайг дагаж, эзнийхээ үгэнд орж Гонконг руу явж байна...

Ерөө үнэнээ л хэлэв. Тэр архинаас амсч, харин махаа санасан нь үнэн болохоор хэд сайхан огтлоод цадчихав. Энэ залуучууд зарим нэг саваагүй, савсаг залуу эрчүүдтэй адилгүй, түмэн газар явж их юм үзсэн шинжтэй. Үнэхээр л ажил хэрэгч хүмүүс шиг санагдана. Нутгийн гурван монгол уулзсных юу эс ярих билээ. Улаанбаатрын сонин хачин, Токиод хоол ямар их үнэтэйг, ачуулсан тэрэгнээс нь манай хил дээр гаалийн татвар гэж бараг авсан үнэнээс нь их мөнгө хураадгийг хоёр залуу хуучлах ажээ. Ерөө Чэжү аралд очиж далайд орж, хэд хоног сайхан амарснаа, тэнд монгол циркчин залуучууд бий гэсэн боловч уулзаж чадаагүйгээ хуучилжээ.

-Тэгээд чамайг үерхдэг хүүхэн Сэрчмаа чинь гаргаж өгөөгүй хэрэг үү? Сэжигтэй л хэрэг байна даа... Гадаадад байгаа манай монголчуудын зарим нь монгол хүнийхээ мөс чанарыг гээсэн байдаг шүү. Аа мэдэхгүй ийм царайлаг хөөрхөн монгол бүсгүй тэр Жан гэдэгт хэрэгтэй байсан ч байж болох... Чи минь бизнесийн хэрэгцээнд золиослогдож яваа юм биш биз? Тайландад гэхэд л жишээ нь газар тайчих урлаг үзүүлэх юм уу, иллэг массаж хийдэг газар ажилд оруулдаг. Тэд өгөх цалин хөлсөө ч сайн өгнө. Гэхдээ ямар ч ажил хийсэн байлаа гэсэн нэг л зүй бусын үүрэг хүлээдэг. Тэр бол үйлчлүүлж байгаа эр хүн хөгшин, залуу ялгаагүй ямар л хүсэлт хэлнэ, түүнийг нь үг дуугүй биелүүлэх ёстой. Тэр нь бол нэг ёсондоо иллэг массаж нь бизнес гэхэд үйлчилгээний нь дотор тэрхүү “хүслийг биелүүлнэ” зүйл нэг гол арга нь байдаг... Би дэндүү хар санаж байж магадгүй л дээ. Гэхдээ л чамайг арай л хөнгөн хуудуу шийдээ юу даа гэмээр санагдаад байгааг нуух юм алга. Уг нь гэрээ хэлцэлтэй юм, хаана ч дураараар явах эрхтэй, цалин ч муугүй тэр ажилдаа хэдэн жил зүтгэсэн бол... Хараар биш, гэрээгээр ажилладаг хүмүүсийн гэрээний хагуу заалтаар солонгосын тал бүх зүйлийг нь хариуцах ёстой шүү дээ. Хамгийн наад зах нь тэр хүнийхээ аюулгүй байдал, эрүүл мэндийг... Ингэхээр хараар нуугдмал амьдарч ажиллаж буй хүмүүсээс хамаагүй давуу эрхтэй байгаа биз дээ? Тэд чинь наад зах нь хүссэн үедээ эх орондоо чөлөөгөөр очоод ирж чаддаг. Ээ мэдэхгүй дээ Ерөө минь... Хэдэн ногоон цаасны ахиугаас болж элдэв муу юм үзүүжин... Чи бидэнтэй холбоотой байгаарай. Бид Гонконгод үргэлж ирж очиж байдаг хүмүүс. Бидэнд сайн түнш ч бий. Май энэ утасны дугаар ав. Манай түнш бол Өвөр монголд их удсан монгол хэлтэй дотор хүн. Ер эндхийн хужаа нар эх газрын хан үндэстэнгүүдээс арай л өөр шүү. Ааш зан сайнтай, хүнд тусархуу, жинхэнэ бизнесмен нар байдаг. Ажил хэрэгч гэж яана даа. Ёстой л за гэвэл ёогүй улс...

Залуу хүмүүс амархан танилцаж, бараг л бие биеэ хайрлах шахуу юм болов. Иймэрхүү хүмүүс сайн байдаг гэж бүсгүй хүнийхээ зөнгөөр Ерөө мэддэг билээ. Чингэж хэдэн цаг сайхан ярилцан дотносож ярилцсаар явгал нэг мэдэхэд буух болчихсон байлаа.

-За Ерөө минь суудалдаа суу. Хана нүдтэй гэсэн юм. Юмыг яаж мэдэх вэ чиний хойноос ажиглаж тагнаж байж ч мэднэ. Энд монгол хүмүүс бидэнтэй Ерөө чи уулзаагүй болог. Буудал дээр хэн хэнээ танихгүй царайлна. Хэрэг болбол энэ утсаар яриарай. Манай түнш утсаа авах вий. Бид түүнд чиний тухай хэлнэ. Босс бидэнд чамайг яривал дуулгах учиртай гэж чи мэд... хэмээн мөнөөхөн хэл зохиолын мэргэжилтэй залуу сэтгэл хөдлөн хэлж ах хүний ёсоор Ерөөг босоход хацар дээр нь хошуу хүргэн үнсчээ.

Ерөөд хоёр сайхан залуу ихэд таалагдав. Тэр нутгаа санасан сэтгэлээсээ хоёр залууд амархан дасч, болдог сон бол унага шиг дагаад явмаар л байв. Гэвч тэр Жанд өгсөн амлалтаа яалтай. Хэрэв Жан түүнийг хуурч Ерөө буруу хазгай зам руу хальтрах дээр тулбал түшээд авах хүн энэхүү харь газар эд л болох нь гэж бодоод онгоцноос буухдаа цүнхээ барин түүнийг үл танигчийн дүрээр холдож буй хоёр сайхан залууг хараад хоолой нь зангирч билээ.

Зочид буудалд дэмий баахан хэвтээд уйлахдаа Ерөө энэхүү олон хүнтэй далайн хот улсаас танилуудаа олж уулздаг юм билүү гэж бодлоо. Хамгийн хэцүү нь хэл мэдэхгүйд л байлаа. Гэхдээ нэг үеэ бодоход Ерөө эрхбиш харь газар амьдарч сурч байгаа монгол хүүхнүүдийн бүрэг ичимтгий зангаа таягдан хаяж хэнтэй ч дохио зангаагаар ярьж өөрийгөө ойлгуулж чаддаг болсон байлаа. Чухам Сөүлд ирчихээд Сэрчмаа ямагт түүнийг хаяж хаашаа ч юм алга болчихдог тул эхний сараасаа эхлээд л гадаа гарч хүмүүстэй дохио зангаагаар ярилцаж эхэлсэн билээ. Тэгж явж ямар ч байсан хоолоо олоод идчихдэг болж, шуугиант Сөүлийн өргөн гудамжаар дэлгүүр хоршоо хаана байдгийг гар хурууны хөдөлгөөнөөр хүнээс асуун хэлүүлж, хэрэгтэй юмаа олж идэж, Улаанбаатар хот руу ярих газрыг хүртэл олоод авсан сан. Одоо тэр зангаараа гудамжинд гарч, утсаар ярих газрыг олсугай. Зоригоо, Болдоо хоёртой хэл авалцан уулзсугай хэмээн Ерөө шийдээд хувцсаа өмсч гарав.

Элдэв бараа дэлгэсэн гудамжны худалдаа ил ажиллаж байна. Арааны шүлс асгарам сайхан жимс тавиурууд дээр алаглан, хаанаас ч юм бэ хятад хоолны сайхан үнэр ханхлана. Гудамж зээлээр хөгжим хангинан, машин тэрэг зай завсаргүй ар араасаа хөвөрнө. Тэгж явтал гудамжны таксфон харагдлаа. Сөүлийнхээс өөр болов уу ямар бол хэмээн бодоод мөнгө хийх гэснээ Гонконгийн мөнгөөр доллараа солиогүйгээ санажээ. Хажуугийн дэлгүүрт оров. Таван доллар гаргаж худалдагч хижээл эрээс утсаар ярих гэсэн юм, задлаад хятад мөнгө болгоод өгөөч хэмээн гуйв. Гар хуруугаараа зангаж утсаар ярих маяг үзүүлэн зангидсан гараа чихэндээ барих зэргээр дохивол худалдагч харин тааламжтайяа инээн дагуулж гарав.

Чингээд мөнөөхөн таксфоны хажууд байх автомат төхөөрөмжинд тавгын дэвсгэртийг шургуулбал тэр даруй задгай юань, бутархай мөнгө гарч ирэв. Сайн санаат худалдагч мөнөөхөн бутархай мөнгөнөөс таксфон хуу хийж утсыг Ерөөд өгчээ. Утас дуудаж хөгшин хүн аваад хятад хэлээр ямар нэгэн юм асуух шиг болов.

-Сайн байна уу? Би Зоригоотой ярих гэсэн юм... хэмээн Ерөө монгол хэлээрээ дуржигнуулаад, нэгэнт утсаар ярьж буй тул худалдагчид англиар ганц мэддэг “Баярлалаа” гэдэг үгээ хэлжээ.

-Та Ерөө авхай юу? Таны тухай Зоригоо надад хэлсэн билээ. Би одоохон дуудаад өгье хэмээн өвөрлөгч аялгатай, нилээд өндөр настай хүний дуу гараад даруй холдон одох шиг болов.

Ерөө сая сэтгэл амран инээмсэглэжээ. Танилуудтайгаа уулзвал ярих ч юм бий. Гэрийнхэндээ тавин доллар ч болсон өгч явуулах юм сан...

-Сайн уу Ерөө. Хаанаас ярьж байна?

-Би та хоёртой уулзмаар байна... Гагцхүү хаана байгаагаа мэдэх юм алга. Буцах болж байгаа юу?

-Арай л болоогүй. Эндээсээ бид хоёр Сингапур орно. Магадгүй бас Тайландад очиж ч магадгүй. Тэгээд энд эргэж ирээд ачаа бараагаа авч усан онгоцоор Тянжин өөд гарна даа. Чи уулзмаар байна уу? Хажуудаа хүн байвал яриулаад орхи. Чамайг хаанаас олж авахаа асууя.

-Жаахан хүлээгээрэй гээд Ерөө ойрхон байсан мөнөөх худалдагч руу гүйв. Дохион зангаагаар утсаар ярина уу гэж арайхан ойлгуулжээ. Худалдагч уриалгахан утас авлаа.

Гучин минут өнгөрөхөд хоёр танил нь таксигаар хүрээд ирэв. Гурвуул дуу алдан уулзацгааж, ойролцоо байх хятад зоогийн газар орж тухлацгаав.

-Танай эзэн чамайг ажилд оруулах гэж яарахгүй байгаа нь сонин байна. Шийдэх юм байгаа болоод тэр биз. Ер чи сонор соргог байхад гэмгүй шүү. Бид чамд эндхийн системээр ажилладаг гар утас авч өгье. Хашир нь дээр. Чи түүнийг хүнд бүү үзүүл. Биеэсээ битгий салга. Хааяахан Улаанбаатартай ярьчихаад, бидэнтэй үе үехэн холбогдоод нуугаад л явж бай гэж танилууд нь хэлжээ. Хоёр сайхан залуу бүсгүйг хооллож, их л халамж анхаарал тавиад хэсэг зуур зоогийн газар сууцгаан инээд наргиантай байснаа явцгаав. Тэднийг хөлсний тэргэнд суугаад хөдлөн одоход Ерөө ах нараасаа харьд ганцаараа үлдсэн охин шиг дагамаар санагдаж билээ. Тэд нар зоогийн газрын үүдэн дээрээс шахуу гар утас худалдан авч өгөхөд Ерөө мөнгийг нь төлөх гэж түрийвчээ гаргасан боловч тэд огт тоосонгүй билээ.

Зочид буудалдаа эргэн ирэхэд Жан маш ууртай, жижүүрийн хажууд байж сууж чадахгүй холхиж байлаа.

-Чи хаачаад ирэв? хэмээн цагдах маягаар Жан ууртай асуужээ.

-Хоод идсэн юм. Бас эмэгтэй хүнд чинь дэлгүүрээс авах юм шаардагдах юм байна шүү дээ.

Солонгосоор эвлүүлэн зүйн байж хэлсэн үгийг нь чихний хажуугаар өнгөрөөгөөд Жан

-Үүнээс хойш зочид буудлаас олон цагаар гарахыг зөвшөөрөхгүй. Чи миний зөвшөөрөлгүй хаашаа ч битгий яв. Гонконг бол чиний хэдэн сар амьдарсан Сөүл биш. Энд ямар ч хүн тааралдаж болно. Болгоомжлох хэрэгтэй. Танай эзэн Ким бидний хооронд чиний аюулгүй байдлыг бүрнээ хариуцана гэсэн ам тохироо бий. Тэр тохироо бол танай улсын “Заг” компаниатай солонгосын талын хийсэн гэрээнээс эхтэй юм... гэж хэлжээ.

Тэгээд өрөө рүү нь дагуулав. Ерөөг огт санаандгүй өрөөндөө орохын хэрд Жан бариад авав. Эр хүний бахь шиг чанга гартаа хааш нь ч хөдөлгөхгүй агдлан барьж, сармис ханхалсан бөөлжис хүрэм амьсгаагаар амыг нь таглан байж озов. Ерөө байдгаараа тэлчилж эцэст

Жангийн урт ургуулсан хумстай гар дотоожийн нь дотуур эмзэг эрхтнийг тэмтрэх үед чадал мөхөс бүсгүй хүнийхээ аргыг хэрэглэн гарыг нь хазаад авав.

-Аа муу гичий... хэмээн Жан ихэд өвдсөн бололтой гараа татаж аваад үлээж,

-За муу золбин монгол гичий чи мэдэж ав. Чиний найз хүүхэн Сэрчмаа чамайг надад 500 доллараар худалдсан. Чи бол амьд таваар мөн. Чамайг яахыгаа би мэднэ. Зөнгөөр нь байлгаад учраа олъё гэтэл болдоггүй юм бол би чамайг маргааш их үнээр Банкогийн хөгшин хужаад зараад өгье? Чи тэгээд насан туршдаа Тайландын тэргүүн баян хөгшин хужаагийн татвар эм болж тэнд үүрд үлдэх болно гэж мэдэж ав. Хэд хоног чамайг амраасан нь чамайг хайрласных биш... Амьд бараа чамайг их үнэ хүргэх зах зээл л хайсан хэрэг. Залуухан монгол хүүхэн авах сан гэсэн Гонконгийн хөгшин хужаа нар зөндөө л байна. Гэвч Тайланд руу амьд бараа гаргах нь надад ашигтай. Маргааш худалдагдана гэж бодоод энэ өмхий зоориндоо хэвтэж бай.

Жан хаалга саван гарч одов. Чингээд өрөөний хаалгыг гаднаас нь дангинатал түгжжээ. Ерөө уйлан унав. Тэр ямар муухай хууртагдав аа. Сэрчмаа гэж ёстой нэг шулам байж гээч. Ханилж яваад нөхрөө гэдэг сэн... Үерхэж яваад харь газар таван зуун ногоон цааснаас намайг зарчихжээ. Ийм юм гэж байх уу? Би ямар үйлс нь харласан хүүхэн бэ? Наймааны амьд таваар болсон би одоо яах вэ? Бурхан минь надад туслаач.

Ерөө дэрээ нортол уйлан орон дээрээ хөдлөх ч сөгөөгүй хэвтсээр байлаа...

Хувь заяа хаана байна?

\* \* \*

Токиогоос ниссэн олон суудалтай “Боинг” онгоц Буянт-Ухаагийн буудал дээр газардав. Нислэгийн зураас дундуур хөнгөхөн дэгдэн гүйсээр асар их дуу чимээ гарган хурдаа хасч гол асрын өмнө, зорчигсод цувж дотогшоо буудал руу орох хоолойны өмнө зогслоо.

Хүмүүс сая л нэг газар дэлхийдээ, монгол газар шороондоо эсэн мэнд газардсандаа баясах мэт суниацгаан, суудлын даруулгаа тайлж зарим нь босоцгоов. Тавиур дээрээс цүнхээ авч үүд рүү яарахдаа Билэгжаргал “Намайг Дэлгэрмаа тосохгүй шүү дээ. Хэл өгч чадаагүй юм чинь...” гэж бодлоо.

Тэрбээр эхнэртэйгээ ярих гэж сүүлийн саруудад бүр ядчихсан билээ. Гэр рүүгээ утас залгахад ямагт хариу өгдөггүй байлаа. Ямар нэгэн буруу хазгай явдал болов уу хэмээн бодож сэтгэл зовоод Улаанбаатарын геологт байх нэг найздаа утас цохиж Дэлгэрмаагийн сургийг гаргаж өгөөч хэмээн гуйв. Тэр найз нь хэд хоног чимээгүй байснаа нэг ярихдаа

-Дэлгэрмаа хотод байхгүй шиг байна. Танай аавынх руу явчихсан юм биш үү. Харин...гээд түгдрэв.

-Юу харин гэж?

Энэхүү нууцлаг бөгөөд дутуу хэлсэн үгний учрыг олоогүй байтал холбоо тасарч утас

тасалданг дуугаар дийд дийд хэмээн зүрх базлуулав. Билгээ бүр сандарчээ. Ямар нэгэн явдал болсон бололтой. Тэрбээр японы талын хүсэлтээр хугацаагаа сунгаж, монголдоо 9-р сард буцах байснаа ямар ч байсан 11-р сар хүргэх болжээ. Хойт японд нээгдэх шинэ уурхайн бэлтгэл ажил дээр Билгээ чөлөө завгүй ажиллаж байна.

Эхнэр нь ер ярихгүй, гэррүүгээ утас цохиод хүн авахгүй ихэд удсаны дараа нэгэн өдөр Билэгжаргал ерөөсөө гэртээ хариад ирье. Энэ уурхай хэдийд ч нээгдэх юм билээ. Дэлгэрмаатайгаа уулзъя. Шинэ хүнийхээ барааг ч нэг харъя. Хөөрхөн хүү төрүүлсэн гэж Дэлгэрмаа хэлсэн шүү дээ гэж боджээ. Тэрбээр тэрхүү хөөрхөн хүүг үзэх сэн гэж эцэг хүний хувьд тэсэхгүй хүсч байв. Үр хүүхдийн мөрөөдөл түүнийг олон жил зовоожээ. Тэр эхнэртээ хайртай билээ. Амьдрал нь хэн ч харсан тэгширч, Билэгжаргалынх гэдэг айл одоо бол хэний ч өмнө нүүр улайхгүйгээр сайхан тохижсон билээ. Билгээ өөрөө Токиод овоо хэдэн мянган долларын цалинтай. Ноён ууланд байх хувийн нь алтны үйлдвэрээс түрээсний мөнгө гээд овоохон мөнгө сардаа ороод ирнэ. Одоо гэрээний хугацаа дуусгаад орхивол хаашаа ч явахгүй Дэлгэрмаатайгаа жарган суух цаг болсон. Тэднийд ганц дутуу юм үр хүүхэд л байсан. Аз болоход тэднийх хөөрхөн хүүтэй болжээ. Ингээд аз жаргал тэгшрэх нь энэ...

Билгээ түрэгхэн шиг хариад ирье хэмээн япон эзэддээ хэлэхэд цаадуул нь татгалзсангүй билээ. Олон таван үггүй, зөнгөөрөө идэвх зүтгэлтэй ажилладаг, олон долоон юм шаардаад байдаггүй, архи дарснаас хол энэхүү монгол инженер японы уул уурхайн корпорацийнханд таалагджээ. Хэрэв Билгээ өөрөө зөвшөөрч гэм, гэрээний хугацааг хэдэн жилээр сунгах сонирхол ч тэдэнд байв. Тийм ч учраас Билгээг түр хариад ирье гэхэд дуртай зөвшөөрөөд Токиогоос Улаанбаатар ирэх очих онгоцны тийзийг авч өгч, цалинг урьдчилан олгожээ.

Чингэж явуулах цаад учирч байв. Ер япончууд итгэл өгсөн хүнийхээ талаар бүрэн судалдаг билээ. Улаанбаатарт байгаа төлөөний хүмүүс нь найдвартай монгол хүмүүсээр дамжуулан Билгээ инженерийн ар гэрийн амьдралыг байнга судалж байлаа. Инженерийн гэргий саяхан нярайлсан бөгөөд энэ залуу хос үр хүүхдийн мөрөөдөл болж, хэдэн жил хүлээсний эцэст чингэж үр заяасанд хязгааргүй баяртай байсан ажээ. Гэтэл төрөөд удаагүй байтал нь гай дайрч Дэлгэрмаа хүүгээ Баруун Наран хэмээх газар үүрд орхисон мэдээ ирэв. Харин тэрхүү эмгэнэлт явдлын тухай инженер Билэгжаргал мэдээгүй буюу эсвэл мэдсэн ч нүүрэндээ тэрхүү хагацлын уй гашууг чадмагаар нууж чадсан юм уу, монгол инженер яасан ч үгүй билээ. Одоо тэгвэл монгол хүний тэсвэр тэвчээртэй сэтгэлээр үрээ алдсныхаа хагацлын гунигийг хэдэн сар үл тоогч болон тэвчсэн залуу эцэг хариад ирье гэж байхад, хүний нь хувьд зовлонг нь ойлгоод чөлөө өгөхөөс аргагүй хэмээн эзэд нь шийджээ.

Ийнхүү Билгээ монгол нутагтаа хөл тавив. Түүнийг ар гэрийн нь ямаршуухан амьдрал угтахыг тэр яахан мэдэх билээ. Бүх явдал нууц битүүлэг байхад харь газар хэл үг авалгүй удсан залуу эцэг япончуудын тааварласан шиг үрээ алдсанаа мэдээд сэтгэлээ хатамжлан тэвчсэн нь бус харин тэр тухай ямар ч ойлголтгүй, хэл мэдээ аваагүйд л хэргийн гол орших ажээ.

Ачаа гээд байх юмгүй, жижигхэн чемоданд эхнэртээ гэж авсан Зүүн өмнөд Азийн орны дархчуудын гараа гаргаж хийсэн олон цэнгийн алтан бугуйвч, дугтуй дүүрэн ногоон цаастай, бяцхан үрдээ гэж Токиогийн нярайн дэлгүүрээс авсан нэг удаа хэрэглэх памперс хэмээх живх, өхөөрдмөөр хөөрхөн цамц өмдний хослол, гарт нь бариулах тоглоом сэлтээс өөр хүнд

үзүүлчихээр юмгүй тул Билгээг шууд л гаргачихав. Хил, гаалийн шалгалтанд ногоон гэрлээр шуурхайхан орсон Билгээ гадаа гарч монгол нутгийнхаа эм шиг цэвэр тунгалаг агаараар ханатлаа амьсгалан хэсэг зуур зогсов. Чингээд хөлсний тэрэг авч хот руу давхилаа.

Буянт-Ухаагийн буудлаас хотын төв орох замд хэд хэдэн удаа зогсов. Машин тэрэг ямар олон болсон юм бэ? Зам нь ачааллаа даахгүй, олон машин урд хойноо орон уралдан давхицгаах нь төвөгтэй ч юм шиг... Чингэсээр гэртээ ирэв. Хот ихэд өнгө засч, харин байшин барилгаар ч ёстой нэг чигжиж өгчээ.

Байрандаа орж хаалганыхаа хонхыг дарлаа. Хэн ч хаалга нээсэнгүй. Энэхүү бүргэдтэй төмөр хаалганыхаа цаана амьд хүн үгүй мэт, ямархан нэг анир чимээ гарсангүй. Гайхаш тасран хэсэг зуур зогссоноо хайш хэрэг, гар цүнхээ уудалж ёроолоос нь холбоотой хоёр түлхүүр гаргаж ирэв. Чингээд хаалгаа түлхүүрдэн арай чамай онгойлгож орлоо. Гэрт бөгчим байв. Хувцсаа тайлж, гар нүүрээ угаачихаад хөргөгчийг нээвэл саяхан авсан хонины мах, нилээд хатах янз орсон бяслэг тэргүүтэн байх ажээ. Гэрийн эзэгтэй өчигдөрхөн байсан бололтой. Чанаж уусан сүүтэй цайны шавхруу гашлаагүй хэвээр байлаа. Гэр орноо сайхан цэвэрлээд, тоос шороогоо арчиж зүлгэсэн нь харваас ил байв. Дэлгэрмаа тун саяхан гэртээ байж, өчигдөр орой юм уу, өнөө өглөө эрт л гараад явчихсан бололтой. Гэнэт Билгээ танил нөхрийн хэлсэн “Авгай чинь танай аавынх руу явчихсан юм биш үү” гэсэн үг санагдаад явчихлаа. Нээрээ тэгсэн л байж таарлаа.

-Гэртээ ирсэн хүн байна даа аяга цай чанаж ууя даа...

Унтлагын өрөөнөөс гарах гэж эргэх тэрхэн агшинд Билгээ орон доогуур хэвтээ жаахан бүр нярай хүүхдийн өхөөрдөм хөөрхөн бойтгийг олоод харчихав. Сэтгэлд нь баяр хөөр, өхөөрдөл төрөөд ирлээ. Билгээ бойтгийг авч үнэрлэв. Нялх амьтны содон үнэр бойтогноос ханхлаж байлаа.

-Энэ чинь миний хүүгийн бойтог байх нь... гэж Билгээ өөрийн эрхгүй энхрийлэн дуун алдлаа.

Хүүгийнхээ бойтгийг үзээд үнэрлэсэн нь Билэгжаргалын амар тайван сэтгэлийг их далайн түрлэг ирэх шиг хөдөлгөж орхив. Тэрбээр бушуухан үрээ үзэхсэн хэмээн яарч гарав. Аяга цай дүрдэг плиткээр хам хум чанан уусан болоод тэрбээр цүнхэндээ ойр зуур хэрэглэх юмаа хийн бариад гарч одлоо. Өөр бодож санасан ч юмгүй шууд л такси барьж суухдаа

-За хө Түнхэл хүргээд өгч чадах уу? Би дөнгөж сая Японоос ирсэн, мөнгөө солиулж амжаагүй. Доллараар тооцоо хийж болно биз дээ? гэж асуув.

Хаа байсан Түнхэл модны аж ахуй, тэгээд доллараар тооцно гэхээр жолооч залуухан эр олзуурхалгүй яахав.

-Өө тэг, тэг. Харин бензин авах л ажил бий.

Чингээд цоо шинэ такси хотын замаар хурдлан одов. Ойн зам адармаатай, газраар мөлхөх шахуу явдаг хотын засмалын хөнгөн тэрэг солонгосын эксель мэт нь яагаад ч явж чадахгүй



тул саяхнаас тээвэрт гарсан япон жип таксийг Билэгжаргал сонгож авчээ. Ийм тэрэгтэй такси бааз ажиллагаагаа эхлээд удаагүй байлаа.

-Зам хол шүү. Засмалаас Рашаантын наахнаас салаад шороон замаар ондогонуулсаар явтал ядарна. Хоёулаа сайн хооллоод гарна байгаа? гэж бензин хийлгэчихээд жолооч хэлэв.

-Тэгье, тэгье.

Хаа саагүй байх гуанзны нэгэнд орж холимог шөл мантуутай цайтай бүтнээр нь авч идэж байхдаа

-Эх нутагтаа ирээд анх хооллож байгаа минь энэ... Уг нь харьд суугаад ирж байгаа хүн эхнэрийнхээ гарын хоолыг идэж, ширээ дүүрэн идэх уух юм дэлгээд, найз нөхдөө урин инээн баясч суувал болох л байсан... гэж гуниглангуй боджээ.

Гээд яахав. Аавындаа одоохон хүрч, гэргий ханьтайгаа уулзан, анхны үрээ үнэрлэн үнсээд л сэтгэл цайраад сайхан болчих юм чинь....

Тэд хөдлөцгөөв. Шинэхэн жип хотын засмалаар нисэх мэт хурдлав.

## ХОРЬДУГААР БҮЛЭГ

-Чи замаа сайн мэдэх юм байгаа биз дээ? Сөгнөгөр Баян гол хүртэл зам гайгүй байх... Харин төмөр замын Баян буурлын амралтаас цааш зам таагүй байж мэднэ...

-Өө та зоволтгүй. Нэгд гэвэд Батсүмбэр чинь миний нутаг. Нөгөөд гэвэл такси барихаасаа өмнө би чинь тавдугаар баазад холын тээвэрт оросын том тэргээр таван жил монгол орны очоогүй газаргүй явчихсан шархтсан чоно... Голдуу зуднаар, их цаснаар л тэжээл хүргэх гэж баруун аймагт өвлийн ид хүйтнээр гарч өгдөг байлаа шүү дээ. Дугуйгаа гинжилчихээд их хунгар дунд сууж барин, хонон өнжин цас малтаад л...

Яриа хөөрөөтэй сайн жолоочтой таарсан нь яамай даа. Амандаа ус балгачихсан юм шиг хичнээн бээрийн газар дув дуугүй явдаг модны тэрэгний жолоочтой Билгээ аавындаа очиж байсан удаа бий. Тийм хүнтэй явах үнэхээр шаналгаатай. Өөрөө тийм их чалчаа биш боловч Билэгжаргал хол замд гангар гунгар гэж явахыг эрхэмлэнэ.

Цаг хугацаа амархан өнгөрөх юм даа. Дэлгэрмаатайгаа суусан тэр нэгэн зуныг одоо тэрбээр санаадхав. Нэг гэртээ чамгүй олон хонож, бараг л өвөртөө орон алдаж халуун амьсгааг нь шөнө чагнан хүсэлд автаж нойргүй тийчлэхдээ Билгээ эр хүний түрэмгий зан гарган залуу бүсгүйн хөнжлийн сэжүүрээс татаад өвөрт нь орж болох л байсан. Дэлгэрмаа ч гэсэн хүслийн нүдээр түүнийг харж, тэр ч байтугай унтсан хойгуур толгойг нь зөөлхөн илдэг байсан. Тэгээд байхад Билгээ зориг гаргаж чадаагүй. Алтны уурхайн ажилдаа өдөрт чөлөө завгүй шогшиж, түүртэн ядардаг ч гэсэн залуу халуун настай хүн тул ганц сайхан хоол идээд, өтгөхөн шиг сүүтэй цай уугаад түр дугхийгээд л хамаг ядаргаа арилчихдаг сан. Чингээд болдог сон бол уурхайн конторт газраар ор засан хажууд хэвтээ Геологийн төв лабораторийн хар нүдэн Дэлгэрмааг шөнөжингөө ноолчихмоор дур хүрэх авч хайрласан сэтгэлээсээ болоод халдаж чаддаггүй байсан. Эр хүнийхээ хувьд тэр бүсгүй хүнтэй унтаж үзсэн үү гэвэл хэдийнээ тэр жаргалыг амсчихсан л байж... Хөдөө хайгуулаар яваад айлд хоноход нь хацар нь холцруутсан арван найм, ёстой ор хөнжлийн явдлын амтанд ороод эр хүнийг татаж чангаа шахсан охид түүнийг цаашаа гэдэггүй л байсан... Хөдөөгийнхөн сонин шүү дээ. Шөнө дөлөөр хаалга үүдний түгжээг мултлан охин дээр нь хэн нэгэн хархүү ирэхэд мэдсээр байсан хэр нь эцэг эх юу ч үл хэлнэ. Хонь хариулж яваа бүсгүй дээр хэн ч давхиж очоод хээр дараад авахад хэн ч хүчирхийлэв энээ тэрээ гэж хэрүүл зарга үл хийнэ. Ёстой юм ёсоороо л болж байна гэж бодох авай.

Хөдөөгийнхөн геологчдод сайн. Тэднээс хэн нэг нь охин хүүхдийг эргүүлэхэд хөл алдах нь шахна. Учир нь геологчдыг хээр тэнэж явдаг болохоос биш эрдэм номын хүмүүс гэж үзнэ. Хамгийн бишрүүлдэг зүйл хайгуулынханд байдаг нь ямар ч догшин лус савдагтай газрыг хөндсөн тэдэнд гай зовлон үл нүүрлэдэг юм. Тэгэхээр нутгийн лус савдаг хүртэл геологчдын гарын дор номхон байдаг ажээ хэмээн бодоцгооно. Лусыг номхотгосон ийм хүнтэй охин нь ханилж гэж жаргана даа хэмээн хөдөөнийхөн бодох авай.

Тэрхүү хонины боруудтай Дэлгэрмааг яагаад ч зүйрлэн бодох аргагүй байлаа. Эрх танхил байдалтай, хэн ч халдашгүй омог бардам гоо үзэсгэлэнт энэ авхайг хүчээр эзэгнэх хүсэл Билгээд байсангүй. Өдөр хоног цаашлах тутам Билгээ түүнд дасчээ. Чингэж дасах тутмаа

сэтгэлдээ ариухнаар бодож явахыг эрхэмлэн, хэрэв зээ биед халдаж нүгэл үйлдэж гэм зүрхэнд хурсан тэр сайхан бүхнээ гутаачих юм шиг санах авай.

Ийм байдлаар цаашаа хэр удах байсныг бүү мэд. Гагцхүү нэг л өдөр найз нөхөр нь авгай хүүхэдтэйгээ ирээд Хараа гол руу Дэлгэрмаа тэр хоёрыг зугаалганд авч явж билээ. Тэгэхэд хээр хонох болж танил найз нь майханд Дэлгэрмаа, Билгээ хоёрыг бараг хүчээр шахуу нэг оронд оруулжээ. Тэр шөнө цэцгийн үнэр анхилсан Дэлгэрмаагийн гэзгийг үнэрлэн анх удаа зориг муутайхан тэвэрч уруул дээрээс нь үнсэхүй, харин залуу бүсгүй түүнээс ч илүү зоримог байж хариу үнсэн таалжээ. Эр бие залуу бүсгүйн энхрийлэлд хөвчрөн чангарч сэтгэлдээ энэхүү эмзэг турьхан амьтанд халдмааргүй байсан авч биологийн сэрэл эз дийлж өөрийн эрхгүй бүсгүйн дээр гарахад хүргэсэн билээ. Чингэж Билгээ нүүр хагарав.

Дэлгэрмаа тэр хоёрын дур таалал бүрнээ таарч тохирдог байлаа. Шөнийн учраа бүр нь тэр хоёрт ядрангуй аз жаргалыг авчирна. Учрал бүхэн амттай байсан тул шөнөжингөө ноололдоод ч Билгээ сэтгэл ханахгүй үе олонтаа. Одоо аян замын зуурт тэр тухай санахад хамаг бие хөвчрөн чангарах шиг болов. Хүүхнээ тэр их санаснаа сая л мэдэв.

-За яагаад дуугаа хураачихав? Ядраа юу? гэж жолоочийн дуу гарлаа.

-Жаахан юм бодоод... Алив нэг сайхан дуулаач гэж Билгээ гуйв.

-Жолооч хүн хамгийн сайн дуучин байдаг гэсэн биз дээ? Тийм ч учраас жолооч нараас олон хүн дуучин болсон гэдэг шүү. Гавьяат Банзрагч, Оросоо гээд л...

-Тэр ч үнэн шүү. Тэрэг бариад хөдөө хээр давхиж явахад дуу л хань болдог шүү. Дуугаараа бид чинь сэтгэлээ гарган хэлж, хүслээ илэрхийлдэг юм шүү дээ. За жишээ нь гээд жолооч нэг дуу чанга хоолойгоор эхэлсэн нь

Хархан нүдний талимаанд чинь

Хайлан уяран суухдаа

Ханийн жаргал эдэлснээ

Хайрт минь би мартаагүй ээ... ээ... гэжээ. Энэ дууны үгийг Билгээ зүрхэндээ ойр хүлээн авч, нээрээ л Дэлгэрмаадаа ингэж л би хэлэх ёстой хүн дээ гэж бодлоо.

xxx

Нэг л мэдэхэд ой хөвчийн дундуур сүлжсэн овон товонтой зам Билгээг аавын нь гэрийн гадаа чирч авчирсан байлаа.

-Нэгэнт хүрээд ирснийх яараад яахав. Гэрт орж цай, хоол идээд, жаахан амраад яв даа хө гэж цүнхээ авангаа Билэгжаргал жолоочид хэлжээ. Машин ирэхийн чимээнээр хэдэн хүүхэд гэрээс гарч ирсэн нь дүүгийн хүүхдүүд ажээ.

-Агаа ирсэн. Билгээ агаа! гэж хүүхэд таниад хашгирав.

-Эмээ, ээжээ Билгээ ах ирсэн. Билгээ ах...

Хүүхдийн шуугианаар ойн гүнд байх гэрээс эхлээд Сайханаа дүү нь, дараа нь ээж нь гарч ирээд дуу алдан тосч ирцгээв.

-Иш муу хүү минь хүрээд ирж... За сайн явж ирэв үү хэмээн ээж нь үнсэв.

Энэхэн хоромд хөгшин эх юу санасныг хэн мэдэх вэ. Харин Билгээ нүдээрээ хэн нэгнийг хайсан мэт ийш тийш харсан нь Дэлгэрмааг үгүйлсэн хэрэг байлаа. Гэрт орцгоов. Дорлиг гуай хүүгийнхээ сургаар босох гэвч чадсангүй. Билгээ бушуухан дэргэд нь очиж золгон хацраа өгч үнсүүлэв.

-За тэгээд сайн сууж байна уу? Танай тэр япон нутагт зуншлага сайхан уу?

Хүүдээ хөөргөө өгч тамхилан Дорлиг сэтгэл их хөөрсөн шинжтэй байхад эх цай аягалж амсуулчихаад дахин шинэ цай тогоонд чанах гэж ус хийв.

-Дэлгэрмаа ирээгүй юу? хэмээн үгийн завсраар Билгээ асуужээ.

-Үгүй шүү дээ. Та хоёр арай яваа биш биз дээ? гэж Гапилмаа гайхжээ.

-Би Токиогийн онгоцноос буучихаад гэрээрээ ороод хүнгүй байхаар нь Дэлгэрмааг хүүтэйгээ аавынд ирсэн юм болов уу гээд шууд гарлаа л даа.

-Чи ирнэ гэж хэл өгөөгүй хэрэг үү?

-Утсаа ер авч өгөхгүй байсан юм л даа...

-За тэгнээ тэр. Сайханаа Түнхэл өртөөнөөс ярих гээд бүр ядчихсан юм. Өнөөх олдмолоо чирээд хаа нэгтээ тэнэж яваагаас гараа гэж үү?

Хөгшин эхийн энэ үг Билгээг цочоов. Юу гэж байгаа юм. Төрсөн хүүгийн нь хүүхэд олдмол байхдаа яахав дээ. Ээж минь хөгширч зөнөө юу даа? гэж гомдосхийв.

-Хөгшин чи аядуухан л байна шүү. Хүүг босгоор хөлөө давуулав уу үгүй юу хачин юм яриад...

-За яадаг юм. Худлаа юм биш, миний муу ач хүүг алга хийчихээд огт өөр зүсмийн хүүхэд тэвэрч ирэх чинь билээ.

-Та нар чинь одоо юу яриад унав аа? гэж Билгээ жолоочоос зовсхийн асуухдаа нуруу руу нь хүйт оргин, толгойтой үс арзайн босох шиг болов.

-За яахав миний хүү аажимдаа учрыг нь ойлгох байлгүй.

Би ч хувьдаа Дэлгэрмаадаа буруу өгч чадахгүй л байгаа... Хүүхдээ тэврээд нэг ирсэн юм зайлуул. Ээж чинь л ачийгаа өгзгөн дээрээ толботой байсан, тэр нь алга, үнэр нь биш байнга энээ тэрээ гэж өөлж муулсаар байгаад Дэлгэрмааг явуулчихсан. Хүний амьдралд юу ч

тохиолдож болно шүү дээ. Чамайг ирэхэд Дэлгэрмаа гэртээ байхгүй байгаа бол хүүхэд нь бүлээрээд эмнэлэг хөөцөлдөж явсан ч юм уу хэн мэдлээ...

Буурал аавын үг нэгийг хэлэх шиг болов. Ямар нэгэн явдал болсон нь тодорхой. Чухам юу гэгч болсон хэрэг вэ? Ээжийн хэлж байгаагаар бол миний хүү үгүй болчихсон ажээ. Энэ үнэн үү? Эсвэл би зүүдэлж, хар дарсан зүүднээсээ болоод солиорох гэж байна уу? Миний хүүг алдчихаад Дэлгэрмаа хаанаас ч юм хүүхэд олчихоод тэвэрч ирсэн гэж үү?

Ямар ч байсан ханьтайгаа уулзахаас нааш сэтгэл амармааргүй байв. Хэрэв осол зэхий явдал болж хүүхдээ алдсан нь үнэн юм бол Дэлгэрмаагийн сэтгэл ямар байгаа нь ойлгомжтой.

Жолооч залуу босч малгайгаа өмсөв.

-Хүү чи хоол унд идээд яваач...

-За яах вэ би эртхэн газар дөхье... Харанхуй болчихвол уулын зам амаргүй... гэж жолооч хэлсэн боловч хаалгаар ормогц хэрүүл уруул хийсэн энэ гэрийн хөгшчүүлд дургүйцсэн нь ил байлаа.

-Үгүй чи байз... Хоёулаа цуг буцнаа.

Билгээ ингэж хэлээд авчирсан бэлэг сэлтээ гарган ээж, аавдаа, дүүдээ, хүүхдүүдэд нь тараажээ. Чингээд хоол хийхийг ч хүлээсэнгүй шууд цүнхээ бариад гараад явчихав.

-Даан ч яав даа Гапилмаа минь... Ганц цаг тэсч болсонгүй юу. Хүүг гомдоочихлоо гэсээр Дорлиг гуай үлдэв.

-Би худлаа хов зөөгөөгүй ээ. Яах аргагүй миний хүүгийн үр биш л байсан. Буурай аавыг чинь өөд болоход өгзгөн дээр нь тэмдэг тавьсан юм. Би хүүг чинь нялхад хэд хоног танайд байж Дэлгэрмаад шөл цай уулгаж асарч тойлж байхдаа үнэрт нь дасч, муу аав минь танайд эргэж төржээ гэж мэргийг нь хараад олзуурхан баярлаж байсан.

Тийм мэргэ тэмдэг тэгж амархан алга болдоггүй юм. Хөгшин эхдээ битгий юм санаарай. Хэлэхгүй байж чадсангүй. Билгээ за ч гэсэнгүй ёо ч гэсэнгүй хацраа өгч үнсүүлээд машиндаа суув. Нэг их айхтар хар юм цээжинд нь бөглөрчихөөд тэрбээр байх суух газраа олж эс чадах шиг санагдан

Харваас ээж нь зөнөсөн буюу, эсвэл голдоо ортол гомдсон шинжтэй ажээ. Чухам юу болоод байгааг Билгээ ойлгож эс чадав. Юуны түрүүн энэ хорвоод хамгаас хайрладаг Дэлгэрмаагаа л тэр өрөвдөж байлаа. Машин энхэл донхолтой ойн замаар ондгонон давхисаар л...

х х х

- Яасан хөөрхөн хүү вэ? Энэ таны хүү юу?

Сувилагч бүсгүйн асуулт Дэлгэрмааг цочоов. Буруу хазгай хэрэг хийсэн нь үнэн болохоор тэрбээр ямагт хүнээс айж цочих бүлгээ.

- Тиймээ хүү минь халуураад... Уг нь зүгээр л байсан хүүхэд...

- Алив оношийг нь үзье дээ. Даруйхан тарианд орсон дээр биз дээ. Ханиад хүндрээд хатгаа болчихвол осолтой...

Сувилагч эмчийн бичсэнийг амаа хөдөлгөн уншихдаа энэ жаахан хүүг хаана ч билээ үзсэн шиг санагдаад байлаа. Хаана үзсэн байж таарах вэ? Яах аргагүй таньдаг л царай... Манайд хэвтэж байсан юм биш биз? Тэгвэл миний хийсэн тарианы сорив байгаа даа...

Сувдаа хэмээх энэ сувилагч туйлын гярхай нэгэн ажээ. Тасагтаа хэвтсэн ямар ч хүүхдийг таньдаг, тариа хийсэн ором мөрөөрөө өөрийн нь сувилгаанд байсан жаал мөн байна гэж мэддэг нь туйлын сонор соргогийг илтгэнэ. Өнөөдөр ирсэн жаахан хүүг яг нэрээр нь биш боловч, зүсээр нь Сувдаа таних шиг болов. Дотор сэтгэлд орж ирсэн таавраа батлахын тулд бүсгүй даруйхан тариа хийхээр авчирлаа. Чингээд бяцхан хүүгийн өхөөрдөм жаахан гарыг бариувчнаас ил гаргав.

- За тэр дээ...

Өөрөө ч мэдэлгүйгээр Сувдаа дуу алдав. Өөрийн тариа хийсний мөр хэд хэдэн газар цэг шиг цагаан сорив

- Чи юу гэвээ? хэмээн нэг л юм мэдсэн шинжтэй Сувдааг дуу алдахад гайхан Дэлгэрмаа асуув.

- Өмнө нь тариа хийлгэж байсан хүүхэд байна. Урхагийг нь бүрмөсөн арилгахгүй бол нэг ханиад юм уу, хатгаа туссан хүүхэд дахин дахин өвдөөд байдаг юм л даа... За сайн барьж байгаарай. Би таръя.

Дэлгэрмаа хүүгээ чанга тэврэв. Тариа хийсэн даруй нэгэнтээ хүү часхийснээ чимээгүй болов.

- Хүүгийн нэр хэн гэлээ?

- Баяраа...

- Уйлдаггүй сайн жаал байна. За тэгээд эмийг нь цагаар сайн өгнө биз. Би цаг цагт нь ирж тариа хийнээ.

Өвчний түүх бичсэн хавтасыг барин тасгаас гарахдаа Сувдаа “Баяраа... Баяраа...” гэж амандаа үглэж байлаа. Тиймэрхүү нэртэй ямар хүүхэд манай тасагт хэвглээ? гэж бодож бодож

- Тиймээ тийм, Баярболд гэж жаахан хүү хэвтэж байсан. Нилээд хэдэн сарын өмнө юм байна шүү. Сахиур нь дөч орчим насны Ууганжаргал гэж эгч байсан. Хааяа нэг уулзаж ярихад өөрөөс хүүхэд төрөөгүй, энэ жаал танилын нь хүүхэд... өргөж авах гэж байгаа юм... гэдэг сэн. Тэгвэл тэр жаахан хүү эргээд ирсэн хэрэг болох нь уу?

Сувдаагийн эм хүний саваагүй зан хөдлөж, тасгийн конторт ормогцоо хэвсэн эмчлүүлж

байгаад гарсан хүүхдүүдийн хуучин өвчний түүхийг шүүрдэн үзье гэж шийджээ. Тэгээд хэрэв Баярболдынх байвал нь одоогийн энэ жаалын өвчний түүхтэй харьцуулж үзэж болох юм. Энд ч, тэнд ч хүүхдийн нас, өндөр уртын хэмжээ, биеийн нь онцлогийн талаар бичсэн байгаа шүү дээ... гэж Сувдаа бодов. Яагаад чухам энэ явдал түүний сонирхлыг татаад байгаагийн учрыг өөрөө ч сайн ойлгосонгүй...

х х х

Хүүгээ унтаж байх зуур хажуугийнхаа хүнд захичихаад Дэлгэрмаа гэр рүүгээ такси авч шурхийв. Яагаад ч юм бэ өчигдрөөс хойш гэр рүүгээ харимаар санагдаад байлаа. Цахилгаан зуухаа залгаастай нь орхичихоогүй байгаа? Угаалгын өрөөнд усны цорго нээгээд мартчихсан юм биш биз... гэх мэтээр ойр зуурын юм бодсноос биш, харин нөхрөө хүрээд ирсэн байх гэж зүүдэлсэн ч үгүй. Ер Дэлгэрмаа хүүгээ ид унтаж байх үеэр ингэж хааяа түргэхэн зуур гэрээ эргэдэг билээ.

Баруун нүдний дээр татав. Тэгэхээр тэр баярладаг билээ. Ямар нэг сонин юм болох гэж байгаа ч шиг зөн совин дуудаж байна. Гэрийнхээ гадаа ирээд цонх руугаа харж, маш яаран орцоороо гүйх шахам оров. Тэгээд хаалганыхаа өмнө очин түлхүүрээ гаргахдаа хэн нэг нь гэрт байгаа шиг санагдаад явчихав. Ямар ч гэсэн хаалгыг хүн онгойлгосон шиг байлаа.

Дэлгэрмаа хаалгаар шурхийн орохдоо хонгилд Билэгжаргал гайхсан юм шиг зогсч байгааг харлаа.

- Билгээ минь...

Билгээ хүүхнээ тэврэн авав. Дэлгэрмаа санасан сэтгэлээсээ, үзсэн туулсан гай зовлонгоосоо болж нөхрөө тэврэн ухаангүй орилов.

-За тайвшир. Би ирчихсэн байна шүү дээ... Сэтгэлээ барь...

Сүүлийн нь үг Дэлгэрмааг өөрийн мэдэлгүй нулимсанд норсон нүүрээ өндийлгөн харахад хүргэв. Энэ үг бол Билгээ нь болсон явдлыг аль хэдийнээ мэдсэнээ хэлсэн шиг байлаа.

- За тийшээ суу. Чи хаанаас ирэв? Эмнэлгээс үү? хэмээн Билгээ одоо бол хайр энхрийллээр биш, ажил хэрэгч хүний дуугаар асуужээ.

Дэлгэрмаа хувцсаа хөнгөлж, гутлаа тайлаад диван дээр очиж суув. Нөхөр нь гал зуухны өрөөнд орж юм түжигнүүлж байснаа тавиур дээр өөх алгалсан чанасан мах, төмстэй, огурцы тавьчихаад авчирав.

- Хоолоо ид дээ хөө...

Хэдий чинээ Билгээ түүнд найр тавих тутам төдий чинээ Дэлгэрмаагийн хоолой зангирч байв.

Билгээ хоёр хундаганд дарс дүүргээд

- За сайн сайхан уулзсных тогтоочих уу? гэж өглөө.

Дэлгэрмаа дарсыг уучихаад махнаас огтлон амандаа хийхдээ яаж нүүр хагарч Билгээд зовлон гачаал бүхнээ тоочих билээ? Хаанаас нь эхлэх билээ? гэж бодож байв.

Билгээ босоод явчихав. Тэгээд дотор өрөөнөөс алтан хайрцагтай нэг юм, мөн гялгар ууттай өөр нэг юмтай авчирч

- Алгаа тосоод нүдээ ань гэж энгүүн хэлжээ. Дэлгэрмааг нүдээ анимагц алган дээр нь нилээд хүнд жинтэй юм тавих шиг болов.

- За хараарай.

Дэлгэрмаагийн алган дээр цул алтан бугуйвч хээ хуараараа гайхуулан гялалзан харагдаж байлаа.

- Миний найз ийм их үнэтэй юм надад өгч яах нь вэ дээ... гэж хэлж буй Дэлгэрмаагийн үгний өнгөнд “Би ийм бэлэг авах гавьяагүй хүүхэн шүү дээ” гэсэн гутрангуй аяс тод байв.

- Хэдэн жил алтны үйлдвэр байгуулах гэж яаж зүтгэлээ дээ. Чи ийм юм зүүх эрхтэй хүүхэн шүү гээд Билгээ гялгар гоёмсог уутнаас хүүхдийн живх, өхөөрдмөөр жаахан өмд цамцны хослол гаргаж ирэв.

- Үүнийг хүүдээ авсан юм...

Энэ удаад Дэлгэрмаа тэсэлгүй чангаар бараг бахирах шахан бачуурч уйлжээ.

- За тайвшир. Уйлаад яах вэ. Үнэнээ л найздаа хэлчих. Онгоцноос бугаад гэртээ ирсэн чинь чи байдаггүй. Би тэгээд аавынд Түнхэл өөд очсон юм... гээд Билгээ ханиа тэврэн халуун дотноор үнсэв.

- Ухаалаг төрсөн чамдаа би баярлаж байна...

Яагаад Дэлгэрмаагийн аманд ийм үг орж ирснийг бүү мэд. Нөхөртөө тэврүүлэн салшгүй сайхан үнэрийг нь авч цээжинд нь нүүрээ нааж тайвшраад Дэлгэрмаа

- Намайгаа уучлаарай... Би их нүгэл хийжээ... хэмээн уйлан дуугарчээ.

х х х

Эх нялхсын төвийн нярайн тасагт Билгээ ханиа даган оров. Тэрбээр эргэлтийнхэн цай цуй авчирдаг тэр хүлээлгийн танхимд сэтгэл ихэд догдолсон байртай хүлээж байхад Дэлгэрмаа хүүг тэвэрсээр орж ирэв.

- За энэ дээ миний хүү...

Билэгжаргал хүүг хоёр гар дээрээ болгоомжтой нь аргагүй авч удаан ажиглаад үнэрлэн үнсэв.



Мариалаг цагаан хөөрхөн хүү л юмсанж... Өөрийн яс махны тасархай тэр талийгаач хүү ямар амьтан байсан бол? Хувь заяа яагаад өөрийн нь үрийг булааж өрөөл бусдын үрийг түүнд тэврүүлэв?

Билгээ үнэн голоосоо харамсан хоолой нь зангирч ирэв. Одоо тэгээд яалтайв дээ? Оргүйгээс охинтой нь дээр гэж үг бий. Нээрээ Дэлгэрмаагийн хэлснээр бурхан тэнгэр ивээж, хөх нь чинэж, сэтгэл нь гансарсан бүсгүйд энэ хүүхдийг зориуд олж өгсөн ч юм билүү?

- Нас маань залуу байна. Хичнээн ч жил амьдарна шүү дээ. Ахиад хүүхэд төрөх л байлгүй. Үр хүүхэдгүй хичнээн айл өөр хүнээс хүүхэд өргөж аваад, тэр нь ууган үр нь болж араас нь өчнөөн төчнөөн нялх зүстэй, нойтон сормуустай амьтан цувсан жишээ олон бий шүү. Азаар олдсон сайхан хүүгээ бөөцийлөн өсгөж байтал чи бид хоёрт өөрийн үр ирэх байлгүй...

Дэлгэрмаа хамаг үнэнээ тоочин нүглээ наманчлаад хоёр залуу талийгаач хүүгийнхээ хойноос нулимс унаган хэсэг суусны дараа ингэж хэлж билээ. Ээжийн нь хэлсэн үг Билгээд ямагт бодогдсоор байлаа. Тэрбээр ханьдаа эхийн хэлсэн үгийг ч нуулгүй хэлжээ.

-Ээжийн буруу байхгүй ээ. Тэгж аашлах нь хэр шүү дээ. Үнэхээр л миний хүү өгзгөн дээрээ тонолж хэлбэрийн мэнгэтэй байсан. Магадгүй үнэхээр буурай аав эргэж ирсэн нь байсан юм уу хэн мэдлээ. Ээж хүүхдийг үнэрээр нь андахгүй таньдаг нь гайхмаар байсан. Би бол уй гашуундаа тэгсэн үү үнэрлэхэд энэ Баяраа яг л миний үр шиг үнэртэй байсан... Гэтэл ээж дор нь өөр хүүхэд байна гэж үнэрээр нь таньж байгаа юм даа...

Ингэж сэтгэл цайрав. Одоо яана гэхэв дээ. Хөөрхөн хүүтэй л үлдэж... Энэ амьтныг хүн болгоод өсгөж авбал нэг л хэрэг...

Билгээ хүүхдийг хажиглаж үзсэнгүй. Одоохондоо бас хэт энхрийлэн, эцгийн сэтгэлээр хайрлаж чадсангүй. Учир нь зүс барааг нь үзээгүй, тэр нэг нялх амьтан зүрхэнд нь шар ус хуруулан байн байн бодогдсоор байлаа.

“Би ямар азгүй хүн бэ? Төрсөн үрийнхээ царай зүсийг ч харж чадалгүй алдчихдаг... Ямар хөөрхөн амьтан байсан бол доо” гэж Билгээ харамсан бодоход зүрх нь өвдөх шиг болно. Билгээ сэтгэлийн далд шаналал юугаа Дэлгэрмаад мэдүүлэхгүй гэж хичээж байв. Тэртэй тэргүй өчнөөн хоног зовж тарчилсан хүүхнийг сэтгэл санаагаар унагаад яах вэ. Аясыг нь дагуулсхийн тайвшруулж авахыг л бодох нь зүй...

Хүүг үнсэж хэсэг зуур тэвэрч байгаад Дэлгэрмаад өгөхөд цаадах нь аваад тасаг руугаа оров. Маргааш нь тэр хоёр Баруун наранд очиж бяцхан хүүгийн шарил дээр толгой гудайлган зогссон билээ. Тэрхүү намхан жаахан овоолсон шорооны толгойд зоосон хавтгай чулуун дээр “Билэгжаргалын Цогтбаяр” гээд төрсөн нас барсан он, сар, өдрийг сийлсэн байлаа.

## ХОРИН НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Сувдаа хуучин данс хараа үзсээр байгаад мөнөөхөн хавраар шахуу хэвтсэн жаахан хүү Баярболдын өвчний түүхийг гаргаж ирэв. Чингээд шинээр нээсэн Цогтбаярын өвчний түүхтэй харьцуулан үзжээ. Хэрэв овог нэрийг л эс тооцвол бүх зүйл таарч байлаа. Харин хуучин дансанд “Батбаярын Баярболд” гэж бичсэн ахул, шинэ дансан дээр “Билэгжаргалын Цогтбаяр” гэсэн нэр дурайж байлаа.

Энэ ямар учиртай юм бэ? Яахлаараа нэг хүүхэд хоёр өөр айлд данстай байдаг хэрэг вэ? Ийм л амархан хүүхдээ өөр хүнд өргүүлчихлээ гэж үү? хэмээн бодтол гэнэт энэ Баярболд гэдэг жаал чинь нээрээ хулгайд алдагдсан шүү гэсэн юм санаанд бууж ирэв. Тэгсэн шүү нээрэн... Эмнэлэг даяар бөөн шуугиан дэгдээгүй юу. Цагдаа нар хүртэл ирчихээд нохой тавих нь халаг эрэл сурал болоо биз дээ? Тэрнээс хойш багагүй хугацаа өнгөрсөн боловч хүүхэд олдсон эсэх нь мэдэгдсэнгүй.

Энэ хүүхэн хүүхэд хулгайлчихмаар тийм хачин амьтан биш л юм шиг... Тэгвэл яагаад хүүхэд энэ хүүхний гарт байдаг билээ? Бас тэгээд хэрэв энэ хүүхэн хүүхдийн хулгай хийсэн бол хөнгөхөн ханиад хүрэв гээд урьд хэвтэж байсан тасагт нь зориуд ирж хэвтмээргүй сэн...

Сувдаа тэгээд Ууганжаргалын утас байна уу үгүй юу хэмээн хуучин өвчний түүхэн дээр хайв. Аз болоход гэрийн утсыг нь тэмдэглэж авсан байлаа. Бүх юмны учрыг мэдэх хүн Ууганжаргал болохоор Сувдаа юу ч гэсэн түүнтэй яриад үздэг хэрэг гэж бодлоо.

Тэр өдөр ойр утас байсангүй тул тэгсхийгээд орхижээ. Дараагийн ээлжин дээр Дэлгэрмаа хүлээлгийн өрөөнд нөхөр нь бололтой нэгэн ганган байрын хар хүүг суулгаад хүүхдийг авч түүн дээр орохын зуурт шурхийн гарч гүйв. Ойр хавь утасгүй тул бүр эмнэлгээс гарч мянган нэрийн барааны дэлгүүр хүрэн утас олж залгажээ. Ууганжаргалын утас хариу өгсөнгүй... Сувдааг буцаж ирэхэд мөнөөхөн Дэлгэрмаа хүүхэн эмчтэй ярилцаад аав нь Токиогоос ирсэн тул хүүхдээ эмнэлгээс түр гаргая гэж гуйсан байлаа.

-Түр ч юу байхав дээ. Бүр гаргасан ч болно шүү дээ. Хүүхэд чинь ямар хатгаа туссан биш. Хөнгөхөн ханиад хүрсэн байсан... Тариа тариулаад эм уугаад гайгүй л болж... Гэрээр эмийг нь сайн өгөөд гам сайн хийвэл дажгүй шүү дээ... гэж эмч хэлээд явуулчихсан байлаа. Ингээд Сувдаа ямарваа нэгэн баримтгүй хоцров. Ядахдаа өвчний түүх нээсэн эмч эхийнх нь хаяг, утсыг тэмдэглэж авсангүй. Одоо тэр яах ёстой вэ? Юу ч гэсэн Ууганжаргалтай ярьж хүүхдийн тухай хэлэх нь хүний ёсоо доо. Одоо хүртэл алдагдсан хүүхдийн сураг гараагүй ч байгаа юм бил үү. Хэрэв ийм ахул хүүхэд нь амьд мэнд байгааг мэдвэл эхийн сэтгэл амрах биш үү гэж боджээ.

xxx

“Бадамлянхуа” зочид буудлын үүдээр шөнийн 3 цагт нүүрэндээ хар баг зүүсэн хоёр чийрэг эр буу барьсаар гэтэн орж ирэв. Тэд халхавчныхаа цаана үүрэглэн суугаа зочид буудлын жижүүрт буу тулган сэрээжээ. Гар бууны онгойсон хар ам өөр рүү нь чиглэж, сүвээ рүү хатуу төмрөөр хүчтэйхэн ёвроод авахад жижүүрийн сүнс гарчих шиг л болов.

-218 номерын түлхүүр аваад марш! хэмээн хар багтан жижүүрт тушаажээ. Жижүүр хижээл эр салгалж чичирсэн гараар өлгөөстэй түлхүүрүүд дотроос 218 дугаартайг авч хаалтынхаа цаанаас гарч ирэв.

-За бушуул.

Оройхон Жан овогт тэнд байрласан монгол залуухан бүсгүйг гадагшаа гарав гэж зэмлэн өрөөнд нь цоожлоод гарч явахдаа хэдэн цаас атгуулан

-Тэр монгол эм дээр хэнийг ч оруулж болохгүй. Өөрийн нь хамрыг ч цухуйлгах хэрэггүй гэж захисан билээ. Гэтэл шөнө дунд юун гангеструуд ингэж түрэмгийлэн орж ирж, буу шийдэм гарган тэр хүүхний өрөө рүү намайг авч явдаг билээ? Ээ дээ манай энэ Гонконг уу? Есөн шид нь бүрдсэн газар даа... гэж боджээ.

Жижүүр явган шатаар хоёр дугаар давхарт гарч бүдэгхэн гэрэлтэй хонгилоор тэднийг дагуулахад буу бэлхнээ барьсан хар багт эр ар талд нь алхам ч холдохгүй явж байв.

Аягүйд бол монгол хүүхнийг энэ дээрэмчид аваад явах биз. Маргааш Жанд юу гэж хэлдэг билээ? гэж жижүүр бодож амжив. Жан бол хүүхний наймаа хийхэд гаршсан хүн гэдгийг жижүүр сайн мэдэх билээ. Газар газрын сайхан охидыг өндөр цалин, үнэгүй хоол, байр мэтийг амлан хуурч авчраад энэхүү “Бадамлянхуа” зочид буудалд хэд хоног хоргодуулан байлгаад нэг л мэдэхэд хөрөнгөлөг баян хужаад өгөх буюу эсвэл дууч эмсийн газар, үгүй бол иллэг хийдэг рашаан сувиллын ажилд оруулж өгдөг байна. Түүний гараас хэн ч мултарч байсангүй. Жан чингэж залуухан охидоор наймаа хийн ихээхэн ашиг олдог бөгөөд жижүүрт ахиухан хахууль өгчихдөг тул тэдний ам хамхигдан, амьд бараа борлуулж буй ажиг сэжиг авсан цагдаагийнхан шиншлэн ирэхэд ч ам үдээстэй дуугүй байж чаддаг ажээ. Тэрхүү итгэл өнөө шөнө ингээд тасардаг байжээ хэмээн жижүүр бодсоор монгол хүүхний байгаа өрөөний өмнө зогсов.

-Бушуу хаалгаа нээ!

Жижүүр ахиад л сүвээнд нь бууны хүйтэн ам тулж буйг мэдэж ямар ч үнээр хамаагүй амьд гарах сан хэмээн шийдэв. Тэрбээр салгалсан гараар цоожны нүхэнд түлхүүрээ хийн эргүүлэхэд салхивч онгорхой байсан бололтой хаалга өөрөө чахран онгойв.

Гадаа хүн ярих шиг болсноо хаалга онгойх чимээнээр хагас нойртой байсан Ерөө бушуухан босч хувцаслав. Царай нь цаас шиг болтлоо цайн айж балмагтсан жижүүр, нүүрэндээ хар багтай хоёр хүний хамт орж ирээд, нэг нь ор руу дөхөв. Тэр хүн нэг юм хятадаар хэлснийг Ерөө ойлгосонгүй. Чингэхэд орны хөл дээр тавилсан хувцсыг нь хаман авч Ерөө рүү шидэн гадуур хувцсаа даруй өмс гэж дохиод мөнөөх хүн гар цүнхийг нь, чемодан савыг нь хивсэн дээр тавьж бүх юмаа үүнд хий! гэж зангав. Чингээд ор дэрийг онгочин тэнд байсан жижигхэн гар утсыг нь гаргаж ирээд Ерөөд өгчээ.

Энэ бүхэн хоромхон зуур болж өнгөрлөө. Ерөөгийн чемоданыг түгжин гарт нь бариулж гар цүнхийг сугавчуулаад тэд гарцгаав. Жижүүрийг мөн л урдаа оруулан буу тулган туусаар Ерөөг бас дундаа оруулан алхсаар шатаар дээрээс бууж ирэв. Гарах хаалганы өмнө очоод нэг

хар багтай эр Ерөөг дагуулан гадагшаа гарахад нөгөө нь хаалтны цаад талд жижүүрийг оруулан нэг юм хэлсэн нь

-Дуугүй ингээд сууж бай. Хэрэв цагдаа дуудвал хохь чинь шүү гэсэн ажээ. Зочид буудлын өмнө бэлэн зэхээ суудлын хар тэрэг зогсч байлаа. Арын хаалгыг онгойлгон эхлээд чемоданыг тавьж дараа нь Ерөөг түлхэн оруулав. Ерөө арын суудал дээр унах шахуу суумагц машин асааж тэд ухасхийн давхижээ. Өвлийнх шиг тас харанхуй биш гэгээтэй өмнөд орны зуны шөнө үүр цайх дөхжээ. Үл таних харь газрын гудамжаар машин хурдалсаар байв.

Хэнд баригдан хаашаа явж буйгаа Ерөө үл мэднэ. Тэр их айсан тул зүрх нь цээжиндээ багтахгүй тонгочин, дэмий л ийш тийш бүлтэгнэн харах ажээ. Магад энэ хүмүүсийг Жан явуулсан буй заа. Хар эртүүр хил давуулан усан онгоцонд суулгаж Тайланд орон руу явах гэж Жан ов зохион түүнийг буудлаас хулгайв уу? гэж санав. Чингэж бодоход муу хувь заяаны золиос болж, итгэж найдаж явсан хүүхэн нь түүнийг харь хүнд худалдсныг санаад байж ядав...

Зочид буудлын өрөөнд эзэмдэн авах гэж дээрэлхээд гараа хазуулсандаа хорссон Жан маргааш гэхэд Тайландын толгой баян хөгшин хужаад их үнээр түүнийг зарна хэмээн заналхийлж хаалга дангинатал түгжээд холдсон билээ. Түүний хөлийн чимээ холдмогц Ерөө ганц аврал тэнд бий гэж бодож Зоригоо руу утас цохив. Ашгүй тэр залуу утсаа өөрөө авчээ. Ерөө уйлан байж болсон бүх явдлыг ярив.

-Би амьд таваар л болсон юм байна. Миний итгэж найдаж явсан үерхдэг хүүхэн намайг Жанд 500 доллараар зарчихсан ажээ. Маргааш гэхэд Жан намайг Тайландын тэргүүн баянд их үнээр зарах нь... Би түүний олон татвар эмийн нэг болж насан туршдаа эх орноо үзэхгүй хөгшин хужаагийн дэвсгэр болж үлдэх нь... Намайг авраач.

Утасны цаад үзүүрт санаа алдах шиг болов.

-Би чамд эрт нэг хэлсэн шүү. Санаж байна уу? Гэрээтэй ажлаа хийгээд олдсон хэдийгээ бөөгнөрүүлээд Сөүлдээ байсан нь дээр байсан биш үү гэж... Анхнаасаа танай эзэн Ким, тэр нэг Сэрчмаа гэдэг хүүхэн, Жан нар хуйвалдан чамайг наймаалах бүх аргаа хийжээ. Чи тэр арганд нь л автчихсан хэрэг. Чэжү аралд явуулж далайн эрэгт амраадаг, цалинг чинь нэмсэн зэрэг чинь зүгээр л занга байсан байхгүй юу. За тэр яахав. Одоо яах вэ гэдгийг бодъё. Тэр Жан наад зочид буудлын жижүүрт хэд гурван цаас өгч хахуульдаж амжсан л байгаа... Аягүйд бол цагдаагийнханд ч хээл хахууль өгсөн байж магадгүй. Болдоо бид хоёрыг очиход юун сайн юм май гээд өрөөний чинь түлхүүрийг өгчихгүй нь магад... Бид түнштэйгээ ярилцъя. Зөвлөцгөөе. Чи битгий их бачимд. Тайван суугаад хүлээж бай. Ямар ч байсан наад зоориноос чинь чамайг суга татан авна гэдгээ чамд амлая. Зүгээр байж байгаад монгол охиноо тэгж ч Тайланд руу ачуулахгүй байх шүү.

Зоригоогийн хэлсэн үг Ерөөг тайвшруулав. Тэрбээр Зоригоод итгэж байлаа. Гэтэл шөнө дөл болтол Зоригоо ярьсан ч үгүй, ямарваа хүн хаалга үүдийг нээн түүнийг аврахаар ирсэн ч үгүй. Гэтэл энэ хар багтангууд... Үл ойлгогдох адал явдалт кинонд гардаг шиг л Ерөө үл таних хотод үл таних хүмүүст олзлуулан хаашаа ч юм давхиж байна. Бүсгүй дэмий л сул асгарах нулимсаа арчих ч сөгөөгүй хярсан туулай шиг арын суудалд бүлтэгнэн суух ажээ.

Машины хаа нэгтэй зогслоо. Хятадаар ярилцах чимээ гарч, машины хаалгыг хэн нэг нь нээв. Нэг юм хэлж дохисон нь чемоданаа аваад тэрэгнээс буу гэж байгаа бололтой. Ерөө буув. Залуухан хөвгүүн араасаа яв гэх шиг түүнийг дагуулав. Ерөө дагалаа. Тэд явсаар намхан шиг байшинд оржээ. Түүнийг авчирсан хар багтай хүмүүс хайчсан юм бүү мэд алга болжээ. Залуухан хятад хөвгүүн Ерөөг дагуулан хурц гэрэлтэй хонгилоор явсаар нэгэн өрөөний хаалга нээв. Тэнд ганц ор, явган ширээ, буланд зурагт харагдана. Хаалганы дээр өлгөсөн цаг шөнийн 3 цаг дөчин таван минутыг зааж байлаа. Явган ширээн дээр жимсний шүүс болон тавагтай усан үзэм, алим тавьжээ.

Залуу хөвгүүн нэгэнтээ тонголзон ёслоод хаалганы түлхүүрийг явган ширээн дээр тавимагц гарч одов. Энэ бүхэн яавч олзлогдсон хүнд хандсан хандлага биш байсан тул Ерөөгийн цээжинд найдварын гэрэл гялсхийв. Тэр аврагдав биш үү. Хар багтнууд өөр хэн ч биш Зоригоо юм уу, түүний түнш монгол хэлтэй мөнөөхөн хөгшин хужаагийн явуулсан элч нар байсан биш үү? Чингэж л шөнө дөлөөр гангестр маягаар түрэмгийлэн зочид буудалд буутай шийдэмтэй, багтай дайрч орохгүй бол Ерөөг авч тэндээс гаргах өөр арга байгаагүй байх л даа...

Ерөө бүр инээд алдах шахав. Ямар ч байсан аюул ард үлджээ гэж бодоход инээмээр байв. Залуу сайхан насаа Тайландын хөгшин баяны татвар эмийн гай зовлон дунд өнгөрөөх аюулаас аврагдлаа. Ямар азаар би Зоригоо, Болдоо хоёртой онгоцонд тааралдав аа? Бурхан гэж байдаг юм байна. Эх нутгийн бурхан л намайг азаар энэ хоёр сайн сэтгэлтэй залуустай учруулав. Одоо би эднээс салахгүй.

Сэтгэл нь нэг ана боловч цэлмэсэн Ерөө гараа угааж, жимсний хүйтэн шүүс ууж, алим идээд ор засч хэвтэв. Нойр хүрэхгүй тийчилсээр өглөөний зургаан цагийн янар түр дугхийжээ.

Тиймээ Ерөө андуурсангүй. Нэг сэрэхэд нь үүдээр Зоригоо инээмсэглэн орж ирж явлаа.

-За ашгүй чөлөөлөгдчихөв үү? Одоо хүүхэн гуай биднээс сална гэж бүү сана. Чамайг дагуулж Болдоо бид хоёр Зүүн өмнөд Азийн орнуудаар хамт бизнесийн ажлаа хөөцөлдөнө гэж мэд. Тэгээд халуун гараас чинь хөтөлсөөр явж эх орондоо хүргэж өгнө. Мэдэв үү? Чамайг аварсан хүн бол манай түнш Ван овогт юм шүү. Түүнийг монголчууд Цагаан Далай гэдэг юм. Далай гуай л чухам ухаан сийлж компанийхаа хоёр ажилтанг гангестр хэмээх дээрэмчин болгож буу шийдэмтэй зочид буудал руу явуулсан хэрэг. Хэрэв ийм арга хэрэглээгүй бол чи өдийд “Бадамлянхуа” буудалдаа уйлаад л сууж байхсан даа. Тэр хүнд баярласан гялайснаа хэлж үзээрэй... гээд Зоригоо хээ шаагүйгээр Ерөөгийн хацар дээр шовхийтэл үнсч билээ.

ТӨГСГӨЛ

-Яаж хоёр яс сална даа...

Батбаяр ийнхүү санаа зовон хэлээд энэ үгнээсээ өөрөө айх шиг болов. Ерөөг төрөхөд ийм үгийг Ууганаа нь хэлсэн шиг санагдана. Гэтэл одоо Ууганжаргал өөрөө төрөх болчихоод түргэний тэргээр нэгдүгээр амаржих газар ирчихсэн ихэд өвдөн сандаргаж байлаа. Аливаад ээлж байдаг ажээ. Ууганаа нь өөрийгөө хэзээ ч үр төрүүлэх чадваргүй гэж бодож асан бол одоо эм хүнийхээ жаргал зовлонг хамт эдлэхээр Ерөөгийн хэвтэж байсан тэр тасагт хэвтжээ.

Батбаярын сэтгэл их зовж байв. Нас дөч гарсан ч гэлээ урьд өмнө үр хүүхэд төрүүлж байгаагүй тулгар амьтан болохоор яах бол сэтгэл зовох нь аргагүй байлаа.

Намрын сэрүүн хэдийнээ оржээ. Өглөө эрт түргэн дуудаад гарахад хүйтэн салхи үлээж, мөр жиндмээр хүйт оргиж байлаа. Түргэн тусламжийн машин дотор бүр хүчтэй өвдсөн Ууганааг түшин явахдаа эхнэр нь хүүхдээ арай машинд гаргачих юм биш байгаа гэж айн түгшжээ. Тэрбээр гар утсаараа Чимгээ рүү ярьж Ууганаа өвдөөд амаржих газар руу явж байна. Ирвэл сайн сан гэж хэлжээ.

Чимгээ тэдний хооронд олон жил болсон мөнөөхөн далд янагийн холбоо бүр тасарчихаагүй боловч, хуучин шигээ үргэлж уулздаг гэвэл худлаа хэлсэн болох буй заа. Хааяахан нэг уулзаад Батбаяр дуртай дургүй тэнгэрийн ёсыг албаар шахуу гүйцэлдүүлэхэд Чимгээ дуртай байдаг авч, энэ хүн түүнээс бүр хөрч холджээ гэдгийг зөнгөөрөө мэдээд нэг их уулзахсан гэж шаардахыг ч байжээ. Тус тусынхаа амьдралыг л хөөцгөөж, харин эм улсын ёсоор Ууганаа тэр хоёр бол үргэлжид уулзан хүүхнүүдийн яриагаар сэтгэлээ засах ажээ.

Ойрд Ерөөгөөс сураг гарсангүй. Харин сэтгэл санаагаар унаж ухаан мэдрэлээ алдтал ууж, эрүүлжүүлэхийн шээс, шинхэг үнэртсэн муухай байранд шившгээ дэлгэж хоносны дараахан гэнэт гар утсаар нь Ерөө дуудаж ярьсан байлаа.

-Би Сөүлээс гараад удаж байна. Хүний үздэг үздэггүйг үзэж туулж л явна даа. Ашгүй сайн санаатай хүмүүстэй тааралдаж тэднийхээ бизнесийн ажилд туслаад Тайланд, Сингапур ороод явж байна. Эднийхээ ажлыг дуусахаар цуг харина даа. Хэл чимээгүй удсныг минь уучлаарай. Би чамдаа хязгааргүй хайртай шүү. Миний өмнөөс Ууганаа эгчийг тэвэрч, хүүг минь үнсээрэй...

Эрүүл саруул яваа бяцхан амрагийнхаа дууг сонсч Батбаяр нар нь гарах шиг болсон авч, хүрээд ирэхэд нь хүүгээ алдчихсан суудаг ээ мөн тоогүй еэ гэж гаслаж билээ. Нэг л явдал болж... Сөүл дэх эзэн нь их мөнгөтэй ажил хайгаад Сөүлээс явчихсан гэж хэлсэн нь үнэн байж таарлаа. Чухам юу болсон юм бол? Амьтан хүнд залилуулав уу? “Хүний үздэг, үздэггүйг үзэж туулж л явна даа” гэсэн үгийн цаана юу байгаа бол? Ерөөг минь авч яваа тэр сайн санаат хүмүүс гэдэг нь хэн юм бол? Арай залуухан эрчүүд биш биз дээ” гэж бодоход Ерөөгөө хэнээс ч гэсэн харамламаар байлаа.

Төрөх газрын хаалгыг цэлийтэл нээн нэгэн өндөр туранхай дэгжин саарал цувтай хүүхэн орж ирсэн нь Чимгээ байлаа.

-За яав? Ууганаа арай төрчихөөгүй биз? Төрөхийн орон дээр гарч уу? хэмээн Чимгээ хэзээний нүүрмэг зангаараа олон асуулт зэрэг зэрэг тавьсаар Батбаярт дөхөж ирэв.

-Уул нь түргэний тэргэн дотор төрчих нь үү гэмээр өвдөөд байсан. Одоо намдчих шиг боллоо. Юу болов доо байз... гэж Батбаяр чингэж төрөөгүй байгаа нь түүний буруу юм шиг шилээ маажив.

-Нааш нь авчрахдаа шар тос уулгасан уу?

-Тэгсэн... Чиний хэлсэн бүхнийг л хийсэн... Баавгайн савар олж өгөөд оруулсан...

-За байз энэ цувыг барьж бай хэмээгээд Чимгээ гадуур хувцсаа тайлж, цагаан халаад өмсөөд хаалга цохин дотогшоо орж явчихав.

Түүнтэй зөрөөд шахуу дотроос овоо өсгөлүүн биетэй жаахан хүү тэвэрсээр нэгэн дунд сургуулийн банди гарч иржээ. Ноосон малгай өмсгөж, бариувчаар гоёсон тэр жаал нүдэнд тусаад ирэхэд өөрийн яс махны тасархай Баярболд хүү нь яах аргагүй мөн шиг санагдаад Батбаяр өөрийн эрхгүй түүн рүү ухасхийв. Чингээд хүүг гар дээрээ авах гэтэл авч яваа жаал

-Хүүе ах аа, та яаж байнаа? гэж уцаарлан дуугарчээ.

-Энэ хэний хүүхэд вэ?

-Дэлгэрмаа эгчийнх... Аавыг нь Билэгжаргал гэдэг юм. Японд суудаг... Дэлгэрээ эгч гадуур хөөцөлдөх ажилтай болчихоод ээжийг харж бай гээд хүүхдээ орхисон юм.

-Чиний ээжийг хэн гэдэг билээ?

-Ээж төрөх газрын эмч... Үзмээ гэдэг...

Хөвгүүн энэ ахаас салахын түүс болж байх шиг...

-Үгүй мөн хачин юм даа. Яах аргагүй л миний хүү мөн дөө. Эцгийн сэтгэл эндүүрмээргүй. Одоохон энэ явдлыг шалгуулах сан...

-За сайн байцгаана уу? Хүүе энэ чинь миний хүү юу? Яасан том болоо вэ? Аль вэ ээж нь үнсье? гэж хэн нэгэн цангинасан дуутай бүсгүй хэлж бандийн гар дээрээс хүүг булаах шахам авч нүүр нүдгүй үнссэн нь Ерөө байлаа...

-Иш Ерөө минь!...

Батбаярын хоолой зангирч, аньсага нь нойт оргиод ирэв. Ерөө нь жаахан тураа юу даа? Ямар гоё сайхан авхай болоо вэ? Хүлээлгийн өрөөнд олон хүн байгаа болохоор ичээд намайг тэвэрч авч чадахгүй байна. Тэрнээс биш ганцаараа байгаа сан бол хэдийнээ тэврээд үнсэж байгаа даа...

-Ах аа, эгч боль л доо. Дэлгэрмаа эгч уурлана шүү... хэмээн аль ч учрыг үл ойлгох жаахан хөвүүн танихгүй ах, эгч нар хүүхдийг ээлжээр тэврэн үнсэхэд гайхан хэлжээ.

-Жаал хүү чи тэр Үзмээ ээжийгээ дууд. Бас тэр Дэлгэрмаа эгчдээ хэл дуулга. Алдагдсан хүүхдийн эцэг эх хоёр хүүхдээ таниад авчихлаа гэж хэл. Энэ хүүхдийг одоо бид хэнд ч өгөхгүй... гэж Батбаяр хүүгээ тэврээд зоримогдуу хэлжээ.

-Алдагдсан хүүхэд ээ? гэж Ерөө гайхан асуув.

-Тиймээ чамайг явсан тэр өдөр өнөөх Бадраа хүүхдийг эмнэлгээс хулгайлсан... Дархан орох

замдаа согтуурч яваад хүүхдийг нэг эмэгтэйд хөхүүлэхээр өгөөд алдчихсан байсан... энэ тухай яривал урт түүх болно... Сүүлд бүгдийг хэлэмз. Одоо бол Ууганаа төрөх гээд... Гэтэл хүү минь олоодохлоо. Чи хүрээд ирлээ. Өнөөдөр чинь ямар азтай буянтай өдөр гэгч вэ?

Чимгээ гараад ирэв. Тэр Ерөөг харж таниад

-Хүүе яасан сонин хүн бэ? Хэзээ хүрээд ирэв ээ? гэж үнсэв.

-Өнөө өглөө онгоцноос буугаад гэртээ ирсэн чинь хүн байдаггүй. Хажуу айлын хүмүүс л Ууганаа эгчийг төрөх гэж өвдөөд наашаа явсан гэхээр нь такси аваад хүрээд ирлээ...

-За ашгүй дээ. Ууганаа гайгүй байна. Өвдөлт нь түр намджээ. Би эмчийг гуйж түргэсгэх тариа хийлгүүлчихлээ гэснээ сая Батбаяр хүүхэд тэвэрсэн байхыг харж,

-Хүүе энэ чинь хэн бэ? Баярболд хүү юу дээ? Та нар хаанаас олоод авах нь энэ вэ? гэж дуу алдлаа.

Үзмээд хүүгээ орхисондоо яарч сандран төрөхийн хаалгаар орж ирснээ Дэлгэрмаа зогтусав. Хэдэн хүн хүүхдийг нь гар дамжуулан үнсэж ярилцах ажээ. Залуу эхийн толгойтой үс арзайн босох шиг болов. Тэр хаашаа ч хөдлөж чадахгүй тушаатай мэт үүдэнд хадаатай зогсчээ.

-Дүү минь чи яв, яв. Тэр Үзмээ ээждээ хэлж биднийг уулзъя гэж байна гэж хэл. Дэлгэрмаа гэдэг эмэгтэйг бас дуудуул гэж хэлээрэй.

Энэ хүүхдийн төрсөн аав нь би, ээж нь энэ Ерөө юм. Эмнэлгээс алдагдаад олон сар болсон хүүхэд... Хүн энэ хүүхдийг хулгайлсан юм. Тэгээд бас дамаа өөр хүнд алдчихсан хэрэг. Цагдаагийнхан эрээд олохгүй байгаа юм. Тэгэхэд чи амаржих газраас тэврээд гараад ирдэг сайн хүү байна...

Үзмээгийн банди Дэлгэрмааг харсангүй бололтой, дотогшоо гүйн оров. Харин Дэлгэрмаа эргэж хаалгаар гарахдаа нүдийг нулимс бүрхээд юу ч харж чадахгүй байлаа. Юу гээчийн гашуун хувь заяа вэ. Ядуу дорой өчүүхэн эх надаар хувь заяа чи яасан их даажин тохуу хийнэ в?

Дэлгэрмаа амаржих газраас гараад хаашаа явахаа мэдэхгүй хандсан зүгтээ явж байв. Өрийг нь өшиглөж өврийг нь хоосолсон гунигт явдалд тэр итгэж чадахгүй байлаа.

Үнэндээ нөхөр нь жаахан хүүд төрий л найртай хандаагүй билээ. Аман дээрээ хатуу үг хэлээгүй боловч үе үе цагдаа нар болсон явдлыг мэдвэл тусгүй юм болно доо гэж цухуйлган, албан ёсоор үрчилж аваагүй хүүхэд хэзээ нэгэн цагт эхдээ очиж л таарна шүү гэсэн нь үнэн байжээ. Чингэж хэлэхэд нь хармын сэтгэлээсээ болж Дэлгэрмаа зөрүүдлэн юу ч дуугараагүй билээ. Гэтэл хулгайн буруу замаар ирсэн хүүхэд ингээд нэг өдөр өөрийн төрсөн аав, ээжээ олчилдог юм байна. Би одоо яах вэ? Хаачих вэ? Билэгжаргал нь хаа байсан Токио хотод суугаа... Дэлгэрмаа уйлан явсаар л байлаа...

Нэгдүгээр амаржих газрын хүлээлгийн өрөөнд хүүхэд тэвэрсэн Батбаяр, Ерөө, Чимгээ гурав



Ууганжаргалын төрөхийг хүлээн хүлээсээр л...

-Амар амгалан шиг л хоёр яс салаасай даа...

**ТӨГСӨВ.**